

Улсын бүртгэлийн дугаар...

Нууцын зэрэглэл **Б**

Аравтын бүрэн ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар

.....

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

НИЙГМИЙН ОРОЛЦОО, ТУСГААРЛАГДАХ ҮЙЛ ЯВЦ, ҮР ДАГАВАР

СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2019-2022

Төслийн удирдагч:	Ц.Пүрэв, Социологийн салбарын ахлах ажилтан, доктор (Ph.D)
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан технологийн сан
Захиалагч байгууллага:	Боловсрол, шинжлэх ухааны яам
Тайлан өмчлөгч:	ШУА-ийн Философийн хүрээлэн

УЛААНБААТАР
2023 ОН

Улсын бүртгэлийн дугаар...

Нууцын зэрэглэл **Б**

Аравтын бүрэн ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар

.....

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

НИЙГМИЙН ОРОЛЦОО, ТУСГААРЛАГДАХ ҮЙЛ ЯВЦ, ҮР ДАГАВАР

СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2019-2022

Төслийн удирдагч:	Ц.Пүрэв, Социологийн салбарын ахлах ажилтан, доктор (Ph.D)
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан технологийн сан
Захиалагч байгууллага:	Боловсрол, шинжлэх ухааны яам
Тайлан өмчлөгч:	ШУА-ийн Философийн хүрээлэн

УЛААНБААТАР
2023 ОН

РЕФЕРАТ

Тайлангийн нэр: Нийгмийн оролцоо, тусгаарлагдах үйл явц, үр дагавар

Хуудас: 142

Зурагт хуудасны тоо:

Тайлан бичсэн газар: Улаанбаатар хот, ШУА-ийн Философийн хүрээлэн

Он: 2023

Тайлан өмчлөгч: ШУА-ийн Философийн хүрээлэн

РЕФЕРАТ

Суурь судалгааны ажлын хүрээнд 1) онол, арга зүйн түвшинд ойлголт, нэр томъёоны хувьд нэгдсэн ойлголтод хүрэх, 2) судлах арга зүй, аргачлалаа тодорхойлж, тогтоох; 3) практик түвшинд нийгмийн оролцоо, нийгмээс тусгаарлагдах үйл явцын ерөнхий төлөв байдал, хандлагыг тодорхойлж, оролцоо багатай, нийгмээс тусгаарлагдаж буй бүлгүүд үүсэх тусгаарлагдах үйл явц, онцлог, явагдаж буй механизмыг судлаж тодорхойлохоор зорьж, дараах зорилтыг дэвшүүлж хэрэгжүүллээ. Үүнд:

- 1) Social exclusion гэх ойлголтыг тодорхойлох;
- 2) Нийгмээс тусгаарлагдах механизмыг судлах арга зүй, аргачлалыг боловсруулах;
- 3) Монгол дахь нийгмийн тэгш бус байдал, давхраажлын ерөнхий дүр зургийг тодруулж, зураглах;
- 4) Нийгмээс тусгаарлагдсан хэсгийн нийгэмд эзлэх хэмжээ, нийгмийн дүр зураг онцлогийг тодорхойлох;
- 5) Тусгаарлагдалтад өртөж буй шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйл, илэрч буй зүй тогтол, гарах үр дагаврын талаар шинэ мэдээлэл, мэдлэг бий болгох;
- 6) Тусгаарлагдаж буй бүлгүүдийн нийгмийн оролцоог хангах, дэмжих арга замын талаар санал зөвлөмж боловсруулах зорилтыг дэвшүүлж хэрэгжүүллээ.

Сэдвийн хувьд харьцангуй шинэлэг бөгөөд одоогийн түвшинд Монголын нийгмийн тусгаарлагдалтын үйл явцыг тухайлан судлаагүй, нийгмээс тусгаарлагдаж, эс хамрагдаж буй хэсэг бүлэг нь нийгэмд хэдэн хувийг эзлэж байна, тусгаарлагдалтын түвшин хэр байна, ямар ямар бүлгүүд тусгаарлагдаж байна, эрсдэлт бүлгүүд нь хэн байна гэх мэт олон асуултанд хариулт алга байв. Эл судалгааны ажил нь эдгээр асуултанд хариу өгснөөрөө, нийгмийн харилцаа, оролцоо нь хязгаарлагдаж, тусгаарлагдалтанд ямар нэг байдлаар өртсөн бүлгүүд, тусгаарлагдалтанд өртөх эрсдэл бүхий тодорхой бүлгүүдийг авч үзсэнээрээ, social exclusion хэмээх ойлголт ухагдахууныг монгол хэлээр хэрхэн томъёолох талаар хэлэлцүүлж, судлаачдын санал бодлыг уг асуудалд төвлөрүүлснээрээ шинэлэг ач холбогдолтой.

Үндсэн ойлголт. Амьдралын чанар, нийгмийн тусгаарлагдалт, амьдралын нөөц боломж хомсдол, нийгмийн тусгаарлагдалтын түвшин, эрсдэлт бүлгүүд, нийгмийн шилжилт, ядуурал, тусгаарлагдах, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах, материаллаг хомсдол, эдийн засгийн тусгаарлагдалт, нийгмийн оролцоо, харилцааны тусгаарлагдалт, нийгмийн үйлчилгээний тусгаарлагдалт.

Гүйцэтгэгчдийн нэрийн жагсаалт

Цэрэнгомбын Пүрэв	Социологийн салбарын ЭШТА, доктор (Ph.D), профессор. (I, II, III, IV, IX).
Оюуны Баасантогтох	Социологийн салбарын ЭШДэА, доктор (Ph.D). (VIII, XI).
Жаргалсайханы Батжаргал	Социологийн салбарын ЭШДэА, докторант, Социологийн салбарын эрхлэгч. (I, III, VI, XI).
Даваадоржийн Номун-Эрдэнэ	Социологийн салбарын ЭШДэА, докторант. (V, XI).
Ёндонгийн Ундрал	Социологийн салбарын ЭШДэА, докторант. (VII).
Жаргалсайханы Пүрэвханд	Социологийн салбарын ЭШДэА, магистр. (IV).
Цэвээний Цэцэнбилэг	Доктор (Ph.D), дэд профессор.
Баднаа Азбаяр	Социологийн салбарын ЭШДэА, магистр.

ТОВЪЁОГ

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	7
ОРШИЛ.....	9
1.1. Суурь судалгааны үндэслэл	9
1.2. Судлагдсан байдал.....	13
1.3. Судалгааны арга зүй	17
1.4. Судалгааны түүвэр, зохион байгуулалт	24
1.5 Суурь судалгааны ажлын даалгавар, гүйцэтгэл.....	26
СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН АГУУЛГА.....	27
2.1. Нийгмээс тусгаарлагдмал байдлыг ойлгохуй, судлахуй	27
2.2. Амьдралын нөөц боломжийн хомсдол ба тусгаарлагдмал байдал	33
2.3. Нийгмээс тусгаарлагдах үйл явц: шинж онцлог, нөлөөлж буй хүчин зүйл	37
2.4. Өрхийн материаллаг хангамж ба хомсдол	40
2.5. Нийгмийн шилжилт ба тусгаарлагдах үйл явц.....	43
2.6. Нийгмийн капитал ба тусгаарлагдах үйл явц.....	45
2.7. Ядуурал ба нийгмийн тусгаарлагдах үйл явцыг судлах нь	47
2.8. Нийгмийн институтчилэл ба тусгаарлагдмал байдал	51
2.9. Хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо ба хүртээмжгүй байдал	53
2.10. Боловсролын үйлчилгээн дэх тэгш бус хамрагдалт	59
2.11. Тусгаарлагдах эрсдэлт бүлгүүд	63
Дүгнэлт	74
ХАВСРАЛТ-1	76
ХАВСРАЛТ-2.....	80

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР¹

Амьдралын чанар - махбодийн эрүүл мэнд, гэр бүл, боловсрол, ажил эрхлэлт, эд хөрөнгө, аюулгүй байдал, эрх чөлөөний баталгаа, шашны итгэл үнэмшил болон хүрээлэн буй орчин нь хувь хүний амьдралд эрсдэл учруулахгүй байх явдал юм.

Гадуурхал - хэн нэгэн, эсхүл хэсэг бүлэг хүнийг үндэс угсаа, шашин шүтлэг, жендэр, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа зэрэгт үндэслэсэн тэгш бус харилцаа.

Маргиналь бүлэг гэдэг нь эмзэг бүлэг, цөөнхийн бүлэг. Маргиналь гэдэг бол тухайн нийгмийн амьдралын хүрээний гадна оршиж буй, сэтгэл санааны болон эдийн засгийн хямралд өртөн эрхийн байдлаа алдсан хувь хүн болон бүлгийн тухай ойлголт юм. Өнөөгийн нөхцөлд шилжих хөдөлгөөн, нүүдэл, суудал, нийгмийн шилжилт, хотжилт, төвлөрөлтөөс шалтгаалан нийгмийн амьдралын хүрээний гадна хоцорч, амьдрал нь доройтох, ёс суртахууны доголдолд орох, сэтгэл мэдрэлийн өвчинд автах, архинд донтох зэрэг нь маргиналь үүсэх эх үүсвэр болдог.

Social exclusion- нийгмээс тусгаарлагдах, эс хамрагдах, орхигдох, гадуурхагдах утгыг агуулж байна. Тусгаарлагдахуй (*exclusion*) буюу эс хамруулалт нь нийгэм дэх хүн амын олонхийн (дундаж иргэдийн) оролцдог эдийн засаг, нийгэм, соёл болон улс төрийн аль ч хүрээн дэх хэвийн холбоо харилцаа, үйл ажиллагаанд нөөц боломжгүй, хүний эрх нь зөрчигдсөн, эд хөрөнгөгүй болсон, ердийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүйн улмаас эсвэл тэдгээрээс татгалзсантай холбогдон илэрч буй цогц бөгөөд олон хэмжээст үйл явц мөн. Ядуурлын үзэл баримтлал нь нөөцийн хуваарилалт, хэрэгцээ хангалтгүй хэрэгжиж буйд гол анхаарлаа хандуулдаг бол, тусгаарлагдахуйн үзэл баримтлал иргэний эрхийн асуудал болон нийгмийн эв нэгдлийн институтээс юуны урьд хөдөлмөрийн зах зээлээс ялгаварлан гадуурхагдснаар иргэний эрх нь хязгаарлагдаж буй асуудлыг авч үздэг гэжээ.

Түүнчлэн тусгаарлагдахуйг эв нэгдлийн нийгмийн институтэд хамрагдах боломж нь хязгаарлагдахтай холбоотой маргинализацийн үйл явц; завсрын буюу захын нөхцөл байдалд амьдарч байгаагаас дадал болсон нийгэм соёлын орчноосоо хүмүүс хөндийрэх үйл явц хэмээн зарим хэсэг нь үздэг байна.

Social segregation /латинаар *segregation* гэдэг нь хуваах, тусгайлах/ хотын орон зайд нийгмийн бүлгүүд ямар нэгэн шинжээр ялгарах, тусгайлан амьдрах явдал. Хотын хязгаарлагдмал хэсэгт албадан болон сайн дурын үндсэн дээр оршин суух, нийгмийн харилцааны саад бэрхшээл, тусгай боловсролын байгууллага аль эсвэл бусад ялгаварлан гадуурхах аргаар арьсны өнгө, анги, угсаатны бүлгийг тусгаарлах, хуваахыг хэлнэ.

Social isolation – Нийгмийн тусгаарлалт. Нийгмийн харилцаа холбоогүй, байнга харьцдаг цөөн хүнтэй, гэртээ удаан хугацаагаар байх, бусадтай харилцахыг эрмэлзэхгүй байх, Нийгэмд харъяалагдах мэдрэмжгүй, нийгмийн харилцаагүй, сэтгэл ханамжтай, чанартай харилцаа холбоогүй байх явдал Хүмүүсийг өдөр тутмын дасал болсон хэвийн амьдралаас нь салгах (шорон, хоргодох газар, цэргийн хээрийн эмнэлэг, зэвсэгт хүчин, сургуулийн дотуур байр зэрэг газарт) //Большой социологический словарь. COLLINS. Дэвид Джери, Джулия Джери. Том 1, М., 1999. С. 233.

¹ Н.Смелзер. Социологи. УБ., 2001. 608-621 дэх тал.

Social inclusion – Нийгмийн үйл ажиллагаанд оролцох, хамрагдах, Нийгмийн харилцаа, нийгмийн үйл ажиллагаанд оролцох, тэгш хамрагдах

Mainstream – Нийгмийн цөм хэсэг, гол бүрэлдэхүүн, дийлэнх хэсэг.

Insider, outsider – нийгмийн дотор байгаа нийгмийн харилцаа, үйл ажиллагаан дунд байгаа хүмүүс, нийгмээс гадуур байгсад, Өөр утга: нууц мэдээллийн эзэмшигч, мэдээллээс гадуур байх

Stigmatisation – аливаа нэгэн тодорхой шинж тэмдгээр хүнийг ялгаварлан гадуурхах

Social discrimination - нийгмийн гишүүдийн зүгээс нас, хүйс, арьсны өнгө зэрэг шалтгаанаар ялгаварлан гадуурхахыг хэлнэ.

Самоисключение – гэдэг нь хувь хүн өөрийгөө бусдаас тусгаарлах үзэгдлийг хэлнэ. Тухайлбал, ядуу хүмүүсийг нийгмийн бусад гишүүн тусгаарлаад, гадуурхаж байвал тухайн хүн өөрийгөө “тусгаарлагдсан” гэсэн байдлаар тодорхойлж хариуд нь өөрийгөө тусгаарлаж эхэлдэг. Энэ нь юуны өмнө сэтгэл зүй, социологийн ойлголт юм.

Сегрегация (segregation) – Ялгаварлан гадуурхсаны үр дагавар болж, арьстан, анги, угсаатны бүлгийг орон зайн хувьд тусгаарлах, салгах. Эдийн засаг нийгмийн гадуурхалтын улмаас олон оронд орон сууц боловсролын хувьд сегрегаци байсаар байна. // Большой социологический словарь. COLLINS. Дэвид Джери, Джулия Джери. Том 2, М., 1999. С. 187-188.

Тусгаарлагдах - Хилари Сильвер өөрийгөө нийгмийн дотор байгаа, нийгмийн идэвхтэй оролцогч (мейнстрим) гэж үзэж тооцож буй хүн амьжиргааны хэрэгсэлтэй буюу байнгын ажил эрхлэлт, орлого, өмч хөрөнгө, газар, орон байр, хэрэглээний тодорхой түвшинд, боловсрол, соёлын капитал, иргэншил, хүндэтгэл хүлээх боломжтой бол оюун ухааны хомсдолтой, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, амиа хорлох гэж оролдогсод, тахир дутуу хүмүүс, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд, мансууруулах бодис хэрэглэгчид, гэмт хэрэгтэн, ганц бие эцэг эх, эмзэг бүлгийн иргэд нийгмийн харилцааны гадна үлдэх юм уу, баялгаас хүртэх боломжгүй байдаг.

Тэгш бус байдал - хүмүүс нийгмийн баялгаас жигд биш хүртэх байдал.

Цөөнхийн бүлэг - өөрсдөд нь зуршмал байдаг биеийн болон соёлын онцлогтой холбогдон адил бусаар харилцах хэсэг хүмүүс.

Нийгмийн шилжилт - хүн амын хэсэг нэг нийгмээс нөгөөд, нэг нийгмийн дотор, эсвэл хувь хүн бүлгийн статус өөрчлөгдөх үйл явц.

Ялгаварлан гадуурхах - цөөнхийн бүлгийн гишүүдийг муу гэгдэх шинжээр нь ялгаварлан шударга бусаар хандах явдал.

ОРШИЛ

1.1. Суурь судалгааны үндэслэл

Нийгмийн тусгаарлагдалтыг хүн нийгмийнхээ үндсэн гол үйл ажиллагаанд өөрөөс хамааралгүй шалтгаанаар оролцож чадахгүй байх явдал буюу нөөц баялгийн дутагдал, нийгмийн эрхийн хангалтгүй байдал, нийгмийн оролцооны дутагдлаас үүдсэн иргэдийн хэвийн үйл ажиллагаанд оролцдоггүй, харилцаагүй байдал юм. Силвер (1994) нь Европын янз бүрийн үндэстний нөхцөл байдлын хүрээнд хэрэглэгдэж буй нийгмийн тусгаарлалтын утга, хэрэглээг агуулсан дараах гурван өөр "парадигм" байна гэж үзсэн.

1. Францын Бүгд найрамдах үзэл ба нийгмийн дэг журмын тухай Дюркгеймийн үзэл баримтлалд үндэслэсэн *эв санааны нэгдэл парадигм* нь нийгмийн тусгаарлагдалтыг нийгмийн эв нэгдлийн задрал бөгөөд орхигдож тусгаарлагдсан хүмүүсийн хэм хэмжээний ба соёлын интеграцийг шаарддаг гэж үздэг.

2. Англи хэлт либерал ардчилсан орнуудад илүү түгээмэл байдаг *мэргэшлийн парадигм* нь нийгмийн тусгаарлагдахуйг хөдөлмөрийн эдийн засгийн хуваарилалтад суурилсан нийгмийн давхаргын үр дагавар, нийгмийн хүрээнд сайн дурын солилцоо хийдэг зарим хүмүүсийг ялгаварлан гадуурхах эсвэл "янз бүрийн хүрээний хоорондох чөлөөт хөдөлгөөнд саад бологч" бусад зүйлс гэж үздэг (Silver 1994)

3. *Монополь парадигм* нь Маркс болон (ялангуяа) Веберийн анги, статусын талаарх ойлголт, эрх мэдлийн харилцааны талаарх бүтээлүүд дээр үндэслэж, нийгмийн тусгаарлагдахуйг монополийн ашиг сонирхол, ялангуяа зах зээлээс үүдэлтэй тусгаарлагдах байдлын үр дүн гэж үздэг (Silver 1994).

Нийгмийн тусгаарлагдалтын чухал шинж чанарууд нь олон хэмжээст байдал, харьцангуй байдал (*ө.х нийгмийн тусгаарлагдалт нь нөхцөл байдлаас шалтгаалсан онцлог шинжтэй*) ба агентлаг зэрэг болно [6]. Агентлаг нь засгийн газар эсвэл хувийн байгууллагууд, нийгмийн орчин эсвэл хувь хүн байж болох юм.

Нийгмийн тусгаарлагдалт нь нийгмээс тусгаарлагдсан үйл явцтай (динамик) зөвхөн холбоотой бус харин нийгмээс тусгаарлагдсан нөхцөл байдлыг (статик) илэрхийлж болно. Нийгмийн тусгаарлагдалт нь материаллаг бус шинж чанар (харилцан хамаарлын хэмжигдэхүүн) болон материаллаг талууд (хуваарилалтын хэмжигдэхүүн) хоёуланг хамтад нь хамааруулж болно. Нийгмээс тусгаарлагдах, эс хамрагдах шалтгаан нь хамт олны түвшинд байж болох боловч хувь хүний шинж чанар, зан үйл онолын хувьд чухал ач холбогдолтой байдаг [7].

Эдүгээ өрнөдийн социологит нийгмийн тусгаарлагдалтыг судлах хоёр үндсэн хандлага байгааг тэмдэглэдэг. Макро түвшинд нийгмийн харилцаа, эв нэгдлийн механизмд хамрагдах боломжгүй байх тэр нөхцөлийг судалдаг бөгөөд ялгаварлан гадуурхалт гэсэн ойлголтоор илэрхийлэгддэг. Микро түвшинд

орхигдсон, тусгаарлагдсан хүмүүс, бүлгийн социаль шинж, амьдралын нөхцөлд анхаарал хандуулдаг бөгөөд гачигдал, хомсдол (*депривация- амьдралын үндсэн хэрэгцээгээ хангаж чадахгүй болох*) гэсэн ойлголт илүү хэрэглэгддэг аж². Сонгодог ойлголтоор нийгмийн орон зайн төв буюу цөм хэсэгт зонхилох чиг хандлага бүхий хүмүүс (*мейнстрим*) түүний гадуур, тодорхой эрхээ эдлэх явцад ялгаварлан гадуурхалд өртөгсөд буюу “бүрхэг” бүс, бүр захад нь нийгмийн харилцаанаас тасарсан бүлэг буюу харанхуй нүх оршдог байна.

Нийгмийн тусгаарлагдалтын үзэл баримтлал бол ядуурлыг шинэ хандлагаар судлаж буй хэрэг бөгөөд ядуурлыг багтаасан илүү өргөн ойлголт юм. Ядуурал нь эдийн засгийн ухааны, харин нийгмийн тусгаарлагдалт бол социологийн хандлага гэж Копенгагены их сургуулийн социологийн профессор П.Абрахамсон үзсэн³. Н.Е.Тихонова Оросын нийгмийн социаль бүтцэд чанарын өөрчлөлт гарах хандлага илэрч, түүний дотор дадал болсон нийтийн ядуурлыг бодвол орхигдогсдын илүү өргөн давхраа үүссэн гэж дүгнэжээ.

Түүнчлэн тусгаарлагдмал байдлыг эв нэгдлийн нийгмийн институтэд хамрагдах боломж нь хязгаарлагдахтай холбоотой маргинализацийн үйл явц; завсрын буюу захын нөхцөл байдалд амьдарч байгаагаас дадал болсон нийгэм соёлын орчноосоо хүмүүс хөндийрэх үйл явц хэмээн зарим хэсэг нь үздэг байна. Маргиналь гэдэг бол тухайн нийгмийн амьдралын хүрээний гадна оршиж буй, сэтгэл санааны болон эдийн засгийн хямралд өртөн эрхийн байдлаа алдсан хувь хүн болон бүлгийн тухай ойлголт юм⁴. Өнөөгийн нөхцөлд шилжих хөдөлгөөн, нүүдэл, суудал, нийгмийн шилжилт, хотжилт, төвлөрөлтөөс шалтгаалан нийгмийн амьдралын хүрээний гадна хоцорч, амьдрал нь доройтох, ёс суртахууны доголдолд орох, сэтгэл мэдрэлийн өвчинд автах, архинд донтох зэрэг нь маргиналь үүсэх эх үүсвэр болдог.

Тусгаарлагдмал байдлыг нийгмийн бүтэц, туйлжилт хийгээд нийгмийн уруудах шилжилт, нийгмийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах, хүний эрх болон эв нэгдэл алдагдах зэрэгтэй холбон үзэх нь түгээмэл ажгуу. Нийгмийн тэгш бус байдал гэдэг нь нийгэм дэх янз бүрийн бүлгүүд нийгмийн эрх болон амьдралын нөөц боломжоор харилцан адилгүй байдаг тэрхүү социаль ялгарлын хэлбэр юм⁵.

Нийгмийн байгууллыг нэг адил эдийн засаг, улс төр болон соёлын байр суурь эзэлдэг бүлгүүдэд хуваагдсан бодгалиудын давхраажилт гэж М.Вебер үзжээ. Чингэхлээр давхраажлыг үзэх түүний үзлийн амин сүнс нь хүмүүсийг эв нэгдэлтэй бүлгүүдэд нэгтгэдэг тодорхой нөхцөлүүдийн тухай таамаглалаас тогтсон бүлгүүд бүрэлдэх тухай онол юм. Харин К.Маркс эд баялаг бол нийгмийн ялгарал, давхраажилтын гол үзүүлэлт гэж үзсэн билээ. Эдийн засгийн тавцан, улс төрийн тэмцэл юм уу соёлын бодит байдалд нийтлэг байр суурь, нийтлэг сонирхолтой байгаа хүмүүс нэгдэн үйлдэх ба холбоо тогтоох, өөрсдийнхөө тэгш

²Тихонова Н.Е. Социальная эксклюзия //Общественные науки и современность. 2002. №6. С.5

³Абрахамсон П. Социальная эксклюзия и бедность //Общественные науки и современность. 2001.№2. №2. С.161

⁴Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. Уб., 2006. х.71.

⁵Социологический энциклопедический англо-русский словарь. М., 2002. С. 449.

эрхт хамтлагаас бусдыг хасах хандлагатай байдаг гэх нь М.Веберийн гол таамаглал болно⁶.

Тэрээр ангийг амьдралын боломжтой холбон үзээд, анги бол “амьдралын боломж (*life chances*)”-оор ойролцоо хүмүүсийн бүлэг юм гэжээ. Өмчлөх өмчгүй боловч байнгын болон түр хугацаагаар хүмүүст янз бүрийн үйлчилгээг санал болгож чадах төрөл буюу тодорхой чадвартай нийгмийн гишүүд нь үзүүлж буй үйлчилгээгээ ашигтай болгож буй аргаараа ялгагдан хуваагддаг байна⁷. Ийнхүү М.Вебер ангид хуваагдах үндсэн шалтгааныг зах зээлд санал болгож чадах өмч, үйлчилгээний төрөл буюу хүний боломжоос шууд шалтгаална гээд хүний амьдралын энэхүү боломжийг эрх мэдэл, өмч (баялаг), нэр хүнд хийгээд шашин шүтлэгтэй холбон үзжээ. Амьдралын боломжийг ангийг хуваах нэг шалгуур болгосон М.Веберийн энэхүү үзэл баримтлалыг социологичид уламжлан авч, нийгмийн давхраажилтын судалгаанд хэрэглэсээр ирсэн байна. Тэрээр амьдралын боломжийн үзүүлэлтээс үйлдвэрлэлийн харилцааны тогтолцоонд хувь хүний эзлэх байр суурь, эрх мэдэл, нэр хүнд, төрөл бүрийн эд баялгийн хэрэглээний талаарх сэтгэл ханамжийн байдлыг илүүтэй чухалчилсан байдаг. Тэдгээр үзүүлэлтэд тулгуурлан тухайн нийгмийг дээд, доод болон тэдгээрийн завсар орших дундаж давхраанд хуваан ангилжээ⁸. Неовеберизмын төлөөлөгчид амьдралын боломжийн үзэл баримтлалыг цаашид хөгжүүлээд, уг ойлголтыг улам гүнзгийрүүлсэн төдийгүй нийгмийн амьдралын янз бүрийн тал тухайлбал, эдийн засгийн аюулгүй байдал, хөдөлмөрийн үйл ажиллагаа, хэрэглээний хүрээг хамруулан судалсны зэрэгцээ амьдралын боломж болон эрсдэл гэсэн ойлголтыг задлах, хэмжих аргачлалыг туршин үзэж, нийгмийн бүтцийн эмпирик судалгаанд ашигласан байна⁹.

Социологит хувь хүний амьдралд тохиолдсон хүндрэл бэрхшээл хийгээд олон нийтийн өмнө тулгамдсан асуудал хоёрын ялгааг тодруулах явдал чухал ач холбогдолтой. “Хүндрэл бэрхшээлүүд тухайн хүний онцлог, бусадтайгаа харилцах холбоонд илэрдэг тул, хувь хүний биологийн өгөгдөл болон түүнийг хүрээлэн буй нийгмийн орчны тусламжтайгаар тэрхүү бэрхшээлээс гарч болно. Тэгвэл асуудал нь хувь хүний хүрээнээс хальсан байдаг тул нийгмийн институт, түүний байгууллагатай хамтран ажиллахыг шаарддаг байна... Ер нь асуудал бол, нийгмийн институтын зохицуулалтад гарсан хямрал юм... Үүнийг шийдэхийн тулд хүмүүсийн бичил орчинд нөлөөлдөг улс төр, эдийн засаг, нийгмийн бүтцийн асуудалд анхаарлаа хандуулахыг биднээс шаарддаг”¹⁰.

⁶Социологийг үндэслэгч суутнууд. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2006. 226 дахь тал.

⁷ Мөнхбат О. Социологийн онол. Сонгодог хийгээд орчин үе. УБ., 2008. 93 дахь тал

⁸Аникин В.А. Социальная стратификация по жизненным шансам: попытка операционализации для массовых опросов//Мониторинг общественного мнения:Экономические и социальные перемены. 2018. № 4. С.39-67. <https://doi.org/10.14515/monitoring>. 2018.4.03.

⁹ Тихонова Н.Е. Социальная структура России: теории и реальность. РАН. ИС. Новый хронограф. М., 2014. Дам эшлэв. //П.Бурдые. Формы капитала //Западная экономическая социология. М., 2004, Sorensen, A. Toward a sounder basis for class analysis. The American Journal of Sociology, Vol. 105, №6; Кастельс М. Информационная эпоха: экономика, общество и культура //М., 2000. Grusky, D. (2001) The Past, Present, and Future of Social Inequality. В.В.Радаев. Понятие капитала, формы капиталов и их конвертация //Общественные науки и современность, 2003, №2. С.8. РАН. ИС.

¹⁰Амлалт (The promise) С. Wright Mills //Улс төр социологийн асуудал. №1. Х.137-139

Зарим судлаачид нийгмээс тусгаарлагдах үйл явцыг судлахдаа Э.Гидденсийн бүтэцжилтийн¹¹, П.Бурдьегийн нийгмийн огторгуйн үзэл баримтлалыг¹² ашиглах зэргээр тусгаарлагдах үйл явцыг нийгмийн бүтэцтэй холбон тайлбарлахыг эрмэлзсэн байна. Тэд нийгмийн тэгш хамрагдал ба тусгаарлагдахуйг орчин үеийн нийгмийн бүтцийн зарчим хэмээсэн. Берт (1982) нарын бүтцийн онолчид үйлдэгч өөрийгөө ижил байр суурьтай бусадтай харьцуулснаар хийх үйлдлээ сонгодог гэж үздэг. Үйлдэл ашиг сонирхлыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйн хувьд үйлдлийг сонгох чадавх нийгмийн бүтцээр загварчлагдана гэсэн байна. Тэгвэл Гидденс (1984) нийгмийн бүтэц хувь хүнийг хэлбэршүүлдэг, эргээд хувь хүн нийгмийн бүтцээ төлөвшүүлдэг хэмээн хоёр талын эргэх холбоотой тул хувь хүний үйлдлээр нийгмийн бүтэц бүтээгддэг, хүмүүсийг тэр үйлдлийг хийхэд бүтэц албаддаг гэж үзжээ.

Нийгмээс тусгаарлагдах үйл явц бол нийгэм дэх санамсаргүй үзэгдэл бус харин ч тогтолцоот шинжтэй учраас нийгмийн бүтцийн онцлогтой уялдан бий болно. Тусгаарлагдагчдын хүсэл сонирхол, хэрэгцээнээс үл хамааран нийгмийн институтийн тогтолцооны хүрээнд нийгмээс тусгаарлагдах төлөвшдөг байна. Нийгмийн институт гэдэг бол улс төрийн бодлогын түвшинд томъёологдож, хэм хэмжээт эрх зүйн баримтад тусгагдсан, олон нийтийн ухамсрын түвшинд шингэсэн стратеги буюу “тоглоомын дүрэм” юм. Тэрээр нийгмийн гишүүдээс чухал шийдвэр гарган түүнийгээ хэрэгжүүлэхэд тус болж, нийгэмд албан ба албан бус дүрмийг буй болгоно. Эрх чөлөө хийгээд шинэ хэрэгцээ хуучирч тохирохоо больсон институт солигдох гол нөхцөл болно. Э.Гидденс функционализм болон феноменологид тулгуурласан бүтэцжилтийн онолдоо институт, байгууллага болон хүний үйл ажиллагааны холбоог илэрхийлсэн загвар гаргасан юм. Түүндээ утга санаа, зонхилох шинж(доминирование), хууль ёсны, хүлээн зөвшөөрөгдсөн байх (легитимация) гэсэн бүрдүүлэгч элемент бүхий институтчлэлийн хүрээ нь нийгмийн үйлдэл хийхэд нөлөөлөх бөгөөд тайлбарлах (интерпретив) бүдүүвч, нөөц бололцоо, хэм хэмжээгээр дамжин нийгмийн практик төлөвшинө. Үүний үр дүнд эрх мэдэл, зөвшөөрөл, цээрлэлээр зохицуулагдах нийгмийн үйл ажиллагаанд оролцогчдын (актор) тодорхой харилцан үйлдэл буй болдог байна¹³. Институт болон нийгмийн үйлдлийн харилцааг хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогын баримт, байгууллагуудын тушаал зааврын дагуу хэрэгждэг тодорхой байдал (сценари) холбож өгнө. Энэхүү үйл явдлыг үүсгэгчид бол хууль тогтоогчид, байгууллагын гүйцэтгэх албан тушаалтнууд болой. Нийгмээс тусгаарлагдахуйг институтчлэх үйл явцыг төлөвшүүлэх гарааны цэг нь төрийн бүтцийн хэрэгцээг хангах тухайлбал, үр дагавар нь тусгаарлагдагчдыг ялгаварлан гадуурхахад хүргэдэг нийгэм дэх олонхийн дэг журмыг дэмжих, эрх баригчдын авлига авах хэрэгцээг хэрэгжүүлэх, хүний эрхийг зөрчих зэрэг зөрчил бүхий засаглалыг тогтоон барихад чиглэдэг

¹¹Ефлова Мария Юрьевна. Социальная эксклюзия депривированных групп (наркозависимых и людей живущих с ВИЧ) в Российском обществе: стратегии институционализации и опыт интеграции. Казанский феде. Университет. Саранск.-2015. С 37.

¹²Дмитриева А. В. Роль потребления наркотиков в структуре социальных отношении: дис. канд. социол. Наук. СПб., 2012.

¹³ Barley S. R., Tolbert P. S. Institutionalization and structuration: Studying the links between action and institution.

байна. Нийгмийн огторгуйн бүтэцжүүлэлт бол тасралтгүй хувирч өөрчлөгдөх үйл явц юм.

1.2. Судлагдсан байдал

Левитас (2006) Британийн ядуурал ба нийгмийн тусгаарлагдалтыг судлах судалгаанд үндэслэн нийгмээс тусгаарлагдалтыг шууд хэмжихийг санал болгосон. Нийгмийн тусгаарлагдалтын бусад аргуудаас ялгаатай нь нийгмийн харилцааг бэхжүүлэх зорилгоор нийгмийн тусгаарлагдалтыг судлах аргыг өргөтгөсөн байдаг. Левитас (2006, 136) Британийн ядуурал ба нийгмийн тусгаарлагдалтыг судлах (БЯНТС) аргыг хүмүүсийн амьдралын чанар, үүн дэх нийгмийн харилцааны байр суурь, нийгмийн харилцаанд ядуурал ба цалинтай ажлын нөлөөлөл ямар байгаад илүү анхаарал хандуулдаг хэмээн тайлбарласан. Иймээс энэ арга нь нийгмээс тусгаарлагдах 1) ядуурал (*зохих орлого, нөөцөөс тусгаарлагдах*); 2) хөдөлмөрийн зах зээлээс тусгаарлагдах (*цалинтай ажилд хамрагдахгүй байх*); 3) үйлчилгээнээс тусгаарлагдах (*төрийн болон хувийн үйлчилгээнээс тусгаарлагдах*); 4) нийгмийн харилцаанаас тусгаарлагдах (*нийгэм, иргэний, улс төрийн оролцоо, нийгмийн дэмжлэг, нийгмийн хамаарал холбоо барих, цагдан хорих*) гэсэн дөрвөн хэмжээсийг ялгаж үзсэн.

Нийгмийн нийтлэг үйл ажиллагаатай холбоотой өгөгдөлд дүн шинжилгээ хийснээр цөөн тооны үл хамаарах зүйлээс илүү өндөр хувь нь өөрсдөө оролцох боломжгүй гэсэн шалтгаанаар оролцохгүй гэж мэдэгдсэн болохыг батлав. Гэсэн хэдий ч зарим нийгмийн бүлгүүдэд оролцоогүй нь залуу насанд хүрэгчид (16-34 насныхан), 65-аас дээш насныхан, эмэгтэйчүүд, хүүхэдтэй өрх толгойлсон хүмүүс, цалингүй ажил эрхэлдэггүй хүмүүс, ядууралд нэрвэгдсэн хүмүүст илүү ихээр нөлөөлж байв. Нийгмийн оролцоог бууруулах эрсдлийн тодорхой хүчин зүйл болж ядуурлыг тогтоосон бөгөөд өрхийн дундаж орлогын 60%-иас доош орлоготой хүмүүс долоо ба түүнээс дээш ажилд оролцохгүй байх магадлал өндөр орлоготой хүмүүсээс гурав дахин их байна.

Нийгмийн сүлжээ, нийгмийн тусгаарлагдмал байдалтай холбоотойгоор Британийн ядуурал ба нийгмийн тусгаарлагдалтыг судлах судалгаагаар дараах үр дүнгүүд гарч байжээ. Хүн амын 18% нь дангаараа амьдардаг бөгөөд энэ нь ялангуяа сүүлийн жилүүдэд эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүдэд нөлөөлдөг болохыг тогтоожээ. Найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ харьцах түвшний хувьд дараах үр дүнгүүд гарчээ. Үүнд: Түүврийн 41% нь өдөр бүр уулзалддаг эсвэл ярьдаг өрхөөс гадна амьдардаг хамаатан садан байхгүй; Хүн амын 9% нь дор хаяж долоо хоног бүр харсан эсвэл ярьдаг өрхийн гадна гэр бүлийн гишүүн байхгүй байна; 1% нь өрхөөс гадуур үр дүнтэй холбоо харилцаатай байдаггүй (өөрөөр хэлбэл жилд дор хаяж нэг удаа уулзаж, ярьдаг гэр бүлийн гишүүд байхгүй); 7% нь дор хаяж долоо хоног бүр уулзах эсвэл ярих найзгүй; 3% нь дор хаяж жилд нэг удаа хардаг, ярьдаг найзгүй байдаг; судалгаанд хамрагдсан хүмүүсийн дөнгөж 1% гаруй нь (бүх эрчүүд) дор хаяж долоо хоног тутам холбоо барьдаг гэр бүлийн гишүүн, найз нөхөд байдаггүй. (Левитас, 2006, 142 дахь тал)

Ядуу амьдарч байгаа хүмүүс болон нийгмийн сүлжээ илүү сайтай ядуу бус хүмүүсийг харьцуулахад хэдийгээр харилцаа холбоо нь ядуусын хувьд гэр бүл рүү нь, ядуу биш хүмүүсийн хувьд найз нөхөд рүү нь чиглэсэн байсан ч хоёр талын хооронд ялгаа бага байсныг тогтоожээ. (Левитас, 2006, р 143). Гэр бүл, найз нөхөдтэйгээ олон удаа уулзахад юу нөлөөлдөг вэ гэж асуухад хамгийн их дурдсан хүчин зүйл бол цаг завгүй байх байсан; 27% нь цалинтай ажил хийгээд цаг завгүй байна гэж хариулсан бол 9% нь хүүхэд асрах үүрэг хариуцлагаас болоод цаг завгүй байна гэж, 4% нь ажил үүргийн улмаас цаг завгүй байна гэжээ. (Левитас 2006, р 148)

Британийн ядуурал ба нийгмийн тусгаарлагдалтыг судлах судалгаагаар нийгмийн харилцааны түвшин нь судалгаанд хамрагдагсдын янз бүрийн нөхцөл байдал дахь дэмжлэгийн түвшинг харгалзан үзсэн байна. Үүнд: ханиад томуу, ямар нэг өвчнөөр өвдөөд хэвтсэн тохиолдолд гэр бүлийн хүрээнд тусламж авах, хүнд хэцүү өрх юм уу цэцэрлэгжүүлэлт хийх ажилд туслалцаа авах; хол байгаа үед гэр, эд хөрөнгөө харуулах хэн нэгэнтэй байх; хүүхэд эсвэл насанд хүрсэн хүнийг асрамжлах хүн хэрэгтэй; амьдралын чухал өөрчлөлтийн талаар зөвлөгөө хэрэгтэй болох; эхнэр/нөхөртэйгээ холбоотой асуудлаас болж сэтгэлээр унах; сэтгэлээр унах, хэн нэгэнтэй ярихыг хүсэх.

Дүн шинжилгээ нь ядуу хүмүүс практик болон сэтгэл хөдлөлийн үзүүлэлтүүдээр бусад хүмүүсээс дэмжлэг сул байгааг харуулж байна. Ажил хийх насны ажилгүй өрх, тэтгэврийн насны өрхийн тэтгэмжийн түвшин доогуур байсан бол ганцаараа амьдардаг хүмүүс хамгийн бага дэмжлэг үзүүлэв. Нөгөө талаар, ганцаардсан эцэг эхчүүд харьцангуй сайн дэмжлэгтэй байсан. Үнэхээр тэд сэтгэл хөдлөлийн хамгийн өндөр түвшний дэмжлэг үзүүлсэн гэж мэдээлсэн. Төлбөртэй ажлын үр дүн нийгмийн дэмжлэгт үзүүлэх нөлөөллийг үнэлэхдээ Левитас ажил хийдэггүй, гэхдээ ядуу өрхөд амьдардаг хүмүүс хамгийн сайн практик дэмжлэг, сэтгэл хөдлөлийн хамгийн сайн туслалцаа үзүүлдэг болохыг тогтоожээ. Гэсэн хэдий ч, энэ бүлгийн бага хэмжээ нь цалинтай ажилд оролцоогүй байх, ядууралд өртөөгүй тохиолдолд нийгмийн гадуурхалд хүргэх эсэхийг тайлбарлахдаа болгоомжтой байх хэрэгтэй гэсэн санааг илэрхийлсэн.

Нийгмийн тусгаарлагдалтын “эрсдлийн” хүчин зүйлийг судлахын тулд Барнс нар тусгаарлагдалтын хэмжигдэхүүн тус бүр дээр логистик регрессийн тусдаа шинжилгээ (*ижил эрсдэлт хүчин зүйлсийг ашиглан*) хийсэн. Дараах эрсдэлт хүчин зүйлүүд тусгаарлагдалтын нэг хэмжигдэхүүнтэй нягт холбоотой байв.

- 1) нийгмийн харилцаа: *ганцаараа амьдрах, хамтрагчгүй, хүүхэд, ах эгч, ажилгүй байх;*
- 2) соёлын үйл ажиллагаа: *эрүүл мэнд муу эсвэл сэтгэлээр унах;*
- 3) иргэний үйл ажиллагаа: *хувийн тээврийн хэрэгсэлгүй, сэтгэлээр унасан эсвэл ажилгүй байх;*
- 4) үндсэн үйлчилгээ: *хөгширсөн, эрүүл мэнд муу, тээврийн хэрэгсэлд нэвтрэх боломжгүй (хувийн болон нийтийн), ганцаараа амьдрах эсвэл сэтгэлээр унах;*

- 5) хорооллын гаднах байдал: эрүүл мэнд муутай, эсвэл хомсдолтой газарт амьдрах;
- 6) санхүүгийн бүтээгдэхүүн: *бага орлоготой, цагаан биш эсвэл байр түрээслэх;*
- 7) материаллаг эд материал: *ганцаараа амьдрах, хөгшин байх, машин, вагон орох, байрлах байргүй байх* (Барнс нар, 2006, х 37).

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудад нийгмийн тусгаарлагдалтын үзэл баримтлалыг тодорхойлох оролдлогын тэргүүн эгнээнд явж ирсэн. Улс орны хэмжээнд явуулсан цуврал судалгаагаар хэрэгжиж буй иргэний болон нийгмийн эрхийн ач холбогдлыг тодруулж, тухайлбал, эрүүл мэндийн үйлчилгээ, суурь боловсрол, материаллаг сайн сайхан байдал зэрэг нь хангалттай ач холбогдолтой болохыг харуулсан (John Hills 2002).

Хамгийн сүүлд гэхэд Дэлхийн банкны бодлогын судалгааны тайлан илтгэлд дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд дэлхий даяар нийгмээс тусгаарлагдах, эс хамрагдах эрсдэлтэй хүн амын талаарх тооцоо одоогоор алга байгааг анзаарч, нийгмээс тусгаарлагдах эрсдэлтэй хүн амын эзлэх хувь, тоог тооцоолсон байна. Энэ нь Сенийн чадавхын арга барилд тулгуурлан, тусгаарлагдалтын харьцангуй, олон хэмжээст, динамик шинж чанарыг онцолсон нийгмээс тусгаарлах үзэл баримтлалын тогтолцоог боловсруулжээ. Энэхүү баримт бичиг нь мөн чанар, нөхцөл байдал, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан тусгаарлагдахад онцгой өртөмтгий хүн амын бүлгүүдийн макро тооллогын хэмжүүрийг боловсруулж, улс орон даяар эмзэг бүлгийн хүн амын хамгийн найдвартай эх сурвалжийг судлан, нийгмээс тусгаарлагдах эрсдэлтэй хүмүүсийг давхар тоолохгүй байх протокол боловсруулжээ. Нийтдээ 2.33 тэрбумаас 2.43 тэрбум хүртэлх хүн буюу дэлхийн хүн амын 32 орчим хувь нь нийгмээс тусгаарлагдах эрсдэлтэй гэсэн тооцоо бий. Өмнөд Ази, Зүүн Ази, Номхон далайн бүс нутагт 1.3 тэрбум ийм хүн амьдардаг бөгөөд тэдний 840 сая нь Энэтхэг, Хятадад л амьдардаг. Үүний зэрэгцээ Сахарын цөлөөс өмнөх Африкийн хүн амын 52 хувь нь тусгаарлагдалтанд өртөмтгий байгаа нь бусад бүс нутгаас хамгийн их нь болж байна. Уг баримт бичигт эдгээр тооцооллын хэд хэдэн үр дагаврыг авч үзэж, ядууст чиглэсэн бодлого нь нийгмээс тусгаарлагдах асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй байж болохыг онцолсон байна. Махлер нарын судлаачид (2021) COVID-19 нэн ядуу хүмүүсийн тоог 2021 онд 711 саяд хүргэсэн (2019 онд 655 сая байсан) судалгаа тайлагнах үеийн байдлаар 2022 онд энэ тоог дор хаяж 786 саяд хүргэнэ гэж тооцоолжээ (Дэлхийн банк 2022b). Цар тахал дэлхийн хэмжээнд улс доторх болон улс хоорондын орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлсэн (Дэлхийн банк 2022a). Энэ хоёр өсөлт нь богино хугацаанд буюу Жини индекст 0.5 хувиас бага байсан ч орлогын тэгш бус байдлын өсөлтийн үр дагавар урт хугацаанд илүү их байж болох юм (Jose Cuesta, Borja Lopez-Naval, Miguel Nino-Zarazua 2022) хэмээн тухайн бодлогын судалгааны өгүүлэлд дүгнэжээ.

Дээр өгүүлснийг нэгтгэн дүгнэвэл нийгмээс тусгаарлагдах явдлыг хэмжихдээ улс орон тус бүрт харилцан адилгүй үзүүлэлтийг ашигласан боловч ялгаварлан гадуурхалт болон хүний эрхийн зөрчлийг илрүүлэхэд чиглэсэн, ахуй

амьдралын эдийн засгийн нөхцөл, эрүүл мэнд боловсролын үйлчилгээнд хамрагдах байдал, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, нийгмийн холбоо сүлжээ, хувь хүний хөгжил, нөөц боломж зэрэг багц индикаторыг түгээмэл хэрэглэсэн байна. Мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргаар цуглуулж, тоон мэдээлэлд хэмжилт хийхдээ олон хэмжээст статистик арга тухайлбал индексийн аргын янз бүрийн хувилбарыг түлхүү хэрэглэх хандлага гарчээ.

Манай орны хувьд нийгмийн интеграци, нийгмээс тусгаарлагдах үзэгдлийн тухайлсан судалгаа ховор бөгөөд тусгаарлагдсан бүлгүүдийг ялангуяа зах зээлийн нийгэмд шилжсэн үеэс эхлэн нийгмийн бүтэц, давхраажлын судалгааны хүрээнд хавсарга байдлаар судалж ирсэн. Арга зүйн хувьд гэхэд тусгаарлагдах үйл явцыг гэхээс илүүтэй тусгаарлагдсан бүлгүүдийн нийгмийн дүр зураг, шинж байдлыг тодруулахад анхаарч байв.

Доктор Х.Гүндсамбуу давхраажлын доод хэсэгт ажилгүйчүүд, ядуус, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, архичид, траншейныхан, гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг хамруулсан¹⁴ бол доктор Ц.Уртнасан зах зээлийн нийгэмд шилжих үетэй зэрэгцэн Монголд амьдралын хэв магийн хувьд ялгаатай “малчид, ажилчид, хувийн хэвшилд, оюуны хөдөлмөр эрхлэгсэд, бизнес эрхлэгчид, нийгмийн доод бүлэг, гуйлгачин хог ухагчид” гэсэн бүлэг бүрэлдсэн гээд давхраажлын хувьд “дээд, дунд, доод анги” гэж гурван түвшнийг¹⁵, доктор О.Мөнхбат 1. Дээд давхраа (*Төр засгийн өндөр албан тушаалтнууд, улс төр эдийн засгийн элитүүд*), 2. Дундаас дээгүүр давхраа (*Төр засгийн дунд тушаалын албан тушаалтан, хэрэгжүүлэгч, агентлагийн удирдлага, банк санхүү, худалдаа, аж үйлдвэрийн болон томоохон пүүс компаний захирал, соёл урлаг, спортын элит бүлэг*), 3. Дунд давхраа (*Жижиг дунд үйлдвэрийн захирал, менежерүүд, их дээд сургуулийн багш нар, эрдэм шинжилгээний ажилтан, эмч, цагдаа, шүүх хяналтын албан хаагчид, төр засгийн байгууллагын доод тушаалтангууд, чинээлэг малчид, өндөр мэргэжлийн ажилчид*), 4. Дундаас доогуур давхраа (*Дунд сургуулийн багш нар, эмнэлгийн дунд мэргэжлийнхэн, цэрэг цагдаагийн доод тушаалынхан, жижиг үйлдвэрлэгчид, худалдаачид, малчид, мэргэжилтэй ажилчид*), 5. Доод давхраа (*Мэргэжилгүй ажилчид, цөөн малтай малчид, ажилгүйчүүд, ядуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох бөгөөд энэ давхрааны эмзэг хэсгийг орон гэргүй тэнэмэл хүмүүс, архичид, гуйлгачид бүрдүүлнэ*) гэж¹⁶ нийгмийн бүлгийн онцлогийг харгалзан бүлэг, давхраанд хуваасан байдаг.

Нийгмийн тусгаарлагдах үйл явцын талаар Монголд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээл болон хэрэгжүүлсэн судалгааны ажлын үр дүнгээс харахад нийгмээс тусгаарлагдах эрсдэлт бүлгүүд, эмзэг бүлгийнхний судалгаа хийгдэж ирсэн ч нийгмийн бүтцийг толорхойлох хүрээнд авч үзсэн гэх мэтээр өөр үзэгдэл, үйл явцыг судлах явцад авч үзсэн тул нийгмийн тусгаарлагдалтын өнцөг хөндөгдөх төдий байна. Мөн тодорхой нэг бүлгийн тусгаарлагдах үйл явцыг судласнаас нийгмийн тусгаарлагдах үйл явцыг өргөн хүрээнд, нийгмийг бүхэлд

¹⁴ Х.Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага. УБ., 2002. 464-513 дахь тал.

¹⁵ Ц.Уртнасан. Монгол нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ. УБ., 2017. 156-169 дэх тал.

¹⁶ О.Мөнхбат. Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ., 2000. 123-124 дэх тал.

нь хамруулан судалсан судалгаа алга байна. Гэхдээ ядуурлын түвшин тодорхойлох судалгаанууд харин давтамжтайгаар хийгдэж ирсэн байна. Ядуурлын болон эмзэг, зорилтот бүлгийн талаарх судалгаанууд л энэ талын судалгааны орон зайг тодорхой хэмжээнд нөхөж ирсэн харагдана.

Төслийн хүрээнд төслийн удирдагч, доктор Ц.Пүрэв нийгмийн давхраажилтыг нөөц боломжийн аргаар судлах арга зүйд тулгуурлан 2015-2016 онд хийсэн “Нийгмийн оролцоо, гадуурхал” сэдэвт судалгааны мэдээлэлд хоёрдогч шинжилгээ хийн эерэг сөрөг нийтдээ 24 субъектив үзүүлэлтийг судалгааны өгөгдлөөс сонгож, индексийн арга хэрэглэн боловсруулалт хийсэн. Боловсруулалтын үр дүнд үндэслэн "Амьдралын эдийн засгийн нөхцөл, ажил дээрх нөхцөл байдал, хүмүүн капиталгаа хадгалах, өсгөх боломж, хэрэглээ ба чөлөөт цагийн онцлог гэсэн дөрвөн багц үзүүлэлтийг ашиглан түүвэр судалгааны өгөгдөлд хоёрдогч шинжилгээ хийж, эерэг болон сөрөг үнэлгээгээр нэгдсэн индекс бодож үзэхэд, судалгаанд хамрагдагсдын олонхийн (54%) амьдралын боломжийн үнэлгээ сөрөг, түүний бараг гуравны нэг нь -5 аас -11 гэсэн утгатай гарсан байв. Энэ баримт өнөөгийн Монголчуудын дунд амьдралын боломж, нөөцөөс эрсдэлт нөхцөл байдал нь илүү давамгайлж буйг харуулна. Амьдралын олон талын эрсдэлт нөхцөлд байгаа иргэдийг гүнзгийрүүлэн судласнаар ялгаварлан гадуурхагдсан, эрх нь зөрчигдсэн, нийгмийн институтын эв нэгдлийн механизмд хамрагдах боломжгүй болоход хүрсэн, гачигдал доройтолд өртөгсөд, бүхэлдээ нийгмийн тусгаарлагдах үйл явцыг танин мэдэх боломжтой болох юм"¹⁷ гэсэн дүгнэлтийг хийсэн нь арга зүйн хувьд тусгаарлагдах үйл явцын талаарх ерөнхий онолыг баримжаалсан, практик судалгаагаар тусгаарлагдаж буй нийгмийн бүлгүүдийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, нэгтгэн дүгнэх аргачлалыг зохих хэмжээнд гарган тавьснаараа ихээхэн ач холбогдолтой ажил болсон.

1.3. Судалгааны арга зүй

Английн социологич Вэллс, Мейдэм нар нийгмээс тусгаарлагдагсдыг илэрч буй хэлбэр, нийгмийн, бүлэг, нийтлэг, институтээс хэр зэрэг хөндийрч байгаагаар нь ангилж, дараах таван хэв маягт хуваан үзсэн¹⁸. Үүнд:

1) *Альтернатив тусгаарлагдагч*: Нийгмийн амьдралын үндсэн урсгалын гаднах альтернатив амьдралын хэв маягийг хамааруулдаг. Ерөнхийдөө сайн дурын шинжтэй юм. Ихэвчлэн үндэс угсаа, шашин шүтлэг, бизнес эрхлэх боломж, гадны хүмүүстэй нийгмийн харилцаанд ордоггүй зэргээс шалтгаалаад хөдөлмөр эрхлэхэд оролцдоггүй хүмүүс хамаарагдана. Жишээлбэл ХХ зууны эхэн үед Лондонгийн зүүн хэсэгт Еврейчүүдийг байрлуулдаг байсан нь үүний тод жишээ юм. (Phillips, 2002).

2) *Тусгаарлагдахын өмнөх шатанд байгаа*: Хэдийгээр саад бэрхшээлтэй тулгардагч нийгэм, улс төр, соёлын амьдралд оролцох боломжтой хэвээр байдаг. Энэхүү саад бэрхшээл нь жинхэнэ нийгмийн тусгаарлагдахын эхлэл болдог.

¹⁷ Ц.Пүрэв. Монголын нийгмийн давхраажилтыг нөөц боломжийн хандлагаар судлах асуудал. Философи, эрхийн судлал. Эрдэм шинжилгээний цуврал-XXXIV. УБ., 2019.

¹⁸ David Phillips, Sociological Studies, University of Sheffield, UK. Social inclusion, social exclusion, and social cohesion: tensions in a post-industrial world. 2008. 10.8

Жишээ нь, Их Британий католикууд одоо ч зарим (*Английн хаант улсын өв залгамжлагчтай гэрлэх боломжгүй г.м*) хязгаарлалттай байна.

3) *Дунд түвшний тусгаарлагдагч*: Энд хамаарч буй хүмүүс зарим онцгой институтээс тусгаарлагдах боловч ерөнхийдөө үндсэн институтийн бүтцэд хамаардаг. Жендерийн улмаас гадуурхагдах нь үүний жишээ юм.

4) *Ахисан түвшний тусгаарлагдагч*: Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс хамаараад оролцооны институтчилагдсан хэлбэрүүд болон олон гол чиглэлээс гадуур байдаг тул тэднийг нийгмийн амьдралд хамруулахад ихээхэн бэрхшээлтэй тулгардаг.

5) *Гүнзгий тусгаарлагдагч*. Энэ бүлэгт хамаарах хүмүүс ихэвчлэн өөрийнхөө ертөнцөд л амьдарна. Тэд ихэвчлэн нийгмийн албан ба албан бус институтүүд болон оролцооны хэлбэрүүдээс бүрэн тусгаарлагдсан байдаг. Түгээмэл биш боловч ийм тохиолдол бас бий гэсэн байна.

Нийгмийн тусгаарлагдалт *өргөн тархсан, гүнзгий, төвлөрсөн* гэсэн гурван хэлбэртэй¹⁹ байх бөгөөд тэдгээрийг хольж хутгахгүй байх нь чухал хэмээн Миллибанд үзжээ. *Өргөн тархсан тусгаарлагдалт* нь ганц нэг үзүүлэлтээр тодорхойлогдох бол, *гүнзгий* нь олон шинжээр тусгаарлагдсан байна. Тэгвэл *төвлөрсөн тусгаарлагдалт* ялангуяа газарзүйн байрлалаар тодорхойлогдож болох бөгөөд орон нутаг, бүс нутгийг хамарсан тулгамдсан асуудал болсон байх жишээтэй. *Гүнзгий тусгаарлагдалт* гэдэг нь амьдралын чанар, аж байдал, ирээдүйн амьдралын өсөлт өөрчлөлтөд ноцтой сөрөг дагавар авчирдаг, хор хохирлын хэмжээ, хамрах хүрээгээр илүү өргөн байдгаараа бусад хэлбэрээс ялгагдана. а) Суурь мэдлэг чадвараар тааруу, удаан хугацаагаар ажилгүй байсан хүмүүс; б) Ядуурсан, муу сууцанд амьдардаг, сэтгэцийн өвчтэй эх эцэг бүхий хүүхдүүд; в) Орон гэргүй хүмүүс, мансуурагчид, ур чадваргүй, хамаатан садангүй хүмүүс зэрэг олон талын гачигдалд өртөгсөд гүнзгий тусгаарлагдсан хүмүүст багтдаг аж.

Мөн гачигдал бүхий бүлгийн нийгмийн хамруулалт ба тусгаарлагдалтыг зарим бүтээлд дараах дөрвөн хэв шинжид хуваажээ²⁰. Ялгаварлан гадуурхагдах байдал болон тусгаарлагдах практик хэр зэрэг тохиолдож байгаагаас гачигдалт бүлгийн нийгмийн тусгаарлагдалтыг гурван түвшинд ангилсан байна. Ялгаварлан гадуурхалт улс төр-эрх зүй, нийгмийн болон эдийн засгийн салбарын аль нэгэнд байгаа бол эхний түвшинд багтаажээ. Энэ түвшинд харьяалагдагсад тусгаарлагдахаас хамрагдах тал нь давамгайлсан хүмүүс юм. Тэгвэл хоёр дахь түвшинд дурдсан гурван салбараас хоёрт нь ялгаварлан гадуурхалтыг мэдэрч, тэр нь нийгмийн практикт хэрэгжсэн иргэд орно. Гурав дахь түвшинд дээрх бүхий л салбар тус бүрийн хувьд гадуурхалд өртөж, гүнзгий тусгаарлагдаж түүнийгээ хүлээн зөвшөөрсөн хүмүүс багтана. Нийгмийн тусгаарлагдалтын хоёр, гурав дахь түвшинд өртөгсдөд тодорхой орон зай, цаг хугацааны нөхцөлд өөрсдөө юмуу

¹⁹ Miliband, D. (2006) *Social exclusion: The next steps forward*, London: ODPM. P. 3.

²⁰ Ефлова Мария Юрьевна. Социальная эксклюзия депривированных групп (наркозависимых и людей живущих с ВИЧ) в Российском обществе: стратегии институционализации и опыт интеграции. Диссертация на соискание ученой степени доктора социологических наук. Казанский федеральный университет. Саранск.-2015. С 79.

иргэний нийгмийн агентуудаас нийгмийн оролцооны тактик боловсруулан тэмцэх шаардлагатай.

Нийгмийн тусгаарлагдалтын нөхцөл байдлыг М.Вольф (Wolf M. Globalization and social exclusion) дараах байдлаар ангилсан байна²¹. Үүнд:

Оршихуйн арга хэрэгслээс тусгаарлагдах. 1960-аад онд тариачдын нийгмээс аж үйлдвэрийн нийгэмд шилжих үед ажиллах хүчний эрэлт нийлүүлэлтээс давна гэсэн таамаглалтай байсан хэдий ч эрэлт нь нийлүүлэлтийг хангаж чадахгүйгээс нийгмийн тусгаарлагдалтанд өртөгсөд бий болсон юм. Ийм төрлийн тусгаарлагдмал байдал 1980-аад онд Африк болон Латин Америкийн орнуудад болсон томоохон бүтцийн өөрчлөлтийн үеэр илүү хүчтэй мэдрэгдэж, энэхүү үйл явц нь юуны өмнө дээд боловсролтой хүмүүс түүнчлэн төрөөс санхүүждэг салбарт ажиллагсдыг илүүтэй хамрах болсон байна. Мөнгөний ханш уналт тэдний орлогыг цөлмөж, дадал болсон амьдралын хэвшлээ орхиход хүргэсэн юм.

Нийгмийн үйлчилгээ, сайн сайхан байдал болон нийгмийн аюулгүй байдлын сүлжээнээс тусгаарлагдах. 1980-аад оныг хүртэл төрөөс хэрэгжүүлдэг үйлчилгээ болон нийгмийн эрхийн хувьд түгээмэл хүлээлт ядуу төдийгүй чинээлэг орнуудын хувьд өссөн юм. Үүнд бүх нийтийн боловсрол, эрүүл мэндийн эрх, ядуурлын эсрэг аюулгүй байдлын сүлжээ, сууцтай байх, цэвэр усны хангамж, хог хаягдлыг зөөх, өнөөгийн төрийн олон улсад зөвшөөрөгдсөн үүргийн дагуу иргэдийн бусад хэрэгцээг хангах шаардлагатай байдаг. Хүн амын нэг бүлгийн хувьд хэд хэдэн нийгмийн үйлчилгээг хорогдуулж, нөгөө бүлэгт нь хэвээр үлдээснээр нийгмийн хамгаалалт багатай бүлгийн тоо нэмэгдэх (өрх толгойлсон эмэгтэйчүүд, орон гэргүй хүмүүс гэх мэт) явдал гардаг.

Хэрэглээний соёлоос тусгаарлагдах. Хүн амын нэгээхэн хэсгийн хувьд тусгаарлагдахыг ядуурал, гачигдал, хоол, орох оронтой байх хэрэгцээ хангагдах боломжгүй болсонтой холбон үздэг. Гэтэл ихэнх хүмүүсийн хувьд хэрэглээнээс тусгаарлагдах нь хэрэглээний элдэв төрлийн, ялгаатай хэм хэмжээний талаарх мэдээлэл олж авахтай холбогдсон нарийн төвөгтэй асуудал болдог байна. Хэрэглэгчдийн хүсэл сонирхол хэрэгжээгүйгээс нийгмийн үйлчилгээний хүрээ болон аюулгүй байдлын сүлжээ түүнчлэн улс төрийн сонгуулиас (сонголтоос) тусгаарлагдан хөндийрөх байдал үүсдэг ажээ. Хэрэглээний аль салбар соёлын талаасаа зайлшгүй хэрэгтэй болохоос хамааран ямарч орлоготой хүмүүс нийгмээс тусгаарлагдах үйл явцад өртөж болох юм.

Улс төрийн сонгуулиас тусгаарлагдах. Ихэнх оронд хүмүүс чөлөөт сонгуульд оролцож, мэдээллийг янз бүрийн эх үүсвэрээс олох боломжтой болсон хэдий ч улс төрийн намуудын олигархжсан, хүнд сурталт дүр төрх, үйл ажиллагааны уршгаар улс төрийн сонгуулиас тусгаарлагдах, эс оролцох явдал арилахгүй байна. Улс төрийн оролцоо нь иргэдэд сайхан амьдрах боломжийг олгоно гэж амлалт өгдөг харьцангуй хүчтэй засаг төрийн шийдвэр бодлого хүртэл дэлхийн даяаршсан эдийн засгийн дэглэм, төрийн эсрэг ноёрхол, популист үзэл

²¹Бородкин Ф.М. Социальные эксклюзии. Социологический журнал. 2003. №3/4. С.9. Өгүүллээс товчлон орууллаа.

суртлын нөлөөгөөр ач холбогдлоо алдаж улс төрийн зүтгэлтнүүд сонгогчдын өмнө өгсөн амлалтаасаа ухрах тохиолдол элбэг болжээ. Улс төрийн сонгуулиас тусгаарлагдах үйл явц нь улс төрийн идэвхгүй болохоос эхлэн хүч хэрэглэсэн хариу үйлдэл болон хувирах хүртэл сөрөг үр дагаврыг авчрах болов.

Олон нийтийн байгууллага болон эвлэлдэн нэгдэхээс тусгаарлагдах. Тусгаарлалтын эсрэг тэмцэхдээ хүмүүсийн ашигладаг байгууллага болон эв нэгдлийн багавтар хэлбэршсэн хэлбэрүүд дараах хүчин зүйлд тулгуурладаг. Үүнд:

- 1) Оршин байхуйн арга хэрэгслийн үүсвэрт хяналт тавихыг эрмэлзэх (ҮЭ, тариачдын нэгдэл, худалдаачдын холбоо г.м)
- 2) Хэрэглэгчдийн хүсэл эрмэлзлэл болон зээлийн хэрэгцээг хангахыг хичээх (хоршоолол болон зээлийн холбоод)
- 3) Төрийн үйлчилгээ болон нутгийн захиргааны юмуу сайн дурын үйлчилгээний байгууллагад хандах (эх эцгийн болон тэтгэвэр авагчдын холбоо г.м),
- 4) Орон нутгийн зөвлөл, хөршийн холбоонд хамаарагдах
- 5) Шашны болон угсаатны ижилслийг хайхад хүрдэг байна.

Олон нийтийн байгууллага хамгаалалтгүй болон тогтворгүй байх аваас нийгмийн шинэ эхлэл, өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, хүн амын зарим хэсэг социал тусгайлалд өртөх нөхцөлийг бүрдүүлдэг.

Болж өнгөрч буй зүйлийг ойлгох боломжоос тусгаарлагдах. Мэдээллийн нийгэм"-ийн үүсэл нь өвөрмөц хэлбэрийн тусгаарлагдалтыг буй болгож байна. Хүмүүсийн нэг хэсэгт нь амьдралын хэв маяг, нас хүйсийн ижилслээ илүү өргөн хүрээнд сонгох боломж олгож байгаа ч заримынх нь амь зуух арга ухааныг төвөгтэй болгож, эрсдэлт байдлыг нэмэгдүүлэхэд хүргэдэг аж. Хүн амын үлэмжхэн хувь нь спортын үйл явдал, алдарт хүмүүсийн хувийн амьдралын тухай зэрэг мэдээллээр хангагдаж сэтгэл ханамжтай байдаг ч үнэн хэрэгтээ өнөөгийн сэтгэл түгшээсэн үзэгдэл, үйл явдлын талаар огт сонсоогүй байх жишээтэй. Тухайлбал нийгмийн шинэ харилцаа төлөвшиж буй өнөө үед хүмүүс компьютер болон мэдээллийн технологи ашиглах боломжгүй байх юм бол, энэ төрлийн тусгаарлагдалтад өртөх болно.

Социологич М.Астоянц хот хөдөөгийн нийгэм соёлын орчинтой холбон нийгмийн тусгаарлагдалтыг кейс судалгааны аргаар судлаад хотын болон хөдөөгийн гэсэн хоёр төрлийн тусгаарлагдалт байна гэж үзжээ. Хотын хүмүүсийн амьдралд бодгаль шинж давамгайлж, салангид хөндий, вакумжсан хязгаарлагдмал орчинд амьдрах явдал элбэг байдгаас ганцаардах, нийгмийн холбоо сүлжээнээс хөндийрөх явдал гардаг бол хөдөөд тухайн бүс нутгийн алслагдмал байдал хийгээд нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил сул байдагтай уялдан нийгмээс тусгаарлагдмал байдал буй болдог гэсэн байна²².

Ийнхүү нийгмийн тусгаарлагдалт нь олон хэлбэр дүрстэй, янз бүрийн түвшинд илрэх үйл явц бөгөөд нийгмийн орон зай хийгээд цаг хугацаанаас

²²Астоянц М.С. Социальное сиротство: условия, механизмы и динамика эксклюзии (социокультурная интерпретация): дис. Док. Социолог. Наук. Ростов- на- Дону, 2007. С. 90.

хамаарч хувь хүн нэг түвшнээс нөгөөд шилжих бололцоотой юм. Гэхдээ энэ шилжилт санамсаргүй байдлаар явагдахгүй нийгмийн амьдралд хэр зэрэг идэвхтэй оролцохоос, тухайн оролцогчийн хөгжил, ур чадвар, нөөц боломж, амьдралын стратегийн сонголтоос ялангуяа улс орны нийгмийн бодлого, бүтэц, нийгмийн институтийн хөгжлөөс ихээхэн шалтгаалдаг ажээ.

Цаашид Монгол дахь нийгмийн тусгаарлагдмал байдалд өртөх эрсдэлт бүлгийг тодорхойлох шаардлага тулгарч байгаа юм. Манай улсын нийгмийн халамжийн хууль тогтоомжид зорилтот бүлэг, эмзэг бүлэг, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, өрх толгойлсон эх (эцэг), амьжиргааны түвшин нь ядуурлын шугамаас доогуур өрх, байнгын асаргаа шаардлагатай иргэн гэх зэрэг нэр томьёо элбэг тохиолддог. Тухайлбал олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагддаг байна. Үүнд: 1) ахмад настан, 2) хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 3) хүнд нөхцөлд байгаа хүүхэд, 4) хүчирхийлэлд өртсөн иргэн, 5) хорих ангиас суллагдсан иргэн, 6) согтуурах мансуурах донтой иргэн, 7) эдгэшгүй хүнд өвчтэй хүн, 8) гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх иргэн, 9) шилжин суурьшсан нийгмийн халамж дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн, 10) өрх толгойлсон эх/эцэг зэрэг болно²³. Ганцаарчилсан ярилцлага, фокус бүлэг зэрэг чанарын судалгаанд хамруулах иргэдийг сонгохдоо эдгээр заалтыг баримжаа болгон ашигласан болно. Түүнээс гадна төвөөс алслагдсан, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ хөгжөөгүй хөдөөгийн оршин суугчид, зарим угсаатны бүлэг ч үүнд хамрагдах боломжтой.

Нийгмээс тусгаарлагдах үйл явц нь хувьсан өөрчлөгдөж байдаг динамик үйл явц болохын дээр хотжилт, даяаршилтын үр дагавар болж, хөгжингүй орнуудад энэхүү үзэл баримтлал өргөн дэлгэрсэн тул тэдгээр оронд хэрэглэж буй судалгааны арга зүйг өвөрмөц аж төрөл, соёл иргэншил бүхий бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч малчдын хувьд шууд хэрэглэхэд төвөгтэйн дээр зөвхөн нэг төслийн хүрээнд хот хөдөөг бүрэн хамруулан судлах хүн хүч, цаг хугацаа болон төсөв зардал зэрэг бусад нөөц хүрэлцэхгүй учраас эхний ээлжинд хот, аймгийн төв, сум суурингийн иргэдийн тусгаарлагдах үйл явцыг судлах нь зүйтэй гэж төслийн багийнхан үзсэн болно.

Нөөц боломжийн хандлага, амьдралын нөөцийн ерөнхий индекс байгуулах арга зүй

М.Веберийн амьдралын боломжийн үзэл баримтлалыг нийгмийн давхраажлын судалгаанд хэрэглэхэд онол арга зүйн хийгээд аргачлалын шинжтэй олон бэрхшээл тулгарч буйг зарим судлаачид дурдаад, Орос орны хүн ардын өнөөгийн амьдралын онцлогийг харгалзан хувь хүний боломжийг нийгмийн ямар хүрээнд авч үзэх түүнчлэн тэдгээрийг хэрхэн яаж хэмжих талаар өрнөдийн судлаачдын арга зүйд тулгуурласан аргачлал боловсруулж, нийгмийн давхраажилтын судалгаанд хэрэглэхдээ *а) амьдралын эдийн засгийн нөхцөл, б) ажил дээрх нөхцөл байдал, в) хүмүүн капитал аа хадгалах, өсгөх боломж, г)*

²³Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн гарын авлага (албан хэрэгцээнд). Уб., 2013, 20 дахь тал.

хэрэглээ ба чөлөөт цагийн онцлог гэсэн дөрвөн багц үзүүлэлтийг ашигласан байна²⁴.

Нийгмийн тусгаарлагдалтын хэв маягчлал, эрсдэлт бүлгийн судалгааны аргачлал

Jehoel-Gijsbers (2004), Jehoel-Gijsbers and Vrooman (2007) нарын боловсруулсан нийгмийн тусгаарлагдалтын хэмжигдэхүүн нь материаллаг хомсдол, нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй, нийгмийн оролцоо хязгаарлагдмал, хэм хэмжээний интеграцийн дутагдалтай гэсэн онолын дөрвөн элементийг шууд хэмжих боломжийг олгодог [20]. Өөрөөр хэлбэл, эдийн засаг-бүтцийн тусгаарлагдалтын хэмжигдэхүүн нь материаллаг хомсдол, нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй байдал, нийгэм-соёлын тусгаарлагдалт нь нийгмийн оролцоо бага, хэм хэмжээний нэгдмэл байдлын дутагдалтай байх гэсэн дэд хэмжигдэхүүнд хуваагдаж байна.

Хүснэгт - 1. Нийгмийн тусгаарлагдалтын хэмжигдэхүүний үндсэн ойлголтын тайлбарлал

Хэмжигдэхүүн	Үндсэн ойлголтын тайлбарлал
Хэм хэмжээний интеграцийн дутагдал	Нийгмийн үндсэн үнэт зүйлтэй нийцэхгүй байх.
Нийгмийн оролцоо хязгаарлагдмал байх	Нийгмийн шууд тусгаарлалт /social isolation/, нийгмийн сүлжээнд оролцох хязгаарлагдмал байдал, нийгмийн оролцоо хангалтгүй байна
Материаллаг хомсдол	Угаалгын машин, өдөр тутмын халуун хоол гэх мэт зарим үндсэн бараа, үйлчилгээ байхгүйгээс болон өр төлбөрөөс болж хүмүүс хомсдолд орох
Нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй байх	Хүмүүсийн ердийн эдлэх эрхээ хэрэгжүүлэх чадваргүй байдал. Энэхүү хэмжигдэхүүнийг эрүүл мэндийн зохих үйлчилгээ, хангалттай боловсрол, амьдрах орчны хүртээмжтэй байдлаар тайлбарладаг.

Нийгмийн оролцоо хязгаарлагдмал байгаа нь хүмүүсийн нийгмийн сүлжээ нь хязгаарлагдмал, бусадтай цөөн холбоо тогтоодог, нийгмийн оролцоо бага байгааг илтгэнэ. Норматив интеграцийн дутагдал гэдэг нь тухайн субъектын нийгэмлэгийн төв хэм хэмжээ, үнэт зүйлийг дагаж мөрдөхгүй байхыг хэлнэ. Бусад хоёр хэмжигдэхүүн нь бүтцийн-эдийн засгийн хэмжигдэхүүн юм. Материаллаг хомсдол гэдэг нь санхүүгийн үндсэн шалтгаанаар үндсэн бараа, үйлчилгээний дутагдал, төлбөрийн өр, асуудалтай өр гэх мэт үндсэндээ хүмүүст бодитой тулгардаг алдагдлыг хэлнэ. Нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй байгаа нь хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээ, хангалттай боловсрол, зохистой амьдрах орчныг авч чадахгүй байна гэсэн үг юм. Хэрэв эдгээр хэд хэдэн хэмжигдэхүүн дээр нэгэн зэрэг хасагдаж байвал нийгмийн тусгаарлагдалт онолын хувьд үүсдэг.

Тусгаарлагдалтад нөлөөлөх дотоод болон гадаад хүчин зүйлийг судлах аргачлал

Нийгмийн тусгаарлагдалт бол нарийн төвөгтэй, олон талтай үзэгдэл гэдгийг судлаачид хүлээн зөвшөөрч буй учраас олон талт хэмжээсээр судлах

²⁴ Тихонова Н. Е. Стратификация по жизненным шансам массовых слоев современного российского общества. //Социологические исследования. 2018. № 6. С. 53-65. DOI: 10.7868/S0132162518060053

аргачлалууд дэвшүүлж байгаагийн нэг нь нийгмээс тусгаарлагдах хувь хүний хандлага, хувь хүний тусгаарлагдалтыг хэмжих олон хэмжээст нийгмийн тусгаарлагдалтын индексийг тооцох аргачлал юм.

Ихэнх судалгаанд нийгмийн тусгаарлагдалтыг бүлэгт суурилсан хандлагаар судалдаг ч энэ нь нийгмээс тусгаарлагдсан бүлгүүдийг илрүүлж гаргах, тодорхойлоход учир дутагдалтай байгааг Р.Левитас нарын бүтээлд тэмдэглэсэн байдаг. Үүнд: “Уламжлалт энэ хандлага нь нийгмээс тусгаарлагдсан бүлгүүдийг (үндэс угсаа, хүйс, байршил гэх мэтээр) тодорхойлоход чиглэсэн байдаг ч ихэвчлэн тэднийг хэн болох талаар урьдчилан тодорхойлчихсон байдаг. Мөн тодорхой нийгмийн цөөнхүүд эсвэл шинээр гарч ирж буй нийгмээс тусгаарлагдсан бүлгүүд гэх мэт судалгааны өгөгдөл эсвэл фокус бүлгийн ярилцлага хийх замаар олж авахад хэцүү байдаг бүлгүүд нь нийгмийн тусгаарлагдалтын судалгаанд жин багатай байх магадлалтай. Зарим бүлгүүд (орон гэргүй хүмүүс, институцийн популяци) ийм судалгаанаас ямагт хоцорсон байдаг”²⁵. Нийгмээс тусгаарлагдахыг бүлгийн хандлагаар авч үзэх нь судалгаанд ийм алдаа гарах эрсдэл дагуулж байгааг шийдвэрлэхийн тулд НҮБХХ-ийн судлаачид нийгмийн тусгаарлагдалтыг хэмжих энэ арга зүй, аргачлалыг дэвшүүлжээ. Энэ нь нийгмийн тусгаарлагдалтыг үйл явц, үр дүн гэж үздэг нийгмээс тусгаарлагдах хүрээгээр судлах асуудлыг авч үзэх явдал юм. Судалгааны ажлын тайлан баримт бичигтээ энэ талаар “Энэ бол тодорхой хувь хүмүүсийг нийгмийн ирмэг рүү түлхэж, нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн холбогдох үйл явцад бүрэн оролцохоос сэргийлдэг үйл явц юм. Үүний үр дүнд энэ нь тусгаарлагдсан, эс хамрагдсан хувь хүний статус, шинж чанарыг илэрхийлдэг. Нийгмээс тусгаарлагдсан байдал нь орлого хомс, төрийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, ажил эрхлэх, боловсрол олох боломж хязгаарлагдмал, нийгмийн болон олон нийтийн сүлжээ, үйл ажиллагаанд хүртээмж муутай гэх мэт олон хэмжээстэй байдаг. Нийгмийн тусгаарлагдалтын өөр өөр хэмжээсүүдийн хоорондын динамик харилцааг ойлгохын тулд тусгаарлагдалтыг “үйл явц” ба “эрхт байдал /статус/” гэж ялгах нь чухал юм. Ингэж салгах нь бүлэгт суурилсан уламжлалт хандлагаас татгалзаж, хувь хүний шинж чанар (эрсдэл), тусгаарлагдалтын хөдөлгөгч шалтгаан, орон нутгийн онцлог шинж чанаруудын хослолыг авч үзэх боломжийг олгодог бөгөөд энэ нь хэмжих боломжтой нийгмийн тусгаарлагдалтын үр дүнд хүргэдэг” хэмээн тайлбарлажээ.²⁶

Товчлон дүгнэвэл НҮБХХ-ийн Братислава бүс нутгийн төвийн А.Иванов, С.Милчер, М.Пелеа тэргүүтэй судлаачид 2011 онд нийгмийн тусгаарлагдалтыг эдийн засгийн амьдрал, нийгмийн үйлчилгээ болон иргэний амьдралаас тусгаарлагдах гэсэн өөр хоорондоо уялдаатай гурван нийгмийн хэмжээсийг хамарсан олон талт үзэгдэл буюу эдгээр гурван хэмжээсийн зарим нь эсвэл

²⁵ Ruth Levitas, Christina Pantazis, Eldin Fahmy, David Gordon, Eva Lloyd and Demi Patsios A.Ivanov, M.Peleah, S.Milcher. The multi-dimensional analysis of social exclusion. Department of Sociology and School for Social Policy Townsend Centre for the International Study of Poverty and Bristol Institute for Public Affairs University of Bristol. January 2007; The Chain of exclusion. United Nations Development Programme. Bratislava Regional Center Human Development Working Paper 2012/2E August 2012. p.6

²⁶ A.Ivanov, M.Peleah, S.Milcher. The Chain of exclusion. United Nations Development Programme. Bratislava Regional Center Human Development Working Paper 2012/2E August 2012. p8-9.

бүхэлдээ олон удаа, бие биенээ бататгаж бэхжүүлсэн хомсдолын үр дүн гэж үзээд бүлэгт суурилсан уламжлалт хандлагаасаа хөндийрч, хувь хүний шинж чанар (эрсдэл), тусгаарлагдалтанд хөтлөгч хүчин зүйл, орон нутгийн онцлог шинж чанаруудын хослолыг судалж эдгээр нь нийгмийн тусгаарлагдалтанд хүргэдэг гэж дүгнэсэн бөгөөд өөрсдийн санал болгож буй нийгмийн тусгаарлагдалтын индексээр хэмжжээ.

1.4. Судалгааны түүвэр, зохион байгуулалт

Түүвэрлэлтийн эхний шатанд Монгол улсын газар нутгийн бүсчлэл, хүн амын харьцаанд үндэслэн баруун бүсээс Ховд аймгийг, хангайн бүсээс Хөвсгөл аймгийг, төвийн бүсээс Өмнөговь аймгийг, зүүн бүсээс Дорнод аймгийг, Улаанбаатар хотоос Багануур, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргээс мэдээлэл авах. Хоёрдугаар шатанд сонгогдсон аймгаас сумдын газар зүйн байршил буюу аймгийн төвөөс алслагдсан байдлыг харгалзан тус бүр хоёр сумыг, дүүргээс 4 хүртэл хороог сонгох. Гуравдугаар шатанд тухайн аймаг суманд албан ёсны харъяалал бүхий сонгуулийн насны нийт хүн амаас 1200 хүнээс буюу Улаанбаатар хотоос 560 респондентоос (сонгосон дүүргүүдийн хүн амын харьцааг харгалзан түүврийн нарийвчлалыг тооцно), аймаг орон нутгаас нийтдээ 640 буюу аймгийн төв тус бүрээс 80, сум тус бүрээс 40, 40 хүнээс, аймаг тус бүрээс 160 хүнээс алхамт түүврийн аргаар мэдээлэл авахаар тооцсон. Цар тахлын нөхцөл байдлын улмаас 2020 (480), 2021 (418) нийт 898 респондентоос анкетийн аргыг ашиглаж мэдээлэл авсан. Буцаалтгүй түүврийн аргаар тооцоолсон, эх олонлог 2,157,011(2020), 95 итгэх магадлалтайгаар 900 хүнээс мэдээлэл авахад алдааны хязгаар ± 3.27 хувь байв. Мэдээлэл цуглуулахдаа тогтоосон квотын дагуу нас, хүйсийн харьцааг хангаж мэдээлэл цуглуулсан.

Судалгааны анхдагч мэдээллийг цуглуулахын өмнө түүврийн нарийвчлалыг 2018 оны статистик мэдээнд тулгуурлан нас, хүйсийн харьцааг дараах байдлаар тооцсон.

Хүснэгт - 2. Эх олонлог ба түүвэр олонлогийн бүтэц, харьцаа

Нас	Тооцсон түүвэр			Түүвэр олонлогийн харьцаа		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
18-24	16.2	99	96	17.8	65	95
25-34	28.0	168	168	22.8	89	116
35-44	22.1	130	136	20.0	76	104
45-54	16.9	96	107	18.6	76	91
55-64	10.6	56	71	14.4	51	78
65+	6.1	29	44	6.3	28	29
НИЙТ	99.9	578	622	100.0	385	513

Тоон судалгаанд Улаанбаатар хотоос 416 респондентоос (сонгосон дүүргүүдийн хүн амын харьцааг харгалзан түүврийн нарийвчлалыг тооцсон), аймаг орон нутгаас нийтдээ 482 респондентоос мэдээлэл авсан.

Хүснэгт - 3. Хөдөө ОН-ийн түүврийн хэмжээ (аймгуудаар)

Аймаг	Сум	Түүврийн хэмжээ	Эрэгтэй	Эмэгтэй
Ховд	Жаргалант	80	37	43
	Дарви	40	19	41
	Мянгад	40	15	25
Хөвсгөл	Мөрөн	80	36	44

	Тариалан	40	18	22
	Чандмань-Өндөр	40	19	21
Өмнөговь	Даланзадгад	-	-	-
	Ханбогд	-	-	-
	Цогт-Овоо	-	-	-
Дорнод	Дорнод	81	39	42
	Матад	41	20	21
	Халхгол	40	19	21
Улаанбаатар		416	163	253
Нийт		898	385	513

Судалгаанд оролцогчдын нийгэм-хүн ам зүйн шинжийг авч үзвэл судалгааны түүвэрт нийгмээс тусгаарлагдах эрсдлийн бүлгүүд боломжийн хэмжээнд хамрагдсан.

Хүснэгт - 4. Судалгаанд хамрагдсан хүн амын онцлог шинж, хувиар

	Нийт /N=900/	Хот /N=659/	Хөдөө /N=241/
Хүйс /эрэгтэй/	42.9	41.9	45.6
Нас /Mean, Std.Dev/	40(14.8)	38.4(14.2)	38.8(14.9)
Группэд байдаг гишүүнтэй	5.1	6,2	2,5
Удаан хугацааны турш өвчтэй байгаа гишүүнтэй	0,7	-	-
Бага боловсролтой, боловсролгүй	4.8	3.8	7.4
Өрх толгойлсон (эмэгтэй, эрэгтэй)	30,3	31,5	28,1
Ажилгүй	24,2	-	-
Ганцаараа амьдардаг	7.0	4.3	7.5
АБ доод түвшинд болон түүнээс доогуур орлоготой*	67,9	63,0	62,4
Төв суурингийн захад, суурингаас алслагдмал байдаг	36,7	25,3	38,8

Тайлбар: 2020 оны байдлаар АБДТ /сард нэг хүнд ногдох/ Ховд -203400 төгрөг, Хөвсгөл- 206000 төгрөг, Дорнод -201700 төгрөг байсанд үндэслэж судалгаанд оролцогч өрхийн бодит орлогыг (зээлтэй өрхийг зээл төлөөд үлдсэн орлогыг авав) ам бүлийн тоонд харьцуулан 210000 төгрөг, түүнээс доош орлоготойг тооцов.

Чанарын судалгааны мэдээллийг ганцаарчилсан, эксперт, бүлгийн ярилцлагын аргаар цуглууллаа. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо нэгд нийгмийн бүлгийн байр, онцлогийг, хоёрт ажил мэргэжлийг шалгуур болгосон. Нийт 17 ярилцлага хийснээс ганцаарчилсан 8, экспертийн 6, бүлгийн ярилцлага 3-ыг зохион байгуулсан. Үүнд:

Ганцаарчилсан ярилцлага:

- *Ахмад настан, өрх толгойлсон эрэгтэй, Мөрөн сум,*
- *Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй, ээжийгээ асардаг, ээж, хүүтэйгээ 3-лаа амьдардаг, Чандмань -Өндөр сум*
- *Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэй, Тариалан*
- *Архины хамааралтай эрэгтэй*
- *Ажилгүй иргэн*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн*
- *Ганц бие*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй*

Экспертийн ярилцлага:

- *Хөдөлмөр, нийгмийн халамж хариуцсан мэргэжилтэн, Тариалан сум*

- *Багийн засаг дарга*
- *Хөдөлмөр эрхлэлтийг хариуцсан мэргэжилтэн*
- *ЕБС-ийн багш*
- *Төрийн байгууллагын мэргэжилтэн*
- *Эрүүл мэндийн газрын ажилтан*

Бүлгийн ярилцлага:

- *Амьжиргааны түвшин доогуур, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлэг, хүйсийн хувьд холимог*
- *Ажилгүй болон улирлын чанартай ажил эрхэлдэг буюу прекариат бүлэг, амьжиргааны түвшнээс доогуур амьдралтай залуу үеийн төлөөлөгч*
- *Өрх толгойлсон, ганцаараа амьдардаг иргэд*

Цар тахлын нөхцөл байдлаас хамаарч нэгд анх тооцсон алхамт түүврийн аргачлалаар мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй болсон, хоёрт мэдээлэл цуглуулах арга буюу сурвалжлагын аргаар мэдээлэл цуглуулахад судлаач болон респондентийн аль алинд эрсдэл үүссэн, гуравт хөл хорионы үргэлжлэх хугацаа, нөхцөл аймгуудад өөр өөр хэрэгжиж байсны улмаас Өмнөговь аймгаас мэдээлэл цуглуулж чадаагүй. Дөрөвт тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй хоёр баг хоёр суурь судалгааны мэдээллийг төсөвлөсөн санхүүжилтийн хэмжээнд буюу бага зардлаар богино хугацаанд гүйцэтгэх шаардлагатай болсон.

1.5 Суурь судалгааны ажлын даалгавар, гүйцэтгэл

Суурь судалгааны сэдэвт ажлын үр дүнд судалгааны тайлан санал зөвлөмж 6 х.х, эрдэм шинжилгээний өгүүлэл 16-г бичиж нийтлүүлэн, нийтдээ илтгэл 12-ийг хэлэлцүүлж, хамтын бүтээл 8.5 х.х бичиж хэвлүүлэхээр төлөвлөсөн. Суурь судалгааны ажлын үр дүнд тайлан нэг (7.4х.х), эрдэм шинжилгээний өгүүлэл 16, эрдэм шинжилгээний илтгэл 20-г хэвлүүлж, хэлэлцүүлэн, хамтын бүтээлийн эхийг бэлтгэж (26х.х), эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хэвлүүлэв.

ЭШ-ний хурал зохион байгуулах ажлыг хүрээлэнгийн 50 жилийн ойн хүрээнд 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр нийгмийн тусгаарлагдалтын судалгааны арга зүй, үр дүнгийн талаар салбар хуралдаан зохион байгуулж, төслийн багийн 6 гишүүн нийгмийн тусгаарлагдалтын судалгааны үр дүнгээр илтгэл тавьж, хэлэлцүүлсэн. Уг илтгэлүүд “Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт” УБ., 2022 эмхтгэлд (163-361 дэх талд) хэвлэгдсэн.

СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН АГУУЛГА

ГОЛ ҮР ДҮН

2.1. Нийгмээс тусгаарлагдмал байдлыг ойлгохуй, судлахуй

Нийгмээс тусгаарлагдах (social exclusion) гэсэн эл ойлголтын хувьд монгол хэлээр хэрхэн оноон томъёолж тогтох нь нэлээд ярвигтай байна. Нийгмээс тусгаарлагдах гэсэн нь шоронд орох, сэтгэцийн эмнэлэгт хэвтэж тусгаарлагдах гэх мэт нийгмээс механикаар тусгаарлагдсан гэсэн шууд утгаар буух, тухайн ойлголттой хольж хутгах эрсдэл байна. Гэвч social exclusion нь эс хамрагдах, оролцоогүй байх, ялгаварлагдан гадуурхагдах, орхигдох, нийгмээс тасарч холдох, тусгаарлагдах, тэгш бус болох гэх мэт олон утгаар илэрхийлэгдэж буй бөгөөд “нийгмээс тусгаарлагдах” хэмээн оноох нь дээрх утгуудыг харьцангуй өөртөө багтаасан гэж үзэж хэрэглэлээ. Нийгмээс тусгаарлагдах гэдэгт тухайн хүн нийгмийнхээ үндсэн гол үйл ажиллагаанд өөрөө хүссэн ч оролцож чадахгүй байх, нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдсан үйл явцыг хамруулж ойлгож байна.

Нийгмийн тусгаарлалт (Social isolation) нь 1) Нийгмийн харилцаа холбоогүй, байнга харьцдаг цөөн хүнтэй, гэртээ удаан хугацаагаар байх, бусадтай харилцахыг эрмэлзэхгүй байх, нийгэмд харъяалагдах мэдрэмжгүй, нийгмийн харилцаагүй, сэтгэл ханамжтай, чанартай харилцаа холбоогүй байх явдал. 2) Орон зайн тусгаарлалтыг энэ ойлголтоор тэмдэглэж байна. 3) Сэтгэл зүйн салбарт илүү холбогдож байна. Бусад хүмүүсээс сэтгэл зүйн хувьд хүнийсэх гэж ойлгож хэрэглэдэг. Мөн хүмүүсийг өдөр тутмын дасал болсон хэвийн амьдралаас нь салгах (шорон, хоргодох газар, цэргийн хээрийн эмнэлэг, зэвсэгт хүчин, сургуулийн дотуур байр зэрэг газарт) гэсэн утгаар хэрэглэгддэг (Дэвид Джери, Джулия Джери 1999).

Энэ хоёр ойлголтын өөр нэг ялгаа нь Social isolation нь сайн дураар, өөрийн хүслээр тусгаарлагдаж болох (John Hills 2002) бол Social exclusion нь өөрийн хүслээр бус, өөрөө хүссэн ч оролцож, хамрагдаж, чадахгүй байх явдал гэж онцлон тодорхойлох нь ч бий. Бүр тодруулбал, social exclusion нь өөрөө мэдэхгүйгээр нийгмийн эсхүл нийгмийн институцийн ямар нэг санаатай ба санаандгүй үйлдэл, эс үйлдэхгүйгээс хамаарч хүн, ялангуяа хүчин мөхөс хүн, бүлэг нийгмээс тусгаарлагдана, мөн энэ ойлголт ялгаварлан гадуурхагдсан шинжийг хадгалж байдаг буюу ижил тэгш боломжоор хангагддаггүй.

Social exclusion нь дор хаяж дараах хоёр аргаар ижил тэгш боломжуудтай зөрчилддөг. Нэгдүгээрт, нийгмийн тусгаарлагдалт (exclusion) нь боловсрол, мэргэжлийн тэгш бус боломж бий болгодог; хоёрдугаарт, улс төртэй холбоотой тэгш боломжийг үгүйсгэх явдал юм. Нийгмээс тусгаарлагдах босго нь хоёулаа боловсрол, мэргэжлийн тэгш бус боломжийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Доод босго доогуур, дотоодын хотуудад газарзүйн хувьд (ялангуяа

АНУ-д) төдийгүй нийгмийн хувьд шууд тусгаарлагдсан (isolation) (ялангуяа Их Британид) томоохон орон сууцны хорооллууд байдаг. Эдгээр газрын заримд нь цөөн тооны хүмүүс байнгын хууль ёсны хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд үр дүн нь ажлын байрны талаарх ердийн ам дамжсан мэдээллийн урсгал бараг бүхэлдээ дутагдалтай байдаг гэж тайлбарлажээ. (John Hills 2002, 20)

Нийгмийн тусгаарлагдалт нь цогц бөгөөд олон хэмжээст үйл явц мөн. Нийгэм дэх хүн амын олонхийн оролцдог эдийн засаг, нийгэм, соёл болон улс төрийн аль ч хүрээн дэх хэвийн холбоо харилцаа, үйл ажиллагаанд нөөц боломжгүй, хүний эрх нь зөрчигдсөн, эд хөрөнгөгүй болсон, ердийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүйн улмаас эсвэл тэдгээрээс татгалзсантай холбогдон энэ үзэгдэл бий болдог. Тэр нь бүхэлдээ хувь хүмүүсийн амьдралын чанар хийгээд нийгмийн шударга ёс, эв нэгдлийн алинд ч сөрөг нөлөө үзүүлнэ.

Европын холбооны ядуурлын хөтөлбөрийн 1994 оны тайланд social exclusion-ийг системчлэн цогц байдлаар гаргаж тавьсан байдаг. Ингэхдээ нийгмийн тусгаарлагдмал байдал (social exclusion) нь нөөцийн дутагдал, нийгмийн эрхээ эдэлж чадахгүй байх зэрэг олон янзын дутагдлыг илэрхийлдэг динамик үйл явц гэж үзсэн байна. Нийгмээс тусгаарлагдах үйл явц нь гэр бүлийн харилцаа болон нийгмийн харилцаа холбооны хагарал, зорилго болон адилслын мэдрэмжээ алдах, олон төрлийн зүйлээр дутагдахад хүргэдэг гэжээ.

Нийгмийн тусгаарлагдмал байдал (social exclusion) гэсэн энэхүү ойлголтыг маш олон янзаар тодорхойлсон байдаг. Зарим судлаачид нь нийгмийн үндсэн үйл ажиллагаанд оролцоо багатай, оролцоогүй байх явдал гэсэн бол нөгөө нэг хэсэг нь нийгмийн тусгаарлагдмал байдлын олон талт байдал, үүнд улс төр, эдийн засаг, соёлын үйл явц, боломжоос ангид байх тал дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Тухайлбал, Европын холбооны ажлын хэсгийнхэн (1998) нийгмийн тусгаарлагдалтыг “доор байдлаас улам доошилж буй динамик үйл явц бөгөөд зарим зүйлээр гачигдалтай байх нь зарим зүйлээр тусгаарлагдахад хүргэж энэ нь эргээд илүү их гачигдал, илүү их нийгмийн тусгаарлагдалтад оруулж, улмаар байнга гачигдах, олон зүйлийн гачигдалд ороход хүргэдэг хэмээн тодорхойлсон. Хувь хүмүүс, өрхүүд болон бусад орон зайн нэгжүүд ажил эрхлэх боломж, эрүүл мэнд, боловсрол, улс төр, нийгмийн амьдрал гэх мэт нөөцийн хүртээмжээс хасагдаж болно”²⁷ гэжээ.

Нийгмийн тусгаарлагдмал байдлын хандлага нь нийгмийн эрхийн үзэл санаатай холбоотойгоор хөгжиж, улам боловсронгуй болж ирсэн бөгөөд "нийгмийн хувьд тусгаарлагдмал болох" гэх статусыг зөвхөн бараа бүтээгдэхүүний хүртээмжгүй байдал гэж ойлгодоггүй, харин эрх олж авах боломжгүй байх гэж ойлгодог. Ядуурлыг орлого эсвэл материаллаг хомсдолтой холбож тодорхойлдог бол нийгмийн тусгаарлагдмал байдлын статусыг хөдөлмөрлөх, орон байртай болох, эрүүл мэндийн үйлчилгээ авах, сурч боловсрох эрх гэх мэт нийгмийн эрхэд хамааруулан тодорхойлдог.²⁸

²⁷ Andrey Ivanov, Mihail Peleah, Susanne Milcher. The Chain of exclusion. United Nations Development Programme. Bratislava Regional Center Human Development Working Paper 2012/2E August 2012. p6.

²⁸ Мөн тэнд.

Нийгмийн тусгаарлагдалтын талаарх олон тодорхойлолтын гол санааг нэгтгэн үзвэл нийгмийн тусгаарлагдалт гэдэг нь хөдөлмөрлөх, орон байртай болох, эрүүл мэндийн үйлчилгээ авах, сурч боловсрох гэх мэт нийгмийн эрхээ эдэлж чадахгүй, эдлэх боломжгүй байх, нийгэмд оролцоогүй, хүссэн ч оролцож чадахгүй байх явдал буюу үндсэндээ нийгмийн оролцоогүй, нийгмийн эрхийн чадамжгүй байдал гэж товчоор тодорхойлж болох юм.

Судалсан олон янзын тодорхойлолтуудад үндэслэн бид энэ суурь судалгааны ажлын хүрээнд “Нийгмийн тусгаарлагдалтыг хүн нийгмийнхээ үндсэн гол үйл ажиллагаанд өөрөөс хамааралгүй шалтгаанаар оролцож чадахгүй байх явдал буюу нөөц баялгийн дутагдал, нийгмийн эрхийн хангалтгүй байдал, нийгмийн оролцооны дутагдлаас үүдсэн иргэдийн хэвийн үйл ажиллагаанд оролцдоггүй, харилцаагүй байдал” гэж тодорхойлж болно.

Нийгмийн тусгаарлагдалт нь нийгмийн ялгарал, туйлжилтын үр дагавар болохын хувьд ядуурлыг судлах социологийн хандлага хэмээн үзээд энэхүү нөөц боломж болон хүний эрхтэй холбоотой олон хэмжээст нийгмийн үйл явцыг микро түвшинд тодорхой орон зай цаг хугацаанаас хамааруулан судалж буй НҮБ-ын Хүний хөгжлийн хөтөлбөрийн арга зүй аргачлал, Нидерландын судлаачид болон Оросын социологичдын үзэл баримтлалыг энэхүү дэд сэдвийн хүрээнд голчлон баримтлаж Монголын нөхцөлд тохируулан хэрэглэхийг хичээв.

Нэгдүгээрт, нийгмээс тусгаарлагдах үйл явц манай оронд хэр тархацтай байгааг багцаалахаар Шведийн судлаач Абрахамсон, Оросын эрдэмтэн Н.Е.Тихонова нарын судлаачдын амьдралын түвшнийг болон нөөц хангамжийн интеграл үзүүлэлтийг тус бүрд нь тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр тооцож гаргасан аргачлалыг өөрийн орны нийгэм-соёлын нөхцөлд тохируулан зарим шалгуур үзүүлэлтийг өөрчлөн хэрэглэхээр боловсруулсан.

Хоёрт, судалгаанд хамрагдагсад нийгмийн орон зайн дотор (insider), эсвэл гадна (outsider) байрлаж байна уу гэдгийг тодорхойлон, монголын нийгэм дэх тусгаарлагдалтын үйл явцын шинж, онцлог, тусгаарлагдалтын хэлбэр, түвшин, тусгаарлагдах эрсдэл бүхий бүлгүүдийн тусгаарлагдалтын түвшин, тэдгээрт тулгамдаж буй асуудал бэрхшээлийг тодорхойлохоор судалгааны арга зүйг европ, данийн судлаачдын боловсруулсан арга зүйд тулгуурлан боловсруулав.

Гурав. Нийгмийн шилжилт, нийгмийн капитал зэрэг үзэглүүд нь нийгмийн тусгаарлагдалттай шалтгаан үр дагаврын эргэх холбоонд байдаг үзэгдлүүд бөгөөд бие биеэ харилцан нөхцөлдүүлж байдаг тул энэ онцлогт тулгуурлан судалсан. Тухайлбал, нийгмийн шилжилт үеийн доторх ба үе хоорондын шилжилтийг судлах арга зүйгээр шинжлэх шаардлагатай ч манай судалгааны хязгаарлагдмал байдал нь үүн дээр илэрч буй бөгөөд судалгааны мэдээллээр ийм үр дүнг шинжлэх боломжгүй байсан тул нийгмийн шилжилтэд нөлөөлөгч хүчин зүйлүүдээр тусгаарлагдсан бүлгүүдийг шинжлэн үзсэн.

Дөрөв. Нийгмийн тусгаарлагдалтыг макро, мезо, микро түвшинд авч үзэж шинжлэв. Нийгмийн түвшинд авч үзэхдээ нийгмийн тусгаарлагдалтын үйл явц, шалтгааныг судлах, ялгаварлан гадуурхалтын үүднээс авч үзсэн бол, бүлэг, хувь хүний түвшинд судлахдаа нийгмийн тусгаарлагдалтын үйл явцын үр дагаврыг судлах, нийгмийн тусгаарлагдалт тухайн эрсдэлт бүлгүүд болон

тусгаарлагдалтын янз бүрийн түвшинд байгаа бүлэгт хэрхэн явагдаж буй онцлог шинж, тулгамдаж буй асуудал бэрхшээлийг гаргалаа.

Английн социологич Вэллс, Мейдэм (*Wessels and Miedema*) нар нийгмээс тусгаарлагдагсдыг илэрч буй хэлбэр, нийгмийн, бүлэг, нийтлэг, институтээс хэр зэрэг хөндийрч байгаагаар нь ангилж, дараах таван хэв маягт хуваан үзсэн²⁹. Үүнд:

6) *Альтернатив тусгаарлагдагч*: Нийгмийн амьдралын үндсэн урсгалын гаднах альтернатив амьдралын хэв маягийг хамааруулдаг. Ерөнхийдөө сайн дурын шинжтэй юм. Ихэвчлэн үндэс угсаа, шашин шүтлэг, бизнес эрхлэх боломж, гадны хүмүүстэй нийгмийн харилцаанд ордоггүй зэргээс шалтгаалаад хөдөлмөр эрхлэхэд оролцдоггүй хүмүүс хамаарагдана. Жишээлбэл ХХ зууны эхэн үед Лондонгийн зүүн хэсэгт Еврейчүүдийг байрлуулдаг байсан нь үүний тод жишээ юм. (Phillips, 2002).

7) *Тусгаарлагдахын өмнөх шатанд байгаа*: Хэдийгээр саад бэрхшээлтэй тулгардагч нийгэм, улс төр, соёлын амьдралд оролцох боломжтой хэвээр байдаг. Энэхүү саад бэрхшээл нь жинхэнэ нийгмийн тусгаарлагдалтын эхлэл болдог. Жишээ нь, Их Британий католикууд одоо ч зарим (*Английн хаант улсын өв залгамжлагчтай гэрлэх боломжгүй г.м*) хязгаарлалттай байна.

8) *Дунд түвшний тусгаарлагдагч*: Энд хамаарч буй хүмүүс зарим онцгой институтээс тусгаарлагдах боловч ерөнхийдөө үндсэн институтийн бүтцэд хамаардаг. Жендерийн улмаас гадуурхагдах нь үүний жишээ юм.

9) *Ахисан түвшний тусгаарлагдагч*: Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс хамаараад оролцооны институтчилагдсан хэлбэрүүд болон олон гол чиглэлээс гадуур байдаг тул тэднийг нийгмийн амьдралд хамруулахад ихээхэн бэрхшээлтэй тулгардаг.

10) *Гүнзгий тусгаарлагдагч*. Энэ бүлэгт хамаарах хүмүүс ихэвчлэн өөрийнхөө ертөнцөд л амьдарна. Тэд ихэвчлэн нийгмийн албан ба албан бус институтүүд болон оролцооны хэлбэрүүдээс бүрэн тусгаарлагдсан байдаг. Түгээмэл биш боловч ийм тохиолдол бас бий гэсэн байна.

Нийгмийн тусгаарлагдалт *өргөн тархсан, гүнзгий, төвлөрсөн* гэсэн гурван хэлбэртэй³⁰ байх бөгөөд тэдгээрийг хольж хутгахгүй байх нь чухал хэмээн Миллибанд үзжээ. *Өргөн тархсан тусгаарлагдалт* нь ганц нэг үзүүлэлтээр тодорхойлогдох бол, гүнзгий нь олон шинжээр тусгаарлагдсан байна. Тэгвэл *төвлөрсөн тусгаарлагдалт* ялангуяа газарзүйн байрлалаар тодорхойлогдож болох бөгөөд орон нутаг, бүс нутгийг хамарсан тулгамдсан асуудал болсон байх жишээтэй. *Гүнзгий тусгаарлагдалт* гэдэг нь амьдралын чанар, аж байдал, ирээдүйн амьдралын өсөлт өөрчлөлтөд ноцтой сөрөг дагавар авчирдаг, хор хохирлын хэмжээ, хамрах хүрээгээр илүү өргөн байдгаараа бусад хэлбэрээс ялгагдана. а) Суурь мэдлэг чадвараар тааруу, удаан хугацаагаар ажилгүй байсан хүмүүс; б) Ядуурсан, муу сууцанд амьдардаг, сэтгэцийн өвчтэй эх эцэг бүхий хүүхдүүд; в) Орон гэргүй хүмүүс, мансуурагчид, ур чадваргүй, хамаатан садангүй хүмүүс зэрэг олон талын гачигдалд өртөгсөд гүнзгий тусгаарлагдсан хүмүүст багтдаг аж.

²⁹ David Phillips, *Sociological Studies*, University of Sheffield, UK. Social inclusion, social exclusion, and social cohesion: tensions in a post-industrial world. 2008. 10.8

³⁰ Miliband, D. (2006) *Social exclusion: The next steps forward*, London: ODP. P. 3.

Нийгмийн тусгаарлагдалтын нөхцөл байдлыг М.Вольф (Wolf M. Globalization and social exclusion) дараах байдлаар ангилсан байна³¹. Үүнд:

Оршихуйн арга хэрэгслээс тусгаарлагдах. 1960-аад онд тариачдын нийгмээс аж үйлдвэрийн нийгэмд шилжих үед ажиллах хүчний эрэлт нийлүүлэлтээс дайна гэсэн таамаглалтай байсан хэдий ч эрэлт нь нийлүүлэлтийг хангаж чадахгүйгээс нийгмийн тусгаарлагдалтанд өртөгсөд бий болсон юм. Ийм төрлийн тусгаарлагдмал байдал 1980-аад онд Африк болон Латин Америкийн орнуудад болсон томоохон бүтцийн өөрчлөлтийн үеэр илүү хүчтэй мэдрэгдэж, энэхүү үйл явц нь юуны өмнө дээд боловсролтой хүмүүс түүнчлэн төрөөс санхүүждэг салбарт ажиллагсдыг илүүтэй хамрах болсон байна. Мөнгөний ханш уналт тэдний орлогыг цөлмөж, дадал болсон амьдралын хэвшлээ орхиход хүргэсэн юм.

Нийгмийн үйлчилгээ, сайн сайхан байдал болон нийгмийн аюулгүй байдлын сүлжээнээс тусгаарлагдах. 1980-аад оныг хүртэл төрөөс хэрэгжүүлдэг үйлчилгээ болон нийгмийн эрхийн хувьд түгээмэл хүлээлт ядуу төдийгүй чинээлэг орнуудын хувьд өссөн юм. Үүнд бүх нийтийн боловсрол, эрүүл мэндийн эрх, ядуурлын эсрэг аюулгүй байдлын сүлжээ, сууцтай байх, цэвэр усны хангамж, хог хаягдлыг зөөх, өнөөгийн төрийн олон улсад зөвшөөрөгдсөн үүргийн дагуу иргэдийн бусад хэрэгцээг хангах шаардлагатай байдаг. Хүн амын нэг бүлгийн хувьд хэд хэдэн нийгмийн үйлчилгээг хорогдуулж, нөгөө бүлэгт нь хэвээр үлдээснээр нийгмийн хамгаалалт багатай бүлгийн тоо нэмэгдэх (өрх толгойлсон эмэгтэйчүүд, орон гэргүй хүмүүс гэх мэт) явдал гардаг.

Хэрэглээний соёлоос тусгаарлагдах. Хүн амын нэгээхэн хэсгийн хувьд тусгаарлагдахыг ядуурал, гачигдал, хоол, орох оронтой байх хэрэгцээ хангагдах боломжгүй болсонтой холбон үздэг. Гэтэл ихэнх хүмүүсийн хувьд хэрэглээнээс тусгаарлагдах нь хэрэглээний элдэв төрлийн, ялгаатай хэм хэмжээний талаарх мэдээлэл олж авахтай холбогдсон нарийн төвөгтэй асуудал болдог байна. Хэрэглэгчдийн хүсэл сонирхол хэрэгжээгүйгээс нийгмийн үйлчилгээний хүрээ болон аюулгүй байдлын сүлжээ түүнчлэн улс төрийн сонгуулиас (сонголтоос) тусгаарлагдан хөндийрөх байдал үүсдэг ажээ. Хэрэглээний аль салбар соёлын талаасаа зайлшгүй хэрэгтэй болохоос хамааран ямарч орлоготой хүмүүс нийгмээс тусгаарлагдах үйл явцад өртөж болох юм.

Улс төрийн сонгуулиас тусгаарлагдах. Ихэнх оронд хүмүүс чөлөөт сонгуульд оролцож, мэдээллийг янз бүрийн эх үүсвэрээс олох боломжтой болсон хэдий ч улс төрийн намуудын олигархжсан, хүнд сурталт дүр төрх, үйл ажиллагааны уршгаар улс төрийн сонгуулиас тусгаарлагдах, эс оролцох явдал арилахгүй байна. Улс төрийн оролцоо нь иргэдэд сайхан амьдрах боломжийг олгоно гэж амлалт өгдөг харьцангуй хүчтэй засаг төрийн шийдвэр бодлого хүртэл дэлхийн даяаршсан эдийн засгийн дэглэм, төрийн эсрэг ноёрхол, популист үзэл суртлын нөлөөгөөр ач холбогдлоо алдаж улс төрийн зүтгэлтнүүд сонгогчдын өмнө өгсөн амлалтаасаа ухрах тохиолдол элбэг болжээ. Улс төрийн сонгуулиас

³¹Бородкин Ф.М. Социальные эксклюзии. Социологический журнал.2003. №3/4. С. 9. Өгүүллээс товчлон орууллаа.

тусгаарлагдах үйл явц нь улс төрийн идэвхгүй болохоос эхлэн хүч хэрэглэсэн хариу үйлдэл болон хувирах хүртэл сөрөг үр дагаврыг авчрах болов.

Олон нийтийн байгууллага болон эвлэлдэн нэгдэхээс тусгаарлагдах. Тусгаарлагдалтын эсрэг тэмцэхдээ хүмүүсийн ашигладаг байгууллага болон эв нэгдлийн багавтар хэлбэршсэн хэлбэрүүд дараах хүчин зүйлд тулгуурладаг. Үүнд:

- 6) Оршин байхуйн арга хэрэгслийн үүсвэрт хяналт тавихыг эрмэлзэх (ҮЭ, тариачдын нэгдэл, худалдаачдын холбоо г.м)
- 7) Хэрэглэгчдийн хүсэл эрмэлзлэл болон зээлийн хэрэгцээг хангахыг хичээх (хоршоолол болон зээлийн холбоод)
- 8) Төрийн үйлчилгээ болон нутгийн захиргааны юмуу сайн дурын үйлчилгээний байгууллагад хандах (эх эцгийн болон тэтгэвэр авагчдын холбоо г.м),
- 9) Орон нутгийн зөвлөл, хөршийн холбоонд хамаарагдах
- 10) Шашны болон угсаатны ижилслийг хайхад хүрдэг байна.

Олон нийтийн байгууллага хамгаалалтгүй болон тогтворгүй байх аваас нийгмийн шинэ эхлэл, өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, хүн амын зарим хэсэг нийгмийн тусгаарлагдалтанд өртөх нөхцөлийг бүрдүүлдэг.

Болж өнгөрч буй зүйлийг ойлгох боломжоос тусгаарлагдах. Мэдээллийн нийгэм"-ийн үүсэл нь өвөрмөц хэлбэрийн тусгаарлагдалтыг буй болгож байна. Хүмүүсийн нэг хэсэгт нь амьдралын хэв маяг, нас хүйсийн ижилслээ илүү өргөн хүрээнд сонгох боломж олгож байгаа ч заримынх нь амь зуух арга ухааныг төвөгтэй болгож, эрсдэлт байдлыг нэмэгдүүлэхэд хүргэдэг аж. Хүн амын үлэмжхэн хувь нь спортын үйл явдал, алдарт хүмүүсийн хувийн амьдралын тухай зэрэг мэдээллээр хангагдаж сэтгэл ханамжтай байдаг ч үнэн хэрэгтээ өнөөгийн сэтгэл түгшээсэн үзэгдэл, үйл явдлын талаар огт сонсоогүй байх жишээтэй. Тухайлбал нийгмийн шинэ харилцаа төлөвшиж буй өнөө үед хүмүүс компьютер болон мэдээллийн технологи ашиглах боломжгүй байх юм бол, энэ төрлийн тусгаарлагдалтад өртөх болно.

Социологич М.Астоянц хот хөдөөгийн нийгэм соёлын орчинтой холбон нийгмийн тусгаарлагдалтыг кейс судалгааны аргаар судлаад хотын болон хөдөөгийн гэсэн хоёр төрлийн тусгаарлагдалт байна гэж үзжээ. Хотын хүмүүсийн амьдралд бодгаль шинж давамгайлж, салангид хөндий, вакумжсан хязгаарлагдмал орчинд амьдрах явдал элбэг байдгаас ганцаардах, нийгмийн холбоо сүлжээнээс хөндийрөх явдал гардаг бол хөдөөд тухайн бүс нутгийн алслагдмал байдал хийгээд нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил сул байдагтай уялдан нийгмээс тусгаарлагдмал байдал буй болдог гэсэн байна³².

Ийнхүү нийгмийн тусгаарлагдалт нь олон хэлбэр дүрстэй, янз бүрийн түвшинд илрэх үйл явц бөгөөд нийгмийн орон зай хийгээд цаг хугацаанаас хамаарч хувь хүн нэг түвшнээс нөгөөд шилжих бололцоотой юм. Гэхдээ энэ шилжилт санамсаргүй байдлаар явагдахгүй нийгмийн амьдралд хэр зэрэг идэвхтэй оролцохоос, тухайн оролцогчийн хөгжил, ур чадвар, нөөц боломж,

³²Астоянц М.С. Социальное сиротство: условия, механизмы и динамика эксклюзии (социокультурная интерпретация): дис. Док. Социолог. Наук. Ростов- на- Дону, 2007. С. 90.

амьдралын стратегийн сонголтоос ялангуяа улс орны нийгмийн бодлого, бүтэц, нийгмийн институтийн хөгжлөөс ихээхэн шалтгаалдаг ажээ.

2.2. Амьдралын нөөц боломжийн хомсдол ба тусгаарлагдмал байдал

Хомсдлын нэгдсэн индекс гаргах зорилгоор **өрхийн эдийн засгийн байдлыг** сууцны төрөл, өртэй эсэх, хувийн өмч, хадгаламж, өрхийн хэрэгцээний зардал, мөнгөн орлогын хүрэлцээний үнэлгээ, өрхийн нэг гишүүнд ногдох мөнгөн орлогын хэмжээ, хувийн бизнесийн орлоготой эсэх зэрэг 8 илтгүүрээр, **ажил хөдөлмөрийн нөхцөлийг** ажиллах орчин нөхцөл, ажилдаа сонирхох байдал, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын нэмэлт хангамж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээн дэх хамрагдалт, ажил дээрх оролцооны идэвх, удаан хугацаагаар ажилгүй байх эрсдэлтэй эсэх зэрэг 7 илтгүүрээр, **хүмүүн капиталын нөөцийг** гэр бүлийн гишүүдийн сургалт болон эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж, эрүүл мэндийн байдал, өвчний улмаас халамжийн үйлчилгээ авсан эсэх, хүүхэд нь цэцэрлэгт хамрагдсан байдал, мэдээллийн технологийн хэрэглээ зэрэг 7 илтгүүрээр **хэрэглээ ба чөлөөт цагийн орчинг** хооллолт, соёл ахуйн зориулалттай эд зүйлсийн хангамж, сууцны нөхцөлийн үнэлгээ, талбай, ээлжийн амралтаа хэрхэн өнгөрөөдөг, амралт авсан үедээ амрах боломж, амьдарч буй газрын орчин нөхцөл аюулгүй байдал, чөлөөт цагийн идэвх зэрэг 8 илтгүүрээр буюу нийт 30 илтгүүрийг сонгосон юм. Дараа нь үзүүлэлтийн уялдаа холбоог илрүүлэх, илүү мэдээлэл бүхий илтгүүрийг сонгох зорилгоор хэмжилтийн найдвартай байдлыг тогтоох статистикийн зарим арга тухайлбал бүлэглэсэн хувьсагчийн гол хэсгийн шинжилгээг хэрэглэв.

Индексийн болон үндсэн хэмжүүрүүдийн тогтвортой байдлыг Кронбахын альфагаар тодорхойлж болох бөгөөд $\alpha \geq 0.70$ байхад тогтвортой байдлыг хангалттай гэж үздэг байна³³.

Энэхүү шалгуурыг баримтлах юм бол өрхийн эдийн засгийн байдал (*Кронбахын альфа* = 0.738), болон хэрэглээ чөлөөт цаг (*Кронбахын альфа* = 0.720), ажил хөдөлмөрийн ажил хөдөлмөрийн нөхцөлийн багц үзүүлэлт (*Кронбахын альфа*=0.683) дээрх шаардлагыг хангасан, харин харин хүмүүн капиталын нөөцийн хэмжүүрийн чанарыг улам сайжруулах хэрэгцээтэй байгаа нь (*Кронбахын альфа*=0.523) харагдсан. Түүнчлэн илтгүүрүүдийг сонгохдоо 1) Гол хэсгийн ачаалал илүүтэйг (0.30–аас их байх) үлдээх; 2) Хоорондоо өндөр хамааралтай хувьсагчдын зөвхөн нэгийг авах; 3) Төслийн судлаачид асуулгыг биечлэн авсан тул, тухайн үзүүлэлтийн агуулгыг илүү тодорхойлж чадахуйц үнэний хувь болон мэдээлэл ихтэй гэж үзсэн зарим асуултыг (өр төлбөр, хөдөлмөрийн хүрээн дэх хуулийн гажуудалт зэрэг) хэмжилтийн чанарын статистик үзүүлэлт бага гарсан ч ерөнхий индекс байгуулахад тооцож оруулах

³³ Terwee CB, Bots SD, de Boer MR, van der Windt DA, Knol DL, Dekker J, Bouter LM, de Vet HC. Quality criteria were proposed for measurement properties of health status questionnaires. J Clin Epidemiol. 2007;60(1):34–42

зэрэг зарчмыг баримталсан болно. Бүлэглэсэн хувьсагчийн гол хэсгийн шинжилгээний дүнг ард хавсаргав (*Хавсралт 2.1-ээс үзнэ үү*).

Дээрх шалгуурыг баримтлан амьдралын нөөц боломжийн 4 багц үзүүлэлтэд багтах эерэг сөрөг утга бүхий дараах илтгүүрийг үлдээж, ерөнхий индекс байгуулахдаа ашигласан.

“Нийгмийн оролцоо ба эс хамрагдал” сэдэвт социологийн асуух аргаар авсан судалгааны мэдээлэлд дээрх аргачлалыг ашиглан олон хэмжээст статистик шинжилгээ³⁴ хийсэн юм. Энэхүү шинжилгээний дүнд тулгуурлан а) Амьдралын эдийн засгийн нөхцөл, ажил дээрх нөхцөл байдал, хүмүүн капиталын байдал, хэрэглээ ба чөлөөт цагийн нөөц тус бүрийн индекс бодох; б) Иргэдийн амьдралын нөөц боломж хийгээд хомсдлын харьцааг тодорхойлох; в) Амьдралын нөөцийн нэгдсэн индексийн тархалт байгуулах; г) Нийгмийн тусгаарлагдалтын хэв маяг үүсгэх; д) Нөөцийн хомсдол бүхий эрсдэлт бүлгүүдийг илрүүлэх, нийгмийн тусгаарлагдмал байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодруулахыг хичээлээ.

Амьдралын нөөц боломжийн дотроос сургалт болон эрүүл мэндийн үзлэгт хамрагдах байдал, интернетийн хэрэглээгээр тооцсон хүмүүн капиталаа хадгалах нэмэгдүүлэх боломжийн индекс (-0.31) бусад гурван багцаас арай өндөр гарсан байв. Судалгаанд хамрагдсан айл өрхүүдийн хамгийн их шаардлагатай эрэлт хэрэгцээний дотор эрүүл мэндээ хамгаалах (50.4%), эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх (42.5%) хэрэгцээ зонхилохын зэрэгцээ арван өрх тутмын гурав нь боловсрол мэдлэг эзэмших боломжийг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзжээ. Манай улс хүмүүн капиталын үзүүлэлтээрээ дэлхийн хэмжээнд дунджаас дээгүүр байранд ордог (2017 оны байдлаар дэлхийн 130 орноос 51-р байранд орсон) хэдий ч мэдлэгээ капитал болгох, шинээр сэтгэх, шинэ арга барилаар ажиллах (know how) явдал (111-р байр) дутагдалтай гарсан байдаг³⁵.

Өрхийн эдийн засгийн нэгдсэн индексийг тооцож үзэхэд судлагдагдсан 10 хүн тутмын тэн хагас нь 1-3 хомсдолт шинжтэй байхад, 18,3 хувь нь 1-2 нөөц боломжтой, өрхийн эдийн засгийн дундаж үзүүлэлт нь -0.54 гарч, эдийн засгийн хувьд гачигдал бүхий хүмүүс нөөц боломжтойгоосоо 2,8 дахин олон байв. Эдгээр үзүүлэлт нь судалгаанд хамрагдагсдын 24.0 хувь нь хугацаандаа төлөгдөөгүй өр төлбөртэй, 28.2 хувь нь өрхийн нэг хүнд сард ногдох мөнгөн орлогоор амьжиргааны доод түвшинд багтдаг, арван хүн тутмын дөрөв нь өрхийн хэрэгцээний зардлыг төлөхөд бэрхшээл учирдаг гэж хариулсантай холбоотой юм.

Ажил хөдөлмөрийн нөхцөл байдлын индекс бусад багцынхтай харьцуулахад хамгийн бага буюу дундаж нь -0.85 гарсан байв. Ялангуяа ажил дээр хөдөлмөрийн хууль тогтоомж ямар нэг байдлаар зөрчигддөг (43.9%), удаан хугацаагаар ажилгүй байх эрсдэлтэй (26.4%), хөдөлмөрийн орчин нөхцөл тааруу (14.1%) зэргээс болж, ажлын байрны нөхцлөө сөрөг үнэлэгсэд эерэг үнэлэгсдээс 7,7 дахин олон байгаа юм. Ийнхүү иргэдээ цалин хөлс сайтай чанартай ажлын

³⁴ Онцлох эерэг хариултад +1, онцлох сөрөг хариултад -1, бусад хариултад 0 оноо өгсөн.

³⁵The Global Human Capital Report. World Economic Forum. 2017. http://www3.weforum.org/docs/WEF_Global_Human_Capital_Report_2017.pdf

байраар хангахгүйгээр тэдний эдийн засгийн нөхцөлийг сайжруулах боломжгүй болохыг судалгааны дүн харуулж байгаа юм. Ажил эрхэлдэг хэрнээ цалин хөлс багатай, нийгмийн хамгаалын гадна талд байдаг, хөдөлмөрийн хууль дүрэм хэрэгждэггүй, хөдөлмөрийн орчин нөхцөл муутай ажил эрхлэгчид түүнчлэн албан бус, стандарт бус, түр зуурын ажилтай, тогтвортой ажлын байргүй хүмүүсийн бүлэг буюу прекариат ажил эрхлэлт манай оронд ч буй болсон бөгөөд түүнийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай болжээ. Статистикийн мэдээнд шинжилгээ хийж үзэхэд хөдөлмөрийн насны нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн ам болон ажиллагчдын тооны эзлэх хувийн жингээр тооцогддог ажиллах хүчний оролцооны түвшин хийгээд хөдөлмөр эрхлэлтийн түвшин цаашдаа буурах хандлага ажиглагдаж байгаа. Өнөөгийн монгол оронд ажилтнуудын шилжих хөдөлгөөн ихтэй, хөдөлмөр эрхлэлт тогтвортой бус, хөдөлмөрийн хөлс доогуур, мэргэжлээрээ дэвших, мэргэших боломжгүй, хуучин техник технологитой, үйлдвэрчний эвлэлгүй зэрэг шинж илэрдэг хөдөлмөрийн хоёрдогч зах зээл давамгайлж байгаа нь нууц биш.

Амьдралын нөөц боломж болон гачигдал хомсдлыг харуулах сонгож авсан дөрвөн багц 12 үзүүлэлтийг нэгтгэсэн нийлбэр индексийн тархалтыг нэгж хэвийн тархалтад шилжүүлэн харьцангуй нэг төрөл гурван бүлэгт хуваахад амьдралын нөөц боломжоор давуутай иргэд 17.7 хувьтай байсан бол, 15.6 хувь нь 12 илтгүүрийн хагас болох 6 буюу түүнээс дээш хомсдолд өртөгсөд, үлдэх хэсэг нь (0-ээс 5 хомсдол бүхий) дундаж хэсэгт багтжээ. Хэрвээ нийгмийн тусгаарлагдалтыг судлах микро хандлагыг үндэс болгон дөрвөн багц үзүүлэлтээс дор хаяад хоёроос доошгүйд нь нөөц боломжийн ямар нэг хэмжээний хомсдол бүхий иргэдийг нөөцийн хомсдолтой буюу нийгмийн тусгаарлагдалтад ямар нэг байдлаар өртөгсөд гэж тооцох юм бол (4 болон түүнээс дээш тооны хомсдолт шинж бүхий) тэдгээр нь судалгаанд оролцогсдын 35.8 хувийг хамарч байна. Нидерландын нийгмийн ухааны хүрээлэнгийн судлаачдын нийгмийн тусгаарлагдмал байдлын бүлгүүдийн босго оноог тогтоохдоо ерөнхий индексийн голч утгыг ашигласан аргачлалд тулгуурлан судалгаанд хамрагдагсдыг хомсдол гачигдлын хэмжээгээр нь дараах таван бүлэгт хуваав. Үүнд: тусгаарлагдалтын өмнөх шатанд буюу тусгаарлагдмал байдалд багавтар өртөгсөд (4-5 хомсдолт шинжтэй) 20.3%, дунд түвшний тусгаарлагдагсад (6-7 хомсдолтой) 11.7%, ахисан түвшний тусгаарлагдагчид (8-9 хомсдолтой) 3.6%, гүнзгий тусгаарлагдагч (10-11 хомсдолтой) 0.3 хувь, харин тусгаарлагдалтад өртөөгүй нь 64.2% болно.

Зураг 1. Нийгмийн тусгаарлагдмал байдлын хэв маягууд



Амьдралын нөөц боломж болон эрсдлийн үзүүлэлтээр үүсгэсэн дээрх таван бүлгийн хувьд тэдний амьдралаа бүхэлд нь болон эрүүл мэндээ үнэлсэн үнэлгээ түүнчлэн нийгмийн амьдралын янз бүрийн хүрээн дэх оролцоо хийгээд сэтгэл зүйн байдалдаа өгсөн үнэлэлт мэдэгдэхүйц ялгаатай.

Бүхэлд нь авч үзвэл, өнөөгийн Монголчуудын дунд амьдралын боломж нөөцөөс эрсдэлт нөхцөл байдал илүү давамгайлах хандлага илэрч байна. Манай оронд иргэний болон нийгмийн эрх нь зөрчигдөж, ялгаварлан гадуурхагдсан, нийгэм төрийн үйлчилгээнээс орхигдсон, ажилгүй эсвэл чанаргүй, тогтворгүй ажлын байр бүхий, амьдралын төрөл бүрийн нөөцийн хомсдолтой, хувийн амьдралдаа сэтгэл ханамжгүй иргэдийн тоо нэмэгдэж, ядуурлаас илүү өргөн хүрээг хамарсан нийгмийн тусгаарлагдмал байдалтай бүлэг үүсэн буй болох нөхцөл бүрджээ.

Өрхийн эдийн засгийн байдал, ажил хөдөлмөрийн нөхцөл, хүмүүн капиталын хуримтлал, хэрэглээ чөлөөт цагийн багц үзүүлэлтийн дундаж утга бүгд сөрөг гарснаас хамгийн эрсдэл өндөртэй нь ажил хөдөлмөрийн нөхцөл, хэрэглээ ба чөлөөт цагийн үзүүлэлт, харин харьцангуй бага эрсдэлтэй нь хүмүүн капиталын нөөц дараа нь өрхийн эдийн засгийн байдал байгааг хүснэгтээс харж болно. Ийнхүү иргэдээ цалин хөлс сайтай чанартай ажлын байраар хангахгүйгээр тэдний эдийн засгийн нөхцөлийг сайжруулах боломжгүй болохыг судалгааны дүн харуулж байгаа юм. Судалгаагаар тогтмол ажилтай, улирлын ажилтай, түр зуурын ажил эрхлэдэг, ажил хийдэггүй гэсэн хөдөлмөрийн зах зээлд оролцох байдлаар ялгагдах дөрвөн бүлгийн сарын мөнгөн орлогын дундаж ялгаа харьцангуй бага байгаагаас үзэхэд, хөдөлмөрийн зах зээлийн голлон зохицуулагч болох ажиллагсдын цалин хөлс өөрийн чиг үүргээ биелүүлж чадахгүй байна гэж хэлэх үндэстэй. Нийгмийн хамгаалал сайтай хөгжингүй орнуудад ажилгүй хүмүүс, өндөр настан тусгаарлалтад өртөх нь бага байдаг бол, хөдөлмөрийн зах зээлийн болон тэтгэврийн тогтолцоо боловсронгуй болж чадаагүй манай орны нөхцөлд ядуурлын шугамаас доош орлоготой иргэд хийгээд 65-аас дээш насны ахмадууд нийгмийн тусгаарлагдмал байдалд өртөх магадлал өндөр гарч байгаа зэрэг онцлог ажиглагдав. Ялангуяа дижитал хүчин зүйлийн нөлөөлөл их байгаагаас мэдээллийн технологийн хангамж хийгээд түүнийг ашиглах чадварыг дээшлүүлэх явдал нийгмийн тусгаарлагдалтаас сэргийлэхэд илүү ач холбогдолтой байж болохоор байна. Тоон болон чанарын судалгааны дүнгээс үзэхэд тусгаарлагдалтын эрсдэлт бүлэгт гэртээ хүүхэд хардаг ээжүүд, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд, амжиргааны түвшин доогуур айл өрх, боловсрол багатай, хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэнд тааруу иргэд, сэтгэл гутралтай болон архинд донтогчид, ганц бие болон өрөөсгөл гэр бүл, төв суурингаас алслагдмал хөдөөгийнхөн, байр сууцны хувьд гэрт амьдрагсад түлхүү хамрагдах магадлалтай байна. Хувь хүний нийгэм-хүн ам зүйн онцлог, хөгжил төлөвшил, нийгэмд эзлэх байр суурьтай холбогдсон хүчин зүйлээс гадна орон нутаг, оршин суугаа газрын онцлог, байршил, хөгжилтэй холбоотой зарим хүчин зүйл (тухайлбал төв суурингийн захад буюу зайтай байрладаг, дэд бүтэц хөгжөөгүй, зах зээлээс хөндий, ажлын байргүй г.м), түүнчлэн нийгмийн институт, төрийн бүх шатны байгууллагын бүтэц, зохион

байгуулалт, үйл ажиллагаа, үйлчилгээний дутагдал доголдол хийгээд хүнд суртал газар авсан, төр нийгмийн бодлого шийдвэрийн зохист байдал, хэрэгжилт дутмаг байгаад иргэд шүүмжлэлтэй ханджээ. Түүнчлэн ковидын нөлөөлөл, улс орны эдийн засгийн хүндрэл зэрэг мезо болон макро түвшний гадаад хүчин зүйлүүд хослон нийгмийн тусгаарлагдмал байдлын хүрээг нэмэгдүүлэх гол нөхцөлийг бүрдүүлж байна.

Төр засгаас иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтэд онцгой анхаарал хандуулж, эдгээр эрхийг хангах талаар төрийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа “НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилт-2030”-т тусгагдсан “хэнийг ч хөгжлийн гадна үлдээхгүй байх” суурь үзэл санааг удирдлага болгох, ялангуяа эмзэг бүлгийн эрхийг тусгайлан хамгаалах чиглэлд онцгой анхаарах талаар хүний эрхийн судлаачдын гаргасан саналыг дэмжиж байна³⁶.

Монголчуудын “Амны билгээс ашдын билэг” гэсэн уламжлалт үнэлэмжийн тогтолцоо, өөдрөг үзэл, зан төлвийн загвар, тогтсон хандлагаас шалтгаалан, олон зүйлийн гачигдал хомсдолд нэрвэгдсэн хэдий ч би амьдрах аргагүй боллоо, хэцүүдлээ, нийгэм нийгмийн институтэд итгэл алдарлаа гэж үзэх нь ховор байна. Тухайлбал, бидний хэмжилтээр нөөцийн хомсдол харьцангуй өндөр гарсан тусгаарлагдмал байдалтай дөрвөн бүлгийн хүмүүсийн дийлэнх олонхи (66-75%) нийгэм болон хүмүүсээс хөндийрч харилцаагүй болсон мэт сэтгэгдэл төрдөггүй гэсэн байна. Гэхдээ энэхүү үнэлгээнд санаа амрах тайвшрах ямар ч үндэс байхгүй бөгөөд тусгаарлагдмал байдал удаан үргэлжлэх юм бол түүнд өртсөн хүмүүс, айл өрх нийгмийн бүхий л хүрээнээс, нийгмийн эв нэгдлээс хөндийрөх улмаар баримжаагаа алдах, нийгмийн сайн сайхан байдалд итгэхээ болиход хүрдгийг гадны орны судлаачид анхааруулжээ.

Дүгнэн өгүүлбээс иргэн бүрийн тодорхой ажил үүргийг гүйцэтгэж чадахуйц ур чадвар болон нөөц боломжийг хөгжүүлэх, тэднийг нийгмийн амьдралын бүх хүрээнд жигд хамруулах, ялангуяа Монголын хөдөлмөрийн зах зээлийг боловсронгуй болгож, иргэдийн оролцоог жигд хангах, төрийн үйлчилгээ (*тухайлбал эрүүл мэнд, боловсрол, амралт чөлөөт цагийн орчин, сургуулийн өмнөх насны байгууллагын хүрэлцээ гэх мэт*)-г нийтэд тэгш хүртээмжтэй болгох, хүний эрхийг дээдлэн ялгаварлан гадуурхлаас ангид байлгахад төр засаг бүх шатны байгуулагууд илүү анхаарах шаардлагатай болжээ.

2.3. Нийгмээс тусгаарлагдах үйл явц: шинж онцлог, нөлөөлж буй хүчин зүйл

НҮБХХ-ийн газраас 2011 онд Европ болон төв Азийн 6 оронд (Казакстан, Македони, Молдов, Серби, Таджикстан, Украин) нийгмийн тусгаарлагдмал байдлын сэдвээр харьцуулсан судалгаа явуулжээ. Эл судалгааныхаа хүрээнд тусгаарлагдалтын индекс байгуулахдаа *А. Эдийн засгийн тусгаарлагдахуй, В. Нийгмийн үйлчилгээнээс тусгаарлагдахуй, С. Иргэний болон нийгмийн амьдрал, сүлжээнээс тусгаарлагдахуй* гэсэн тус бүр нь 8 нийтдээ 24 индикатораас бүрэлдэх гурван багц үзүүлэлтийг хэрэглэн хэмжилт (гурван

³⁶ Хүний эрхийн үндэсний форум. 2021. Эрх чөлөө, тэгш боломж, эв нэгдэл. Илтгэлийн эмхтгэл. х.123.

хэмжээст) хийсэн байна. Түүнээс гадна нийгмийн тусгаарлагдмал байдлын индексийг тусгаарлагдалтын **хөдөлгөгч** (бүтэц /*төр хийгээд хувийн байгууллагын хэм хэмжээ*/, зан төлөв /*үнэт зүйлс, зан төлөвийн загвар, ёс заншил*/, бодлоготой холбоотой), **хувь хүний онцлог шинж** (хүйс, угсаа гарал, нас, бэлгийн чиг баримжаа, итгэл үнэмшил, хөгжлийн бэрхшээл г.м) **орон нутгийн өвөрмөц нөхцөл** (хүний амьдарч буй тодорхой орчныг илэрхийлэх үндэстний бүс нутгийн нөлөөтэй хүчин зүйлс), **иргэдийн нийгэмд эзлэх байр суурь** (орлого, эрүүл мэнд, ажил эрхлэлт, боловсролын түвшин, нөөц бололцоогоо ашиглах боломж г.м) зэрэг үзүүлэлттэй хэрхэн холбогдож буйг тодорхойлох зорилго тавьжээ.

Нийгмийн тусгаарлагдалтын хэмжээс болон илтгүүрүүд: А. Эдийн засгийн тусгаарлагдмал байдал, В. Нийгмийн үйлчилгээнээс тусгаарлагдах, С. Иргэний болон нийгмийн амьдрал хийгээд сүлжээнээс тусгаарлагдах гэсэн гурван хэмжээст харьяалагдах 24 илтгүүрийг аль болохоор дээрх судалгааныхтай дүйцүүлэхийг хичээж, бидний амьдрал, аж төрөлд төдийлөн тохирохгүй байсан зарим асуултыг өөрчлөн оруулсан юм.

Нийгмийн тусгаарлагдалтын гурван хэмжээс тус бүрээр дундаж индекс тооцож үзэхэд, нийгмийн үйлчилгээнд эс оролцогчид хамгийн олон, дараа нь нийгмийн оролцоо, сүлжээнээс хөндийрөгчид, эцэст нь эдийн засгийг харуулах үзүүлэлтээр гачигдал хомсдолд өртөгсөд орсон байна. Тооны хувьд харьцангуй цөөн хэдий ч эдийн засгийн тусгаарлагдахуйг үзүүлэх 8 илтгүүр бүгд хомсдолд орсон нийгмийн оролцооны хувьд 7 илтгүүр нь сөрөг утгатай, мөн нийгмийн үйлчилгээний 7 үзүүлэлт нь шаардлага хангахгүй байгаа хүмүүс айл өрх ч тохиолджээ. Өрхийн эдийн засгийн 8 илтгүүрийн ихэнхид гачигдал хомсдолтой хүмүүс 8.7 хувь, харин нийгмийн үйлчилгээ болон нийгмийн оролцоо гэсэн хэмжээсийн хувьд дээрх үзүүлэлт харгалзан 10.9%; 8.8% байлаа. НҮБХХ-ийн хөтөлбөрийн судлаачид нийгмийн тусгаарлагдалтын ерөнхий индексийг энэхүү гурван хэмжээсийг нэгтгэн тооцоод хоёроос доошгүй хэмжээсийн илтгүүр нь хомсдолтой байвал (өөрөөр хэлбэл 24 илтгүүрээс 9 болон түүнээс дээш шинжээр хомсдолтой бол) тэдгээр хүмүүсийг нийгмийн тусгаарлагдалтад өртсөн гэж тооцсон юм.

"Нийгмээс тусгаарлагдсан" хүн амын хомсдолын эрчимт байдлыг (А) олохдоо хомсдолын дундаж тоог боломжит хамгийн их тоо (бид 24 илтгүүр сонгосон)-нд хуваана. Хомсдолын дундаж хувь нь нийгмийн тусгаарлагдалтын эрчмийн талаар нэмэлт мэдээлэл өгдөг. Харин засварлагдсан коэффициент буюу олон хэмжээст индекс нь тусгаарлагдмал байдалтай хүн амын эзлэх хувь (бутархай хэсэг) Н болон тусгаарлагдалтын эрчимт байдал А-ийн үржвэртэй тэнцүү.

Өрхийн эдийн засгийн тусгаарлагдалт, нийгмийн үйлчилгээ болон нийгмийн харилцаа, сүлжээнээс тусгаарлагдах байдлын гурван үзүүлэлтийг нэгтгэн нийгмийн тусгаарлагдалтын нэгдсэн индексийг судлагдсан 900 иргэний хувьд байгуулж үзвэл, дараах хэд хэдэн статистик шинжтэй дүгнэлт хийж болох юм. Үүнд:

Нэгдүгээрт, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн газраас гаргасан аргачлалд тулгуурлан хоёроос доошгүй хэмжээсийн хувьд тусгаарлагдмал болон хомсдолт байдал илэрсэн буюу 9 болон түүнээс дээш хомсдолын илтгүүр бүхий иргэнийг ямар нэг байдлаар тусгаарлагдмал байдалтай байна гэж үзэх юм бол, судлагдсан хүмүүсийн 31.0 хувьд нь нийгмээс хөндийрөх, тусгаарлагдах, нийгмийн үйл ажиллагаанд эс хамрагдах хандлага илэрч байна.

Хоёрдугаарт, Нэгдсэн индексийн тархалтыг нэгж хэвийн тархалтад шилжүүлэн, +1-ээс их завсарт харьяалагсдыг (11-19 хомсдолт шинжтэй) нийгмийн тусгаарлагдалтад өртөгсөд гэж үзвэл тэдгээр нь 15.7 хувийг эзэлнэ. Эдгээр хүмүүсийг тусгаарлагдалтын дунд, ахисан, гүнзгий түвшинд тусгаарлагдагчид хэмээн үзэж болох юм. Тэгвэл үлдэх 15.3 хувь нь тусгаарлагдалтын өмнөх шатанд байгаа иргэд болно.

Гуравдугаарт, *Нийгмийн тусгаарлагдмал байдлын эрчимт байдал (А) нь 46.1 хувь*, нийгмийн тусгаарлагдмал байдалд өртөгсдийн хомсдолт шинжийн дундаж нь 11.1 буюу нийслэл хот, хийгээд хот, хөдөөд нэг иргэн 24 илтгүүрээс 11-д нь хомсдол гачигдалд орсон бараг ижил үзүүлэлттэй байв (*Иргэд хамгийн багадаа 1, хамгийн ихдээ хомсдолын 19 шинжтэй, судлагдагсдын тэн хагас нь 7-оос их хомсдолт шинжтэйн дээр 5 илтгүүрийн хувьд хомсдол гачигдал бүхий хүмүүс хамгийн олон тохиолджээ*). Нийгмийн тусгаарлагдмал байдлын индекс нь 14.3 гарав. Индекс нь нийгмийн тусгаарлагдмал байдлын тоо, эрчмийн үзүүлэлтийн шууд үр дүн бөгөөд индексийн утга их байх тусам нийгмийн тусгаарлагдмал байдал их байна гэсэн үг.

Дөрөвдүгээрт, Нийгмийн тусгаарлагдмал байдлын илрэл буюу гачигдал хомсдлын эрчимт байдал хотоос хөдөөд харьцангуй илүү байгаа дүр төрх ажиглагдав.

Бүхэлд нь нэгтгэн дүгнэвэл, суурь судалгааны мэдээлэлд үндэслэн эдийн засгийн амьдрал, нийгмийн үйлчилгээ болон иргэний оролцоо, харилцаанаас тусгаарлагдах гэсэн 3 хэмжээс, 24 илтгүүрийг тогтоож, гурван хэмжээсийн хоёроос доошгүйд сөрөг үнэлгээ авч, нийтдээ 9 буюу түүнээс дээш гачигдал, хомсдолтой аваас тухайн хувь хүнийг нийгмийн тусгаарлагдмал байдалд ямар нэг байдлаар өртсөн гэж үзсэн болно. Эдгээр илтгүүрийг аль болохоор дээрх судалгааныхтай дүйцүүлэхийг хичээсэн хэдий ч нэг талаар энэ аргачлалыг шууд хэрэглэж анкетаа боловсруулаагүй, нөгөө талаас зарим асуулт нь Монгол хүмүүсийн амьдрал ахуйд төдийлөн тохирохгүй байсан тул цөөвтер асуултыг өөрчлөн оруулсан юм. Түүний зэрэгцээ индексийн найдвартай болон тогтвортой байдлыг дээшлүүлэх зорилгоор олон хүчин зүйлийн шинжилгээ, регрессийн болон корреляцийн шинжилгээ зэрэг олон хэмжээст статистик аргыг боломжийн хэрээр ашиглахыг хичээв.

Судалгаанд оролцогчдын гуравны нэгээс илүү хувь нь нийгмээс ямар нэг байдлаар тусгаарлагдсан, тухайлбал судалгаанд хамрагдагсдын 15.3 хувийг тусгаарлагдалтын өмнөх болон дунд түвшинд, харин 15.7 хувийг ахисан болон гүнзгий түвшинд хамаарч байна. Түүнчлэн нийгмийн тусгаарлагдалтын эрчимт байдал буюу нийгмээс тусгаарлагдсан хүмүүс хичнээн их хомсдолд орсныг тодорхойлоход дунджаар 24 илтгүүрээс 11-д нь хомсдолд орсон дүр зураг

ажиглагдав³⁷. Хомсдолын энэхүү тоон үнэлгээнээс үзэхэд тусгаарлагдалтын янз бүрийн түвшний хүмүүс өрхийн нэг хүнд ногдох мөнгөн орлогын хэмжээгээрээ дунджаар нийгмээс тусгаарлагдаагүй иргэдээс 1,6–2,5 дахин бага байгаа (*анкет-сурвалжлагын өгөгдлөөр*) хэдий ч, тусгаарлагдалтын өмнөх болон дунд түвшинд хамрагдагсдын 21,6 хувь нь, ахисан түвшний хүмүүсийн 4,3 хувь нь ядууралд өртөөгүй боломжийн хийгээд чинээлэгдүү амьдралтай хүмүүс байлаа. Ийнхүү тусгаарлагдалтын энэхүү индекс амьжиргааны доод түвшин хийгээд ядуурлын үзүүлэлтээс илүү өргөн хүрээг хамарч байна гэж хэлж болох юм.

Чанарын судалгааны мэдээллийг шинжлэхэд боловсрол бага, хөгжлийн бэрхшээлтэй, эрүүл мэнд тааруу, өндөр нас, ганц бие үр хүүхэдгүй, идэвхгүй байдал, зан төлөв харилцаа муутай, ажил хөдөлмөр хийдэггүй, орлого байхгүй, түр зуурын орлого л олдог, архи уух, архинд донтох гэх зэрэг *хувь хүний эрсдэлт шинж байдал*, байгаль газарзүйн нөхцөл байдал, цаг уур, зах зээлээс хол, бараа бүтээгдэхүүнээ аваачиж борлуулах боломж нь хомс, ажилгүйдэл өндөр, ажлын байр байдаггүй, дэд бүтэц тааруу, (*зам муутай, байшин барилгын чанар муу, нэгдсэн халаалт байхгүй, сумын төвийн барилгуудыг уурын зуухаар халаадаг*) зэрэг *ОН-ийн онцлог нөхцөл байдал*, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын алдаа, төрийн үйлчилгээ, бодлого дутагдаж байгаа, нийгмийн халамжийн бодлого гажуудсан зэрэг *нийгмийн тусгаарлагдалтанд хөтлөгч хүчин зүйлүүдийн* харилцан үйлчлэлийн үр дүнд иргэд нийгмээс тусгаарлагдахад хүрч байна.

2.4. Өрхийн материаллаг хангамж ба хомсдол

Өрхийн амьдралын түвшин, аж байдлыг илэрхийлэх нэг гол хүчин зүйл нь орлогын хэмжээ, түүний эх үүсвэр юм. Гэр бүлийн гишүүдийн нас, хүйс, боловсрол, эрхэлж буй ажил, мэргэжлээс хамаараад өрхийн орлого харилцан адилгүй эх үүсвэрээс бүрддэг. Зарим өрхийн орлого зөвхөн цалин хөлснөөс бүрддэг бол заримынх нь групп тэтгэврийн мөнгө, бизнес, түрээсийн орлого гэх мэт орлогын эх үүсвэртэй байдаг. Өрхийн нийт орлого нь өрхийн мөнгөн орлого дээр өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлсийн мөнгөн дүнг нэмснээр тодорхойлогддог³⁸. Бид энэ хэсэгт өрхийн мөнгөн орлого, түүний хүрэлцээг гаргахдаа өрхийн орлогын бүтэц, орлогын хэмжээ, түүний хүрэлцээ, хуримтлал зэргийг авч үзсэн.

Өрхийн орлого нь үндсэн ажлын хөлс (35.7%), тэтгэвэр тэтгэмж (32.3%), худалдаа наймаа, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого (10.4%), МАА эрхэлсэн орлого (12.9%), бусдын тусламж, дэмжлэг (4.9%), газар тариалангийн (2%), бусдад зээлсэн мөнгө, хадгаламжийн хүү (1.8%) зэрэг эх үүсвэрээс бүрдэж байна. Хөдөлмөр эрхэлдэг хүнгүй өрхийн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх

³⁷ Тэгэхдээ энэхүү судалгаа нь нэг талаар цаг хугацааны хувьд цар тахлын үетэй давхцсаны улмаас хүмүүсийн өгсөн мэдээлэлд тэр үеийн нийгмийн сэтгэл зүйн таатай бус байдал нөлөөлсөн, нөгөө талаас түүврийн төлөвлөсөн хэмжээнээс 2.5 дахин цөөн хүн судалгаанд хамрагдсан тул судалгааны дүнг тухайн цаг хугацаа, тэрхүү орон зайн хүрээнд л авч үзэх боломжтой.

³⁸ Ядуурал, өрхийн орлого, зарлага, дундаж хэрэглээ. АДТ. // <https://www.1212.mn/> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Мэдээлэл шинэчилсэн хугацаа: 2021-04-22

хувь бусад өрхийнхтэй харьцуулахад мэдэгдэхүйц их (21.6) харин МАА-н бүтээгдэхүүнээс олох орлого арай илүү байв.

Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлого 1.314.190 (хамгийн их давтагдсан утга 1.000.000) төгрөг бөгөөд түүнээс зээл төлөөд үлдэж буй сарын дундаж орлого 783.170 (моод утга 500.000) төгрөг буюу өрхийн нэг гишүүнд 204483 төгрөг ногдоно. 2020 оны байдлаар нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ нь амьжиргааны доод түвшинтэй харьцуулбал 184787 төгрөгнөөс доош хэрэглээг ядуу гэж тооцон тухайн үеийн ядуурлын шугамнаас 20000 төгрөгөөр илүү. Өрхийн нэг хүнд ногдох сарын мөнгөн орлогыг тэдний хариултад тулгуурлан тооцоход, нэг хүнд ногдох сарын дундаж орлого 401629 төгрөг, тавин хувь нь 300000-аас доош харин бусад нь түүнээс дээш орлоготой, сардаа 200000 төгрөгийн орлоготой хүмүүс хамгийн олон. ... өлөн зэлмүүн амьдралтай, орлого маань яагаад ч хүрэлцдэггүй гэж хариулсан иргэдийн сарын дундаж орлого 558,076 байгаа бол чинээлэг талдаа, ердийн орон сууц, байр, байшин авахад хүрэлцээтэй гэж хариулагсдынх 2,408,928 болж өсч байв.

Судалгаанд оролцогчид өөрсдийн өрхийн орлогын хүрэлцээг үнэлсэн субъектив үнэлгээнд үндэслэн дундаас дээш, дунд, дундаас доогуур, доод гэсэн дөрвөн хэв маягт хуваан авч үзсэн. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 16.1 хувь нь доод, 28.1 хувь нь дундаас доош, 52.6 хувь нь дунд, 3.2 хувь нь дундаас дээш түвшинд амьдарч байна.

Судалгаанд оролцогчдын 71.1 хувь нь хадгаламж, хуримтлал байхгүй гэж хариулжээ. Харин 15.1 хувь нь бий, хуримтлалаараа 1 жил хүртэлх хугацаанд амьдрах боломжтой, 13.8 хувь хуримтлалтай боловч үүгээр мөн хугацаанд амьдрах боломжгүй гэв. Суурьшлын байдлаар нь харьцуулахад хадгаламж, хуримтлалгүй иргэд хөдөө орон нутагт хотынхоос 3.8 хувиар илүү байсан бол хуримтлалтай иргэд хотод арай их байдаг.

Судалгаанд оролцогч бараг гурван хүн тутмын нэг нь өр зээлгүй байхад 70.8 хувь нь өр зээлтэй, үүнээс 42.8 хувь нь бүрэн төлөгдөөгүй банкны зээл, 11 хувь нь хувь хүмүүст өртэй, 9.4 хувь нь ББСБ, ломбарданд барьцаат зээлтэй, 5.8 хувь нь ажлын газартаа бүрэн төлөгдөөгүй зээлтэй, 1.8 хувь нь бусад эх үүсвэрээс зээлсэн өртэй байв. Иргэдийн зээл дунджаар өрхийн орлогын 42.2 хувийг эзэлж, үүнээс илүү гарахад эргэн төлөлт хүндэрч байна. Тухайлбал, зээлийн эргэн төлөлт огт хүндрэл үүсгэдэггүй гэж хариулсан иргэдийн зээлийн хэмжээ өрхийн орлогын 31.9 хувийг эзэлжээ. Ийнхүү судалгаанд хамрагдсан 10 өрх тутмын 7 нь өр зээлтэй, 4-5 өрхийн хувьд зээлийн эргэн төлөлт хүндрэл учруулж байгаа байгаа дүр зураг ажиглагдав.

Өрхийн амьдарч буй сууцны нөхцөлөөр нь гурван бүлэгт хуваан авч үзсэн бөгөөд тэдний 30.8 хувь нь орон сууцанд, 62 хувь нь бие даасан сууцанд, 7.2 хувь нь түрээсийн болон бусад хэлбэрийн сууцанд амьдарч байна.

Арван өрх тутмын дөрөв нь хувийн хашаа байшинтай, 15.6 хувь нь малтай, гуравны нэг гаруй нь машинтай, дөрөвний нэг нь гэр түүнчлэн 8.8 хувь нь хувьцаа эзэмшдэг, 9.0 хувь нь хадгаламжтай байв. Хувийн дэлгүүр аж ахуйн нэгжтэй, амьдарч буй байрнаас гадна өөр байртай өрхүүд байхын зэрэгцээ 5.3 хувь нь өөрийн гэсэн өмчгүй гэжээ. Газраа хувьчилж авсан айл 138 (нэг айлд 0.22 га), бод

малтай айл 127, бог малтай айл 117 байгааг дундажлан бодвол малтай нэг айлд 40 бод, 216 бог ноогдоно. Ялангуяа хот аймгийн төвд оршин суудаг мал бүхий иргэдийн тоо хөдөөгийнхөөс цөөн хэдий ч өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд бод малын тоогоор хөдөөгийн суурингийн оршин суугчдаас дутуугүй байх боломжтой нь хүснэгтээс харагдана.

К дунджийн кластер шинжилгээний аргыг (эрэмбийн хэмжүүрээр) хэрэглэн судалгаанд хамрагдагсдыг гурван бүлэг болгон хуваавал, *нэгдүгээрт*, дээрх бүх эдлэл зүйлсийн хангамж хийгээд хуучирч муудаагүй зэрэг чанарын үзүүлэлтээр илүү өндөр түвшин бүхий эдлэл хэрэглэл бүхий өрх айл 16.9 хувийг эзэлнэ. *Хоёрдугаарт*, дурдсан ихэнх эд зүйлсийн хангамж, хэрэглээ хамгийн бага, хэрэглэдэг хэдий ч тэр нь нэлээд хуучирсан эд зүйлсийн хангамж багатай минимал амьдралын хэв маягийг баримтлагч 45.2 хувьтай байна. Тэд хурдан удмын морь, уран зураг урлагийн бүтээл зэрэг зарим цөөн зүйлийн хэрэглээгээр дундаж хангамж бүхий өрхөөс ялимгүй илүүтэй байв. *Гуравдугаарт*, харин ихэнх эд зүйлсийн хангамж хийгээд эдлэж хэрэглэсэн хугацаагаар нөгөө хоёр бүлгийн дунд байрлах өрхүүд 37.9 хувийг бүрдүүлжээ. Удаан эдэлгээтэй эд хогшил, гэр ахуйн техник хэрэгслийн хангамж өндөртэй нэгдүгээр бүлэгт хүйсийн хувьд эмэгтэйчүүд (61.8%), дээд боловсролтой (59.2%), тогтмол ажилтай хүмүүс (63.2%), төрийн байгууллагад ажиллагсад (32.2%), хувийн компанийн ажилтнууд (22.4%) хот суурингийн төвд амьдрагсад (51.3%), өрхийн бүтцийн хувьд нийлмэл гэр бүл (28.3%) түлхүү хамрагдсаныг харьцуулсан хүснэгтээс харж болно.


Асуух аргаар авсан судалгааны өгөгдөлд шинжилгээ хийсэн дүнгээс үзэхэд 10 өрх тутмын 3 нь мөнгөн орлогоороо амьжиргааны доод түвшинд буюу ядуурлын байдалд амьдарч, 44.2 хувь нь өрхийн орлогын хэмжээндээ сэтгэл хангалуун бус, 10 өрх тутмын 7 нь өр зээлтэй, 4-5 өрхийнх нь зээлийн эргэн төлөлт хүндрэл учруулж байгаа дүр зураг ажиглагдав.

Хот, хөдөөгийн төв сууринд оршин суугчдын дунд байр сууцаа тохижуулах, халуун хүйтэн ус, инженерийн шугаманд холбох, гэрийн мод, дэвсгэр бүрээсээ шинэчлэх тулгамдсан хэрэгцээ үүссэний дээр ялангуяа гэрт амьдрагчдын байр сууцны нөхцөл чанартаа өгсөн үнэлгээ хамгийн бага гарчээ. Ялангуяа сумын төвд оршин суугчдын сууцны нөхцөл нийслэл хот, аймгийн төвийнхөөс мэдэгдэхүйц доогуур байгааг судалгааны дүн харуулав. Судалгаанд оролцогчдын тэн хагас нь эдийн засгийн нөөцгүй, 17 хувь нь боломжийн нөөцтэй, тэдний зөвхөн 6 хувь нь нөөцөө капитал болгон ашиглаж байна хэмээн хэлж болох юм. Хүмүүсийн амьдралаа бүхэлд нь үнэлэх үнэлгээнд хоол хүнс, хувцас хунарын хангамж, амьдарч буй газрын орчин нөхцөл, тав тух, аюулгүй байдал зэрэг анхдагч хэрэгцээ зонхилох байр суурь эзлэсээр байна.

Материаллаг хомсдолын нэгдсэн индекс байгуулахын тулд “Бүлэглэгдсэн хувьсагчийн гол хэсгийн шинжилгээний арга”-ыг хэрэглэн гол хэсгийн ачаалал нь 0,3–аас их, хэмжээс нь нэг байхад Кронбахын альфа 0,7-аас их байх шалгуурыг хангасан 15 илтгүүрийг ашиглан материаллаг хомсдолын нэгдсэн индекс бодож үзэхэд дунджаар нэг айл өрх 3-4 шинжээр гачигдал, хомсдолд өртсөн. Хомсдолын шинжүүдээс хадгаламж хуримтлалгүй (71.1), гэнэтийн зардал (57.4), эмнэлэг эмчилгээний төлбөр (51.6) төлөхөд хүнд, маш хүнд гэж хариулсан нь

хамгийн өндөр хувьтай гарчээ. Судлагдагсдын 10 хувьд материаллаг хомсдолын дээрх шинжүүд байхгүй гэсэн бол 10 хүн тутмын 9 нь ямар нэг хэмжээгээр эд өлгийн зүйлс, мөнгө төгрөгөөр гачигдаж дутагддаг болох нь харагдав.

Зураг 2. Материаллаг хомсдолын нэгдсэн индекс



Өнөөгийн нөхцөлд иргэдийн амьдралын нэн чухал анхдагч хэрэгцээг бүрэн хангах явдал тэднийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах чухал хөшүүрэг болох талтай. Түүнчлэн иргэдийн оршин суугаа газрын байршил, ажил эрхлэлт, өрхийн бүтэц, хувь хүний нийгэм хүн ам зүйн зарим шинжүүд тухайлбал тухайн хүний боловсролын түвшин бага байх, төв суурингаас алслагдмал байдал, өрхийн ажилгүй болон түр ажил эрхэлдэг гишүүдийн тоо нэмэгдэх тусам материаллаг хомсдолын индекс өсөх хандлагатай байна. Өрөөсгөл гэр бүл болон олон хүүхдүүдтэй өрхөд материаллаг хомсдол, гачигдалт шинж бусад өрх айлаас илүүтэй илэрчээ. Харьцуулсан хүснэгтээс материаллаг хомсдолын индекс нэмэгдэхэд нийгмийн тусгаарлагдмал байдлын түвшин дагаад өсөх магадлал харагдав.

Бүхэлд нь авч үзвэл Монгол улсын эгэл жирийн олон иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, тохиромжтой цалин хөлс авах, хүнс, хувцас орон сууцыг оролцуулаад амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралын нөхцөлөө байнга сайжруулах зэрэг эдийн засаг, нийгэм соёлын эрх зөрчигдөж, “Төрөөс ... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн Монгол Улсын үндсэн хуулийн заалт бодитой хэрэгжиж чадахгүй байна.

2.5. Нийгмийн шилжилт ба тусгаарлагдах үйл явц

Нийгмийн шилжилт болон нийгмээс тусгаарлагдах үйл явц нь шалтгаан үр дагаврын эргэх холбоонд орших бөгөөд бие биеэ харилцан нөхцөлдүүлж байдаг үзэгдлүүд юм. Нийгмээс тусгаарлагдах үзэгдэл нь нийгмийн шилжилтийн хэвтээ эсхүл босоо чиглэл дэх уруудах хөдөлгөөний үр дагавар, мөн шалтгаан болдог.

НҮБ-аас 1978 онд боловсруулсан амьдралын чанарын шалгуур үзүүлэлтүүдийн тогтолцоонд 1) төрөлт, нас баралтын түвшин болон хүн амын бусад хүн ам зүйн шинж чанар; 2) ариун цэврийн болон эрүүл ахуйн амьдралын нөхцөл; 3) хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ; 4) амьдрах нөхцөл; 5) боловсрол, соёл; 6) хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлт; 7) хүн амын орлого, зарлага; 8) амьжиргааны өртөг, хэрэглээний үнэ; 9) тээврийн хэрэгсэл; 10) амралт зугаалгын

зохион байгуулалт; 11) нийгмийн хамгаалал; 12) хувь хүний эрх чөлөө³⁹ гэсэн 12 үндсэн бүлэг үзүүлэлт багтдаг. Судалгааны хүрээнд амьдралын чанарыг хэмжих объектив болон субъектив үнэлгээнд үндэслэх арга зүйг ашиглан, респондентын амьдралын чанарыг илэрхийлэх 9 багц, 18 нэгж үзүүлэлтийг сонгон эерэг, сөрөг үнэлгээ өгч нэгдсэн индексийг тооцсон.

Зураг 3. Амьдралын чанарын нэгдсэн индекс (хэвийн тархалтад шилжүүлсэн утгаар)



Амьдралын чанарын нэгдсэн индексийг Z хэвийн тархалтад шилжүүлэн, амьдралын чанар доогуур (-1 ба түүнээс доош) 16.2%, тааруу (-1 -0) 30.3%, дундаж (0 - +1) 35.9%, сайн (+1 ба түүнээс дээш) 17.5% гэсэн дөрвөн бүлэгт хуваан авч үзсэн.

Амьдралын чанар болон тусгаарлагдмал байдлын түвшин хоорондын хамаарлын коэффициент нь $r=0.556^{**}$ байгаа нь эл үзэгдлүүд харилцан шууд хамааралтай болохыг харуулна. Тодруулбал, амьдралын чанар буурах тусам тусгаарлагдах, тусгаарлагдалтын гүнзгийрэлтэд өртөх нь нэмэгдэж, амьдралын чанар сайжрах тусам тусгаарлагдалтаас ангид болж, тусгаарлагдалтад өртөх эрсдэл буурч байна.

Нийгмийн тусгаарлагдмал байдлын аль түвшинд байгаагаас үл хамааран тухайн бүлэгт багтаж буй хүмүүсийн олонх нь уруудах чиглэлийн нийгмийн шилжилтэд орж байна. Нэг талаас нийгмээс тусгаарлагдах үйл явц нь босоо чиглэлийн нийгмийн шилжилтийн уруудах хөдөлгөөний шалтгаан юм. Нөгөө талаас тусгаарлагдмал байдал нийгмийн бүтцийн дундаас доош, доогуур бүлэгт зонхилж байгаа нь эл үзэгдлийн нийгмийн бүтцэд үзүүлж буй үр дагавар болно. Харин эсрэгээрээ нийгмийн шилжилтийн өгсөх чиглэлийн хөдөлгөөнд оролцогчдод тусгаарлагдмал байдал, түүний шинж ажиглагдахгүй байна.

Нийгмийн тусгаарлагдмал байдлын гүнзгийрэлтээс гарах, эрсдлийг бууруулахад нийгмийн бүтцийн өгсөх чиглэлийн мобиль хөдөлгөөнийг дэмжих, уруудах эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Үе хоорондын шилжилт хөдөлгөөнийг шинжлэхэд мэдээлэл төдийлөн хангалттай биш боловч байгаа тохиолдлуудад шинжилгээ хийж үзэхэд

³⁹ OECD. Quality of life. Well-Being indicators. [47918063.pdf \(oecd.org\)](https://www.oecd.org/dataoecd/47/91/47918063.pdf)

тусгаарлагдмал бүлэгт үе хоорондын хөдөлгөөн хязгаарлагдмал байгаа нь ажиглагдсан. Өөрөөр хэлбэл тусгаарлагдмал бүлэгт үе хооронд (эцэг/эх – би – үр хүүхэд гэсэн гурван үечлэлийн хүрээнд) нийгмийн байр суурь, статус хийгээд тусгаарлагдмал байдлын шинж, онцлог хадгалагдах шинжтэй байв. Энэ нь тусгаарлагдмал бүлэгт харъяалагдаж буй хүмүүс тэрхүү байр суурь, нөхцөлөө өөрчлөх, дээшлүүлэхэд хүндрэлтэй, нээлттэй тэгш боломж хомс болохыг харуулж байна.

2.6. Нийгмийн капитал ба тусгаарлагдах үйл явц

Нийгмийн тусгаарлагдалт ба нийгмийн капиталын талаарх ойлголт яригдаж хэрэглэгдэх болсон, судалгааны идэвхтэй сэдэв болсон хугацаа зөрүүтэй ч хол зөрүүгүй юм. 2000-аад оноос шинжлэх ухааны судалгаа, улс төр бодлогын хэлэлцүүлэгт улам бүр анхаарлын төвд орж ирснээс хойш судлан шинжлэх хүрээ, судалгааны ач холбогдол нь улам бүр өргөжсөөр байна. Тухайлбал, нийгмийн капиталын ойлголтыг авч үзэж, судлах нь эдийн засаг, нийгмийн үзэгдлийг тайлбарлахад ач холбогдолтой болохыг судлаачид хүлээн зөвшөөрдөг тийм ч учраас 2000 оноос хойш нийгмийн капиталын онолын болон эмпирик судалгааны бүтээлүүд нэмэгдсэн. Нийгмийн капиталын судалгаа ч засаглалын болон эдийн засгийн хөгжлийн тогтвортой, үр дүнтэй байдалд нийгмийн капитал нь биет болон хүний капиталаас илүү чухал болохыг харуулдаг [1].

Нийгмээс тусгаарлагдалтыг судлах нь мөн нийгмийн нэгдэл нягтралыг хангах, нийгмийн тогтвортой байдал, хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой. Түүнчлэн нийгмээс тусгаарлагдаж орхигдох шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, хамрах хүрээг тодорхойлох нь нийгмийн тусгаарлагдалтын бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн бодлогыг үнэлэхэд тустай. Нийгмийн тусгаарлагдалтын үзэл баримтлал нь ядуурал, хомсдолын судалгаа шиг зөвхөн материаллаг хомсдолоор хязгаарлах бус нийгмийн эрх нь хангагдахгүй байх, оролцоо бага, хэм хэмжээ, соёлын интеграцийн дутагдал, нийгмийн харилцаанаас тусгаарлагдах гэсэн өргөн хүрээнд асуудлыг авч үзэж тайлбарлахыг эрмэлзэж байгаа болно. Бодлогын хүрээнд аль нэг асуудлыг хэлэлцэхэд нөгөө асуудал нь яригдах нь нэн түгээмэл байдгаас үзэхэд ч эдгээр нь харилцан холбоотой үзэгдэл үйл явц гэдэг нь харагддаг. Нийгмийн тусгаарлагдалтын эсрэг эм нь нийгмийн капитал бөгөөд үүнтэй адил нийгмээс тусгаарлагдах нь нийгмийн капиталын нөөцийг шавхдаг [2] гэж зарим судлаач дүгнэдэг.


Тусгаарлагдалтад нөлөөлөх дотоод болон гадаад хүчин зүйлийг судлах арга зүйн дагуу [30] бид тусгаарлагдалтын индекс байгуулахдаа эдийн засгийн тусгаарлагдалт, нийгмийн үйлчилгээнээс тусгаарлагдах, иргэний болон нийгмийн амьдрал, сүлжээнээс тусгаарлагдах гэсэн тус бүр нь 8 нийтдээ 24 индикатораас бүрэлдэх гурван багц үзүүлэлтийг хэрэглэн хэмжилт (гурван хэмжээст) хийсэн [31]. Энэ аргачлалаас “Иргэний болон нийгмийн амьдрал, сүлжээнээс

тусгаарлагдах” хэмжигдэхүүн нь дараах 8 хэмжихүүнээр тодорхойлж авч үзсэнээс 7 нь нийгмийн капиталын хэмжигдэхүүнтэй нэг ижил үзүүлэлтүүдээс бүрдэж буй.

Иргэний болон нийгмийн амьдрал, нийгмийн харилцаа, сүлжээнээс тусгаарлагдах. Судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 9 нь ямар нэг байгууллага, бүлгийн гишүүнчлэлгүй байгаагаас ардчилсан нийгэм дэх иргэний болон нийгмийн харилцаанаас хөндийрөх хандлагын хамгийн гол үзүүлэлтийн тоонд оржээ.

Харин гэр бүл ойр дотныхоо хүмүүстэй харилцдаггүй эсвэл бага харилцдаг гэсэн хүний эзлэх хувь (4.7 хувь) харьцангуй цөөн байгаа ч онцгой тохиолдолд тусламж гуйж хандах хүн байхгүй эсвэл их цөөн гэсэн хариулт 47.2 хувьтай, бусадтай харилцаатай байх, танил талын хүрээгээ өргөжүүлэхэд анхаарал тавихгүй байх (35.8%) явдал элбэг тохиолддог, улс төрийн үйл ажиллагаанд (сонгууль г.м) оролцдоггүй хүмүүсийн тоо төдийлөн буурахгүй байгаа (21.7%) зэрэг нийгмийн харилцааны хомсдолын шинжүүд мэдэгдэж байна. Нэг хүн дунджаар нийгмийн харилцааны 2.5 хомсдолт шинжтэйн дээр 8 илтгүүрээс аль нь ч хомсдолд өртөөгүй хүн бараг байхгүй, нийгмийн харилцааны 7 гачигдал хомсдол бүхий шинжтэй хүмүүс ч бас гарчээ.

Зураг 4. Нийгмийн оролцооны тусгаарлагдалт



Нийгмийн харилцааны 8 илтгүүрээр гарсан дүнг нэгтгэн үзэхэд судлагдагсдын 3.3 хувьд хомсдолын дээрх шинжүүд байхгүй, 2 хомсдолт шинж бүхий хүмүүс хамгийн олон, 8 илтгүүрээс тэн хагасаас багагүйд нь гачигдалд өртсөн хүмүүсийн эзлэх хувь 22.3 байна (зураг 1).

Нийгмийн тусгаарлагдалтын гурван хэмжигдэхүүн тус бүрээр дундаж индекс тооцож үзэхэд, нийгмийн үйлчилгээнд эс оролцогчид хамгийн олон, дараа нь нийгмийн оролцоо, сүлжээнээс хөндийрөгчид, эцэст нь эдийн засгийг харуулах үзүүлэлтээр гачигдал хомсдолд өртөгсөд орсон байна. Тооны хувьд нийгмийн оролцооны хувьд 7 илтгүүр нь сөрөг утгатай. НҮБХХ-ийн хөтөлбөрийн судлаачид нийгмийн тусгаарлагдалтын ерөнхий индексийг энэхүү гурван хэмжээсийг нэгтгэн тооцоод хоёроос доошгүй хэмжээсийн илтгүүр нь хомсдолтой байвал (өөрөөр хэлбэл 24 илтгүүрээс 9 болон түүнээс дээш шинжээр хомсдолтой бол) тэдгээр хүмүүсийг нийгмийн тусгаарлагдалтад өртсөн гэж тооцсон юм. Судлагдсан хүмүүсийн 31 хувь нь нийгмээс хөндийрөх, тусгаарлагдах, нийгмийн амьдралд оролцоогүй, эс хамрагдах хандлага илэрч байна. Нэгдсэн индексийн тархалтыг нэгж хэвийн тархалтад шилжүүлэн, +1-ээс их завсарт харъяалагсдыг (11-19 хомсдолт шинжтэй) социаль тусгаарлагдалтанд өртөгсөд гэж үзвэл тэдгээр нь 15.7 хувийг эзэлж байна. Эдгээр хүмүүсийг дунд, ахисан, гүнзгий түвшинд

тусгаарлагдагчид хэмээн үзэж болох юм. Тэгвэл үлдэх 15.3 хувь нь тусгаарлагдалтын өмнөх шатанд байгаа иргэд болно.

Нийгмийн капиталын хэмжигдэхүүнүүд дээр дурдсан нийгмийн оролцоо(2), нийгмийн харилцаа(2), нийгмийн сүлжээ(2), аюулгүй байдал, ерөнхий итгэл, гишүүнчлэл гэсэн 9 илтгүүрээр хэмжиж индекс бодож, нийгмийн капиталын индексийн тархалтаар судалгаанд оролцогчид нийгмийн капиталын хувьд 6 бүлэгт хуваагдаж байна. Үүнд: 1) нийгмийн капиталгүй 0,7 хувь; 2) маш муу капиталтай 3,6 хувь; 3) нийгмийн капитал тааруу бүлэг 17.3 хувь; 4) нийгмийн капитал дунд зэрэг 15,3 хувь; 5) нийгмийн капитал боломжийн 46,9 хувь; 6) нийгмийн капитал сайтай бүлэг 15.6 хувь байв.

Тусгаарлагдмал байдлын индексийн тархалтаар тусгаарлагдалтын түвшинг 5 хэв шинжид хувааж үзэн тэдгээр бүлгүүдэд нийгмийн капитал хэр байгааг шинжлэхэд тусгаарлагдаагүй бүлгийнхэн хамгийн нийгмийн капитал сайтай нь байгаа бөгөөд тусгаарлагдмал байдлын түвшин өндөрсөх тусам нийгмийн капитал тааруу болж байна. Тусгаарлагдсан түвшин ба нийгмийн капиталын байдлын хооронд урвуу хамааралтай ($r=-.493$; $p<.05$) байв.

Тусгаарлагдаагүй бүлгийн 52,3 хувь нь нийгмийн капитал боломжийн болон 21,3 хувь нийгмийн капитал сайтай байгаа бол тусгаарлагдалын дунд түвшинд ийм хүмүүс 33,3 ба 3,7 гэсэн харьцаатай. Харин ахисан, гүнзгий тусгаарлагдсан бүлгүүдэд нийгмийн капитал боломжийн, сайн байгаа хүмүүс маш бага буюу огт байхгүй, ахисан түвшинд тусгаарлагдсан хүмүүсийн 1/10 нь нийгмийн капиталгүй, 55.6 хувь нь нийгмийн капитал маш муу болон тааруу түвшинд, гүнзгий түвшинд тусгаарлагдмал байгаа хүмүүсийн хувьд 93,3 хувь нь нийгмийн капитал маш муу болон тааруу түвшинд байна.

2.7. Ядуурал ба нийгмийн тусгаарлагдах үйл явцыг судлах нь

Ядуурлын ойлголтоор дамжуулан нийгмийн эмзэг бүлгийн нөхцөл байдлыг тайлбарлах нь хангалтгүй байгаа учраас social exclusion гэсэн ойлголтыг социологичид хэрэглэх болсон ялангуяа Европын холбооны орнуудад өргөн ашиглаж байна.

Social exclusion буюу нийгмийн тусгаарлагдмал байдал хэмээн ойлголт нь ядуурлын судалгаан дээр суурилсан, динамик чанартай үзэгдэл. Энэ нь хувь хүн, айл өрх, нийгмийн бүлгүүдийн суурь боломжийн хязгаарлагдмал байдлыг тодорхойлдог. Тусгаарлагдмал байдалд орсноор хүмүүс олон жилийн турш нийгмийн дийлэнхийн хүртэх боломжтой төрөл бүрийн үйлчилгээ, нийгмийн сүлжээ, хөгжлийн боломжоос гадуур байдаг. Тус ойлголт ядуурал ба бага орлого, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх хязгаарлагдмал боломж, нийгмийн дэмжлэг бага эсвэл дутмаг, оршин суугаа газар, амьдрах орчны ерөнхий байдал нь тааруухан, нийгмийн үйлчилгээ авах эрхтэй хүмүүсийн тооноос хасагдах байдал гэсэн таван үндсэн үзүүлэлттэй холбоотой.

“Ядуурлын соёл” гэсэн ойлголтыг АНУ-ын Иллиной их сургуулийн антропологийн профессор О.Льюис 1959 онд анх шинжлэх ухааны эргэлтэнд оруулсан. Тэрбээр 1950-1960-аад онд Латин Америкийн хөдөөгийн амьдралыг

судалж тухайн үеийн ядуурлын социологийн судалгаанд болон улс төрийн бодлогод том хувь нэмэр оруулсан билээ. Ядуурлын соёл гэсэн ойлголтоор дамжуулан ядуу хүмүүсийн сэтгэл зүйн шинж тэмдгийг тодорхойлох анхны оролдлогуудын нэг байсан. О.Льюис ядуурлын түвшинг багасгах төрийн бодлогыг шүүмжилж, нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь үр дүнгүй, амжилтанд хүрээгүй хэмээн дүгнэжээ. Төрийн халамжийн хөтөлбөрийн үр дүнгүй байдал нь доод болон дунд ангийн харилцаа холбоо сул, хэт ялгаатай байдагтай холбоотой. Ойлголтын хувьд ядуурлын соёл гэдэг нь нийгмийн, соёлын, сэтгэл зүйн болон материаллаг хангамжийн хомсдолтой амьдралын хэв маягийн нэг хэлбэр гэж тодорхойлсон байдаг.⁴⁰ (М.В.Ефремова 2014.)

Ядуурлын дэд соёлын агуулга, шинж чанарыг ил болгох, тухайн дэд соёлыг тээгчдийг тодруулах үйл явц нэгэн зэрэг явагдаж байв. Нийгмийн ёроолын амьдралын талаарх дэлгэрэнгүй тайлбарт ядуурлыг аж үйлдвэрийн нийгмийн үзэгдэл гээд 2 зүйлээс улбаатай хэмээн тайлбарлажээ. Үүнд нэгдүгээрт, ядуурал нь нийгмийн нөхцөл байдал ба капитализмын сул талын үр дүнд бий болсон, хоёрдугаарт, хүмүүний мөн чанарын сул талаас (архидалт, залхуурал гэх мэт) үүдэлтэй гэжээ. Ерөнхийдөө ядуучууд болон ажилчин анги буюу мэргэжилгүй ажилчдыг ижил утгаар авч үзэж байв. “Ядуурлын соёл” -ын онолыг гаргасан судлаачид ч ядуучуудыг ажилчин (А.Дэйвис) эсвэл аж үйлдвэржсэн нийгмийн доод ангид (В.Миллер) багтааж байжээ. Тухайн үеийн нийгмийн давхраажилтын схемийн анализ шинжилгээнд ядуучууд гэсэн ойлголтыг ашигладаг байсан. Гэвч “ядуу” гэдэг ойлголт нь цэвэр бүтцийнх биш бөгөөд субъектив мэдрэмжийг агуулж, тухайн нийгмийн үнэт зүйлсийн систем дэх ядуучуудын байр сууринаас хамаардаг. Жишээлбэл, дундад зууны үед хүн амын хамгийн доод давхарга ч өөрийгөө ядууд тооцдоггүй байсан бөгөөд ядуурал нь тухайн нийгмийн хэм хэмжээ байсан. Нийгмийн мобил хөдөлгөөн өндөртэй аж үйлдвэржсэн, чөлөөт зах зээлтэй нийгэмд л “орчин үеийн” ядуучууд гарч ирж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, баян болох боломж ч байхгүй, хүсэл ч байхгүй хүмүүс гарч ирсэн. О.Льюис нийгмийн доод давхарга дундын “ядуурлын соёлыг” чөлөөт зах зээлийн нийгэмтэй холбож үзсэн. Ажилгүйдлийн түвшин өндөртэй, хувь хүний амжилт, ажлын дэвшил үнэлэгддэг нийгэмд л ядуурлын соёл бий болдог гэжээ. О.Льюисын хувьсгалын өмнөх ба дараах үед Кубад хийсэн судалгааны дүнгээр ядуурлын соёл социализмын нийгэмд бий болох боломжгүй гэжээ. Учир нь хүмүүс хувьсгалаас өмнөх үеийнх шиг ядуу, заримдаа ядуусын хороололд амьдардаг байсан ч тэдгээрт ядуурлын дэд соёлын шинж тэмдэг болох сонирхолгүй, идэвхгүй, сул дорой байдал ажиглагдаагүй байна. Льюисийн тодорхойлсон загварууд нь Уорнер ба түүний дагалдагчдын “нийгмийн доод анги” буюу хамгийн сул дорой, зохион байгуулалтгүй бүлгийн зөвхөн нэг хэсгийг л авч үзсэн. Үүгээр “ядуурлын соёл”-д автагдсан нийгмийн хүрээ нь багасан, зөвхөн байнгын ядуу байдаг хүмүүс л багтах болсон⁴¹ (С.С.Ярошенко 1994).

⁴⁰ М.В.Ефремова, И.О.Патоша, О.В.Полуэктова. Основные подходы к изучению феномена бедности в зарубежных психологических исследованиях. Современная зарубежная психология. Т. 3, №3/2014.

⁴¹ Ярошенко С. С. Синдром бедности. // Социологический журнал, 1994. Том. 0. № 2. С. 43-50. Электрон эх сурвалж: <https://www.jour.isras.ru/index.php/socjour/article/view/64>

Харин 1960-70-аад онд тухайн үзэл баримтлалын хүрээнд “ядуурлыг тээгч”-ээр үндэстний цөөнхийг (жишээлбэл, Америкийн хар арьстнуудын доод анги) төсөөлж байсан. Түүний дараа янз бүрийн үндэстний ядуучуудын амьдралын хэв маягийн ижилсэг байдлыг тогтоосноор тухайн үзэл баримтлалыг дэмжсэн судлаачдын тоо нэлээн багассан. Тиймээс ядуучуудын соёлыг судлахад ядуучууд гэсэн ойлголт нь тодорхоогүй, нийгмийн ямар давхаргад оруулах нь ялгаатай байдаг. Нийгмийн бүтцэд ядуучууд ямар байр суурь эзэлж байгааг авч үзэхэд зөвхөн багахан хэсэг нь л өөрийн гэсэн нийгмийн олонхоос ялгаатай тусгай дэд соёлтой гэж дүгнэж байна.⁴²

Ядуу хүмүүс нийгэмд бүрэн оролцохыг хориглоогүй боловч нийгмийн идэвхтэй оролцоо нь сул байдаг. Учир нь тэд өөрийн хүслээр бусдаас зайгаа барьж нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хэрэгтэй гэж үздэггүй. Дэлхий даяар олон сая хүн илүү орлоготой, мөнгөтэй болоход аливаа нэгэн хүчин чармайлт гаргадаггүй гэжээ. Тэдний бодлоор илүү сайхан амьдрах боломж угаасаа байхгүй, хуучнаараа амьдарсан нь дээр байдаг. Мөн ядуу, сул дорой байдалд хувь хүн өөрөө буруутай бөгөөд бодит байдал дээр амьдралаа өөрчлөх дургүй.

Шинэ цагийн нийгмийн сэтгэлгээний түүхэнд К.Маркс андерклассын асуудлыг анхлан тавьсан хүмүүсийн нэг юм. Марксын "хөдөлмөрийн нөөц арми" гэсэн ойлголт нь "андеркласс" гэсэн нэр томъёотой агуулгын хувьд нийцдэг. Маркс энэ нийгмийн бүлэгт *насны улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан өндөр настай ажилчид; ажил хайж хот руу нүүж ирсэн хөдөө орон нутгийн ажилчид; тогтмол орлогогүй хүмүүс; хотын ядуусын хамгийн доод шатны ядуучууд болон ажилгүй бүх хүмүүс; люмпен пролетариат буюу гэмт хэрэгтэн, биеэ үнэлэгчид, тэнүүлчид* гэсэн таван дэд бүлэг багтдаг хэмээсэн. Орчин үед "андеркласс" гэсэн ойлголтод Марксын үеийн "ядуучууд", "люмпен пролетариат", "бүдүүлэг ядуучууд" гэж нэрлэгддэг бүлгүүд багтдаг. Америкийн шинжлэх ухааны нийгэмлэгт андерклассыг юуны өмнө нийгмийн олонхоос дор амьдардаг үндэстэн, арьс өнгөний цөөнхөөс бүрдсэн хүн амын давхарга гэж ойлгодог. Өөрөр хэлбэл, андеркласс нь ядуучуудыг хооронд ялгаж ядуучуудын давхраажлыг илэрхийлсэн ойлголт юм. Европт андерклассыг голчлон ямар нэгэн шинж тэмдгээр хязгаарлагдмал тусгаарлагдсан нийгмийн бүлэг, давхарга гэж ойлгодог. Үүний зэрэгцээ андерклассд нэг төрлийн хүмүүс багтдаггүй учраас Маркс болон Веберийн үзэл баримтлалын дагуу анги гэж ойлгодоггүй.

Английн социологич П.Саундерс нийгмийн үйлдвэрлэлд оролцдоггүй бүх хүмүүсийг андерклассд оруулах нь хамгийн түгээмэл үзэл бодол гэж үздэг. Андерклассын ихэнх төлөөлөгчдөд орчин үеийн нийгэмд босоо хэлбэрийн нийгмийн шилжилтийн гол суваг болох мэргэжил, боловсрол дутагдаж байна. Орчин үеийн социологичид андерклассын дөрвөн үндсэн шинж чанарыг ялгаж үздэг. Үүнд: материаллаг гачигдал, нийгмийн маргиналь байдал, төрийн

⁴² Ярошенко С. С. Синдром бедности. //Социологический журнал, 1994. Том. 0. № 2. С.43-50. Электрон эх сурвалж: <https://www.jour.isras.ru/index.php/socjour/article/view/64>

дэмжлэгээс бүрэн хамааралтай байх, хувь заяанд найддаг дэд соёл⁴³ (Ё.Ундрал 2015).

Андеркласс буюу ядуучууд нь эмзэг, сул дорой, бусдаас хэт хамаарсан, өөрийгөө голж, өөрийгөө удирдаж чаддаггүй, хяналтгүй, ирээдүйгээ төлөвлөх чадваргүй, хувь заяанд бүрэн найддаг хүмүүсээс бүрддэг байна.

Ядуурал бол хувь хүн эсвэл нийгмийн бүлгийн эдийн засгийн нөхцөл байдлын шинж тэмдэг бөгөөд тэдгээр нь амьдрах, хөдөлмөрийн чадвараа хадгалах, үр удмаа хадгалахад шаардлагатай хамгийн бага хэрэгцээний тодорхой хүрээг хангаж чадахгүй байна. Улс орнуудын ядуурлын түвшинг үнэлэхдээ мэргэжилтнүүд ихэвчлэн ДНБ эсвэл нэг хүнд ногдох ДНБ зэрэг үзүүлэлтүүдийг ашигладаг. Гэсэн хэдий ч бодит байдал дээр тухайн улсын орлого хүн амын дунд жигд бус хуваарилагдах боломжтой байдаг тул эдийн засагчид ядуурлын шугамаас доогуур амьдарч хүн амын тоог тодорхойлдог нь илүү оновчтой тооцоолол юм. Дэлхийн 167 орноос Монгол улс ядуурлын түвшнээр 95 дугаар байр (2018 оны тооцоогоор) эзэлсэн бөгөөд хамгийн сүүлд Африкийн орнууд, хамгийн ядуурал багатайд нь Европын орнууд тэргүүлж байна⁴⁴.

Ядуурлыг бууруулах арга хэмжээг дэлхийн бүх орнуудын засгийн газрууд авч байгаа бөгөөд үр дүнтэй арга хэмжээг голдуу хөгжиж буй орнууд л хэрэгжүүлж чадаж байна гэдгийг дээрх мэдээллээс харж болно. Тиймээс улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг дээшлүүлснээр ядуурлыг бууруулах боломжтой юм. Ядуурал нь аж үйлдвэржсэн нийгмийг тодорхойлж буй нэг шинж тэмдэг бөгөөд статик үзүүлэлт юм. Анх Англид ядуурлын судалгаа хэрэгжүүлж эхлэхэд ядуурлын шугам, амьжиргааны доод түвшин зэрэг ойлголтыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд постмодерн буюу аж үйлдвэржилтийн дараах нийгэмд шинэ ойлголтоор дамжуулан ядуурлын өргөн цар хүрээг тодорхойлох болсон.

Нийгмийн тусгаарлагдмал байдал нь зөвхөн шинжлэх ухааны төдийгүй нийгэм-улс төрийн үзэл баримтлал бөгөөд ХХ зууны дунд үеэс ядуурал, гадуурхал, гачигдалтай холбоотой Баруун Европын дискурст өргөн ашигладаг байсан бөгөөд өнөө үед маш их тархсан. Анх 1950-иад онд Францын улс төрийн мэтгэлцээнд ашигласан хийгээд 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэн үед Европын Эдийн засгийн Холбооны Сайд нарын зөвлөлөөс Европ дахь нийгмийн тусгаарлагдмал байдалтай тэмцэж, интеграци, эв нэгдлийг дэмжих тухай тогтоол баталсан. Европын зарим орнууд тусгаарлагдмал байдлын эсрэг тогтолцоог бий болгосноор Европт өргөн тархсан. Энэхүү үзэл баримтлалыг Их Британид шинжлэх ухаан, улс төрийн хэлэлцүүлэгт хамгийн идэвхтэй ашигладаг бөгөөд 1997 оноос хойш үүнтэй тэмцэх зорилгоор төрийн тусгай байгууллага болох Нийгмийн тусгаарлагдмал байдалтай тэмцэх газар байгуулагджээ.

Манай судалгаагаар тусгаарлагдмал байдлын түвшинг индексийн хэлбэрээр гаргаж үүгээр зөвхөн ядуурлын түвшин бус амьдрах орчны нөхцөл, өрхийн сарын орлогын хүрэлцээ, эзэмшиж буй эд зүйлс, боловсрол мэдлэгээ

⁴³ Ё.Ундрал. Теоретические подходы к изучению андеркласса. Философи, эрхийн судлал. Тод бичиг. УБ., 2015. 152 дахь тал.

⁴⁴ Рейтинг стран по уровню бедности. // <https://nonews.co/directory/lists/countries/poverty-rate>

дээшлүүлэх боломж, мэдээлэл авах байдал, харилцааны сүлжээ зэрэг олон хүчин зүйлийг багтаасан юм.

Нийгмийн тусгаарлагдмал байдалтай холбоотой өөр нэг ойлголт бол “ядуурлын соёл” юм. Энэ нь хэдэн үе дамжсан байнгын ядуу хүмүүсийг тодорхойлох соёлын буюу дэд соёлын үзэл баримтлал юм. Энэхүү ойлголт олон шүүмж дагуулсан боловч судлаачийн байр сууринаас хамаараад ядуучуудын дунд нийгмийн олонхоос ялгаатай дэд соёлын шинж тэмдэг илрүүлэх боломжтой байдаг. Тэдгээрийн гол шинж тэмдэг нь бусдаас хараат байх, амьдралаа төлөвлөх чадваргүй байх, хувь заяанд найдах, өөртөө итгэх итгэл муу байх зэрэг болно. Монгол улсын хувьд ядуучуудын нэг хэсэг нь халамжийн мөнгө хэт хөөцөлдөх, түүнээс хамааралтай болох, үүнтэй уялдан хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байна.

Улаанбаатар хотод нийгмийн тусгаарлагдмал байдал нь хотын сегрегацийн үйл явцтай холбогддог байгаа. Өрхийн сарын орлого, боловсролын түвшин, орон сууцны хэлбэрийн дагуу хотыг гурван хэсэгт хувааж болно. Хотын төв хэсэг нь харьцангуй тусгаарлагдаагүй, дээд боловсролтой, орлого сайтай, орон сууцанд амьдардаг хүмүүс зонхилж байгаа бол хотын төвд ойролцоо хэсэгт дээд, бүрэн дунд болон бүрэн бус дунд боловсролтой, орон сууц болон хашаа байшинд амьдардаг, орлого дунд, захын хэсэгт бүрэн дунд, бага болон боловсролгүй, орлогын түвшин доогуур, тогтмол бус орлогын эх үүсвэртэй, гэр ба хашаа байшинд голдуу амьдардаг хүмүүс зонхилж байна.


2.8. Нийгмийн институтчилэл ба тусгаарлагдмал байдал

Нийгмийн тусгаарлагдмал байдал судлагдахууны хувьд олон хүчин зүйлээс хамаарах динамик шинжтэй үзэгдэл бөгөөд нийгмийн институтийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хамрагдаж буй байдалд үндэслэн тодорхойлох бололцоотой гэж үздэг. Иймд тус бүлэг нийгмийн институтийн зургаан хэв маягийг, шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж тусгаарлагдмал байдлын хамрах хүрээ, гүнзгийрэлтийг тодорхойлохыг оролдлоо.

Судалж буй ойлголт болоод судлагдахуун нь бидний тохиолдолд шинэлэг учир арга зүй, сонгон буй институт, үр дүнг тооцох шалгуур нь оновчтой бус байх магадлалтай ч эл материалаас алдаа оноог нь шүүж цаашид илүү боловсронгуй болгож судлах суурийг тавьж байгаагаараа ач холбогдолтой.


Институтийн түвшинд нэгд соёлын, хоёрт боловсролын, гуравт улс төрийн, дөрөвт эдийн засгийн, тавд нийгмийн харилцааны, зургаад нийгмийн хамгаалын үйлчилгээ орж буй бөгөөд эхний гурван институтийн үйлчилгээнээс иргэдийн дийлэнх олонх нь тусгаарлагдсан шинжтэй байна. Нарийвчилбал, тодорхой нэг үйлчилгээнд соёлын хувьд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдахаас хэтэрдэггүй, боловсролын хувьд залуучууд нийтлэг үйлчилгээний чиглэлээр суралцах, улс төрийн хувьд сонгуульд оролцох зэргээр хязгаарлагдаж байна.

Зураг 5. Оролцоо институтээр



Оролцооны хувьд, нэгэн зэрэг 15 төрлийн үйлчилгээнд зэрэг хамрагдаж буй бөгөөд оролцоо өндөртэй хэсгийнхэн нь 7.0 хувийг бүрдүүлж байгаа бол 55.1 хувь нь 10-12, 35.5 хувь нь 7-9 үйлчилгээнд хамрагдаж байна. Нийгмийн институтийн гадна бүрэн орхигддог хүн гэж байхгүй боловч бидний судалсан баримтаар судалгаанд оролцогчдын 1/3 нь (37.8%) тусгаарлагдсан гэж болохоор байна.


Зураг 6. Институтийн оролцоо: хамгийн ихдээ 21 хүртэл байх боломжтой



Институтээс хамаарах тусгаарлагдалт (Gerd Schienstock and et all 1999)-ын үзэл баримтлалд дэвшүүлснээр үр дүнг нэгтгэн харвал судалгаанд оролцогчдын 6.1 хувь нь дурдсан зургаа, 31.2 хувь нь таван институтийн үйл ажиллагаанд оролцож байна.

Онолын хувьд дөрөв болон түүнээс дээш институтийн үйл ажиллагаанд оролцохгүй байх тохиолдол нь тусгаарлагдалтын хамралт, гүнзгийрэлтийг илэрхийлэх боломжтой бөгөөд энэ нь судалгаанд оролцогчдын 62.6 хувийг бүрдүүлж байна.

Зураг 7. Нийгмийн институтчилэл ба тусгаарлалтын хамралт, гүнзгийрэлт



Зарим тохиолдолд институт бүрээс үйлчилгээнд хамрагдах шаардлагагүй байж болох ч сонирхсон, эсвэл шаардлагатай тохиолдолд үйлчилгээгээ авч чадаж байгаа эсэх нь илүү ач холбогдолтой (дараа дараагийн судалгаанд арга

зүйн хувьд анхаарах О.Б) бөгөөд судалсан баримтаар 20.2 хувь гүнзгий тусгаарлалтад өртсөн бөгөөд шаардлагатай үйлчилгээгээ авч чаддаггүй гэж үзэх бүрэн үндэслэл байна.

Судалсан баримт, үр дүнгээс нэгтгэн дүгнэхэд институтээс хамаарсан тусгаарлалт харьцангуй өргөн хүрээг хамарсан шинжтэй бөгөөд оролцоо нь хувь хүний өдөр тутмын хэрэгцээ (Эдийн засаг: орлого олох, өмчтэй байх г.м) болон нийтийг хамарсан үйл ажиллагаа (Улс төр: сонгуулийн идэвх)-аар, харилцаа нь субъектийн харилцаа тогтоосон бичил бүлгээр хязгаарлагддаг. Сайн дурын болон сонирхлын бүлгийн үйл ажиллагаа, соёлын болоод шийдвэр гаргах түвшний уулзалт, хэлэлцүүлэг дэх оролцоо, идэвх зайлшгүй бус боловч хангалтгүй.

Нийгмийн шинж байдлаар: 35-аас дээш насныхан (35-44 насныхан 24.2%, 45-54 насныхан 19.2%, 55-64 насныхан 17.0%, 65-аас дээш насныхан 6.6%), эмэгтэйчүүд (56.0%), гэр бүлийн хувьд өрх толгойлсон эхчүүд (17.6%), тусгай дундаас доош боловсролтой иргэд (71.4%: үүнээс тусгай дунд 13.2%, бүрэн дунд 44.5%), нийгмийн гарлын хувьд малчид (29.1%), шилжин ирэгсэд болон зах гэр хороолол, хөдөөд амьдардаг иргэд тусгаарлагдалтад өртөх магадлал харьцангуй өндөр.

Бүхэл дүр зургаар нь нэгтгэн харвал нийгмийн институтүүдийн үйлчилгээ хэр хөгжсөнөөс хамаарч тусгаарлагдалт хамралт, түвшин тодорхойлогддог гэсэн дүгнэлтийг хийж болно. Шалтгааны хувьд үүнд нэг талаас институтүүдийн үйлчилгээний хүртээмж, нөгөө талаас хувь хүний идэвх, санаачлага сул байгаатай холбоотой.

2.9. Хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо ба хүртээмжгүй байдал

Ямар нэг зүйлээр дутагдах байдал нь гадуурхалтын ерөнхий хэлбэр гэж Алкок (1997) үзээд, “нийгмийн гадуурхал” хэмээх ойлголтыг орчин цагийн нийгмийн нөхцөл, байдалтай холбон тайлбарлахад нэлээд төвөгтэй гэсэн байна. Харин Кэйзелбах (2000) ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, бага ур чадвар бүхий ажилчид ажилгүйдэлд ихээр өртөн материаллаг болон нийгмийн наад захын стандарт үйлчилгээг авч чадахгүй хүмүүсийн тоо өссөөр байгаа өнөөгийн нөхцөл байдалд “нийгмийн гадуурхал” нь асуудлыг тайлбарлах чухал ойлголт болно гэжээ. Тэрээр “нийгмийн гадуурхалт ” олон хэмжээст, өргөн хүрээг хамарсан ойлголт, үйл явц болохын хувьд түүнд хүмүүний амьдралын нийгмийн болоод эдийн засгийн байдал төлөв төдийгүй, хувь хүний өөрийнх нь болон нийгмийн нөөц бололцооноос хамаарах нөхцөл байдал ч багтана гэж үзсэн. Түүнчлэн “нийгмийн гадуурхал” гэсэн ойлголтыг ажилгүйдэлтэй холбогдох байдлаар нь дараах 6 хэмжигдэхүүнд хуваасан байна. Үүнд: 1) хөдөлмөрийн зах зээлд нэвтрэхэд үүсэх саад, бэрхшээлтэй холбоотойгоор хөдөлмөрийн зах зээлээс тусгаарлагдах, 2) ажилгүй байснаар төрөөс болон гэр бүлийн гишүүдээс санхүүгийн хувьд хамааралтай болох улмаар эдийн засгийн боломжоос гадуурхагдах, 3) ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлого, үйлчилгээ болон боловсролын системийн зохисгүй оновчгүй байдал зэргээс болж эмзэг бүлгийн зарим иргэд зохистой хөдөлмөр эрхлэх боломжоос тусгаарлагдах 4) нийгмийн

сүлжээнд хамрагддаггүй хувь хүн эсвэл бүлгүүд өөрөө өөрсдийгөө тусгаарлах, 5) нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх стандарт үйлчилгээг авч чадахгүй байгаатай холбоотойгоор нийтлэг соёлоос тусгаарлагдах 6) санхүүгийн чадавхи муу ажилгүй иргэд дэд бүтэц сул хөгжсөн эсвэл зарим талаар огт хөгжөөгүй газар оронд амьдарч байгаагаас үүдэлтэй үүсэх орон зайн тусгаарлагдахуй зэрэг болно (П.Бямбадорж, 2010).

Тогтвортой ажил эрхэлдэггүй хүмүүсийг зарим судлаачид прекариат бүлэгт багтаан түүнийг “шинэ аюултай анги”⁴⁵ хэмээн нэрлээд, тийм бүлэгт залуучууд, эмэгтэйчүүд, ахмад хүмүүс, шилжин ирэгсдийн төлөөллийг багтаажээ. Иймээс түр, бүрэн бус ажил эрхлэлт, далд ажилгүйдэл, албан бус ажил эрхлэлт, сүүдрийн буюу “саарал” эдийн засаг гэх мэтээр зарим нэг салангад чиглэлд анхаарлаа хандуулах бус, харин шинэ давхраат бүлэг болохынх нь хувьд прекариат бүлгийг цогц байдлаар судлах шаардлагатайг судлаачид⁴⁶ тэмдэглэсэн байна.

Манай улсын хувьд ажиллах хүчний оролцооны түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшингийн үзүүлэлтүүд 2000 оноос хойш ялангуяа 2007 оноос хойш мэдэгдэхүйц буурчээ. Тухайлбал 2000 онд дээрх үзүүлэлтүүд 61,0%; 58,0 % гэсэн харьцаатай байсан бол, 2018 онд 53,4 % 49.6% болж тус тус буурсан байна. Сүүлийн хорь орчим жилийн хугацаан дахь Монгол улсын ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харуулах статистик үзүүлэлтэд шугаман регрессийн шинжилгээ хийж үзэхэд, доорх төлөв хандлага ажиглагдав⁴⁷.

$$y_1 \text{ (ажиллах хүчний оролцооны түвшин)} = 63.405 - 0.482 x(\text{он})$$

$$y_2 \text{ (хөдөлмөр эрхлэлтийн түвшин)} = 63.174 - 0.585 x(\text{он})$$

Өөрчлөлт энэ хэвээр үргэлжлэх юм бол ажиллах хүчний оролцооны түвшин 2025 онд 50,9 хувь, 2030 онд 48,5 хувь харин хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2025 онд 45,0 хувь 2030 онд 42,0 хувь болтлоо буурах дүр зураг харагдана. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн ам болон ажиллагчдын тооны эзлэх хувийн жин улам буурна гэсэн үг. Ингэвэл хөдөлмөрийн зах зээл дэх иргэдийн оролцоо буурч, түүний гадна үлдэгсэд улам нэмэгдэхэд хүрнэ.

Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үздэг⁴⁸. Иймд ажиллагч гэдэг ойлголтод тогтмол бус орлого цалинтай, түр зуурын ажил эрхлэгчид хамрагдаж буй тул тэднийг хөдөлмөрийн зах зээлд бүрэн оролцогч хэмээн үзэх аргагүй юм.

Өнөөгийн монголын нийгэмд ажил эрхлэлтийн стандарт бус шинэ хэлбэрүүд үүсэн буй болж, зарим талаар мэргэшлийн төрөлжилтийн харьцангуй байдал ихсэж, гүйцэтгэж буй ажил нь боловсрол, мэргэшлийн түвшинтэйгээ тохирохгүй байхын зэрэгцээ тогтмол бус цалин орлоготой хүмүүс харьцангуй нэмэгдэх хандлага ажиглагдах болов. Манай улс зах зээлийн нийгэмд

⁴⁵Стэндинг Г. Прекариат- новый опасный класс. М., 2014.

⁴⁶Голенкова З.Т. Новые явления и процессы в глобальном мире //Процессы социальной интеграции и дезинтеграции в трансформирующихся обществах России и Монголии. М, Уб., 2016. С.55.

⁴⁷Монгол Улсын статистикийн эмхтгэл. 2016., х. 66; Монгол Улсын статистикийн эмхтгэл. 2018., х. 78-д буй мэдээнд хийсэн шинжилгээ.

⁴⁸Монгол Улсын статистикийн эмхтгэл. 2018., х.74.

шилжсэнээр албан ёсоор ажил эрхэлдэггүй иргэдийн тоо нэмэгдсэн хэдий ч, аливаа хүн давхар ажил хийх, өрхийн хувийн аж ахуй, бичил бизнес болон хувиараа хөдөлмөр эрхлэх зэргээр орлогоо нэмэгдүүлэх боломж нөхцөл бас бүрдсэн

Ажилгүйдэл нэмэгдэхэд ажиллах хүчний эрэлт нийлүүлэлтийн хууль зах зээлийн зарчмаар хэрэгжихгүй байх явдал гол нөлөө үзүүлнэ. “Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа”-наас үзэхэд ажиллах хүчний нийт эрэлтийн 25.5 хувь нь барилгын салбарт, 19.0 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 14.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлд бий болохоор байгаа бол, нийт ажиллах хүчний эрэлтийн 71.5 хувь нь байнгын, 25.5 хувь нь түр ажиллах хүчний эрэлт, 65.3 хувь нь шинэ, 34.7 хувь нь сул ажлын байрны эрэлт байна. Ялангуяа ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлтийн тогтворгүй байдал зэргээс болж сул ажлын байр үүсэх явдал элбэг тохиолддог ажээ. Ажиллах хүчний хомсдол бий болоход ажил олгогчдын хувьд шинээр авах ажилтаны боловсрол, мэргэжлийн ур чадвар, ажлын туршлагаас гадна ажлын хариуцлага, хувь хүний төлөвшил, тогтсон хандлага (зөөлөн ур чадвар) шаардлага хангахгүй байгаа бол, ажил хайгчийн хувьд ажлын байрны нөхцөл, цалин хөлс голох байдал, тогтвор суурьшилтай ажиллахгүй байх зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлдөг байна⁴⁹.

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал идэвхжихийн хэрээр компаниуд зах зээлээ өргөтгөх үүднээс шинэ технологийг эрж хайж, хэрэглэгчдэд зориулсан шинэ бүтээгдэхүүний төлөө өрсөлдөх болсон нь дижитал хэрэглээг улам бүр нэмэгдүүлж байна. Дэлхийн эдийн засгийн форумас 2018 онд зохион байгуулсан “Ирээдүйн ажил мэргэжлийн тайлан- 2018”-д дурдсанаар хэрэгцээ нь өсөх ажил мэргэжилд тоон өгөгдлийн шинжээчид ба эрдэмтэд, хиймэл оюун ухаан, машин сургалтын мэргэжилтнүүд, ерөнхий ба үйл ажиллагааны менежерүүд, программ хангамж болон аппликейшн хөгжүүлэгч, шинжээчид, их тоон өгөгдлийн болон дижитал хувьсгалын түүнчлэн байгууллагын хөгжлийн мэргэжилтнүүд, мэдээллийн технологийн үйлчилгээ зэргийг оруулсан байна.

Олон улсын чиг хандлагаас үзэхэд 2022 онд ажил олгогчдоос ажилтанд тавих голлох ур чадварыг аналитик сэтгэлгээ ба шинийг санаачлах болон идэвхтэй суралцах стратеги, технологийн дизайн болон программчлал, бүтээлч сэтгэлгээ, шүүмжлэлт сэтгэлгээ болон дүн шинжилгээ хийх, асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чадвар, манлайлагч болон нийгэмд нөлөөлөх чадвар, сэтгэл хөдлөлөө удирдах, эргэцүүлэн бодох, асуудал шийдэх, төсөөлөн бодох чадвар, системийн дүн шинжилгээ болон үнэлгээ хийх чадвар хэмээн үзжээ⁵⁰. Улс орны эдийн засгийн нөхцөл байдал, аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн өсөлттэй уялдан ажиллах хүчний эрэлтийн дийлэнх буюу 65.3 хувь нь шинэ ажлын байр байгаа тул мэргэжилтэй ажилтан болон мэргэшсэн ажилтан бэлтгэхдээ

⁴⁹Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт. Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа. Уб., 2018. 63 дахь тал.

⁵⁰ The future of jobs report 2018. World Economic Forum, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт. Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа. Уб., 2018. 60-61 дахь тал.

хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаанд тулгуурлах, мэргэжилтэн бэлтгэхдээ шинэ зууны ажилтанд нэн шаардлагатай байгаа голлох ур чадварыг эзэмшүүлэх, ур чадвараас гадна хувь хүний төлөвшил, ёс суртахууны хүмүүжилд илүү анхаарах шаардлагатай болсныг дээрх судалгааны дүн харуулах болов.

Ажлын байран дээр хууль дүрэм хэрэгждэггүйгээс хүмүүс ажилдаа сонирхолгүй болох, ажилтан болон удирдлагын хооронд зөрчил үүсэх зэрэг нь хөдөлмөрийн зах зээлд оролцох боломж нөхцлийг бууруулдаг. Хүний эрхийн үндэсний комисст дунджаар жилд 600-700 гомдол ирдгийн 50-60 хувь нь хөдөлмөрлөх эрхтэй холбоотой байдаг ажээ⁵¹. Төрийн байгууллага үндэслэлгүйгээр ажлаас халах, ажлын байрны дарамт, албан тушаал бууруулах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, туршилтаар ажилд авах нэрийн дор цалин хөлс өгөхгүй ажиллуулах зэрэг зөрчил их гардаг байна.

Түүнчлэн хүйсийн тэгш эрхийн төвөөс хийсэн судалгаагаар “Гурван хүн тутмын нэг нь ажлын байрандаа бэлгийн дарамтад өртөж, хохирогч болсон хэн нэгнийг мэддэг”, “таван эмэгтэйн нэг нь ажлын байрандаа бэлгийн дарамтад өртөж хохирогч болсон” дүн гарчээ. Улсын их хурлын гишүүн асан Н. Оюундарь “Хүчний нэг байгууллага дээр бүр 28 эмэгтэй бэлгийн дарамтад ямар нэг байдлаар өртсөн тоон мэдээ, өргөдөл, гомдолтойгоо бий... Ажлын байрны бэлгийн дарамт жирийн үзэгдэл болсоны жишээ энэ... Боловсрол, соёл урлаг, спортын байгууллагад ч бэлгийн дарамт зөндөө байна” гэж нэг ярилцлагадаа дурдсан байв. (Өдрийн сонин. 2019. №229). Түүнчлэн хөдөлмөр эрхлэж байгаа ялангуяа баар цэнгээний газар ажиллаж байгаа оюутан охид ажлын байрны бэлгийн дарамтад өртөх магадлал өндөр байдаг аж⁵².

Манай орны хувьд албан бус хөдөлмөр эрхлэлт нь албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, ХАА-н бус бөгөөд хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэдийг хамруулна гэж заасан байдаг. Хөдөө аж ахуйн салбар дахь албан бус салбарын үйл ажиллагааг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг тул ОУХБ нь хөдөө аж ахуйн (ХАА) салбарыг албан бус салбарын хүрээнээс гаргаж, зөвхөн ХАА-н бус чиглэлийн үйл ажиллагааг тус салбарт хамруулан тооцож ирсэн. 2019 оноос эхлэн ХАА салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг тооцдог болсон. Улсын хэмжээнд нийт ажиллагчдын 856.0 мянга (74.7%) нь ХАА-н бус салбарт ажиллаж, тэдгээрийн 195.2 мянга 22.8 хувь нь албан бус хөдөлмөр эрхэлдэг. Харин нийт 1146.2 мянган ажиллагчдын буюу ХАА-н салбарын ажиллагчдыг оруулсан дүнгээр 476.1 мянга буюу 41.5 хувь нь албан бус хөдөлмөр эрхэлж байна⁵³.

Чанарын судалгааны дүнгээс харахад ажилгүй иргэд нэлээд түгээмэл буй дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, судалгаанд оролцогч багийн дарга “Суман дээр ажлын байр байдаггүй учраас ерөөсөө л нэг түр зуурын орлого л

⁵¹Л. Дүгэрсүрэн // Өдрийн сонин. 2019. №34.

⁵²Э. Алтанзул. Хөдөлмөр эрхлэж буй эмэгтэй оюутны ажлын байрны бэлгийн дарамт //Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам (эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл). Уб., 2014. 93 дахь тал.

⁵³Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2019. Үндэсний статистикийн хороо. УБ., 2020. 62 дахь тал.

олдог байдаг. Тэгээд ямар ч орлогогүй айл ёстой цэвэр нөгөө түр зуурын орлого хүнд юм хийж өгөөд л одоо өнөөдөр хэн намайг юм хийгээд өг гэх нь вэ тэрийг л хараад л тэгээд л явж байдаг. Сумын төв дээр бол одоо ойр зуур юм хийгээд мөнгө олох тийм боломж маш хомс. Ажлын үнэлгээ нь бага. Тэгээд бие биеэ таньдаг мэддэг улсууд бас нэг айхтар тэгээд л юм өгчихгүй, найз нөхдийн хүрээнд тусалж дэмжисхийгээд л бага сага юм өгөх жишээний⁵⁴ гэсэн бол залуу гэр бүлийн төлөөлөл “Манай нөхөр өмнө нь ачигч хийдэг байсан. Уг нь авто засварчин мэргэжилтэй. Одоо хувиараа машин засдаг болохоор тогтмол орлого гэж байхгүй. Зундаа ажил гайгүй ч өвөлдөө таг зогсчихдог. Ажилтай үедээ сард 500, 600 мянга заримдаа 800 мянга олдог⁵⁵” гэж хариулсанаас ажилгүйчүүд болон прекариат бүлгийнхэн нэлээд түгээмэл буй нь харагдаж байна.

Ажилгүйдэлд нөлөөлөх хоёрдох хүчин зүйл гэвэл хувь хүний төлөвшил, хөдөлмөрт хандах хандлага, тэдний идэвхт чанар, бодол сэтгэлгээний хоцрогдолтой холбогдож байна. Хувь хүний төлөвшил хөгжлийн дутагдалтай холбоотой хүчин зүйл хөдөөтэй харьцуулахад хотын оршин суугчдын дунд илүү тохиолддог гэж хүмүүс үзжээ.

Залуучуудын хөдөлмөрийн зорилго, үнэт зүйл, сэдэл, тогтсон хандлагад материаллаг урамшууллын тал зонхилохын сацуу, хүнийг хөдөлмөрт идэвхжүүлдэг нийгмийн хэрэгцээ, дотоод сэдэл нэмэгдэх хандлага илэрч, одоогоор хийж бүтээх хэрэгцээнээс бусадтай харилцах хэрэгцээ давамгайлан хөгжих байдал ажиглагдав. Түүний зэрэгцээ хувь хүн өөрийгөө хөгжүүлэх, хэрэгжүүлэх хэрэгцээ бас нийгмийн харилцааны согог дутагдалд дулдуйдсан хууль ёсны бус аргаар орлого олох, амар хялбар амьдрах гэсэн сөрөг хандлага залуусын дунд аль аль нь харьцангуй хэмжээгээр идэвхжих хандлагатай болжээ.


Хөдөлмөрийн хүрээнд гарч буй зөрчлийн талаарх асуултуудад өгсөн иргэдийн хариултад фактор шинжилгээ хийж үзэхэд дараах з хүчин зүйл гарсан бөгөөд тэдгээр нийтдээ нийт дисперсийн өөрчлөлтийн 52 хувийг эзлэж байв. Үүнд нэгдүгээрт, хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй ажиллуулах, эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө авсан тохиолдолд цалин өгөхгүй байх, цалингийн нэг хэсгээс татвар, хураамж авч, нөгөө хэсгээс татвар авалгүй олгох, ажлын ачаалал ихтэй тохиолдолд илүү цагийг нөхөж төлөхгүй байх, цалингаа хугацаандаа өгөхгүй байх **зэргээр хөдөлмөрийн гэрээ цалин хөлстэй холбоотой нэг дүгээр хүчин зүйл** (нийт дисперсийн өөрчлөлтийн 32.0%- ийг тайлбарлаж буй), хоёрдугаарт, ажлын байранд элдвийн дарамт, хүчирхийлэл үзүүлэх, аюулгүй байдлыг хангахгүй байх, ялгамжтай, шударга бус хандах зэрэг **ялгаварлан гадуурхалтай холбоотой хүчин зүйл** (11.0%), гуравдугаарт, **нэмэлт нийгмийн хангамж үйлчилгээтэй холбогдсон хүчин зүйл** (9.0%) ялгарч байна. Судалгаанд оролцсон нийт иргэдийн өгсөн хариултад тулгуурлан хөдөлмөрийн хүрээнд хууль дүрмийн хэрэгжилт, илэрч буй зөрчил доголдлын цар хэмжээг тодорхойлох зорилгоор индексийн арга хэрэглэн тэдгээр дутагдлын давхцлын тоо болон хувийн жинг

⁵⁴ Экспертийн ярилцлагын тэмдэглэл. НОЭХСС. 2020.

⁵⁵ ГЯ. 23 настай, эмэгтэй. Ярилцлагын тэмдэглэл. НОЭХСС. 2020.

тооцож дараах зурагт үзүүлэв. Хөдөлмөрийн харилцааны нэгдсэн индексийг тооцоолоход дундаж нь 1.86, медиан утга 1.00 гарсан.

Зураг 8. Хөдөлмөрийн харилцааны индексийн тархалт



Судалгаанд оролцсон 10 хүн тутмын 6 нь хөдөлмөрийн харилцаатай холбогдсон зөрчлүүд ямар нэг байдлаар гардаг гэж хариулсан бол, үлдэх хэсэгт дээрх дутагдал илрээгүй байв. Судалгаанд оролцогчдын 13.3 хувьд 5 болон түүнээс дээш зөрчлийг ажил олгогчийн зүгээс гаргасан ажээ. Хууль дүрмийн хэрэгжилтийг ажилт эрхлэлтийн байдлаар харьцуулан шинжлэхэд зөрчлийн дундаж тоо тогтмол болон улирлын хийгээд цагийн ажлын алинд ч ойролцоо гарсан бөгөөд албан бус юмуу улирлын хийгээд цагийн ажилд хөдөлмөрийн хууль, журам зөрчигдөх нь ихсэх хандлага илэрч байв.

Сүүлийн хорь орчим жилийн статистик судалгааны дүнд хийсэн шинжилгээнээс үзэхэд цаашдаа Монгол улсын ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурах хандлага ажиглагдав. Ийнхүү хөдөлмөрийн зах зээл дэх иргэдийн оролцооны ойрын болон хэтийн төлөв хандлагыг нарийвчлан судлан тогтоож, төрийн бодлого боловсруулахдаа түүнийг харгалзан үзэх шаардлагатай. Улсын хэмжээнд байгаа нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амыг насны бүтцээр шинжлэхэд боломжит ажиллах хүчний 39.4 хувь нь 40-54 насныхан эзэлж байгаагаас харахад хөдөлмөрийн зах зээлээс тусгаарлагдахуйн судалгааг энэ бүлэгт илүү төвлөрүүлбэл зохистой байж болох талтай.

Судалгаанаас үзэхэд тогтмол ажил хөдөлмөр эрхлэдэггүй, тогтворгүй нийгмийн байдал бүхий, ажил эрхлэдэг хэдий ч цалин хөлс нь амьдралд нь хүрэлцдэггүй, нийгэм-эрх зүйн баталгаа болон нийгмийн хамгааллын арга хэрэгслээр хангагдах боломжоо бүрэн эсвэл хагас алдсан, иргэний болон нийгмийн эрх нь зөрчигдсөн, хувийн амьдралдаа сэтгэл ханамжгүй хүмүүс буюу орчин үеийн социологийн хэллэгээр бол прекариат бүлэг үүсэн буй болжээ. Иймд энэ бүлгийн дотоод бүтэц, түүний үүсэн буй болоход нөлөөлж буй хүчин зүйл, гарах үр дагаварыг хөдөлмөрийн зах зээлээс тусгаарлагдахуйн үзэл баримтлалд тулгуурлан цогц байдлаар, олон хэмжээст үзүүлэлтийн уялдаа холбоонд нь судлах арга зүй аргачлалыг Монгол орныхоо онцлог, хүн ардынхаа соёл уламжлалд нийцүүлэн боловсруулах шаардлага тулгарч байна. Судалгааг сүүдрийн буюу далд эдийн засаг, улс орны аюулгүй байдал, өнөөгийн мэдээллийн замбараагүй урсгал, сүлжээний гэх бизнес эрхлэлт, авлига, хээл хахууль, хувь хүний болон нийгмийн институтын төлөвшил, өнөөгийн засаглалын

төлөв байдал, төр засгаас явуулж байгаа бодлого, түүний хэрэгжилт зэрэг олон хүчин зүйлтэй уялдуулан хийвэл зохилтой.

Сүүлийн жилүүдэд Хөдөлмөр, нийгэм хамгааллын судалгааны институтээс хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа, цалин хөлсний бүтцийн судалгаа, мөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг тогтмол явуулж гарч буй өөрчлөлт хандлагыг тодорхойлдог болсон нь судлаачид болон төрийн бодлого боловсруулагчид, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах ажилтнууд, олон нийтэд шаардлагатай мэдлэг мэдээлэллээр хангахад чухал ач холбогдолтой болж байна. Харин эл судалгааг улам гүнзгийрүүлэн, судалгааны багийн бүрэлдэхүүнд социологич, эдийн засагчдаас гадна, сэтгэл зүйч, зах зээл судлаач, мэдээллийн технологич, ирээдүй судлаач зэрэг олон мэргэжлийн судлаачдыг оролцуулан, цогц байдлаар шинжилгээ хийж, хөдөлмөрийн зах зээлээс тусгаарлагдахуйд нөлөөлж буй төр засаг, нийгмийн институтын үйл ажиллагаатай холбогдох гадаад хүчин зүйлүүд болон хувь хүн түүний төлөвшил хөгжил, хөдөлмөрт хандах хандлага, нөөц боломж, ур чадвартай холбоотой дотоод хүчин зүйл, түүнчлэн өвөрмөц тогтсон үзэл, алдагдаж буй эрхээ хамгаалах чадваргүй байх зэрэг хүнийсэлтэй уялдсан шалтгаан зэргийг илрүүлэхэд түлхүү анхаарч, зах зээлийн харилцааны түвшинг нэмэгдүүлэх арга замыг боловсруулах шаардлагатай юм.

2.10. Боловсролын үйлчилгээн дэх тэгш бус хамрагдалт

Сурч боловсрох нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд нийгмийн гишүүдийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд суурь ач холбогдолтой. Нийгмийн бүхий л гишүүдийг нийтийн боловсролын үйлчилгээнд үнэ төлбөргүй хамруулж чадвал нийгмийн тэгш бус байдлын тогтолцоог илүү нээлттэй бөгөөд уян хатан болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Боловсролын тэгш бус байдалд үзүүлэх нөлөөний талаар социологийн онолууд маргалддаг. Бүтэц чиг үүргийн онолчдын үзэж байгаагаар бүх нийтийн боловсрол нь залуу үеийнхний эдийн засгийн баялаг, эрх мэдлийн ялгаа бүхий нийгмийн гарлын нөлөөг зөөллөж, байр сууриа ахиулах боломжийг олгосноор нийтийн сайн сайхан байдлыг тогтооход чухал үүрэгтэй (Alan C Herckhof, 2011). Судлаач Гор, Жеймс Г.Ладвиг нар (1994) боловсрол нь бүх хүмүүст дээд зиндааны байр суурьт хүрэх баталгаа болж чадахгүй ч, боломжийг тэгшитгэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үзсэн. Тэд нэгдүгээрт, хүн бүрд боловсрол эзэмших боломж нээлттэй байгаа, хоёрдугаарт, тухайн нийгэмдээ чухал, үнэ цэнэтэй гэгдэх шинжлэх ухааны болоод бусад шаардлагатай агуулгыг боловсролыг агуулга нь тусгаж байдаг, гуравдугаарт, анги, шашин шүтлэг, хэл, кастын ялгааг хүлээн зөвшөөрч, хүлцэж хүлээн авах орчныг бүрдүүлэн хүн бүрт нийгмийн гарлаа өөрчлөх боломжийг олгох замаар “боломжийн тэгш байдал”-ыг тогтоож чадна гэж үзсэн (J.M.Gore, James G Ladwig, 1994).

Нийгмийн гишүүд олдмол статусад хувийн сонголт болон өрсөлдөөнөөр хүрдэг, тусгай чадамжийг шаардах байр суурьт нийгмийн гишүүдээс шүүж,

шалгаруулахад боловсрол тусалдаг гэж бүтэц чиг үүргийн онолчид үздэг. Эрхэлж буй ажлын нэр хүнд, цалин хөлсний хэмжээ ба боловсролын түвшин хоорондоо шууд хамааралтай учраас боловсролыг нийгмийн “шүүлтүүрийн машин” хэмээжээ (Spring Joel, 1976). Ямар түвшний боловсрол эзэмшиж, үнэмлэх, диплом олж авна төдий чинээ нэр хүндтэй ажил хөдөлмөр эрхэлж, орлого олох боломж бүрддэг байна. Нийгмийн гишүүд алдар хүнд, эд баялаг, эрх мэдлээр өндөр байр суурьт хүрэхийн тулд өрсөлдөж, шалгарах боломжийг сургууль олгодог (Hughes. M, Kroehler. C.J, Vander Zanden. J.W, 1999). Алдар хүнд, эрх мэдэл, өндөр орлого бүхий, өмч хөрөнгийг бүтээж чадах байр сууринд нарийн мэргэжсэн чадамжийг сайтар эзэмшсэн хүн л хүрнэ. Өөрөөр хэлбэл, орчин үеийн нийгэмд боловсрол нийгмийн байр суурийн шилжилт хийх сувгийн үүргийг гүйцэтгэж байна. Эмэгтэйчүүд, угсаатны цөөнх, ядуу, боломжоор тааруу нийгмийн ангийн гаралтай суралцагч сургуульд суралцсанаар тэдэнд зонхилогч, ноёрхогчдын институт нээлттэй болж, нийгмийн давхраажилтын тогтолцоог уян хатан болгон, эдийн засаг, улс төрийн гээд бүхий л институтэд томоохон өөрчлөлтийг авчрах боломжтой. Тодруулбал, ангийн давхраажилт харьцангуй нээлттэй чанар нэг талаас капиталист зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, нөгөө талаас бүх нийтийн боловсролын институтийн үр нөлөө юм.

Бүтэц чиг үүргийн онолд үндэслэн хөгжсөн хүмүүн капиталын тухай онол нь хүнд хэдий чинээ хөрөнгө оруулалт хийнэ, хувь хүн төдийгүй нийгэм эдийн засгийн үр шимийг төдий чинээ хүртдэг болохыг баталдаг. Өөрөөр хэлбэл, хүний өнгөрсөн цагт сурч боловсроход нь хэдий чинээ хөрөнгө оруулна, төдий чинээ ирээдүйдээ эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой байна гэж үздэг. Боловсрол, сургалт нь хувь хүний танин мэдэхүйн чадамжийг хөгжүүлнэ. Энэ нь түүний хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. Бүтээмжтэй байдал нь боловсролтой буюу ур чадвартай хүний орлого өндөр байхад хүргэнэ. Ийнхүү хүний капиталыг хэмжих боломж олгоно хэмээн Хүний капиталын онолын судлаач Бекер (S.Chattopadhyay, 2012) үзжээ. Энэхүү тайлбар сурч боловсрох тэгш бус нөхцөл байдлыг шүүмжлэх гэхээсээ зөвтгөдөг хэмээн шүүмжлэгддэг. Гэхдээ сурч боловсрох нөхцөлийн тухайн нийгмийн бодит байдлыг өгүүлснийг дурдах нь зүйтэй.

Бүтэц чиг үүргийн онолчид боловсролыг нийгмийн гарлын байр сууриа өөрчлөх суваг болдог хэмээн эерэг талаас хардаг бол харин Зөрчилдөөний онолын (ялангуяа неомарксист) социологичид боловсрол бүх хүнд ийм үр нөлөөтэй байж чаддаг уу гэсэн асуултыг дэвшүүлж нөгөө талаас харах ёстойг сануулдаг. Залуучууд янз бүрийн шалгалтуудыг өгснөөр өндөр боловсрол эзэмшсэнээ баталгаажуулж, энэ нь тэдний нийгмийн гарлаа өөрчлөхөд чухал үүрэгтэй байдаг. Гэтэл тэрхүү шалгалтуудыг давж чадах эсэх нь зайлшгүй шаардагдах зардал, төлбөрийг нь төлж чадах эсэхээс хамаардаг. Коллинз (1979) боловсрол эзэмших боломж нь ангийн харьяаллаас ихээхэн хамааралтай гээд өндөр орлоготой, ази болон цагаан арьстан америкчуудын SAT-ийн онооны дундаж уугуул америкчууд, Испани болон африк гаралтай америкчуудын онооноос өндөр байна гэжээ. Тэгэхээр коллеж, их сургуульд элсэхэд чухал үүрэгтэй энэхүү шалгалт нь ангийн бүтцээс хамаарч, цаашлаад дээд

боловсролын зэрэг нь ямар орлоготой байхыг тодорхойлж байгаа (Hughes. M, Kroehler. C.J, Vander Zanden. J.W, 1999) тул нийгмийн гарлыг өөрчлөх гэхээсээ ангийн бүтэц хадгалагдахад үр нөлөөтэйг нотолсон юм (С.Түмэндэлгэр, 2023).

Францын социологич П.Бурдые боловсролыг “соёлын нөхөн үйлдвэрлэгч” болох талаас нь анхааран, сургууль нь соёлын үнэт зүйлс, итгэл үнэмшлийг батжуулж, дамжуулж байдаг бөгөөд тухайн хүүхэд хэзээ сургуулиа орхино, тэр чинээгээр түүний олж авсан үнэт зүйлс, итгэл үнэмшил нь хязгаарлагддаг хэмээн үзсэн. Түүнчлэн судлаач К.Уиллис (1977) сургууль нь ажилчны хүүхдийг ажилчин болоход хүргэж байгааг өөрийн судалгаагаар баталсан байдаг. Түүний судалгаа дундаж ангиас гаралтай багш нарын боловсруулсан дүрэм журмыг ажилчин ангиас гаралтай сурагчид ямагт зөрчдөг бөгөөд энэ нь тэдгээрийн хоорондын соёлын ялгаанаас үүдэлтэй ч, дундаж ангийнхны соёл, хэл, хэм хэмжээгээр тодорхойлогдсон сургууль нь ажилчин ангийн хүүхдийг үргэлжлүүлэн суралцахаас зайлсхийж, ажилчдын эгнээнд сайн дураар элсэхэд хүргэж байгааг харуулжээ (С.Түмэндэлгэр, 2018).

Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу бүх иргэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролыг үнэ төлбөргүйгээр эзэмших эрхтэй. Сургууль цэцэрлэг нь нийгмийн гишүүдийг ямар нэг ялгаварлалгүйгээр тэгш хамруулж байж сурч боловсрох эрх бүрэн утгаараа хэрэгжих юм. ЮНЕСКО-ийн тодорхойлсноор, тэгш хамруулах боловсрол (inclusive education) гэдэг нь “суралцахуй, соёл, болон нийгэм-хамт олон дахь оролцоог нэмэгдүүлэх хийгээд боловсролын гадна үлдээд байгааг (excluded) болон боловсролын дотоодод орхигдоод байгааг (excluded) бууруулах замаар суралцагчдын хэрэгцээний ялгаатай байдлыг харгалзан, хариу арга хэмжээ хэрэгжүүлэх үйл явц” юм (UNESCO, 2020) гэжээ. Энэ нь суралцахуйн бүхий л явц дахь сурагчдын ялгаатай байдлаас үүдэлтэйгээр тулгарсан бүхий л саад бэрхшээлийг тодорхойлон, тэдгээрийг арилгаж байж хэрэгждэг.

Энэхүү тодорхойлолтод тулгуурлан авч үзвэл, тэгш хамруулахуйц сургуулийн орчин нь дараах түлхүүр элементээс бүрдэнэ. Үүнд: 1) хүүхдийн хэрэгцээний ялгаатай байдлыг харгалзах, 2) нийгмийн тэгш хамруулалтын үзэл баримтлалын үүднээс боловсролын үйлчилгээний гадна үлдээд байгаа болон үйлчилгээний дотоодод орхигдоод байгааг бууруулахад анхаарах ёстой (С.Түмэндэлгэр, 2018). Тэгш хамруулахуйц боловсролын орчин бүрдсэн эсэхийг тодорхойлоход “Бүх хүүхэд сургуульд бүрэн хамрагддаг уу? Бүх сурагчдад сургууль, цэцэрлэгийн орчин аюулгүй бөгөөд эрүүл байх нөхцөлийг бүрдүүлсэн үү? Бүх сурагчдад үр дүнтэй суралцах боломжийг олгосон уу?” зэрэг асуултад хариулах шаардлагатай юм (World Bank, 2019). Энэхүү бүлэгт нэгдүгээрт, цэцэрлэг, сургуульд хамрагдаж чадалгүй хэн орхигдоод байгаа хийгээд орхигдох эрсдэлтэй, цэцэрлэг, сургуульд хамрагдсан хэдий ч орчны хувьд бүх хүүхдэд аюулгүй бөгөөд эрүүл байх нөхцөл бүрдсэн эсэх, мөн бүх суралцагчдад чанартай боловсрол эзэмших адил тэгш боломж хангагдсан эсэх асуудлыг баримтад тулгуурлан авч үзэхийг хичээв .

Аль нэг боловсролын түвшинд хамрагдсан тодорхой насны суралцагчдын тоог тэрхүү насны бүлгийн нийт хүн амын тоонд харьцуулан тооцдог “хамран

сургалтын цэвэр жин” бага боловсролын түвшинд 2021-2022 оны хичээлийн жилд 95.7, суурь боловсролын түвшинд 93.8 хувь байна (ҮСХ, 2021). Харин нас харгалзалгүй тооцдог хамран сургалтын бохир жингийн хувьд бага боловсролын түвшинд 97.0 хувь, суурь боловсролын түвшинд 96.3 хувь байна. Бага боловсролын түвшинд цэвэр ба бохир жин 1.3 хувийн зөрүүтэй байгаа нь 6 насандаа зарим сурагчид сургуульд орохгүй байгаатай холбогддог. 2021-2022 оны хичээлийн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 настай нийт хүүхдийн 3.0 хувь буюу 11.4 мянган хүүхэд, суурь боловсролд хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдийн 3.7 хувь буюу 9.2 мянган хүүхэд сургуульд хамрагдаагүй аж. Суурь боловсролд хамрагдаагүй нийт хүүхдийн 59.4 хувь нь эрэгтэй хүүхэд байгаа тул сургуулийн гадна үлдэгсдийн дунд хөвгүүд илүү тохиолдох магадлалтай байгаа юм (ҮСХ, 2021).

Энэхүү бүлэг нь боловсролын үйлчилгээний хүртээмж, орчин, чанарын байдлыг Зөрчилдөөний онолын хандлагад тулгуурлан, тэгш хамруулах үзэл баримтлалын үүднээс нийгмийн ямар бүлгийн гишүүд боловсролын үйлчилгээнээс орхигдох хандлагатай байгаа тухай хөндлөө. Ерөнхийдөө сүүлийн 20 гаруй жилийн хугацааны хоёрдогч эх үүсвэрийн мэдээлэлд тулгуурлав. Мөн тус бүлгийн агуулгыг сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын албан ёсны үйлчилгээний хүрээгээр хязгаарласан болно. Боловсролын талаар өмнө хийгдсэн судалгаануудад ерөнхий боловсролын сургууль (ЕБС), цэцэрлэгийн гадна үлдэх эрсдэл амьжиргааны түвшин доогуур, малчин, хөдөөнөөс хот руу шилжин суурьшигч өрхийн суралцагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (ХБХ) илүүтэй өндөр болох (B.Batjargal, D.Tungalag, 2018), нөгөө талаас хоёрдогч мэдээллийн олдцоос хамаарч бүлгийн агуулга хязгаарлагдав.

Малчин өрхийн, амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшсан өрхийн, сүм хийдэд шавилан сууж буй, эрх нь хязгаарлагдсан хүүхдүүдэд цэцэрлэг, сургуулийн үйлчилгээ, анги танхим дахь чанартай боловсролын үйлчилгээний гадна үлдэж, орхигддог болохыг сүүлийн 20 жилийн хугацаанд хийгдсэн судалгаа, үнэлгээний баримтууд болон статистикийн холбогдох мэдээллүүд нотолж байна.

Малчдын хүүхэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын нийгмийн бусад хүүхдийн адил түвшинд хамрагдаж чадахгүй байна. Хэдийгээр малчдын хүүхдэд зориулсан сургуулийн өмнөх боловсролын хувилбарт үйлчилгээг санал болгож байгаа ч хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, зарцуулж буй санхүүжилт зэргээр эрс ялгаатай нөхцөл бүхий үйлчилгээнд хамрагдаж байна. Сургуулийн дэргэдэх дотуур байрны үйлчилгээ малчдын хүүхдийг сургуульд хамруулахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа ч хүртээмжтэй бус, дотуур байрны тав тух тааруу, хүүхэд хамгааллын асуудлууд гардаг зэрэг нь малчдыг хоёр тусдаа амьдрах, илүү өндөр зардалтайгаар хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг тулгаж байна. Хүүхдийн тооноос хамаарсан боловсролын санхүүжилтын тогтолцоо нь багшлах боловсон хүчин, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хийгээд чанарын ялгаатай байдлыг бий болгож байгаагаас боловсролын үнэлгээний дүнгээр сум, багийн сургуулийн сурагчдын дундаж оноо бусад сургуулийн сурагчдынхаас доогуур гарч байна.

Сургууль, цэцэрлэгийн гадна үлдэж буй хүүхдүүдийн дунд ХБХ өндөр хувийг эзэлж байгаа нь ХБХ-ийг боловсролын тусгай байгууллагад сургадаг гэх хандлага хийгээд цэцэрлэг болон ЕБС-ийн материаллаг орчны нийцтэй бус байдал, багш, ажилтнуудын бэлтгэл, санхүүжилтын дутмаг байдалтай холбогдож байна. Түүнчлэн, эдгээр хүчин зүйлс ЕБС-д ХБХ суралцаж байгаа ч сургалтын үйл ажиллагаанаас бусад хүүхдийн адил үр шим хүртэж чадахгүй нөхцөлд хүргэдэг.

Амьжиргааны түвшин доогуур буюу ядуу байдал нь сургууль, цэцэрлэгийн зардлыг дийлэхгүй байх, өрх гэр бүлээ тэжээх, гэрийн ажил хийх (амьжиргаа доогуур байх тусам бага наснаас эхэлдэг) зэрэг амьжиргаанд хамаарах шалтгааны улмаас сургууль, цэцэрлэгийн гадна үлдэх голлох хүчин зүйлсийн нэг болно. Анги дүүргэлт ихтэй сургуульд суралцах, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдаж чадахгүй байх, зөвлөн туслах эцэг эхийн дэмжлэг сул байх, унших, танилцах ном ховор, асран хамгаалагчийн хараа хяналт дутагдах, багштай нь холбоогүй байх, сургуулийн бэлтгэл хангагдахгүй байх зэрэг нь ядуу өрхийн хүүхдийн сурч боловсрох үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор ядуу өрхийн хүүхдийн хувьд тоо бодох хийгээд унших чадвар, элсэлтийн шалгалтын амжилт зэрэг боловсролын чанарын үзүүлэлтүүд мэд эгдэхүйц доогуур үнэлгээтэй гарчээ.

Шилжин ирсэн хүүхдүүд бичиг баримтын зөрчилтэй эсвэл ядуурлын улмаас сургуульд үргэлжлэн сурах боломжгүй болох, сүм, хийдийн сургалтын үйл ажиллагаа ердийн сургуулийн сургалтын цагтай давхацдаг, санхүүжилтын хөшүүрэг дутмаг зэргээс болж сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд боловсролын үйлчилгээний гадна үлдэх зэрэг сөрөг үзэгдэл гарсаар байна. Түүнчлэн, урьдчилан хориход цагдан хоригдож буй хүүхдэд боловсролын үйлчилгээг хүргэх хувилбар зохицуулалт дутмагаас тэд сургууль завсардахад хүрдэг.

Иймд Монгол Улс дахь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын үйлчилгээ хэнийг ч үл орхигдуулсан хүртээмжтэй, адил чанартай байж хүүхэд бүрийн нийгмийн гарлын нөлөөг бууруулах гэхээсээ илүүтэйгээр өнөөгийн нийгмийн давхраажилтын нөлөөн дор, түүнийг дахин үйлдвэрлэх чиг хандлагатай байна.

2.11. Тусгаарлагдах эрсдэлт бүлгүүд

Архины хамааралтай хүмүүс. Архи хэрэглэх нь зөвхөн архи уух гэсэн зан үйлээр, хор уршиг нь зөвхөн тухайн хүнээр хязгаарлагддаггүй. Гэр бүл, нийгэмд үзүүлэх хор уршиг нь асар их. Согтууруулах ундааны⁵⁶ хамаарал бүхий хүн⁵⁷ нийгмийн гадна хаягдаж, тусгаарлагдах буюу наад захын эрхээ хэрэгжүүлэх, хамгаалагдах эрхээ эдлэж чадахгүй хөсөр хаягдахад хүрдэг.

⁵⁶ **Архи, согтууруулах ундаа:** Согтууруулах ундааны гол найрлага нь этилийн спирт (C_2H_5OH) алкоголь юм. Хуулийн дагуу хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, 2 хувиас дээш этилийн спирт агуулсан дарс, пиво, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи согтууруулах ундаанд хамаарна.

⁵⁷ **Хамаарал бүхий хэрэглээ:** Донтолт буюу элдэв шалтаг шалтгаанаар согтууруулах төрлийн ундааг хэрэглэнэ. Олон хоногоор донтон хэрэглэнэ.

Архины хамаарал бүхий хүнийг ихэнх хүмүүс жигшиж (75.6%), өөрөөсөө болж иймдээ хүрсэн арчаагүй нэгэн гэж үзэж тэвчихгүй байх (56.2%), архичин хүнээс аль болох зугтахыг хүсч, зайлсхийх (74.3%) хандлага хамгийн их гаргадаг.

Зураг 9. Хүмүүсийн зүгээс архи хэтрүүлэн хэрэгчид, архины хамааралтай болсон хүнд хандах хандлага⁵⁸




Гурван хүний нэг нь “өөрийнх нь хэрэг, надад хамаагүй” гэж үл хэрэгсэж, тэднийг хайхардаггүй бол “өвчтэй хүн, өвчин туссан хүн гэж харж өрөвдөж тусалдаг” (17.0%), “архинаас гарахад нь туслахыг хичээдэг” (29.2%), “архичин хүн ч гэсэн хүн учраас ойлгож хүндлэхийг хичээх хэрэгтэй” (25.4%), хэнд ч тохиолдож болно, ер нь тэднийг зөвтгөх бодол төрдөг (12.9%) гэх мэт эевэргүү зөөлөн хандлага ихэнхдээ төрж, тэднийг уучил, тусалж дэмжихийг хичээдэг хүмүүс бас байна. Агуулгаар нь нэгтгэвэл:

- архичин хүнийг жигших, тэвчдэггүй,
- тэднээс зугтаж зайлсхийн, үл хайхардаг,
- өрөвдөж тусалдаг, архинаас гаргахыг хичээдэг,
- хүн гэж хандаж ойлгохыг эрмэлзэдэг, тэднийг зөвтгөж боддог гэсэн ийм 4 өөр ойлголт, хандлага байна.

Архичин хүмүүсийг “жигшдэг, тэвчиж чаддаггүй” болон тэднээс “аль болох зугтааж, үл хэрэгсдэг, хайхрахыг хүсдэггүй” хүмүүс архи согтууруулах ундааны хэрэглээний хувьд эрсдэл бүхий, дундаж эрсдэлтэй гэр бүл (57.2%: 52.6%) хамгийн их жигшдэг бол өндөр эрсдэлтэй, донтсон-донтож байсан гишүүн бүхий (47.4%: 40.0%) гэр бүл архины хамаарал бүхий хүмүүсийг ойлгож, туслах хандлагатай байдаг.

⁵⁸ **Тайлбар:** Хүмүүсийн зүгээс архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэгч, донтсон хүмүүст “цаг үргэлж, ихэнхдээ” хэрхэн ханддагийг зурагт үзүүлж байна.

Зураг 10. Архины хамааралтай хүнд хандах хандлага, гэр бүлийн архи согтууруулах ундааны хэрэглээний эрсдэлийн түвшингээр харьцуулсан нь



Донтсон, донтож байсан гишүүн бүхий гэр бүлд архичин хүмүүсийг хүн гэдэг утгаар нь хүндэлж ханддаг, ойлгохыг хичээдэг эевэргүү сэтгэлээр архичин хүмүүст хандагсад эрсдэлийн түвшин доогуур бусад гэр бүлүүдээс (9.3-23.2 пунктээр илүү) давамгайл байна.

Архи, согтууруулах ундааны хэрэглээний түвшнээс хамаарч нийгмийн харилцаа болон үйлчилгээнд хамрагдах боломж нь тодорхойлогдох шинжтэй бөгөөд хэвийн хэрэглээтэй нөхцөлд харилцаа тогтвортой, нийгмийн нийтлэг үйлчилгээнд хамрагдах боломжтой. Хамаарлын түвшин өндөр, донтолт бүхий хэрэглээтэй хүмүүсийг нийгмийн харилцааны гадна зориуд үлдээх буюу тусгаарлах, нийгмийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, эдгээр хүмүүст чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний өртөг зардал өндөр бөгөөд санхүүжилт хомст, тусгайлсан эмчилгээ үйлчилгээ үзүүлэх бүтэй бий болоогүй, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх нөхцөл орчин нөхцөл бүрэн бүрдээгүй. Бодлогын талаас архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, сэтгэл заслын болон эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлэх “бодит чадамж, үр нөлөө” бүхий бодлого үгүйлэгдэж байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд. Монгол Улсад 2021 оны байдлаар 106,169 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь нийт хүн амын 3.1% болно⁵⁹. Хөгжлийн бэрхшээлийг төрлөөр нь авч үзвэл хөдөлгөөний, сэтгэцийн, харааны, сонсголын бэрхшээл давамгайлж байна⁶⁰. Төрөлхийн эсвэл олдмол эсэхээс үл хамааран хөгжлийн бэрхшээл нь нөөц боломжийн аль ч хэлбэрээр хомсдох, нийгмийн үйлчилгээ, оролцоо, харилцаанаас хязгаарлагдах, амьдралын чанар, амьжиргааны тааруу байх, нийгмийн бүтэц дэх байр суурь, давхрааны хувьд доогуур байх суурь шалтгаан болж байна. Тухайлбал, бусад хүмүүстэй харьцуулахад амьдралын чанар тааруу, доогуур байдал ХБИ 20.8 пунктээр, ХБ-тэй гишүүнтэй өрхөд 7.1 пунктээр өндөр бөгөөд нөөцийн хувьд дунд ба түүнээс доош давхраанд илүү хамаарч байна. Түүнчлэн бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой, үйлдвэрлэл барилга, гар урлал, суурин төхөөрөг, машин механизмын оператор, техникч туслах мэргэжилтэн, худалдаа үйлчилгээний мэргэжил, мэргэшилтэй юм.

⁵⁹ МУҮСХ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, аймаг, нийслэлээр. [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#). 2022.12.20 хандав.

⁶⁰ МУҮСХ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хэлбэрээр. [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#). 2022.12.20 хандав.

Хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн тусгаарлагдмал байдал⁶¹ 42.9 хувь байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд ХБ, хүнд өвчтэй өрхийн гишүүнтэй бүлгээс 23.3 пунктээр, бусад бүлгээс 28.1 пунктээр илүү байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ахисан болон гүнзгий тусгаарлагдалтад өртөх байдал⁶² 14.3 хувь байгаа нь нөгөө хоёр бүлгээс 2.5-8.1 пунктээр өндөр юм. Харин хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй өрхийн гишүүнтэй бүлгийн тусгаарлагдах эрсдэлт⁶³ байдал бусад бүлгээс өндөр байна. Энэ нь нийгмээс тусгаарлагдмал байх, тусгаарлагдах эрсдэлд ороход нөлөөлдөг чухал хүчин зүйлсийн нэг нь удаан хугацаанд хүндээр өвдөх, төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээл болохыг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй, удаан хугацаанд өвдсөн, асаргааны хүнтэй өрхийн амьжиргааны түвшин тааруу байна. Өрхийн гишүүд хөдөлмөрийн чадвараа урт болон богино хугацаанд алдах, байнгын асаргаанд байх нь нийгмийн байр суурийн хувьд уруудах, эдийн засгийн нөөцөөр хомсдох, өрхийн амьжиргаа буурахад шууд нөлөөлдөг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн үйлчилгээнээс тусгаарлагдах буюу хомсдох нь нэг талаас тусгай хэрэгцээт хүмүүст нийгмийн үйлчилгээг хүргэх арга хэлбэр оновчгүй, зохицуулалт тодорхой бус, хүний нөөцийн хүртээмж, чадавх хангалтгүй, санхүүжилт, материаллаг хангамж, техник болон технологи тааруу зэрэг төрийн бодлого, нийгэм, эдийн засаг, технологийн хөгжлөөс хамаарсан макро түвшний хүчин зүйлстэй холбоотой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс физиологийн хүндрэлээс хамаараад нийгмийн оролцоо, харилцаанаас тусгаарлагдах, хязгаарлагдах нь нийтлэг байна. Түүнчлэн хүүхдүүд төдийгүй том хүмүүс гадуурхах, шоовдорлох тохиолдол ч цөөн биш аж.

Судалгааны дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, асаргаанд байдаг гишүүнтэй өрхийн тусгаарлагдмал байдал хийгээд тусгаарлагдах эрсдэл бусад бүлгээс үлэмж өндөр байна. Өөрөөр хэлбэл тусгаарлагмал байх, тусгаарлагдах эрсдэлт хүчин зүйлсийн нэг томоохон шалтгаан нь хөгжлийн олдмол болон төрөлхийн бэрхшээл юм. Мөн өрхөд хүнд өвчтэй, асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүн байх нь тухайн өрхийн болон гэр бүлийн бусад гишүүдийн тусгаарлагдах эрсдлийг нэмэгдүүлдэг байна.

Төрөлхийн эсвэл олдмол эсэхээс үл хамааран хөгжлийн бэрхшээл нь нөөц боломжийн аль ч хэлбэрээр хомсдох, нийгмийн үйлчилгээ, оролцоо, харилцаанаас хязгаарлагдах, амьдралын чанар, амьжиргааны тааруу байх, нийгмийн бүтэц дэх байр суурь, давхрааны хувьд доогуур байх суурь нэгэн шалтгаан болж байна.

Ахмадууд, тэтгэврийнхэн. Чухамдаа ахмад настнууд хөдөлмөр эрхлэгчээс тэтгэвэр авагч болж нийгмийн бүтцийн хувьд ахмад настан хэмээх бүлэгт харъяалагдах болдог. Энэ нь тэдэнд ганцаардал, бие махбодийн болон оюун санааны доройтол, санхүү болоод амьдралын чанар буурах, нийгмээс

⁶¹ Тусгаарлагдмал байдал = Тусгаарлагдалтын дунд + Ахисан тусгаарлагдалт + Гүнзгий тусгаарлагдалт


⁶² Тусгаарлагдмал байдлын гүнзгийрэлт = Ахисан тусгаарлагдалт + Гүнзгий тусгаарлагдалт

⁶³ Тусгаарлагдах эрсдэлт түвшин = Тусгаарлагдалтын өмнөх шат

тусгаарлагдсан мэдрэмж төрүүлдэг нь судалгааны дүнд (Ахмад настны социаль асуудал: үр дагавар, төлөв хандлага 2022) илэрч байна. Физиологийн нас⁶⁴ нь хүний нийгмээс тусгаарлагдмал байх, тусгаарлагдах эрсдэлд нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл мөн бөгөөд өндөр настнуудын нийгмийн сайн сайхан байдлыг бууруулж, нийгмээс тусгаарлагдах байдлыг нэмэгдүүлдэг.

Насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам тусгаарлагдалтын түвшин гүнзгийрч байгаа нь ахмадуудад (55-аас дээш насныхан⁶⁵) нийгмээс тусгаарлагдах эрсдэл илүү өндөр байгааг харуулж байна.

Зураг 11



Ахмадуудын 55 хувь нийгмээс тусгаарлагдаагүй байгаа нь нийт судалгаанд оролцогчдоос 14 пунктээр бага, харин тусгаарлагдах эрсдэлт бүлгээс 5 пунктээр, дунд түвшинд тусгаарлагдсан бүлгээс 7 пунктээр, ахисан болон гүнзгий түвшинд тусгаарлагдсан бүлгийн хувьд 3 пунктээр тус тус өндөр байв.

Зураг 12.



Тусгаарлагдмал байдлын төрлийнх нь хувьд ахмадуудын нөхцөлийг судалгааны нэгдсэн дататай харьцуулвал нийгмийн үйлчилгээнээс тусгаарлагдах байдал ойролцоо, нийгмийн оролцооноос тусгаарлагдах нь харьцангуй бага,

⁶⁴ Физиологийн нас - төрснөөс эхлэн тооцох он цагийн нас бөгөөд үүнийг албан ёсны нас гэж нэрлэх нь бий, нийгмийн нас – зан төлвийг, сэтгэл зүйн нас – мэдрэмжийг илэрхийлдэг гэж үздэг.

⁶⁵ “Нийгмийн даатгалын ерөнхий хуульд” зааснаар 55 настай эмэгтэй, 60 настай эрэгтэй хүнийг ахмад настан гэж үзэж тэтгэвэр тогтоолгох эрх үүсдэгээс үзвэл эдгээр насны иргэдийг Монгол Улс албан ёсоор ахмад настан гэж тооцдог болохыг үндэслэн эл судалгаанд **ахмад настан** хэмээн 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэйчүүдийг авч үзлээ. Ингэхэд судалгаанд нийт 160 ахмад настан хамрагдсан бөгөөд үүнээс, 33.1% нь эрэгтэйчүүд, 66.9% эмэгтэйчүүд байв.

харин эдийн засгийн тусгаарлагдмал байдал, хийгээд эдийн засгийн нөөцийн дутагдал 20 гаруй хувиар илүү байна. Түүнчлэн амьдралын чанар тааруу эсхүл доогуур байх нь ахмадуудын хувьд судалгааны нэгдсэн дүнгээс 5-11 пунктээр өндөр юм.

Ахмад настнуудыг насны бүлгээр нь ахимаг (55-59 настай), ахмад (60-64 настай), өндөр (65-69 настай), өтөл (70-аас дээш настай) гэсэн 4 бүлэгт хуваан тусгаарлагдмал байдлыг нь авч үзсэн. Ингэхэд насны бүлгээс хамааран тэдний тусгаарлагдмал байдал хийгээд тусгаарлагдалтын гүнзгийрэлт илүү болж буй нь судалгааны дүнгээс харагдана. Тухайлбал, ахимаг настнуудын 71 хувь тусгаарлагдаагүй байгаа бөгөөд энэ нь насны бусад бүлгээс 15-30 пунктээр өндөр юм. Харин өндөр ба өтөл настнуудын ахисан, гүнзгий түвшний тусгаарлагдмал байдал бусад бүлгээс харьцангуй их байв. Судалгааны нэгдсэн дүнтэй харьцуулж үзвэл өндөр болон өтөл настнуудын ахисан, гүнзгий түвшний тусгаарлагдалт 3-4 пунктээр илүү байгаа нь бага дүн биш.

Тусгаарлагдмал байдлын гурван төрөл буюу эдийн засгийн тусгаарлагдалт, нийгмийн үйлчилгээ хийгээд нийгмийн оролцооны тусгаарлагдалтын аль нь ахмадуудад илүү тохиолдож буйг⁶⁶, насны бүлэг бүрээр авч үзье. Ингэхэд ахмадуудын нас өндөрсөх тусам тэдний эдийн засгийн тусгаарлагдмал байдлын түвшин өсч, илүү гүнзгийрч байна. Тухайлбал, эдийн засгийн ахисан ба гүнзгий түвшинд тусгаарлагдах байдал ахимаг насныханд 7.9% байгаа бол ахмадуудад 23.1%, өндөр настнуудад 13.3%, өтөл настнуудад 20% байна. Харин тусгаарлагдаагүй бүлэг ахимаг насныханд 13.2% байгаа нь насны бусад бүлгээс ойролцоогоор 2-3 дахин өндөр үзүүлэлт юм. Нийгмийн үйлчилгээ хийгээд нийгмийн оролцооны тусгаарлагдалтын хувьд ч ахмадуудын нас ахих тусам тусгаарлагдмал байдал нэмэгдэж, илүү гүнзгийрч буй зүй тогтол ажиглагдана.

Хүснэгт 5. Ахмадуудын насны бүлэг ба тусгаарлагдалтын төрлүүд⁶⁷, хувиар

Тусгаарлагдмал байдлын түвшин	Насны бүлэг											
	Ахимаг			Ахмад			Өндөр			Өтөл		
	ЭЗ	НҮ	НО	ЭЗ	НҮ	НО	ЭЗ	НҮ	НО	ЭЗ	НҮ	НО
.00	13.2	10.5	13.2	6.2	3.1	13.2	-	-	16.2	5.0	-	10.0
1.00	23.7	13.2	31.6	18.5	12.3	31.6	13.5	8.1	18.9	15.0	10.0	25.0
2.00	28.9	23.7	13.2	18.5	27.7	13.2	24.3	35.1	27.0	10.0	35.0	15.0
3.00	10.5	34.2	21.1	27.7	26.2	21.1	32.4	32.4	13.5	25.0	20.0	20.0
4.00	15.8	7.9	13.2	6.2	15.4	13.2	16.2	18.9	10.8	25.0	20.0	15.0
5.00	2.6	7.9	2.6	13.8	10.8	2.6	2.7	2.7	8.1	10.0	10.0	5.0
6.00	5.3	2.6	5.3	6.2	3.1	5.3	8.1	2.7	5.4	10.0	5.0	10.0
7.00	-	-	-	3.1	1.5	-	2.7	-	-	-	-	-

⁶⁶ Тусгаарлагдаагүй – 0, тусгаарлагдалтын өмнөх түвшин 1-2, тусгаарлагдмал байдлын дундаж түвшин 3-4, ахисан болон гүнзгий буюу дундаас дээш тусгаарлагдсан 5 ба түүнээс дээш хэмээн хувааж болно.

⁶⁷ ЭЗ (эдийн засгийн шинжүүдээр тусгаарлагдсан байдал), НҮ (нийгмийн үйлчилгээнээс тусгаарлагдмал байдал), НО (нийгмийн оролцооноос тусгаарлагдмал байдал)

Түүнчлэн ахмадуудын гэр бүлийн байдал тэдний нийгмээс тусгаарлагдах эрсдлийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, бүтэн гэр бүлээр амьдарч буй ахмадуудын тусгаарлагдаагүй байдал 65% байгаа нь гэр бүлийн өрөөсгөл хэв маягтай ахмадуудаас 15-40 пунктээр өндөр байна. Эсрэгээрээ гэр бүл салаагүй ч тусдаа амьдарч байгаа хүмүүсийн 1/2, бэлэвсэн хүмүүсийн 1/3, гэр бүл салсан болон ганц бие ахмадуудын 1/4 нь тусгаарлагдмал байдалд байна. Мөн ганц бие ахмадуудын 1/2 тусгаарлагдах эрсдэлт бүлэгт байгаа нь бусад гэр бүлийн хэв маягтай ахмадуудаас ойролцоогоор 2 дахин өндөр юм. Гэр бүлийн гишүүн биш ч тусламж гуйж ханддаг эсхүл хандах боломжтой хүмүүс олон байх тусам тусгаарлагдмал байдалд буй ахмадуудын тоо буурч байна. Өөрөөр хэлбэл бусдын тусламж дэмжлэг нь ахмадуудыг нийгмээс тусгаарлагдах эрсдэлийг бууруулдаг чухал хүчин зүйл юм.

Зураг 13.

Ахмадуудын тусгаарлагдмал байдал ба бусдын тусламж дэмжлэг



Ахмадуудын сэтгэл ханамж ба тусгаарлагдмалын түвшин хоорондын корреляцийн хамаарлын шинжилгээг хийхэд сэтгэл ханамж болон тусгаарлагдмал байдлын түвшин нь урвуу бөгөөд ач холбогдолтой хамааралтай байна. Тодруулбал, сэтгэл ханамжийн түвшин буурах тусам тэдний тусгаарлагдмал байдлын түвшин өсч байгаа зүй тогтол ажиглагдав. Өөрөөр хэлбэл тусгаарлагдмал байдлын түвшин өсөх тусам тэдний сэтгэл ханамжийн байдал буурч байна. Эдгээрийн дотроос ахуй амьдралын тав тух, бүхэл амьдралын сэтгэл ханамж, боловсрол мэдлэг авах, ажиллах боломж нөхцөл хийгээд материаллаг хангамж (хооллох, хувцаслах, орон сууцны нөхцөл)-ийн сэтгэл ханамж илүү өндөр хамааралтай байна.

Түүнчлэн сэтгэл ханамжийн түвшингээр тусгаарлагдмал байдал⁶⁸-ыг нь харьцуулахад сэтгэл ханамж маш муу, муу гэсэн үнэлгээ өгсөн хүмүүсийн олонх нь тусгаарлагдмал байдалд байгаа нь шинжилгээнээс харагдана. Энэхүү суурь судалгаатай зэрэгцэн явуулсан “Ахмад настны нийгмийн социаль асуудлын судалгаагаар ойролцоогоор ахмадуудын 1/10 нь оролцоо бага, маш бага болон

⁶⁸ Тусгаарлагдмал байдал = дунд, ахисан болон гүнзгий түвшинд тусгаарлагдаж буй бүлгийн нийлбэр дүн болно.

оролцоогүй байна. Насны бүлгээр ахмадуудын идэвх оролцоо буурч байгаа ч ахмадуудын дунд идэвх оролцоогүй байдаг, харилцаа багатай, нийгмээс тусгаарлагдмал хэсэг бүлэг ч байна. Ялангуяа 65-аас дээш насныхны дотор тусгаарлагдмал байдлын эрсдэл өндөр байгааг өмнөх бүлгүүдэд дурдсан. Ахмадууд эдийн засгийн оролцоо маш дутмаг, хөдөлмөрийн зах зээлээс ялгаварлагдаж тусгаарлагдах хандлага нийтлэг байна. Судалгаанд оролцогч ахмадуудын ойролцоогоор 1/5 ямар ч нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй, хөнгөлөлт авдаггүй. Зах зээлийн нийгэмд шилжсэний дараах хямралт жилүүдэд ахмадуудыг үеэ өнгөрөөсөн, хоцрогдсон ардчилал, шинэчлэлийг хойш татагч мэтээр ойлгож харах, тэтгэврийн насны хүмүүсийг үргэлжлүүлэн ажил хийхийг дэмжихгүй, залуучуудад зайгаа тавьж өгөхийг ил далдаар сануулж, ач гучаа хараад гэртээ суухыг шахах зэргээр ахмад настны эрхэнд халдаж байсан. Нийгмийн ийм тогтсон хандлага, ялгаварлан гадуурхалт нь ахмад настны ажил эрхлэлт, эдийн засгийн оролцоог бууруулах нэг хүчин зүйл болж байгааг эл судалгааны тайланд дүгнэсэн (Ж.Батжаргал 2022). Ер нь харааны, сонсголын, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй ахмадууд, асрамжийн газрын ахмад настнуудын хувьд гэртээ, асрамжийн газрын байран дотроо л ихэвчлэн байх учраас амьдрах орон зай нь хязгаарлагдмал, бусадтай харилцах, нийгмийн оролцоо нь хумигдмал буюу гадна орчны бусад хүмүүстэй харилцах нь бараг үгүй байв. Иймээс зөвхөн гадна орчинд явагдах нийгмийн оролцооны байдлыг анхаарах бус тэдэнд чиглэсэн тэдний дотор орчинд зориулсан зохион байгуулалттай үйл ажиллагааг өргөжүүлж сайжруулах, тэдгээр ахмадуудад хүргэж буй төрийн үйлчилгээг чанарын өөр түвшинд хүргэх, асрамжийн газрыг тэдний оролцоог дэмжсэн, хөгжих орчин болгох, тэдний оюун санааны, харилцааны хэрэгцээг хангах, өөрсдөө хийж бүтээх, өсөж хөгжих боломж бололцоогоор хангах нь нэн чухал байна (Ж.Батжаргал 2022). Асрамжийн газрын ахмадуудаас гадна жирийн ахмадуудын дунд ч өөрсдийгөө нийгэмд хэрэггүй болсон орхигдсон хүмүүс гэж үзэх нь цөөнгүй тохиолдож байв. (ФБЯ. Ахмад настны социаль асуудал 2020)

Ялангуяа ахмадууд нийгмийн харилцаатай байх, нийгмийн үйл ажиллагаанд оролцоотой байх хүсэл сонирхолтой хэдий ч 1) эрүүл мэндийн байдал нь хязгаарладаг, 2) тэтгэвэрт гарч, ажил хөдөлмөр эрхлэхгүй болсон, 3) хань ижил нь нас барж, ганцаараа үлдэх, 4) орлого багасаж, амьжиргаа доройтох, 5) өөрийн сул тал, бусадтай адил харилцаж чадахгүй зэргээс болсон (*жишээ нь, сонсгол муу учраас бусдад буруу ойлгогдох, буруу сонсож буруу ярих вий гэсэн*) санаа зовнил, эмээх сэтгэл төрдөг тул харилцахаас зайлсхийдэг. 6) Харилцааны хүрээ хумигдмал болсонтой (*үе тэнгийн, хамт ажиллаж амьдарч байсан, найзлаж нөхөрлөж явсан хүмүүс нас барж, цөөрсөн, зарим нь тоохоо больсон, залуучуудыг танихгүй г.м*) холбоотойгоор (Ж.Батжаргал 2022) нийгмээс тусгаарлагдаж байгаа аж.

Гадаад дахь хөдөлмөрийн мигрантууд. Гадны улс орныг зорих монголчуудын тоо жилээс жилд өсч өдгөө нийт хүн амын 3.7% буюу 122.3 мян.хүн хилийн чанадад амьдарч байна. Зөвхөн БНЧУ-д гэхэд л ойролцоогоор 10000 монголчууд ажиллаж, амьдардаг (ЭСЯ, 2020). Тэдний ойролцоогоор 60%,

гадаадад амьдарч буй нийт монголчуудын 30% хувиараа болон гэрээгээр ажиллах зорилготой, 14% нь суурьших зорилготой байна (ҮСХ 2020).

Хөдөлмөрийн мигрантуудын өмнө тулгамддаг хамгийн чухал асуудлууд нь тухайн нийгмийн интеграцид нэгдэх, нийгэм-соёлын орчин нөхцөлд дасан зохицох шаардлагатай болдог. Нийгмийн харилцаа, нийгмийн сүлжээ, нийгмийн капиталын асуудал нь тухайн хүнийг энэхүү өөрчлөлтөнд хэр дасан зохицож чадахад нөлөөлөх төдийгүй мөн дасан зохицож чадсаныг харуулах үр дүн болдог учраас тэдний нийгмийн харилцаа холбоо, нийгмийн капиталын асуудлыг авч үзэх нь ач холбогдолтой юм.

Чехэд амьдарч буй монголчуудын 62% нийгмийн капиталдаа анхаарч, хичээдэг бол эсрэгээрээ бусадтай харилцаатай байх, танил талтай байхыг анхаарч чухалчилдаггүй хүмүүс 38%-ийг эзлэж байв.

Нийгмийн сүлжээ. Нийт судалгаанд оролцогчдын 32% нийгмийн сүлжээ нь ердийн түвшинд, 9% харьцангуй өргөн нийгмийн сүлжээнд байдаг бол 44% нийгмийн сүлжээ бага, 16% нийгмийн ямар ч сүлжээгүй байна.

Нийгмийн өргөн сүлжээнд байхыг эрхэмлэдэг бүлэгт судалгаанд оролцогчдын 37.6% нь хамарч байна. Эл бүлгийнхэн найз нөхөд, ах дүү нар, хамаатан садан, хамт ажиллагсад, Чех дэх монголчууд болон чех хүмүүстэй ч тогтмол харилцаатай байх хэрэгтэй гэж үздэг.

Нийгмийн сүлжээний харилцаа нь *хэрэгцээнд нь үндэслэдэг бүлгийнхэн* 32.2% байв. Эдгээр хүмүүс найз нөхөд, ах дүү нартайгаа тогтмол харилцаатай, харин бусад хүмүүстэй хэрэгцээтэй үедээ харилцахыг эрмэлздэг.

Нийгмийн сүлжээний харилцаанд харьцангуй идэвхгүй байдаг хүмүүс 30.2% байв. Эдгээр хүмүүс найз нөхөд, ах дүү нартайгаа тогтмол харилцаатай байх, хамаатан садан, хамт ажиллагсад, Чех дэх монголчуудтайгаа хэрэгцээтэй үед харилцах, чех хүмүүстэй тааралдсан үедээ л харилцдаг, Чех дэх монголын ЭСЯ-ны ажилтнуудтай харилцдаггүй гэжээ.

Улс доторх сүлжээ. Монголчууд гэр бүлсэг хүмүүс бөгөөд Чехэд ажиллаж амьдарч буй монголчууд хэнтэй илүү дотно нөхөрсөг харилцаатай байдгийг тодруулахад 1) гэр бүл, ах дүүс (27.8%), 2) найз нөхөд (19.9%), 3) хамт ажиллаж буй хүмүүс (15.9%), 4) хамаатан садны (13.5%) харилцаа илүү дотно нөхөрсөг байдаг гэжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх (86.1%) нь өдөрт 1-2 таньдаг хүнтэй уулзаж, ярьж, харилцдаг.


Харин Чех дэх монголчууд хоорондын харилцаа дотно нөхөрсөг байдаг гэж 19% үзжээ. Тэдний хувьд цөөн тооны найз нөхөд, садан төрлийн хоорондын харилцаа голлодог (34%) бөгөөд бие биенээсээ болгоомжилсон харилцаа их (26.1%), бүгд дор дороо хувиа борлуулаад л явж байдаг (26.7%) гэж тодорхойлжээ.

Улс хоорондын сүлжээ. Бараг бүгд Монгол руу гэр бүлийнхэнтэйгээ холбогдож, харилцдаг. Монголд байгаа найз нөхөдтэйгөө 1/2, цөөнх хэсэг нь ажлын газар, мэргэжил нэг хүмүүс, танилуудтайгаа харилцаатай байдаг. Харин шинээр харилцаа үүсгэх, төрийн албаныхантай холбогдох нь маш бага байв. Ингэхдээ өдөр бүр Монголд байгаа хүмүүстэй холбогддог, харилцааны эрчим нь нягт хүмүүс 58,6%, харилцааны эрчим дундаж буюу долоо хоногт 1 удаа

харилцдаг нь 27%, харилцааны эрчим сул (сардаа 1, эсвэл баяр ёслолоор л холбогддог) хүмүүс 14.3% байна.

Тусгаарлагдмал байдлын нэгдсэн индексийг тооцвол Чехэд амьдарч буй монголчууд хамгийн багадаа 3 шинжээр, хамгийн ихдээ 17 шинжээр тусгаарлагдаж байгаа бөгөөд дундаж (mean) нь 9.9 байна. Нэгдсэн индексийн хэвийн тархалтад шилжүүлвэл -2.28-аас +2.37 хооронд байна.

Зураг 14



Тусгаарлагдаж буй шинжийнх нь тоогоор нийгмээс тусгаарлагдмал байдлын таван түвшинд ангилав.⁶⁹ Ингэхэд хилийн чанадад амьдарч буй монголчуудын 1/3 нь тусгаарлагдаагүй байгаа бол тусгаарлагдалтын өмнөх буюу эрсдэлт түвшинд 25%, дунд түвшинд 22%, ахисан болон гүнзгий түвшинд 21% нь багтаж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд тусгаарлагдалтын түвшин гүнзгийрэх тусам нийгмийн үйлчилгээ болон нийгмийн оролцооноос тусгаарлагдах нь илүү байна. Харин эдийн засгийн тусгаарлагдмал байдал харьцангуй бага юм.

Гадаад шилжигчдийн нийгэм, хүн ам зүйн зарим шинж байдлаар тусгаарлагдмал байдлын түвшинг авч үзэхэд эмэгтэйчүүд илүү өртөмтгий байна. Мөн хүүхдээ хараад гэртээ байгаа, ажилгүй хүмүүсийн олонх нь, техникийн болон үйлчилгээний ажилтан, ажилчдын 30-50 хувь нь дундаас дээш түвшинд тусгаарлагдмал байдалд байна. Түүнчлэн тэдний гадаад хэлний мэдлэг, ашиглах байдал тааруу бол тусгаарлагдах эрсдэл хийгээд тусгаарлагдмал байдлын гүнзгийрэлтийг нэмэгдүүлж буй.

Суурьшлын хувьд хөдөө тосгон, сууринд амьдардаг хүмүүс жижиг хотод амьдарч буй хүмүүсээс 21.6 пунктээр, нийслэл, томоохон хотод амьдардаг хүмүүсээс 36.7 пунктээр илүү тусгаарлагдмал байгаа бөгөөд тусгаарлагдах эрсдэл 2-7 пунктээр өндөр байна. Мөн суурьшин амьдраад хоёр хүртэл жил болж буй хүмүүсийн тусгаарлагдмал байдал таваас дээш жил амьдарч буй хүмүүсээс ойролцоогоор 3 дахин илүү байгаа нь гадаад шилжих хөдөлгөөнд оролцогчдын

⁶⁹ *Тайлбар*: Тусгаарлагдаагүй 8 хүртэл шинжээр, тусгаарлагдалтын өмнөх 9-10 шинжээр, тусгаарлагдалтын дунд түвшин 11-12 шинжээр, ахисан тусгаарлагдалт 13-14 шинжээр, гүнзгий тусгаарлагдалт 15-17 шинжээр хомстсон.

тусгаарлагдмал байдал, түүний түвшинд суурьшин амьдарсан хугацаа нөлөөтэй байгааг харуулна.

Архи, согтууруулах ундааны хэрэглээний түвшнээс хамаарч нийгмийн тусгаарлагдалтын байдал янз бүрийн түвшинд байх магадлалтай байна. Архи, согтууруулах ундааны хамаарлын түвшин өндөр, донтолттой хүмүүс ялангуяа нийгмийн тусгаарлагдмал байдалд нийгмийн харилцааны гадна зориуд үлдээх буюу тусгаарлах, нийгмийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, эдгээр хүмүүст чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний өртөг зардал өндөр бөгөөд санхүүжилт хомс, тусгайлсан эмчилгээ үйлчилгээ үзүүлэх бүтэц бий болоогүй, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл бүрэн бүрдээгүй байгаа юм. Бодлогын талаас архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, сэтгэл заслын болон эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлэх “бодит чадамж, үр нөлөө” бүхий бодлого үгүйлэгдэж байгаа юм.

Судалгааны дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, асаргаанд байдаг гишүүнтэй өрхийн тусгаарлагдмал байдал хийгээд тусгаарлагдах эрсдэл бусад бүлгээс үлэмж өндөр байна. Өөрөөр хэлбэл тусгаарлагмал байх, тусгаарлагдах эрсдэлт хүчин зүйлсийн нэг томоохон шалтгаан нь хөгжлийн олдмол болон төрөлхийн бэрхшээл юм. Мөн өрхөд хүнд өвчтэй, асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүн байх нь тухайн өрхийн болон гэр бүлийн бусад гишүүдийн тусгаарлагдах эрсдлийг нэмэгдүүлдэг байна.

Төрөлхийн эсвэл олдмол эсэхээс үл хамааран хөгжлийн бэрхшээл нь нөөц боломжийн аль ч хэлбэрээр хомсдох, нийгмийн үйлчилгээ, оролцоо, харилцаанаас хязгаарлагдах, амьдралын чанар, амьжиргааны тааруу байх, нийгмийн бүтэц дэх байр суурь, давхрааны хувьд доогуур байх суурь нэгэн шалтгаан болж байна. Хомсдмол байдлын шинжээр нь авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эдийн засаг, нийгмийн оролцоогоор гачигдмал, нийгмийн үйлчилгээний хомсдолт байдалд байна.

Нийгмийн тусгаарлагдмал байдлын олон улсын судалгаануудад нас (физиологийн, нийгмийн, сэтгэл зүйн) бол нийгмээс тусгаарлагдахад нөлөөлж буй нэгэн хүчин зүйл болохыг авч үздэг. Манай судалгаанд ч энэ таамаглал батлагдаж хүмүүсийн нас ахих тусам нийгмээс тусгаарлагдах байдал нэмэгдэж буй нь ажиглагдсан. Ингэхдээ насны бүлгийн хувьд ахмадууд нийгмээс тусгаарлагдах байдал өндөр байв. Өөрөөр хэлбэл ахмад настнуудын $\frac{1}{4}$ нь тусгаарлагдмал байдалд, $\frac{1}{5}$ нь тусгаарлагдах эрсдэлт бүлэгт багтаж байв. Энэ нь насны бусад бүлгээс мэдэгдэхүйц өндөр үзүүлэлт юм.

Түүнчлэн ахмад настнуудыг дотор нь насных нь эрэмбээр 4 бүлэгт хуваан авч үзвэл нас ахих тусам тусгаарлагдмал байдал хийгээд тусгаарлагдах эрсдэл өсч буй зүй тогтол хадгалагдаж байлаа. Тэр тусмаа өтөл настнуудын тусгаарлагдал байдал 35% байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байв. Тусгаарлагдмал байдлын төрлөөр авч үзвэл ахмадуудын дунд эдийн засгийн тусгаарлагдмал байдал харьцангуй өндөр юм. Ахмад наснуудын тусгаарлагдмал байдалд нөлөөлж буй зарим хүчин зүйлийн тухайд, тэдний гэр бүлийн байдал, бусдын тусламж дэмжлэг, сэтгэл ханамжийн байдал нөлөөлж байна. Нийгмийн

харилцаа, оролцооны хувьд Чехэд амьдарч буй монголчуудын 1/3 нь нийгмийн өргөн харилцаанд байдаг бол 1/3 нь хэрэгцээнд суурилсан харилцаанд, мөн 1/3 нь хумигдмал хүрээний харилцаанд байдаг байна. Монголд байгаа гэр бүлийнхэнтэйгээ бүгд харилцаа холбоотой байдаг бол Чехэд амьдарч буй монголчуудын хооронд бие биеэс болгоомжилсон харилцаа зонхилно. Тэнд амьдарч буй монголчуудын хүрээнд харилцаагаа өргөжүүлэх сонирхол төдийлөн байхгүй, өөрт хэрэгцээтэй хэсэг бүлгийн хүрээгээр харилцаагаа хязгаарлаж, тэр хүрээнд байхыг эрмэлздэг. Тэдний хувьд нийгмийн босоо сүлжээнээс хөндлөн сүлжээний харилцаа илүү байх бөгөөд 2/3 нь ямар нэгэн байгууллагад гишүүнчлэлгүй байв. Чехэд амьдарч буй монголчуудын 40 гаруй хувь нь ахисан болон гүнзгий түвшинд тусгаарлагдсан байх бол 1/4 нь тусгаарлагдах эрсдэлд байна. Тэдний дунд нийгмийн үйлчилгээ, нийгмийн оролцооноос тусгаарлагдах нь нэлээд байдаг боловч эдийн засгийн тусгаарлагдмал байдал харьцангуй бага юм. Мөн хөдөө тосгон сууринд амьдардаг, шилжиж ирээд хоёр хүртэл жил болж буй, эмэгтэйчүүд голдуу, ажилгүй, техник-үйлчилгээний ажилтан, туслах ажилчин хийж буй хүмүүсийн ахисан болон гүнзгий тусгаарлагдалт илүү өндөр байна. Түүнчлэн тэдний тусгаарлагдмал байдлын түвшинд, тусгаарлагдах эрсдэлд өртөх магадлалд чех хэлний мэдлэг, оршин суух зөвшөөрлийн төрөл чамгүй нөлөөтэй аж. Гадаад хүн гэдгээсээ болж зарим төрлийн харилцаанд ялгаварлан гадуурхагдах, тэгш бус харилцааг мэдэрдэг бөгөөд ийм төрлийн мэдрэмж өндөр байх нь тэдний тусгаарлагдмал байдлын түвшинг гүнзгийрүүлэхийн хамт харилцаанаас тусгаарлагдах эрсдлийг нэмэгдүүлж байна.

Дүгнэлт

Хувь хүний эрсдэлт шинж байдал, орон нутгийн онцлог нөхцөл байдал, нийгмийн тусгаарлагдмал байдлын хүчин зүйлийн харилцан үйлчлэлийн үр дүнд хувь хүн нийгмээс тусгаарлагдахад хүрдэг. Өөрөөр хэлбэл, бага боловсрол, хөгжлийн бэрхшээл, цөөнх байх гэх мэт нийгмийн тусгаарлагдалтын олон эрсдэлт шинжтэй хувь хүмүүс нь эдийн засгийн нөхцөл байдал, ажил эрхлэх боломж, дэд бүтцийн хөгжил муудсан, хүчирхийлэл гарч байсан, амьдарч буй орчин сүйдсэн зэрэг орон нутгийн орчин, нөхцөл байдлын дунд нийгмээс тусгаарлагдахад хүрдэг гэж үзжээ. Харин бүтэц, институци байгууллагууд, үнэлэмж, зан төлөвийн хэв маяг, бодлого гэх мэт нийгмийн тусгаарлагдмал байдалд хөтлөгчид нь хувь хүний эмзэг байдлыг нийгмийн тусгаарлагдахал хүргэх үйл явцыг удаашруулах юм уу хурдасгадаг гадаад хүчин зүйлс болдог байна. Эдгээр гол гурван хүчин зүйлийн харилцан үйлчлэлийн үр дүнд бий болж буй нийгмээс тусгаарлагдах үзэгдлийг үйл явц дунд нь судлах, тэдгээрийн нөлөөллийг тодорхойлон хэмжилт хийх аргачлалаар судалгааг явуулахад дараах үр дүн гарав.

Нэгдүгээрт, судлагдсан хүмүүсийн 31.0 хувьд нь нийгмээс хөндийрөх, тусгаарлагдах, нийгмийн үйл ажиллагаанд эс хамрагдах хандлага илэрч байна.

Хоёрдугаарт, Нийгмийн тусгаарлагдмал байдалд өртөгсөд 15.7 хувийг эзэлнэ. Эдгээр хүмүүсийг тусгаарлагдалтын дунд, ахисан, гүнзгий түвшинд

тусгаарлагдагчид хэмээн үзэж болох юм. Тэгвэл үлдэх 15.3 хувь нь тусгаарлагдалтын өмнөх шатанд байна.

Гуравдугаарт, Нийгмийн тусгаарлагдмал байдлын эрчимт байдал (А) нь 46.1 хувь, нийгмийн тусгаарлагдмал байдалд өртөгсдийн хомсдолт шинжийн дундаж нь 11.1 буюу нийслэл хот, хийгээд хот, хөдөөд нэг иргэн 24 илтгүүрээс 11-д нь хомсдол гачигдалд орсон бараг ижил үзүүлэлттэй байв. Нийгмийн тусгаарлагдмал байдлын индекс нь 14.3 гарав. Индекс нь нийгмийн тусгаарлагдмал байдлын тоо, эрчмийн үзүүлэлтийн шууд үр дүн бөгөөд индексийн утга их байх тусам нийгмийн тусгаарлагдмал байдал их байна гэсэн үг.

Дөрөвдүгээрт, Нийгмийн тусгаарлагдмал байдлын илрэл буюу гачигдал хомсдлын эрчимт байдал хотоос хөдөөд харьцангуй илүү байгаа дүр төрх ажиглагдав. Тусгаарлагдалтын энэхүү индекс амьжиргааны доод түвшин хийгээд ядуурлын үзүүлэлтээс илүү өргөн хүрээг хамарч байна гэж хэлж болох юм.

Тавдугаарт, Боловсрол бага, хөгжлийн бэрхшээлтэй, эрүүл мэнд тааруу, өндөр настай, ганц бие үр хүүхэдгүй хүмүүс, тэдний идэвхгүй байдал, зан төлөв харилцаа муутай, ажил хөдөлмөр хийдэггүй, орлого байхгүй, түр зуурын орлого л олдог, архи уух, архинд донтох гэх зэрэг хувь хүний эрсдэлт шинж байдал, байгаль газарзүйн нөхцөл байдал, цаг уур, зах зээлээс хол, бараа бүтээгдэхүүнээ аваачиж борлуулах боломж нь хомс, ажилгүйдэл өндөр, ажлын байр байдаггүй, дэд бүтэц тааруу, (зам муутай, байшин барилгын чанар муу, нэгдсэн халаалт байхгүй, сумын төвийн барилгуудыг уурын зуухаар халаадаг) зэрэг орон нутгийн онцлог нөхцөл байдал, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын алдаа, төрийн үйлчилгээ, бодлого дутагдаж байгаа, нийгмийн халамжийн бодлого гажуудсан зэрэг нийгмийн тусгаарлагдалтын хүчин зүйлийн харилцан үйлчлэлийн үр дүнд иргэд нийгмээс тусгаарлагдахад хүрч байна.

ХАВСРАЛТ-1

ШУА-ИЙН ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭНД
2019-2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН

“НИЙГМИЙН ОРОЛЦОО БА ТУСГААРЛАГДАХ ҮЙЛ ЯВЦ, ҮР ДАГАВАР”
СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ҮР ДҮНД ГАРСАН

ГОЛ БҮТЭЭЛ

Эрдэм шинжилгээний өгүүлэл (гадаадад-4)

1. Ё.Ундрал, В.Г.Жалсанова. Социологический анализ пространственной сегрегации Улан-Батора. // “Теория и практика общественного развития”. Научный журнал. 2019/4. С. 51-55 // <https://doi.org/10.24158/tipor.2019.4.7>
2. Ж.Батжаргал, Д.Номун-Эрдэнэ. Чех улс дахь монголчуудын нийгмийн капитал, нийгмийн харилцааны зарим онцлог. 616-618 дахь тал. DOI: 10.53954/9785604788981_616 // Мир Центральной Азии-V: Сборник научных статей, Улан-Удэ, 30 июня – 03 2022 года. – Новосибирск: Сибирское отделение РАН, 2022. – 722 с. – ISBN 978-5-6047889-8-1. – EDN APQLJU // <https://elibrary.ru/item.asp?id=48693647>
3. I.E.Sokolovskaya, Tsetsenbileg Tseveen. Capitalization of the education sector: problems and prospects. // Economic and Social Development (Book of Proceedings), 60th International Scientific Conference on Economic and Social Development - XX International Social Congress (ISC 2020), Moscow, 20-21 October, 2020. P.524-532 // https://www.esd-conference.com/upload/book_of_proceedings/Book_of_Proceedings_esdMoscow2020_Online.pdf
4. Ё.Ундрал, Б.Азбаяр. Монгол дахь ахмадуудын нийгмийн ялгаварлан гадуурхалт болон материаллаг байдал. (Социальная дискриминация и материальное положение пожилых людей в Монголии) DOI: 10.53954/9785604788981_613 // “Мир центральной Азии – V” ОУЭШХ-ын эмхэтгэл. Новосибирск, 2022. 613-615 дахь тал.

Эрдэм шинжилгээний өгүүлэл (дотоодод-12)

1. Ц.Пүрэв. Монголын нийгмийн давхражилтыг нөөц боломжийн хандлагаар судлах асуудалд // ШУА-ийн Философийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. №XXXIV. “Тод бичиг” хэвлэлийн газар. УБ., 2019. 90-102 дахь тал.
2. Ц.Пүрэв. Нийгмийн ялгарал ба тусгаарлагдахуй: ойлголт, хэмжилт, туршилт // “Социологи” эрдэм шинжилгээний бичиг. XIII (№517). УБ., 2020. 20-33 дахь тал. МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Социологи, нийгмийн ажлын тэнхим.
3. Ц.Пүрэв, П.Бямбадорж. Хөдөлмөрийн зах зээлд оролцохуй ба тусгаарлагдахуй // ШУА-ийн Философийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. №XXXV. “Тод бичиг” хэвлэлийн газар. УБ., 2020. 105-123 дахь тал.
4. Ж.Батжаргал. “Ахмад настны нийгмийн харилцаа, нийгмийн капиталын байдлыг судлах нь”. //ШУА-ийн Философийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. Боть XXXV. “Тод бичиг” хэвлэлийн газар. УБ., 2020. 153-165 дахь тал.
5. О.Баасантогтох. Covid-19: иргэдийн амьдрал, амьжиргаанд тулгарч буй бэрхшээл // ШУА-ийн Философийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. №XXXV. “Тод бичиг” хэвлэлийн газар. УБ., 2020. 166-175 дахь тал.
6. Ц.Цэцэнбилэг, Ц.Уянга. Гэр бүлийн амьдралын мөчлөг, шинж байдал. //ШУА-ийн Философийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. №XXXV. “Тод бичиг” хэвлэлийн газар. УБ., 2020. 141-152 дахь тал.

7. Ц.Пүрэв, Ж.Батжаргал. Нийгмийн тусгаарлагдалтын олон хэмжээст индекс байгуулсан аргачлалыг туршсан нь. //ШУА-ийн Философийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. №XXXV. “Тод бичиг” хэвлэлийн газар. УБ., 2021. 21-50 дахь тал.
8. Д.Номун-Эрдэнэ. Монголын нийгмийн бүтцийн судалгаанд нийгмийн давхраажилтын зарим арга зүйг хэрэглэх нь. //ШУА-ийн Философийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. №XXXVI. “Тод бичиг” хэвлэлийн газар. УБ., 2021. 51-70 дахь тал.
9. Ц.Пүрэв. Монголчуудын амьдралын нөөц боломжийн судалгааны зарим дүнгээс. //“Социологи” эрдэм шинжилгээний бичиг. МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Социологи, нийгмийн ажлын тэнхим.
10. О.Баасантогтох. Social Exclusion: хэрэглээ, ойлголтын олон янз байдал. //“Социологи” эрдэм шинжилгээний бичиг. МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Социологи, нийгмийн ажлын тэнхим. УБ., 2022.
11. Т.Бүрэнжаргал, Ё.Ундрал. Хотын социологийн үүсэл хөгжил ба сегрегаци //“Социологи” эрдэм шинжилгээний бичиг. МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Социологи, нийгмийн ажлын тэнхим. УБ., 2022.
12. Ц.Пүрэв. Социологийн өгөгдлийг боловсруулахад хүчин зүйлийн шинжилгээний аргыг хэрэглэх нь (0.6 х.х). // Идэр эрдэм онлайн сэтгүүл. УБ., 2021.

Эрдэм шинжилгээний илтгэл (гадаадад-6)

1. Цэвээний Цэцэнбилэг, Ариунбилэг Хүрэлхүү. Оценка значимости организации психологической службы в средних школах Монголии: проблемы и перспективы. //“Практическая психология в условиях современных кризисов: проблемы, перспективы и решения” Всероссийская научно-практическая конференция с международным участием, посвященная 90-летию БГПИ-БГУ. Улан-Удэ, 23 сентября 2021. /Хэвлэгдээгүй/
2. Цэвээний Цэцэнбилэг, Цогтбаатар Уянга. Кризисы и жизненные циклы семей Монголии. //“Практическая психология в условиях современных кризисов: проблемы, перспективы и решения” Всероссийская научно-практическая конференция с международным участием, посвященная 90-летию БГПИ-БГУ. Улан-Удэ, 23 сентября 2021.
3. Мадюкова С.А., Ерохина Е.А., Чанкова И.В., Цэцэнбилэг Цэвээний. Этнические, государственные, международные языки: функции, смыслы, ценности. //Языки и смыслы: материалы XX Международной научной конференции молодых ученых в области гуманитарных и социальных наук /редкол.: В. В. Петров и др. Новосибирский государственный университет. – Новосибирск: ИПЦ НГУ, 2022. – 404 с. — С. 419-435. // https://elibrary.ru/download/elibrary_50180554_90841195.pdf
4. Жаргалсайхан Пурэвханд. Об исследовании “трудных, исключенных” групп: обсуждение психологических методов //“Практическая психология в условиях современных кризисов: проблемы, перспективы и решения” Всероссийская научно-практическая конференция с международным участием, посвященная 90-летию БГПИ-БГУ. Улан-Удэ, 23 сентября 2021.
5. Ц.Пүрэв, П.Бямбадорж. Прекариат бүлгийг судлах онол арга зүйн зарим асуудал. //“Social Security and Population Social Protection in the Modern Context” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Зохион байгуулагч: Буриадын их сургууль. 2022.06.10.
6. Ц.Цэцэнбилэг. Подростки и их безопасность в Интернет пространстве. //“Человек в современном мире: кризис и глобализация”. Международная научная междисциплинарная конференция (Россия-Франция-Италия), Со-организаторы: Образовательно-культурный Центр “Интер-Спутник” (Москва, Россия), Российский Государственный Социальный Университет (Москва, Россия), Государственный Университет Управления (Москва, Россия), 1-5 июля 2020. /Хэвлэгдээгүй/

Эрдэм шинжилгээний илтгэл (дотоодод-14)

1. Ц.Цэцэнбилэг. Нийгмийн тэгш бус байдлыг бууруулахад олон улсын доноруудын үүрэг, оролцоо. //“Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах нь: мэдлэгээс төрийн бодлогод” олон улсын эрдэм шинжилгээний семинар. УИХ-ын Тамгын газар, ШУА, ЮНЕСКО. 2019.7.17-19. УБ., 2020.
2. О.Баасантогтох. Хот, хөдөөгийн тэгш бус байдал: бүс нутгийн ялгаа. //“Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах нь: мэдлэгээс төрийн бодлого” эрдэм шинжилгээний олон улсын семинарын эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар, ШУА, ЮНЕСКО. 2019.7.17-19. УБ., 2020. 186-195 дахь тал.
3. О.Баасантогтох. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл ба албадлын шинжтэй тусгаарлах арга хэмжээ, түүний ялгаатай байдал. (0.6 х.х) // “Хүрэл тогоот-2020” эрдэм шинжилгээний хурал. Зохион байгуулагч: Монголын залуу эрдэмтдийн холбоо. 2020.12. /Хэвлэгдээгүй/
4. Ж.Батжаргал. Нийгмийн капитал ба нийгмийн тусгаарлагдалтын холбоо хамаарал ба шинжилгээг уялдуулах нь (0.6х.х) //Идэр эрдэм онлайн сэтгүүл. УБ., 2021.
5. О.Баасантогтох. Нийгмийн тусгаарлалт: хэрэглээ, ойлголтын олон янз байдал (Монголд хийсэн зарим судалгааны тайлан, үр дүнд хийсэн шинжилгээ) (0.6 х.х) //“Идэр эрдэм” онлайн сэтгүүл. УБ., 2021.
6. Д.Номун-Эрдэнэ. Нийгмээс тусгайлагдах үйл явцын шинжилгээнд нийгмийн шилжилтийг судлах арга зүйг хэрэглэх нь (0.4 х.х) //“Идэр эрдэм” онлайн сэтгүүл. УБ., 2021.
7. О.Баасантогтох. Малчдын нийгмийн ялгарал. //“Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага” ЭШБХ. Зохион байгуулагч: Цогц хөгжлийн үндэсний төв ТББ. “Новотел” зочид буудал. УБ. 2021.11.26.
8. Ц.Пүрэв. Монголчуудын амьдралын нөөц боломжийн судалгааны зарим дүнгээс. //“Монголын нийгмийн харилцаа: төлөв байдал, хандлага” Социологийн VI симпозиум. Зохион байгуулагч: МУИС, НШУС, Нийгмийн судалгааны хүрээлэн. УБ., 2022.6.15.
9. Ц.Пүрэв. Монголчуудын амьдралын нөөц боломж, хомсдол, нийгмийн тусгаарлагдалт. //“Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт” ОУЭШХ. Философийн хүрээлэнгийн 50 жилийн ой. “Соёмбо принтинг” ХХК. УБ., 2022. 163-194 дэх тал.
10. Ж.Батжаргал. Нийгмийн тусгаарлагдалт ба нийгмийн капитал: онол арга зүй, эмпирик үр дүн. //“Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт” ОУЭШХ. Философийн хүрээлэнгийн 50 жилийн ой. “Соёмбо принтинг” ХХК. УБ., 2022. 219-243 дахь тал.
11. О.Баасантогтох. Нийгмийн институт ба нийгмийн тусгаарлагдалт. //“Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт” ОУЭШХ. Философийн хүрээлэнгийн 50 жилийн ой. “Соёмбо принтинг” ХХК. УБ., 2022. 244-257 дахь тал.
12. Д.Номун-Эрдэнэ. Нийгмийн мобиль хөдөлгөөн, тусгаарлагдалт. //“Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт” ОУЭШХ. Философийн хүрээлэнгийн 50 жилийн ой. “Соёмбо принтинг” ХХК. УБ., 2022. 322-332 дахь тал.
13. Ё.Ундрал. Ядуурал ба тусгаарлагдах үйл явц. //“Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт” ОУЭШХ. Философийн хүрээлэнгийн 50 жилийн ой. “Соёмбо принтинг” ХХК. УБ., 2022. 333-348 дахь тал.
14. Ж.Пүрэвханд. Албан бус хөдөлмөр эрхлэлт тусгаарлагдалттай холбогдох нь. //“Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт” ОУЭШХ. Философийн хүрээлэнгийн 50 жилийн ой. “Соёмбо принтинг” ХХК. УБ., 2022. 349-361 дэх тал.

Боловсруулсан судалгааны арга зүй, аргачлал, хэрэглэгдэхүүн

1. Ц.Пүрэв, Ж.Батжаргал, О.Баасантогтох. Нийгмийн оролцоо ба тусгаарлагдах үйл явц, үр дагавар. Туршилтын судалгааны удирдамж (1.4 х.х).
2. Ц.Пүрэв, Ж.Батжаргал, О.Баасантогтох. Нийгмийн оролцоо ба тусгайлагдах үйл явц, үр дагавар. Суурь судалгааны удирдамж (2 х.х).
3. Ж.Батжаргал, Д.Номун-Эрдэнэ. “Нийгмийн оролцоо ба тусгаарлагдах үйл явц, үр дагавар” ГЯ, ЭЯ, ФБЯ-ын асуулга (0.6 х.х).
4. Нийгмийн оролцоо ба тусгаарлагдах үйл явц, үр дагавар судалгааны анкет (1 х.х).
5. Ж.Батжаргал, Д.Номун-Эрдэнэ. “Чех дэх монголчууд” анкетын асуулга (0.9 х.х).
6. Ж.Батжаргал “Чех дэх монголчууд” ГЯ, ЭЯ, ФБЯ-ын асуулга (0.6 х.х).

Судалгааны үр дүн, тайлан, санал зөвлөмж

1. “Нийгмийн оролцоо ба тусгаарлагдах үйл явц, үр дагавар” судалгааны тайлан (13 х.х). ШУА. ФХ. 2022.
2. Судалгааны нэгдсэн дүнгийн хүснэгт (2 х.х)

Нэг сэдэвт бүтээл

1. “Монголын нийгэм дэх тусгаарлагдах үйл явц, үр дагавар” (26 х.х). Ред: Ц.Пүрэв, Ж.Батжаргал. УБ., 2023.

Ном товхимол

1. М.Золзаяа, Ё.Ундрал. Нийгмийн тэгш бус байдал. (А5 хэмжээ. 50 нүүр) ШУА. Танин мэдэхүйн цуврал – 79. Ред. Ц.Пүрэв. УБ., 2021.

Ярилцлага

1. Ж.Батжаргал. Ядуурлын эсрэг жор бий юу? Өнөөдөр сонин.
<https://www.unuudur.mn/a/249750>

ХАВСРАЛТ-2

Эрдэм шинжилгээний өгүүлэл (гадаадад)

Ж.Батжаргал, Д.Номун-Эрдэнэ. Чех улс дахь монголчуудын нийгмийн капитал, нийгмийн харилцааны зарим онцлог. 616-618 дахь тал. DOI: 10.53954/9785604788981_616 //Мир Центральной Азии-V: Сборник научных статей, Улан-Удэ, 30 июня – 03 2022 года. – Новосибирск: Сибирское отделение РАН, 2022. – 722 с. – ISBN 978-5-6047889-8-1. – EDN APQLJU // <https://elibrary.ru/item.asp?id=48693647>

DOI: 10.53954/9785604788981_616

*Жаргалсайхан Батжаргал
Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс
jargalbj999@gmail.com*

*Даваадорж Номун-Эрдэнэ
Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс
nomunerdene.d@gmail.com*

ЧЕХ УЛС ДАХЬ МОНГОЛЧУУДЫН НИЙГМИЙН КАПИТАЛ, НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ ОНЦЛОГ

Эл илтгэлд Монгол улсын ШУА-ийн Философийн хүрээлэн, БНЧУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2019 онд хийсэн “Чех дэх Монголчууд” судалгааны үр дүнд үндэслэн Чехэд ажиллаж буй монголчуудын нийгмийн харилцаа, нийгмийн сүлжээ, нийгмийн капиталын байдал, онцлогийн талаар танилцуулав. Мөн монгол ажилчдыг Чехийн нийгэмд нэгтгэхэд нийгмийн капитал хэрхэн нөлөөлж байгааг авч үзлээ. Шилжин ирэгсэд монголчуудын нийгмийн сүлжээгээр дамжуулан илүү сайн ажлын байртай болж, ажиллах нөхцөлөө сайжруулах давуу талтай. Энэ нь тэднийг нийгмийн шинэ орчинд дасан зохицоход тусалдаг ч эргээд Чехийн нийгэмд нэгдэхэд нь саад учруулж байгаа юм.

Түлхүүр үг: нийгмийн капитал, нийгмийн харилцаа, нийгмийн сүлжээ, монголчууд, цагаач иргэд.

*Jargalsaikhan Batjargal
Institute of Philosophy of the, Mongolian Academy of Science
Mongolia, Ulaanbaatar*

*Davaadorj Nomun-Erdene
Institute of Philosophy of the Mongolian Academy of Science
Mongolia, Ulaanbaatar*

SOME FEATURES OF SOCIAL CAPITAL AND SOCIAL RELATIONS OF MONGOLIANS IN THE CZECH REPUBLIC

The report presents the results of a study of social relations, social networks and social capital of Mongolians who work in the Czech Republic based on the “Mongolians in the Czech Republic” survey from 2019 conducted in collaboration of the Institute of Philosophy in Mongolia and the Institute of Sociology in Czech Republic. It also examines the impact of social capital on the integration of mongolian workers into Czech society. Migrants have the advantage of being able to find better jobs and improve their working conditions through the social network of Mongolians. It assumes that it helps them to adapt to the new social environment, but also prevents them from integration into the society.

Keywords: social capital, social relations, social network, Mongolians, migrants.

Оршил

Гадны улс орныг зорих монголчуудын тоо жилээс жилд өсч өдгөө нийт хүн амын 3,7% буюу 122.3 мян. хүн хилийн чанадад амьдарч байна. Зөвхөн БНЧУ-д гэхэд л ойролцоогоор 10000 монголчууд ажиллаж, амьдардаг (ЭСЯ, 2020). Тэдний ойролцоогоор 60%, гадаадад амьдарч буй нийт монголчуудын 30% хувиараа болон гэрээгээр ажиллах зорилготой, 14% нь суурьших зорилготой байна (ҮСХ, 2020). Хөдөлмөрийн мигрантуудын өмнө тулгамддаг хамгийн чухал асуудлууд нь тухайн нийгмийн интеграцид нэгдэх, нийгэм-соёлын орчин нөхцөлд дасан зохицох шаардлагатай болдог. Нийгмийн харилцаа, нийгмийн сүлжээ, нийгмийн капиталын асуудал нь тухайн хүнийг энэхүү өөрчлөлтөнд хэр дасан зохицож чадахад нөлөөлөх төдийгүй мөн дасан зохицож чадсаныг харуулах үр дүн болдог учраас тэдний нийгмийн харилцаа холбоо, нийгмийн капиталын асуудлыг авч үзэх нь ач холбогдолтой юм.

Онол, арга зүйн баримтлал

Нийгмийн харилцаа, нийгмийн сүлжээ, нийгмийн капитал гэсэн ойлголтууд нь өөр хоорондоо нягт холбоотой. Нийгмийг бүрдүүлэгч хүмүүс, бүлэг, байгууллага, төр гэх мэт эдгээр агентуудын хоорондын харилцаа нь тодорхой бүтэцтэй байх бөгөөд харилцааны бүтцийг бүх оролцогчдыг холбож буй сүлжээ гэж үзэх нь бий. Харилцаа холбоо нь оролцогчдын хоорондын харилцаа холбоо төдий биш, үүгээр мөн янз бүрийн нөөцийг солилцдог. Нийгмийн сүлжээг тодорхой хувь хүмүүс болон тэдний хоорондын нийгмийн харилцаа холбоо, нийгмийн холбоо хамаарлын цогц юм хэмээн тодорхойлдог. Нийгмийн капиталыг Ф. Фукуяама нийгэм дэх бодит харилцаануудын дундаас үүсдэг, нийгмийн бүлгүүдийн хамтын ажиллагааг хөхүүлдэг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хамтын үнэлэмж юм гэж тэмдэглэсэн (Фукуяама 2005: 320). П. Бурдые капитал бол нийгмийн харилцаа гэж үзсэн бол Ж. Коулман “нэг талаас, нийгмийн капитал нийгмийн сүлжээнүүдийн мөн чанар нөгөө талаас, нийгмийн холбоо харилцаа нь сүлжээний оролцогчдод нөөц ба бусад ашиг тусыг бий болгох боломжийг олгоход л илэрдэг” (Попов 2011) гэж үзжээ. Путнам “нийгмийн капиталыг нийтийн ашиг буюу оролцооны боломж, иргэний чиг баримжаа, бусад хүмүүст итгэх итгэлийн хэмжээ” гэж үздэг (Putnam 1993). Судалгааны үр дүнгээс. Чехэд амьдарч буй монголчуудын 62% нийгмийн капиталдаа анхаарч, хичээдэг бол эсрэгээрээ бусадтай харилцаатай байх, танил талтай байхыг анхаарч чухалчилдаггүй хүмүүс 38%-ийг эзлэж байв. Нийгмийн сүлжээ. Нийт судалгаанд оролцогчдын 32% нийгмийн сүлжээ нь ердийн түвшинд, 9% харьцангуй өргөн нийгмийн сүлжээнд байдаг бол 44% нийгмийн сүлжээ бага, 16% нийгмийн ямар ч сүлжээгүй байна. Нийгмийн өргөн сүлжээнд байхыг эрхэмлэдэг бүлэгт судалгаанд оролцогчдын 37,6% нь хамарч байна. Эл бүлгийнхэн найз нөхөд, ах дүү нар, хамаатан садан, хамт ажиллагсад, Чех дэх монголчууд болон чех хүмүүстэй ч тогтмол харилцаатай байх хэрэгтэй гэж үздэг. Нийгмийн сүлжээний харилцаа нь хэрэгцээнд нь үндэслэдэг бүлгийнхэн 32,2% байв. Эдгээр хүмүүс найз нөхөд, ах дүү нартайгаа тогтмол харилцаатай, харин бусад хүмүүстэй хэрэгцээтэй үедээ харилцахыг эрмэлздэг. Нийгмийн сүлжээний харилцаанд харьцангуй идэвхгүй байдаг хүмүүс 30,2% байв. Эдгээр хүмүүс найз нөхөд, ах дүү нартайгаа тогтмол харилцаатай байх, хамаатан садан, хамт ажиллагсад, Чех дэх монголчуудтайгаа хэрэгцээтэй үед харилцах, чех хүмүүстэй тааралдсан үедээ л харилцдаг, Чех дэх монголын ЭСЯ-ны ажилтнуудтай харилцдаггүй гэжээ.

Улс доторх сүлжээ. Монголчууд гэр бүлсэг хүмүүс бөгөөд Чехэд ажиллаж амьдарч буй монголчуудхэнтэй илүү дотно нөхөрсөг харилцаатай байдгийг тодруулахад 1) гэр бүл, ах дүүс (27,8%), 2) найз нөхөд (19,9%), 3) хамт ажиллаж буй хүмүүс (15,9%), 4) хамаатан садны (13,5%) харилцаа илүү дотно нөхөрсөг байдаг гэжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх (86,1%) нь өдөрт 1-2 таньдаг хүнтэй уулзаж, ярьж, харилцдаг. Харин Чех дэх монголчууд хоорондын харилцаа дотно нөхөрсөг байдаг гэж 19% үзжээ. Тэдний хувьд цөөн тооны найз нөхөд, садан төрлийн хоорондын харилцаа голлодог (34%) бөгөөд бие биенээсээ болгоомжилсон харилцаа их (26,1%), бүгд дор дороо хувиа борлуулаад л явж байдаг (26,7%) гэж тодорхойлжээ. Улс хоорондын сүлжээ. Бараг бүгд Монгол руу гэр бүлийнхэнтэйгээ холбогдож, харилцдаг. Монголд байгаа найз нөхөдтэйгөө 1/2, цөөнх хэсэг нь ажлын газар, мэргэжил нэг хүмүүс, танилуудтайгаа харилцаатай байдаг. Харин шинээр харилцаа үүсгэх, төрийн албаныхантай холбогдох нь маш бага байв. Ингэхдээ өдөр бүр Монголд байгаа хүмүүстэй холбогддог, харилцааны эрчим нь нягт хүмүүс 58,6%, харилцааны эрчим дундаж буюу долоо хоногт 1 удаа харилцдаг нь 27%, харилцааны эрчим сул (сардаа 1, эсвэл баяр ёслолоор л холбогддог) хүмүүс 14,3% байна. Нийгмийн капиталын хэлбэрүүд. Холбогч нийгмийн капитал (хөндлөн сүлжээ). Хөндлөн сүлжээний хамгийн нягт харилцаатай буюу голд байгаа бүлэг гэр бүл ойр дотны хүмүүс, дараагийн тойрогт найз нөхөд, монгол хүмүүс, үзэл бодол нэг хүмүүс, ажлынхан, нэг зиндааны хүмүүс, хөршүүд гэсэн дарааллаар байршиж байна. Хөндлөн сүлжээн дэх дээр дурьдсан бүлгүүдтэй харилцах харилцаа холбоо нэлээд ялгаатай байна. Тухайлбал, гэр бүл ойр дотны хүмүүс, найз нөхөд, бусад

монголчууд, үзэл бодол нэг хүмүүстэй харилцаа холбоо илүү гүн, бие биенээ дэмжиж, туслан хамтран ажиллах нь илүү байдаг. Эдгээр бүлэгт харилцдаггүй хүн 0-7.4% байгаа бол илүү их харилцдаг, холбоо хэлхээ сайтай байдаг 10,3-36,7% байна. Чехэд амьдарч буй монголчуудын хувьд хөршүүд, ажлынхан нь ихэвчлэн гадны иргэд байгаа учраас эдгээр бүлгүүдтэй харилцаа холбоо сул байх нь давамгайлж байна. Хөршүүд, байрныхантайгаа 29,4% харилцдаггүй.

Гүүр бологч нийгмийн капитал (босоо сүлжээ). Чех дэх монголчуудын 1/2 төрийн албаныхантай, барагцаагаар 1/3 үзэл бодол, шашин өөр болон нийгмийн байр суурь өндөр хүмүүстэй, 1/4 доогуур нийгмийн байр суурьтай хүмүүстэй, 1/5 чех болон гадаад хүмүүстэй харилцдаггүй. Босоо харилцааны сүлжээнд хамгийн бага харилцаа холбоотой байдаг бүлэг нь төрийн албаныхан, бусдаас арай давуу харилцаатай байдаг бүлэг нь нийгмийн байр суурь доогуур хүмүүс, чех, гадаад хүмүүс байв. Итгэл. Итгэлийн ерөнхий үзүүлэлтээр 4:1 харьцаагаар бусдад итгэх итгэл тааруу байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын 1/5 ихэнх хүмүүст итгэж болно гэж үзэж байгаа бол 4/5 ихэнх хүмүүс итгэл даадаггүй гэжээ. Шаталсан кластер шинжилгээний үр дүнгээр эхний бүлэгт хамаатан ураг төрлийн хүмүүс, хоёрдугаар бүлэгт найз нөхөд, нутаг нэгт монголчууд, хөрш, хамт ажиллагсад, гуравдугаар бүлэгт чех хүмүүс, Чехийн ОН-ийн засаг захиргаа, Чех дэх Монголын ЭСЯ-ны ажилтнууд оржээ.

Гишүүнчлэл. Нийт хүмүүсийн 66,1% ямар ч гишүүнчлэлгүй, харин 33,9% монголчуудын холбоо, сонирхлын бүлэг, биеийн тамир спортын холбоо, сургууль цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл, улс төрийн намзэрэг арав гаруй байгууллагад харъяалагддаг. Ойролцоогоор 1/5 нэг байгууллагад, 6% нь 2 байгууллагад, 2,6% нь 3 байгууллагад харъяалалтай байна. Нийгмийн капитал ба нийгмийн интеграци. Эрүүл мэнд, боловсрол гэх мэт нийгмийн үйлчилгээ авахад ихэнх хүмүүст хэл мэдэхгүйгээс, хэлний чадвар тааруу байгаагаас харилцахад асуудал үүсдэг (46,3%), мэдээлэл авч чадахгүй, үйлчилгээнд хэрхэн хамрагдах, хэнд хандахаа мэдэхгүй байх(17,3%) зэрэг асуудал тулгардаг байна. Олноороо байдаг хотод амьдардаг, хамтдаа ажилладаг монголчууд чех хэл сураагүй, тэр байтугай 10-аас дээш жил амьдарч буй хүмүүсийн дунд хүртэл чех хэл сураагүй хүмүүс олон байв. Чех хэл эзэмшиж чадаагүйгээс ажил албан тушаал ахиж дэвших боломжгүй, нийгэм соёлын амьдралд оролцож чадахгүй, хүмүүстэй харилцах нь ч хязгаарлагдмал байна.

Дүгнэлт.

Чехэд амьдарч буй монголчуудын 2/3 нь нийгмийн сүлжээ байхгүй, сул байгаа бөгөөд 1/3 нь өөрсдийн нийгмийн капиталыг өргөжүүлэхэд анхаардаггүй. Тэдний хувьд холбогч нийгмийн капитал өндөр байгаа тул гүүр бологч нийгмийн капитал нь бага байна. Босоо сүлжээнд харилцагч бүлгүүдтэй харьцангуй жигд харилцдаг, ялгаа бага байсан бол хөндлөн сүлжээнд бүлгүүдтэй эрс ялгаатай байдлаар харилцдаг онцлогтой байв. Бүлгүүдтэй харилцах харилцааны дундаж хандлагаар харьцуулан үзвэл нийгмийн капитал тааруу байгааг харуулж буй харилцдаггүй гэсэн хүмүүсийн хувь босоо сүлжээнд бараг 4 дахин их, харилцаа холбоо сул гэсэн үзүүлэлтийн хувь мөн 7,1 пунктээр илүү байна. Харин нийгмийн капитал өндөр байгааг харуулах үзүүлэлтүүд хөндлөн сүлжээнд давуу байгаа юм. Хамгийн их итгэдэг, дотно хүмүүсийн хүрээг хамаатан, ураг төрлийн хүмүүс бүрдүүлж байна. Шилжин ирсэн хүмүүс монголчуудынхаа сүлжээг дайчилж ашиглах нь илүүсайнажиллох, ажлын нөхцөлөө сайжруулах зэрэг давуу талыг олгон нийгмийн шинэ орчинд дасан зохицоход нь дэмжлэг тусламж болдог хэдий ч тэднийг тухайн нийгмийн интеграцид нэгдэхэд нь саад учруулж байна.

Ном зүй:

1. Попов Д. Д. Социальный капитал в сетевых экономических структурах // Вестник Костромского государственного университета им. Н. А. Некрасова. 2011. № 3. С. 393–395.
2. БНЧУ-д амьдарч буй Монголчуудын мэдээлэл // БНЧУ-д суугаа ЭСЯ. Прага, 2021.
3. “Чех дэх Монголчууд” судалгааны тайлан // МУ-ШУА, ФХ. Улаанбаатар, 2021.
4. Фукуяма Ф. Нийгмийн капитал ба хөгжил: хөгжлийн шинэ асуудал // Ардчиллын чанар.
5. Судалгааны өгүүллийн эмхэтгэл. UNDP. Улаанбаатар, 2005. 320 х.
6. Хүн ам орон сууцны улсын тооллого // YCX. Улаанбаатар, 2020.
7. Putnam Robert D. The American Prospect // The Prosperous Community. NY, 2000. No. 4 (13). P. 35–42

Эрдэм шинжилгээний өгүүлэл (дотоод)

Ц.Пүрэв. Социологийн өгөгдлийг боловсруулахад хүчин зүйлийн шинжилгээний аргыг хэрэглэх нь (0.6 х.х). // Идэр эрдэм сэтгүүл. УБ., 2021.

Социологийн өгөгдлийг боловсруулахад хүчин зүйлийн шинжилгээний аргыг хэрэглэх нь

*Ц.Пүрэв. Эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
доктор (Ph. D)*

Хүчин зүйлийн шинжилгээний математик үндэслэл, үе шат, тавигдах шаардлага. Социологит олон хувьсагч бүхий их хэмжээний өгөгдлийг ижил төстэй байдлаар нь нэгтгэн цомхотгож, хүчин зүйл гэж нэрлэгдэх цөөн хувьсагчаар солихын тулд олон хэмжээст статистик аргын төрөл болох хүчин зүйлийн шинжилгээний аргыг өргөн хэрэглэдэг. Нэг хүчин зүйлд орсон хувьсагчид өөр хүчин зүйлд харьяалагдах хувьсагчдыг бодвол хоорондоо статистик холбоо хамаарал илүүтэй байна гэсэн үг. Нөгөө талаас өгөгдлийн хэмжээг багасгаад зогсохгүй судлаачийн сонгож авсан хувьсагчдын хоорондох уялдаа холбоо, тэдгээрийн далд бүтцийг илрүүлэн тодорхойлох явдал хүчин зүйлийн шинжилгээний аргын бас нэг зорилт болно⁷⁰.

Хүчин зүйлийн шинжилгээний математик загвар дараах шугаман тэгшитгэлийн системээр тодорхойлогдоно.

Үүнд: $x_i = a_{i1} F_1 + a_{i2} F_2 + \dots + a_{im} F_m + d_i V_i$ (1)
($i = 1 \dots n$) бол, x_i – нь анх өгөгдсөн хувьсагчид харин $m < n$ байна.

Энд, F_1, F_2, \dots, F_m эрж буй хүчин зүйл, харин V_1, V_2, \dots, V_m , нь дээрх хүчин зүйлээр үл тайлбарлагдах шинжийн хэлбэлзлийн утгыг тодорхойлох хүчин зүйл. Хүчин зүйл гэдэг бол өөр хүчин зүйлд орсон хувьсагчидтай харьцуулахад хоорондоо илүү холбоо хамаарал бүхий бүлэг хувьсагчид юм. Сонгодог хүчин зүйлийн шинжилгээнд, $F_1, F_2, \dots, F_m; V_1, V_2, \dots, V_m$, хүчин зүйлүүдийг харилцан хамааралгүй (ортогональ) гэж үзнэ. Коэффициент a_{ij} – г хүчин зүйлийн ачаалал (**factor loading**) гэдэг.

Хүчин зүйлийн шинжилгээний горим дараах гурван үе шатыг дамжин хэрэгжинэ⁷¹. Үүнд: **нэгдүгээрт**, Хувьсагчдын утгаар Пирсоны корреляцийн коэффициент бодож корреляцийн матриц байгуулна. Ингэхдээ матрицийн гол диагоналийн дагуу 1 биш, Барлетийн боловсруулсан хамгийн их корреляцийн аргаар тооцсон нормчлогдсон ерөнхий дисперсийн үнэлгээг байрлуулсан байдаг. Зарим судлаачдын хийсэн шинжилгээнээс үзэхэд 5-аас доош утга бүхий хувьсагчдын хувьд Пирсоны корреляцийн коэффициент ач холбогдол багатай учир 10 баллын үнэлгээтэй асуултуудын хувьд хүчин зүйлийн шинжилгээг харин 5-аас доош хувилбар бүхий асуултуудын хувьд бүлэглэсэн өгөгдлийн гол бүрдүүлэгчийн шинжилгээ (**CatPCA**)-г хэрэглэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байдаг⁷².

Хоёрдугаар шатанд хүчин зүйлүүдийг илрүүлэн, тайлбарлал хийх гол зүйл болсон a_{ij} хүчин зүйлийн ачааллыг бодно. Энэ үед гол бүрдүүлэгчийн хийгээд гол хүчин зүйлийн

⁷⁰ SPSS Base 8.0, Applications Guide. Chicago., 1998. P. 317.

⁷¹ Е. Е. Фомина. Факторный анализ и категориальный метод главных компонент: Сравнительный анализ и практическое применение для обработки результатов анкетирования // Гуманитарный вестник. 2017. № 110. С. 7;

⁷² И.К. Зангиева, А. Н. Ротмистров. Сравнительный анализ способов проведения факторного анализа на порядковых переменных // Мониторинг общественного мнения: Экономические социальные перемены. 2018. №3. С. 29-46.

болон хамгийн их үнэний хувийн аргаас сонгон хэрэглэдэг. Практикт хүчин зүйлүүдийг тодруулах гол бүрдүүлэгчийн арга (**Principal components analysis**) өргөн дэлгэрчээ. Түүний гол санаа нь

$X = (x_1, x_2, \dots, x_k)$ олон хэмжээст огторгуйд хувьсагчид нь хоорондоо нягт холбоо хамааралтай бүлгийг ялгаж, тэдгээрийг гол бүрдүүлэгч $Y = (y_1, y_2, \dots, y_k)$ -ээр солиход оршино. Олон хувьсагчийг цөөн хүчин зүйлээр сольсноос гарах нийт алдаа хамгийн бага байхуйцаар хүчин зүйлийн ачааллыг тооцон боддог. ГБА-ын математик загварыг дараах томъёогоор илэрхийлж болох юм. Үүнд: $y_j = \sum_{i=1}^k \alpha_{ij} z_i$ (2)

y_j бол гол бүрдүүлэгч буюу хүчин зүйл, харин ($j = 1, \dots, m$); α_{ij} - нь y_i гол бүрдүүлэгчид z_i хувьсагчийн оруулж буй хувь нэмэр болно. z_i нь анхны хувьсагчийг стандарт хэлбэрт оруулсан байна. Өөрөөр хэлбэл $z_i = (x_i - \bar{x}_i) / s_i$, $i = 1, \dots, k$ стандарт хувьсагчийн дундаж нь тэг, дисперс нь нэгтэй тэнцэнэ.

Гол бүрдүүлэгчийг үүсгэхдээ дараах алгоритмыг хэрэглэнэ. Үүнд:

1. Өгөгдсөн хувьсагчийг шинэ хувьсагчдын дисперс нь ижил байхын хамт координатын эх нь өгөгдлийн огторгуйн төвд шилждэг тийм нөхцөл бүхий стандарт хэлбэрт шилжүүлнэ.
2. Гол бүрдүүлэгч $Y = (y_1, y_2, \dots, y_k)$ – ийн шинэ ортогональ огторгуйг байгуулахын тулд $Z = (z_1, z_2, \dots, z_k)$ огторгуйн шугаман хувиргалт хийнэ.

$$y_j = \sum_{i=1}^k \alpha_{ij} z_i \quad (3) \quad i, j = 1, \dots, k$$

Энэ хувиргалтыг хийхийн тулд $\Delta = \{\alpha_{ij}\}$ коэффициентийг бодно. Ингэхдээ дараах шаардлагыг тавьдаг. Үүнд:

- гол бүрдүүлэгч нь z_1, z_2, \dots, z_k хувьсагчдын шугаман хослол байх ёстой.
- гол бүрдүүлэгч ортогональ байх хэрэгтэй
- эхний гол бүрдүүлэгч (хүчин зүйл)- ийн түүврийн дисперс хамгийн их дараачийнх нь гуравдахиаас их гэх мэтээр дараалан буурсан байна. Өөрөөр хэлбэл $s^2(y_1) \geq s^2(y_2) \geq \dots \geq s^2(y_k)$;
- Анхны хувьсагчдын нийт дисперс нь гол бүрдүүлэгчдийн дисперсийн нийлбэртэй тэнцүү байна.

Гол бүрдүүлэгчийг бодохын тулд эхний өгөгдлийн корреляцийн матрицийн хувийн вектор болон хувийн утга ($\delta_1, \delta_2, \dots, \delta_k$) – г бодох хэрэгтэй. Хувийн утгууд нь шинэ хувьсагчийн дисперстэй тэнцэнэ. Тухайлбал $s^2(y_1) = \delta_1 \geq s^2(y_2) = \delta_2 \geq \dots \geq s^2(y_k) = \delta_k$ (Зураг 1-ээс үз).

Харин хувийн векторууд нь $\Delta = \{\alpha_{ij}\}$ матрицын баганатай давхцана. $(\alpha_{1i} \dots \alpha_{ki})^T$ бол δ_i хувийн утгад харгалзах i – дугаар хувийн вектор болно.

α_{ij} утгыг хүчин зүйлийн ачаалал гэнэ. Энэ нь анхны хувьсагч x_i болон шинээр бодож олсон гол бүрдүүлэгч F - ийн хоорондох корреляцийн коэффициент юм. $|\alpha_{ij}| > 0,7$ байх хувьсагчдыг хүчин зүйлд багтааж үзнэ. Хүчин зүйлийн зохистой тоог тогтоохдоо тайлбарлагдаж буй дисперсийн хувиар илэрхийлэх Кайзерийн шалгуур, түүнчлэн Кеттелийн шалгуурыг хэрэглэдэг юм.

3. Мэдээлэл багатай хувьсагчдыг зайлуулснаар $Y = (y_1, y_2, \dots, y_k)$ огторгуйн хэмжээсийг бууруулна. Үүний тулд хувийн утгатай холбогдох Кайзерийн шалгуурыг хэрэглэж болно. Хувийн утга $\delta_i \geq 1$ буюу мэдээлэл ихтэй хувьсагчид гол бүрдүүлэгч буюу хүчин зүйлийг бүрдүүлнэ.

Гуравдахь шатанд үүссэн шинэ хүчин зүйлүүдэд тодорхой тайлбар өгөх боломж багатай болох нөхцөлд хүчин зүйлийн эргүүлэлт (**Rotation**) хийж шийдийг сайжруулдаг. Эргүүлэлт хийдэг варимакс (**Varimax**), кватримакс (**Quartimax**), эквимакс (**Equamax**), бикватримакс зэрэг олон арга бий. Хүчин зүйлийн ачаалал өндөр байхуйцаар хувьсагчийн тоог хамгийн цөөн болгоход чиглэсэн ортогонал эргүүлэлтийг варимакс

гэнэ. Энэ арга хүчин зүйлийг тайлбарлахад илүү дөхөмтэй байдгаас практикт өргөн хэрэглэгдэнэ.

Хүчин зүйлийн шинжилгээнд дараах шаардлага буюу хязгаарлалт тавигдана.

Үүнд:

- Энэ шинжилгээнд хамруулах хувьсагчид хэвийн тархалттай байх ёстой.
- Хувьсагчид интервал эсвэл эрэмбийн хэмжүүрээр хэмжигдсэн байна. Гэхдээ зарим тохиолдолд тухайн асуултыг тийм үгүй гэсэн дихотоми хувьсагч болгон өөрчлөөд 1 ба тэг гэсэн коод өгч, энэ шинжилгээг хийдэг тал бий.
- Хэмжилтийн янз бүрийн түвшин бүхий хувьсагчдыг хамруулж болохгүй. Өөрөөр хэлбэл хувьсагчид нь хэмжилтийн нэг ижил түвшинтэй байна гэсэн үг.

Эл арга социологит өргөн нэвтэрсний дээр, тооцоолох электрон машины программчлал бэлтгэгдсэн, алгоритм нь баялаг олон хувилбартай, математик хувиргалт хийх зэргээр шийдийг улам сайжруулах боломжтой зэрэг сайн талтай боловч, нөгөө талаас социологит тоогоор илэрхийлэгдэх шинжүүд харьцангуй цөөн буюу нэрлэсэн болон эрэмбийн хэмжүүртэй асуулт элбэг байдаг, бас нийгмийн үзэгдэл хоорондоо тэр бүр шугаман хамааралтай байдаггүйн дээр янз бүрийн агуулга бүхий шинжүүдийг хүчин зүйл нэгтгэдэг учраас тэдгээрийг нэрлэх, тодорхойлон бичих тайлбарлахад төвөгтэй зэрэг бэрхшээл тулгардаг тал бий⁷³. Иймээс дээрх дутагдалтай талыг нөхөх зорилгоор социологит өргөн хэрэглэгддэг хэмжилтийн олон түвшин бүхий хувьсагчдад зориулсан хүчин зүйлийн шинжилгээний илүү боловсронгуй хэлбэр болох бүлэглэгдсэн хувьсагчийн гол бүрдүүлэгчийн шинжилгээ (CatPCA) зэрэг зохистой хэмжилт хийх аргын өөр алгоритмууд SPSS программд боловсрогдсон байдаг.

Хүчин зүйлийн шинжилгээний хэрэглээ. Тус хүрээлэнгийн социологийн салбараас 2015-2016 онд явуулсан “Нийгмийн оролцоо, гадуурхал” сэдэвт социологийн судалгаагаар хүмүүсийн амьдралын нөхцөл байдлын үнэлгээ сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох зорилгоор судалгааны анкетад дараах багц асуултыг оруулсан юм. Үүнд:

Хүснэгт 1. Амьдралын нөхцөл байдлын үнэлгээ (хувиар)

	Маш их хангалуун	Ер нь хангалуун	Дунд зэрэг	Хангалуун биш	Огт сэтгэл хангалуун биш	Хари улж мэдэхгүй	Дундаж
Материалаг байдалд	11.4	29.8	35.1	12.1	6.4	5.2	3.29
Орлого (ажлын хөлс, тэтгэвэр, тэтгэмж, цалин)	8.2	22.0	36.2	21.3	8.5	3.8	3.00
Амьдарч буй газарт	12.6	34.0	33.3	11.9	4.7	3.6	3.39
Орон сууцны нөхцөлд	9.5	31.0	33.5	13.2	6.3	6.4	3.26
Хооллолтондоо	17.7	39.7	26.3	9.0	2.2	5.1	3.65
Эрүүл мэндийн байдалд	14.1	36.1	31.8	10.1	4.0	4.0	3.48
Боловсрол, мэргэжилдээ	16.6	36.0	27.7	10.4	4.4	4.9	3.52
Ажил эрхлэлт (эрхэлж буй ажилд)	10.4	30.8	25.6	13.3	6.2	13.7	3.30
Ажил хөдөлмөрийн нөхцөл	7.5	25.6	29.0	17.1	6.1	14.7	3.14
Мэргэжил дээшлүүлэх, албан тушаал ахих боломжид	7.0	17.7	30.4	19.3	10.1	15.5	2.91
Хувийн аюулгүй байдалд	8.8	26.6	35.5	14.8	6.1	8.3	3.19
Нийгэмд эзэлж буй байр суурьт	6.7	29.5	34.7	13.8	6.7	8.5	3.17
Гэрлэлт, гэр бүлийн амьдралд	25.0	39.4	16.9	5.2	4.2	9.3	3.84
Хүүхдүүд, ойр дотны хүмүүстэй харилцах харилцаанд	24.4	45.2	18.0	4.7	2.2	5.4	3.90
Нэр хүнд, бусдын хүндлэлд	13.1	41.0	30.0	6.2	3.2	6.4	3.58
Амьдрал бүхэлдээ	14.2	37.3	31.4	6.4	4.4	6.2	3.54

⁷³ Ц. Пүрэв. Социологийн мэдээллийг шинжлэх статистик арга. УБ., 2018. 85 дахь тал.

Энэхүү судалгаанд Хөвсгөл, Архангай, Дархан, Ховд, Орхон аймаг болон нийслэл Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 829 хүн хамрагдсан байна⁷⁴. Энэхүү 16 хувьсагчийг илүү тайлбарлаж чадахуйц хүчин зүйл хэмээн нэрлэгддэг цөөн хувьсагчаар солихын тулд SPSS программ дахь хүчин зүйлийн шинжилгээний аргыг хэрэглэв. Үүний тулд дараах үйлдлийг гүйцэтгэнэ.

Analyze → **Dimension Reduction** → **Factor** → **Variables** → Энэ нүдэнд хувьсагчдаа татаж оруулна. Дараа нь

Descriptives...

Statistics

■ **Univariate descriptive**

Correlation Matrix

■ **Coefficients**

Extraction...

Display

■ **Scree plot**

Rotation...

Method

° **Varimax**

Display

■ **Loading plots**

Scores...

■ **Save as variables**

Options...

Coefficient Display Format

■ **Sorted by size**

■ **Suppress absolute values less than: 0. 70**

Descriptive Statistics хүснэгтэд бидний сонгож авсан 16 хувьсагч тус бүрийн дундаж, стандарт хазайлт болон түүврийн хэмжээ гарч ирнэ. Хүүхдүүд ойр дотны хүмүүстэй харилцах харилцаа хийгээд гэрлэлт гэр бүлийн харилцаандаа өгсөн үнэлгээний дундаж утга хамгийн өндөр гарсан бол, мэргэжил дээшлүүлэх болон албан тушаал ахих боломжийн үнэлгээний дундаж утга бусдаас бага гарсан байна. Хүүхдүүд ойр дотны хүмүүстэй харилцах харилцааны үнэлгээний дисперсийн утга хамгийн бага буюу харьцангуй жигд хариулт авсан бол, мэргэжил дээшлүүлэх болон албан тушаал ахих боломжийн үнэлгээ илүү жигд бус гарчээ. Энэхүү асуултад 557 хүн бүрэн хариулт өгсөн тул түүврийн хэмжээ 557 байгаа нь хүснэгтээс харагдана.

Дараа нь Correlation Matrix гэсэн хүснэгт гарч ирнэ. Баруун диагоналийн дагуу 1 гэсэн тоонууд байрласан тэгш хэмт матрицад Пирсоны корреляцийн коэффициентийн утга байх бөгөөд нийтдээ $16 \times 15 / 2 = 120$ коэффициентад шинжилгээ хийх боломж гарч ирнэ. Тухайлбал ажил хөдөлмөрийн нөхцөл болон ажил эрхлэлтийн үнэлгээний хоорондох холбоо хамаарал хамгийн их ($r = 0. 776$) гарсан бол, орлого хийгээд хүүхэд ойр дотны хүмүүсийн харилцааны үнэлгээний хоорондох холбоо хамаарал хамгийн бага ($r = 0. 241$) байгаа зэргийг тогтоох жишээтэй.

Communalities (Эгэл хүчин зүйлүүдийн дисперс) хүснэгтэд хувьсагч бүрийн хувьд ердийн хүчин зүйлийг тайлбарлаж буй тухайн хувьсагчийн дисперсийн эзлэх хувь буюу олон хүчин зүйлийн корреляцийн квадратыг бодно. Энэ нь эгэл хүчин зүйлүүдийн дисперс гэсэн үг.

⁷⁴ ШУА-ийн Философийн хүрээлэнгийн социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар. “Нийгмийн оролцоо, гадуурхал” сэдэвт социологийн судалгааны дүн. Уб., 2015.


Total Variance Explained: Initial хүснэгтэд хувьсагч тус бүрийг бүрдүүлэгч хэмээн үзэж хүчин зүйлийг тайлбарлах дисперсийн хувийг бодож гаргадаг. Хувийн утга нь 1-ээс багагүй байх гэсэн Кайзерийн шалгуурыг хэрэглэвэл дараах гурван хүчин зүйл үүсэж, тэдгээр нь нийт ерөнхий дисперсийн 68,17 хувийг тайлбарлах боломжтой гарчээ. Энэ хувь хэдий чинээ их байх буюу 100 - д ойр байх тутам хүчин зүйлийн шинжилгээний үр дүнг илүү сайн болсон гэж үзэх үндэстэй.

Хүснэгт 2. Хүчин зүйлийн хувийн утга (Eigenvalues)

Утга	Хүчин зүйлүүд		
	1	2	3
Хувийн утга	8.515	1.360	1.033
Ерөнхий дисперсийн хувь	24.681	23.928	19.567
Хуримтлагдсан хувь	24.681	48.608	68.175

16 хувьсагчийн хувьд бодож гаргасан хувийн утгыг цэгэн графикаар үзүүлсэн Scree plot гэсэн доорх зургаас илүү тодорхой харж болно.

Зураг 1. Хувийн утга бүрдүүлэгчийн тооны хоорондох холбоо хамаарал



Ж.Батжаргал. Нийгмийн капитал ба нийгмийн тусгаарлагдалтын холбоо хамаарал ба шинжилгээг уялдуулах нь (0.6х.х) // Идэр эрдэм онлайн сэтгүүл. УБ., 2021.

НИЙГМИЙН ТУСГААРЛАГДАЛТ БА НИЙГМИЙН КАПИТАЛ: ХОЛБОО ХАМААРАЛ БА ШИНЖИЛГЭЭГ УЯЛДУУЛАХ НЬ

Ж.Батжаргал.
Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын ЭШДЭА, докторант

Товч агуулга:

Илтгэлд нийгмийн тусгаарлагдалт болон нийгмийн капиталын ойлголт, үзэл баримтлал, тэдгээрийг хэмжих арга, хэмжигдэхүүнүүдийг авч үзэж, судлан буй хоёр үзэгдэл үйл явцын холбоо хамаарал, хэрхэн уялдуулан шинжлэх талаар хөндлөө.

Гол нэр томъёо: Нийгмийн тусгаарлагдалт, нийгмийн капитал, нийгмийн тусгаарлагдалтын болон нийгмийн капиталын үзэл баримтлал, хэмжилт, хэмжигдэхүүнүүд

Abstract: *The report examines the concepts of social exclusion and social capital, their measurement methods and dimensions, and how to analyze these two subjects in a coherent manner.*

Keywords: *Social exclusion, social capital, the concepts of social exclusion and social capital, measurement, dimensions*

Ойлголт, үзэл баримтлалын хэрэглээ ба ач холбогдол

Нийгмийн тусгаарлагдалт ба нийгмийн капиталын талаарх ойлголт яригдаж хэрэглэгдэх болсон, судалгааны идэвхтэй сэдэв болсон хугацаа зөрүүтэй ч хол зөрүүгүй юм. 2000-аад оноос шинжлэх ухааны судалгаа, улс төр бодлогын хэлэлцүүлэгт улам бүр анхаарлын төвд орж ирснээс хойш судлан шинжлэх хүрээ, судалгааны ач холбогдол нь улам бүр өргөжсөөр байна. Тухайлбал, нийгмийн капиталын ойлголтыг авч үзэж, судлах нь эдийн засаг, нийгмийн үзэгдлийг тайлбарлахад ач холбогдолтой болохыг судлаачид хүлээн зөвшөөрдөг тийм ч учраас 2000 оноос хойш нийгмийн капиталын онолын болон эмпирик судалгааны бүтээлүүд нэмэгдсэн. Нийгмийн капиталын судалгаа ч засаглалын болон эдийн засгийн хөгжлийн тогтвортой, үр дүнтэй байдалд нийгмийн капитал нь биет болон хүний капиталаас илүү чухал болохыг харуулдаг. (Putnam 1993, 183).

Нийгмээс тусгаарлагдалтыг судлах нь мөн нийгмийн нэгдэл нягтралыг хангах, нийгмийн тогтвортой байдал, хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой. Түүнчлэн нийгмээс тусгаарлагдаж орхигдох шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, хамрах хүрээг тодорхойлох нь нийгмийн тусгаарлагдалтын бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн бодлогыг үнэлэхэд тустай. Нийгмийн тусгаарлагдалтын үзэл баримтлал нь ядуурал, хомсдолын судалгаа шиг зөвхөн материаллаг хомсдолоор хязгаарлах бус нийгмийн эрх нь хангагдахгүй байх, оролцоо бага, хэм хэмжээ, соёлын интеграцийн дутагдал, нийгмийн харилцаанаас тусгаарлагдах гэсэн өргөн хүрээнд асуудлыг авч үзэж тайлбарлахыг эрмэлзэж байгаа болно.

Нийгмийн тусгаарлагдалт ч нийгмийн капитал ч тэр аль аль нь үзэл баримтлалын хувьд бүрхэг, олон янзаар тайлбарлагддаг олон хэмжээст цогц үзэгдлүүд юм. Эдгээр үзэл баримтлал юугаараа өөр хоорондоо холбогдох вэ гэдгийг авч үзэхийн тулд нэн түрүүнд нийгмээс тусгаарлагдах болон нийгмийн капиталын ойлголт, үзэл баримтлал, судлах асуудлын өнцгийг тодруулан авч үзье.

Нийгмээс тусгаарлагдах ойлголт, үзэл баримтлал

Нийгмээс тусгаарлагдах (social exclusion) гэсэн эл ойлголтын хувьд монгол хэлээр хэрхэн оноон томъёолж тогтох нь нэлээд ярвигтай байна. Нийгмээс тусгаарлагдах гэсэн нь шоронд орох, сэтгэцийн эмнэлэгт хэвтэж тусгаарлагдах гэх мэт нийгмээс механикаар тусгаарлагдсан гэсэн шууд утгаар буух, тухайн ойлголттой хольж хутгах эрсдэл байна. Гэвч social exclusion нь эс хамрагдах, оролцоогүй байх, ялгаварлагдан гадуурхагдах, орхигдох, нийгмээс тасарч холдох, тэгш бус болох гэх мэт олон утгаар илэрхийлэгдэж буй бөгөөд “нийгмээс тусгаарлагдах” нь дээрх утгуудыг харьцангуй өөртөө шингээсэн гэж үзэж хэрэглэлээ. Нийгмээс тусгаарлагдах гэдэгт тухайн хүн нийгмийнхээ үндсэн гол үйл ажиллагаанд өөрөө хүссэн ч оролцож чадахгүй байх, нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдсан үйл явцыг хамруулж ойлгож байна.

Нийгмээс тусгаарлагдах үйл явц олон талтай асуудал учраас судлаачид аль нэг талыг нь барьж, эс бөгөөс хэд хэдэн шинжийг онцлон янз бүрийн өнцгөөр тодорхойлсон байдаг. Олон судлаач нийгмийн үндсэн үйл ажиллагаанд оролцоо багатай, оролцоогүй байх явдал гэж үзжээ. Тухайлбал⁷⁷,

“Нийгмээс тусгаарлагдах /social exclusion/ нь ядуурлаас илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд зөвхөн материаллаг арга хэрэгсэл биш, эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын амьдралд үр дүнтэй оролцох чадваргүй болох, зарим онцлог шинж чанаруудаас болон үндсэн нийгмээс алслагдсан байдал юм. (Даффи, 1995)

“... нийгэм дэх хүмүүсийн дийлэнх олонхи нь оролцдог нийгмийн харилцаа, ёс заншил, нийгмийн үйл ажиллагаанд оролцоо дутмаг байх эсвэл оролцоогүй байхыг нийгмийн тусгаарлагдал гэж тодорхойлж байна. Одоогийн хэрэглээнд үүнийг “төлөв” гэхээс илүү “явц” гэж үздэг бөгөөд энэ нь ядууралтай харьцах харилцааг нарийн тодорхой болгоход тусалдаг. (Гордон нар, 2000, х.73)

“...хэрэв (а) тухайн газарт оршин суудаг боловч (б) өөрөөс нь хамааралгүй шалтгаанаар, тухайн нийгэм дэх иргэдийн хэвийн үйл ажиллагаанд (в) оролцохыг хүсч байгаа ч оролцож чадахгүй байвал тухайн хүнийг нийгмээс тусгаарлагдсан гэж ойлгоно” гэж үзжээ. (Burchardt, Le Grand and Piachaud. 1999, 229)

“Хувь хүмүүс болон тэдний нийгэмлэгүүд хоорондоо туйлширсан, нийгмийн ялгаатай, тэгш бус болдог үйл явц” (ESRC, 2004) гэх зэргээр тодорхойлсон.

Нийгмийн тусгаарлагдалтын янз бүрийн талыг онцлон тэмдэглэснээс дурьдвал Пиерсон (2002) нь нөөцийг ашиглах эрхгүй байхаас үүдэлтэй нийгмийн тусгаарлагдахуйг онцолсон байдаг бол Барнс (2005), Бирн (1999) нар нийгмийн тусгаарлалтын олон талт байдал, үүнд улс төр, эдийн засаг, соёлын үйл явц, боломжоос ангид байх тал дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Сен (2000) нь нийгмээс тусгаарлагдахад нөлөөлөх харилцааны талуудыг онцлон тэмдэглэсэн. Фишер (2011) нь тусгаарлагдалтыг өдөөж, нийгмийн давхраажилтыг бэхжүүлж, нийгмийн хөдөлгөөнд саад болж буй бүтцийн болон идэвхтэй үйл явцад голчлон анхаарлаа хандуулдаг.⁷⁸

Нийгмийн тусгаарлагдалт руу чиглэсэн эдгээр янз бүрийн чиг хандлага, нийгмийн хариу үйлдлүүд нь зарим талаар нийгэм, улс төр, соёлын агуулгаар тодорхойлогдоно. Силвер (1994) нь⁷⁹ Европын янз бүрийн үндэстний нөхцөл байдлын хүрээнд хэрэглэгдэж буй нийгмийн тусгаарлалтын утга, хэрэглээг агуулсан дараах гурван өөр “парадигм” байна гэж үзсэн.

1. Францын Бүгд найрамдах үзэл ба нийгмийн дэг журмын тухай Дюркгеймийн үзэл баримтлалд үндэслэсэн *эв санааны нэгдэл парадигм* нь нийгмийн тусгаарлагдалтыг орхигдож тусгаарлагдсан хүмүүсийн хэм хэмжээний ба соёлын интеграцийг шаарддаг нийгмийн эв нэгдлийн задрал гэж үздэг.

⁷⁷ Levitas R, Pantazis C, Fahmy E, Gordon D, Lloyd E, Patsios D. The Multi-dimensional analyses of social exclusion. Department of Sociology and School for Social Policy Townsend Centre for the International Study of Poverty and Bristol Institute for Public Affairs University of Bristol. January 2007.

⁷⁸ Social exclusion in cross-national perspective: actors, actions, and impacts from above and below. Edited by Robert J.Chaskin, Bong Joo Lee, and Surinder Jaswal. Oxford University Press. 2019. p.35

⁷⁹ Social exclusion in cross-national perspective: actors, actions, and impacts from above and below. Edited by Robert J.Chaskin, Bong Joo Lee, and Surinder Jaswal. Oxford University Press. 2019. p.36

2. Англи хэлээр ярьдаг либерал ардчилсан орнуудад илүү түгээмэл байдаг *мэргэшлийн парадигм нь* нийгмийн тусгаарлагдахуйг хөдөлмөрийн эдийн засгийн хуваарилалтад суурилсан нийгмийн давхаргын үр дагавар, нийгмийн хүрээнд сайн дурын солилцоо хийдэг зарим хүмүүс ялгаварлан гадуурхах эсвэл "янз бүрийн хүрээний хоорондох чөлөөт хөдөлгөөнд саад болгоч" бусад зүйлс гэж үздэг (Silver 1994: 543)

3. *Монополь парадигм* нь Маркс болон (ялангуяа) Веберийн анги, статусын талаарх ойлголт, эрх мэдлийн харилцааны талаарх бүтээлүүд дээр үндэслэж, нийгмийн тусгаарлагдахуйг монополийн ашиг сонирхол, ялангуяа зах зээлээс үүдэлтэй тусгаарлагдах байдлын үр дүн гэж үздэг (Silver 1994).

Нийгмийн тусгаарлагдалтын чухал шинж чанарууд нь олон хэмжээст байдал, харьцангуй байдал (*ө.х нийгмийн тусгаарлагдалт нь нөхцөл байдлаас шалтгаалсан онцлог шинжтэй*) ба агентлаг зэрэг болно.⁸⁰ Агентлаг нь засгийн газар эсвэл хувийн байгууллагууд, нийгмийн орчин эсвэл хувь хүн байж болох юм.

Нийгмийн тусгаарлагдалт нь нийгмээс тусгаарлагдсан үйл явцтай (динамик) зөвхөн холбоотой бус харин нийгмээс тусгаарлагдсан нөхцөл байдлыг (статик) илэрхийлж болно. Нийгмийн тусгаарлагдалт нь материаллаг бус шинж чанар (харилцан хамаарлын хэмжигдэхүүн) болон материаллаг талууд (хуваарилалтын хэмжигдэхүүн) хоёуланг хамтад нь хамааруулж болно. Нийгмээс тусгаарлагдах, орхигдох шалтгаан нь хамт олны түвшинд байж болох боловч хувь хүний шинж чанар, зан үйл онолын хувьд чухал ач холбогдолтой байдаг.⁸¹

Хэмжилт, шалгуур үзүүлэлт

Нийгмээс тусгаарлагдах ойлголтыг тодорхойлох, шинжлэх аргын талаар үндсэн хоёр хандлагын хооронд маш том ялгаа бий. Эхний хандлага нь "нийгмээс тусгаарлагдах" ойлголтыг шинжлэхэд нөөц ба тэдгээрийн хуваарилалтанд төвлөрдөг Англи-Саксоны уламжлалд, нөгөө хандлага нь хүмүүс нийгэмд хэрхэн уялдаж, бусадтай холбогдсон байдал (нийгэм-соёлын тусгаарлалт) дээр төвлөрдөг Францын уламжлалд үндэслэдэг.

Эдгээр уламжлалд үндэслэн нийгмээс тусгаарлагдах үйл явцыг тодорхойлж, судлаж хэмжих арга зүйг боловсруулсан судлаачдын арга зүйн баримтлалыг товч авч үзье.

Их Британийн судлаач Бурчардт болон түүний хамтрагчид (1999) нь нийгмийн тусгаарлагдалтыг судлах 1) **хэрэглээ** (бараа, үйлчилгээ худалдан авах чадвар); 2) **үйлдвэрлэл** (эдийн засгийн болон нийгмийн үнэ цэнэтэй үйл ажиллагаанд оролцох); 3) **улс төрийн оролцоо** (орон нутгийн болон үндэсний хэмжээний шийдвэр гаргах түвшинд оролцох); 4) **нийгмийн харилцан үйлчлэл** (гэр бүл, найз нөхөд, хамт олонтойгоо нэгдэх) гэсэн дөрвөн хэмжигдэхүүнийг тодорхойлжээ. Эдгээр хэмжигдэхүүн тус бүр нь өөрөө чухал ач холбогдолтой гэж үзсэн үр дүнг илэрхийлдэг. Аль ч хэмжүүрийн оролцоо дутагдалтай байх нь нийгмээс тусгаарлагдахад хангалттай юм. Жишээлбэл, тухайн хүн боломжийн хэрэглээтэй, улс төр, нийгмийн оролцоотой байсан ч гэсэн үйлдвэрлэлд оролцохгүй байх нь асуудалтай байдаг.

⁸⁰ Дам ишлэл. Silver H, Miller S. Social exclusion: the European approach to social disadvantage. 2003. Indicators 2: 1–17.// Addi P. L. van Bergen, Stella J. M. Hoff, Erik J. C. van Ameijden, Albert M. van Hemert. "Measuring Social Exclusion in Routine Public Health Surveys: Construction of a Multidimensional Instrument" өгүүллээс дам ишлэв.

⁸¹ Jehoel-Gijsbers G, Vrooman C (2007) Explaining social exclusion: A theoretical model tested in the Netherlands. The Hague: The Netherlands Institute for Social Research|SCP. p3.

Хүснэгт 1. Нийгмийн тусгаарлагдалтын үзүүлэлтүүд

Хэмжигдэхүүн	Үзүүлэлт ба босго
Хэрэглээ	Өрхийн тэнцвэржүүлсэн цэвэр орлого нь дундаж орлогын талаас бага байна
Үйлдвэрлэл	Ажил эрхэлдэггүй эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, боловсрол, сургалтанд хамрагддаггүй, эсвэл гэр бүлээ хардаг (өөрөөр хэлбэл ажилгүй, удаан хугацаагаар өвчтэй байсан, хөгжлийн бэрхшээлтэй, эрт тэтгэвэрт гарсан "бусад")
Улс төрийн оролцоо	Ерөнхий сонгуульд санал өгөөгүй, байгууллагын (улс төрийн нам, худалдааны нэгдэл, эцэг эхийн холбоо, эсвэл түрээслэгчид /оршин суугчдын холбоо г.м) гишүүн биш
Нийгмийн харилцан үйлчлэл	Сонсох, тайвшруулах, хямралд туслах, тайвшрах, өөрт чинь үнэхээр талархах эдгээр таван зүйлийн аль нэгнийх нь хувьд дэмжлэг үзүүлэх хүн байхгүй.

Мөн Их Британийн судлаач Bradshaw (2004) хувь хүн бусдаас тусгаарлагдаж, хямралд өртсөн үедээ хэн нэгнээс тусламж авч чадахгүй, иргэний болон улс төрийн түгээмэл үйл ажиллагаанд оролцох боломжгүй, гэмт халдлагад өртөхөөс байнга айж, эмээж амьдрах нь нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж буйн илрэл гэжээ. Их Британийн "Ядуурал ба нийгмээс тусгаарлагдах явдал" судалгаагаар Bradshaw-ийн боловсруулсан эдгээр үзүүлэлтийг хэмжиж, иргэд мөнгөгүйдээ оролцооноос татгалздаггүй харин оролцох хүсэл, оролцох цаг зав, хань болж хамт явах хүнгүй байдал, өөрийн оролцоог нь ойшоож үзэхгүй байх вий гэсэн айдас зэрэг хүмүүс хоорондын харилцааны, сэтгэл зүйн асуудлуудаас үүдэн тэр бүр нийгмийн харилцаанд оролцож чаддаггүй болохыг тогтоожээ. (Gordon, Levitas et al, 2000).

Барнс нарын судлаачид (2006)⁸² нийгмийн тусгаарлагдалтын эрсдэлийн хүчин зүйлийг судлахын тулд дараах хэмжигдэхүүнийг гаргасан. Үүнд:

- Нийгмийн харилцаа (харилцааны "давтамж" ба хүүхдүүд, гэр бүл, найз нөхөдтэйгээ харьцах "нягтрал")
- Соёл, амралтын үйл ажиллагаа (кино театрт явах)
- Иргэний үйл ажиллагаа (орон нутгийн сонирхлын бүлгийн гишүүнчлэл, сайн дурын ажил, санал хураалт)
- Үндсэн үйлчилгээ (эрүүл мэндийн үйлчилгээ, дэлгүүр);
- Хороолол, хөрш (нутгийн иргэдийн аюулгүй байдал, найрсаг байдал);
- Санхүүгийн бүтээгдэхүүн (банкны данс, тэтгэвэр);
- Материаллаг бараа (хэрэглээ тогтвортой, төвийн халаалт)

Нидерландын эрдэмтэд дээр дурьдсан онол, арга зүйн 2 уламжлалыг нэгтгэн, нийгмийн тусгаарлагдалтыг 1) эдийн засгийн-бүтцийн тусгаарлагдалт; 2) нийгэм-соёлын тусгаарлагдалт гэсэн хоёр гол чиглэлтэй үзэл баримтлал хэмээн үзсэн. Үүнд: эхний хэмжигдэхүүн нь материаллаг (орлого ба бараа) болон материаллаг бус (нийгмийн эрх) гэсэн хоёр хуваарилалтын асуудлыг тодорхойлж өгдөг. Хоёрдахь хэмжигдэхүүн нь мөн нийгмийн болон соёлын интеграци гэсэн хоёр чиглэлд хуваагдана: нийгмийн интеграци нь нийгмийн харилцаа холбоо, сүлжээнд чиглэгддэг; соёлын интеграци нь үнэт зүйлс, хэм хэмжээг үнэлдэг.⁸³

Jehoel-Gijsbers (2004), Jehoel-Gijsbers and Vrooman (2007) нарын боловсруулсан нийгмийн тусгаарлагдалтын хэмжигдэхүүн нь материаллаг хомсдол, нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй, нийгмийн оролцоо хязгаарлагдмал, хэм хэмжээний интеграцийн дутагдалтай гэсэн онолын дөрвөн элементийг шууд хэмжих боломжийг олгодог.⁸⁴ Өөрөөр хэлбэл, эдийн засаг-бүтцийн тусгаарлалтын хэмжигдэхүүн нь

⁸² R.Levitas, C.Pantazis, E.Fahmy, D.Gordon, E.Lloyd, D.Patsios. The Multi-dimensional analyses of social exclusion. Department of Sociology and School for Social Policy Townsend Centre for the International Study of Poverty and Bristol Institute for Public Affairs University of Bristol. January 2007.

⁸³ Jehoel-Gijsbers G, Vrooman C (2007) Explaining social exclusion: A theoretical model tested in the Netherlands. The Hague: The Netherlands Institute for Social Research|SCP.

⁸⁴ Vrooman J.C., Hoff S.J.M. The Disadvantaged among the Dutch: A Survey Approach to the Multidimensional Measurement of Social Exclusion. Social Indicators Research 113(3): 1261-1287 (August 2013; online version 21

материаллаг хомсдол, нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй байдал, нийгэм-соёлын тусгаарлагдалт нь нийгмийн оролцоо бага, хэм хэмжээний нэгдмэл байдлын дутагдалтай байх гэсэн дэд хэмжигдэхүүнд хуваагдаж байна.

Хүснэгт 2. Нийгмийн тусгаарлагдалтыг хэмжих 4 хэмжигдэхүүний оперционализиаци⁸⁵

Хэмжигдэхүүн	Оперционализиаци
Хэм хэмжээний интеграцийн дутагдал	Нийгмийн үндсэн үнэт зүйлтэй нийцэхгүй байх. Голландын нөхцөлд энэ нь "бусад хүмүүсийг үл хүндэтгэх" эсвэл "зөвхөн лхагва гарагт хогоо хаяхыг зөвшөөрдөг байхад мягмар гарагт хогоо хаях ..." гэх мэт асуудлуудтай холбоотой*.
Нийгмийн оролцоо хязгаарлагдмал байх	Нийгмийн тусгаарлалт /social isolation/, нийгмийн сүлжээнд оролцох хязгаарлагдмал байдал, нийгмийн оролцоо хангалтгүй байна
Материаллаг хомсдол	Угаалгын машин, өдөр тутмын халуун хоол гэх мэт зарим үндсэн бараа, үйлчилгээ байхгүйгээс болон өр төлбөрөөс болж хүмүүст тохиолддог алдагдал.
Нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй байх	Хүмүүсийн ердийн эдлэх эрхээ хэрэгжүүлэх чадваргүй байдал. Энэхүү хэмжигдэхүүнийг эрүүл мэндийн зохих үйлчилгээ, хангалттай боловсрол, амьдрах орчны хүртээмжтэй байдлаар оперционализиаци хийдэг.

*Ишлэлийг Голландын Нийгмийн Судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан фокус бүлгүүдийн оролцогчдын ярианаас ишлэв.

Нийгмийн оролцоо хязгаарлагдмал байгаа нь хүмүүсийн нийгмийн сүлжээ нь хязгаарлагдмал, бусадтай цөөн холбоо тогтоодог, нийгмийн оролцоо бага байгааг илтгэнэ. Норматив интеграцийн дутагдал гэдэг нь тухайн субъектын нийгэмлэгийн төв хэм хэмжээ, үнэт зүйлийг дагаж мөрдөхгүй байхыг хэлнэ. Бусад хоёр хэмжигдэхүүн нь бүтцийн-эдийн засгийн хэмжигдэхүүн юм. Материаллаг хомсдол гэдэг нь санхүүгийн үндсэн шалтгаанаар үндсэн бараа, үйлчилгээний дутагдал, төлбөрийн өр, асуудалтай өр гэх мэт үндсэндээ хүмүүст бодитой тулгардаг алдагдлыг хэлнэ. Нийгмийн үндсэн эрхийн хүртээмж хангалтгүй байгаа нь хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээ, хангалттай боловсрол, зохистой амьдрах орчныг авч чадахгүй байна гэсэн үг юм. Хэрэв эдгээр хэд хэдэн хэмжигдэхүүн дээр нэгэн зэрэг хасагдаж байвал нийгмийн тусгаарлагдалт онолын хувьд үүсдэг.⁸⁶

Нийгмийн капиталын ойлголт, үзэл баримтлал

Нийгмийн капиталын тухай бүх ойлголт нь нийгмийн харилцаанд төвлөрдөг бөгөөд түүний гол элементүүд нь нийгмийн сүлжээ, иргэний оролцоо, харилцан үйлчлэлийн хэм хэмжээ, ерөнхий итгэлцлийг агуулдаг. Өргөн утгаар нь авч үзвэл хамтын ашиг сонирхлын төлөө хамтын ажиллагаа, хамтын үйл ажиллагааг хөнгөвчлөх дундын хэм хэмжээ, үнэт зүйл, итгэл үнэмшил, итгэлцэл, сүлжээ, нийгмийн харилцаа, институц хэлбэрийн хамтын хөрөнгө гэж тодорхойлдог. Энэ бол янз бүрийн хэмжээс, төрөл, хэмжлийн түвшин бүхий олон хэмжээст цогц ойлголт юм.⁸⁷

Нийгмийн капиталын орчин үеийн гол судлаачдын нэг Патнемын нийгмийн капиталын баримтлалын гол санаа нь нийгмийн харилцаа холбоосууд нь хувь хүний ба бүлгийн бүтээмжид нөлөөлдөг ба нийгмийн капитал хувь хүмүүсийн хоорондын

September 2012) p.4; Jehoel-Gijsbers G, Vrooman C (2007) Explaining social exclusion: A theoretical model tested in the Netherlands. The Hague: The Netherlands Institute for Social Research|SCP.

⁸⁵ Hoff S, Vrooman C (2011) Dimensies van sociale uitsluiting: Naar een verbeterd meetinstrument [Dimensions of social exclusion: Towards an improved measurement instrument]. The Hague: The Netherlands Institute for Social Research|SCP. 101 p.; Vrooman JC, Hoff SJM (2013; online version 2012) The Disadvantaged among the Dutch: A Survey Approach to the Multidimensional Measurement of Social Exclusion. Social Indicators Research 113: 1261–1287. //Addi P. L. van Bergen, Stella J. M. Hoff, Erik J. C. van Ameijden, Albert M. van Hemert. "Measuring Social Exclusion in Routine Public Health Surveys: Construction of a Multidimensional Instrument" өгүүллээс дам ишлэв.

⁸⁶ Vrooman J.C., Hoff S.J.M. The Disadvantaged among the Dutch: A Survey Approach to the Multidimensional Measurement of Social Exclusion. Social Indicators Research 113(3): 1261-1287 (August 2013; online version 21 September 2012) p.4;

⁸⁷ Хумнатат Бхандари, Куми Ясунобу. Нийгмийн капитал гэж юу вэ? үзэл баримтлалын талаарх дэлгэрэнгүй тойм. //Азийн нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл. Боть 37. Дугаар 3. 2009., p480.

харилцаагаар өвлөгддөг юм. (Putnam 2000: 18; Coleman 1995: 392, 394; 1988: S98, S100-101).

Хувь хүмүүсийн хоорондын харилцаа нь нийгмийн сүлжээ, харилцан ойлголцол, итгэлцлийг бүрдүүлдэг. (Putnam 2000: 18-19). Нийгмийн амьдралын эдгээр шинж чанарууд нь нийгмийн капитал юм. Хамтын зорилгод хүрэхийн тулд илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг эдгээр нь оролцогч нарт олгодог. (Putnam 1996: 66; 1995: 664-665). Нийгмийн капитал нь хүмүүс хоорондын харилцаанаас хамаардаг. Хэрэв харилцан нягт уялдаатай нийгмийн харилцааны сүлжээнүүд бий болсон байвал нийгмийн чанар өндөр байна (Putnam 2000: 18-19). Нийгмийн капитал нь хувь хүн, хамт олны асуудал агуулдаг. Хувь хүмүүс өөрсдийн ашиг сонирхлыг дэмждэг харилцааг бий болгодог. Жишээлбэл, олон хүмүүс өөрсдийнхөө хүний капиталаараа ажил хайж олдоггүй, харин сүлжээнээс шалтгаалсан байдаг. (Putnam, Goss 2001: 20; Putnam 2000: 20). Нөгөө талаас нийгмийн капитал нь төрийн болон зах зээлийн ажилд ашигтай. (Putnam, Goss 2001: 19; Putnam 1993: 181).⁸⁸

Нийгмийн капиталын сүлжээний хандлагын төлөөлөгч Роналд С. Бурт үйлдлийн бүтцийн онолдоо Коулманы нийгмийн капиталын онолыг суулгаж өгсөн. Энэ онол нийгмийн үйлдлийг гүйцэтгэгч үйлдэгчийн тухай баримжаа таамаглалыг бий болгодог. Үйлдэгч нь хувийн зорилгоо хөөн түүний ашиг тусыг нэмэгдүүлэхийг зоригч хувь хүн эсвэл бүлэг байж болно. Үйлдэгчид өөрсдийн санхүүгийн эзэмшлээр тодорхойлогддог ба хүний капитал болон нийгмийн капитал нь нийгмийн бүтэц дэх тэдний байр сууриар бий болдог. Капиталын бусад хэлбэрүүдээс ялгаатай нь нийгмийн капитал гэдэг наад зах нь 2 үйлдэгчийн хоорондын харилцааг агуулдаг. Нийгмийн капиталд хөрөнгийн эрхийг үйлдэгчид хүний капитал болон санхүүгийн капитал шиг ганцаараа эзэмшдэггүй, харилцаа хамааралтай үйлдэгчид аль аль нь нийгмийн капиталыг эзэмшдэг. (Burt 1992: 8-9).⁸⁹

Хэмжилт, шалгуур үзүүлэлт

Нийгмийн капитал нь ойлголт, үзэл баримтлалын хувьд хатуу тогтоогүй, тодорхой бус, мөн олон талт шинж чанартай байдаг учраас хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг судлаачид туршиж, тухайн нөхцөл байдалдаа тохируулан хэрэглэсээр ирсэн. Нийгмийн капиталын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох гишүүнчлэл, итгэлцэл, нийгмийн сүлжээ гэсэн хэмжигдэхүүнүүдийг янз бүрийн нөхцөлд өөр өөр байдлаар хэрэглэсэн байдаг. Үүнд⁹⁰:

- Итгэлцэл (Cox and Caldwell 2000; Falk and Guenther 1999; Glaeser et al. 2000; Guenther and Falk 1999; Kolankiewicz 1996);
- Гишүүнчлэл (Baum and Ziersch 2003; O'Connell 2003; Price 2002; Warde et al. 2003; Wollebaek and Selle 2003);
- Гишүүнчлэл ба итгэлцэл (Lappe et al. 1997; Lochner et al. 2003; Veenstra 2002);
- Гишүүнчлэл, итгэлцэл, харилцан үйлчлэх хэм хэмжээ (Ишам нар. 2002; Скрабски ба бусад. 2003; Ставерен 2003); болон
- Сүлжээний нөөц (Zhao 2002).

Роберт Патнем⁹¹ АНУ-ын нийгмийн капиталыг тодорхойлохдоо а) Олон нийтийн буюу байгууллагын амьдралын b) Олон нийтийн ажилд оролцох оролцооны c) Олон нийтийн сайн дурын үйл ажиллагааны d) Албан бус нийтэч байдлын e) Нийгмийн итгэлцлийн хэмжигдэхүүн гэсэн үндсэн 5 багц хэмжигдэхүүнээр хэмжсэн байдаг.

Нийгмийн капиталд бүтцийн, харилцааны болон танин мэдэхүйн хэмжигдэхүүнүүдийг ялгаж салгах аргачлалыг Nahapiet & Ghoshal (1998) нар боловсруулсан.

⁸⁸ Häuberer J. Social Capital Theory. p53-54.

⁸⁹ Häuberer J. Social Capital Theory. p87-88.

⁹⁰ T. Claridge. Measurement of Social capital.

<https://www.socialcapitalresearch.com/literature/operationalisation/measurement/-ggv> татаж ашиглав.

⁹¹ T. Claridge. "Measurement of Social capital" өгүүллээс дам ишлэв.; Putnam. R. Bowling alone: the collapse and revival of American community. http://bowlingalone.com/?page_id=7

Хүснэгт 3. Нийгмийн капиталын хэмжигдэхүүн⁹²

Бүтцийн хэмжигдэхүүн	Танин мэдэхүйн хэмжигдэхүүн	Харилцааны хэмжигдэхүүн
Нийгмийн бүтэц	Хамтын /нэгдмэл/ ойлголт	Харилцааны мөн чанар ба чанар
<ul style="list-style-type: none"> ▪ Сүлжээний уялдаа холбоо ба тохиргоо ▪ Үүрэг, дүрэм, жишиг, журам 	<ul style="list-style-type: none"> ▪ Дундын хэл, код, өгүүлэмж ▪ Нэгдмэл үнэт зүйлс, хандлага, итгэл үнэмшил ▪ Хамтын зорилго, алсын хараа 	<ul style="list-style-type: none"> ▪ Итгэлцэл ба найдвартай байдал ▪ Хэм хэмжээ ба хориг арга хэмжээ /санкц/ ▪ Үүрэг, хүлээлт ▪ Адилсах ба адилсал

Харилцааны нийгмийн капитал нь итгэлцэл, үүрэг хариуцлага, хүндэтгэл, тэр ч байтугай нөхөрлөл зэрэг хувийн харилцааны шинж чанар, чанаруудтай холбоотой нийгмийн капиталын хэмжигдэхүүн юм. Нийгмийн капиталын харилцааны хэмжигдэхүүний гол талууд нь итгэлцэл ба итгэлцэл, хэм хэмжээ, хориг арга хэмжээ, хүлээх үүрэг, хүлээлт, адилсах, адилсал юм.⁹³

Стоун нийгмийн капиталыг нийгмийн сүлжээний бүтэц, чанар гэж үзэж болно гээд ингэснээр нийгмийн капиталын үндсэн хэмжээсүүд нь итгэлцэл, харилцан солилцоо (чанар)-оор тодорхойлогддог нийгмийн харилцааны сүлжээ (бүтэц) юм гэжээ.

Хүснэгт 4. Нийгмийн капиталын үндсэн хэмжигдэхүүнүүд, тэдгээрийн шинж чанарууд⁹⁴

Нийгмийн харилцааны бүтэц: сүлжээнүүд	Нийгмийн харилцааны чанар: хэм хэмжээнүүд
<p>Хэв маяг: Албан бус/ албан</p> <p>Хэмжээ/ хүчин чадал: Хязгаарлагдмал/өргөн цар хүрээтэй</p> <p>Орон зайн: Өрхийн / дэлхийн</p> <p>Бүтцийн: Нээлттэй / хаалттай Нягт / сийрэг Нэг төрлийн / гетероген</p> <p>Харилцан хамааралтай: Босоо / хэвтээ</p>	<p>Итгэлцлийн хэм хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн итгэлцэл • Танил / хувийн • Ерөнхийлсөн • Иргэний / байгууллагын итгэлцэл <p>Харилцан солилцооны хэм хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> • Бараагаар үйлчилгээгээр/ оронд нь • Шууд / шууд бус • Яаралтай /хойшлуулсан

Эх сурвалж: Stone (2001. p.7)

Нийгмээс тусгаарлагдах ба нийгмийн капиталын шинжилгээг уялдуулах нь

Дээр авч үзсэн ойлголт, үзэл баримтлал, судлан шинжлэх арга барил, хэмжүүрийн онцлог зэргээс үүдээд судлан буй хоёр үзэгдэл, үйл явцыг дараах байдлаар уялдуулан судалж шинжлэх боломжтой байна. Үүнд:

- 1) Нийгмээс тусгаарлагдах ба нийгмийн капиталын аль аль нь нийгмийн харилцаа, харилцан үйлчлэлтэй нягт холбогддог. Тухайлбал, нийгмээс тусгаарлагдах нь нийгмийн амьдралын үндсэн үйл ажиллагаа, харилцаанаас тусгаарлагдах, оролцоогүй байх явдал тэгвэл нийгмийн капиталын үндэс нь нийгмийн харилцаа, үйл ажиллагааны идэвхтэй байнгын оролцоо юм. Өөрөөр хэлбэл, “нийгмийн капитал нь нийгмийн харилцаанд шингэсэн бөгөөд хүмүүс харилцан үйлчлэлцэх үед хэрэгждэг” (Nahapiet, J., Ghoshal, S. 1998)⁹⁵. Эндээс тухайн 2 судлагдахууны

⁹² Nahapiet, Janine and Sumantra Ghoshal. 1998. “Social Capital, Intellectual Capital, and the Organizational Advantage.” *Academy of Management Review* 23(2):. p.251

⁹³ Nahapiet, Janine and Sumantra Ghoshal. 1998. “Social Capital, Intellectual Capital, and the Organizational Advantage.” *Academy of Management Review* 23(2):. p.251

⁹⁴ Tristan Claridge. “Measurement of Social capital” өгүүллээс дам ишлэв. <https://www.socialcapitalresearch.com/literature/operationalisation/measurement/-ggv> .

⁹⁵ Nahapiet, J., Ghoshal, S. (1998). Social capital, intellectual capital, and the organizational advantage. *Academy of Management Review*, 23(2), 242

давхцалыг олж харж болно. Хэрэв тухайн хүн нийгмийн үндсэн үйл ажиллагаанд хүсэвч оролцож чадахгүй, нөөцийг ашиглах эрхгүй, бусадтай харилцаа хязгаарлагдмал байгаа бол нийгмээс тусгаарлагдсан гэж ойлгохын хамт нийгмийн капитал тухайн хүнд бага буюу байхгүй байна гэж таамаглах боломжтой. Иймээс нийгмээс тусгаарлагдах болон нийгмийн капиталын ойлголтууд нь харилцан холбоотой, холбон судалж болох сэдвүүд юм.

- 2) Нийгмийн капитал ба нийгмээс тусгаарлагдах нь хувь хүн, бүлэг, нийгмийн түвшинд судлагдах ч хувь хүн дээр төвлөрч, хувь хүнээс эхэлнэ. “Нийгмийн капиталын үндэс нь хувь хүмүүс ба тэдгээрийн харилцаа холбоо юм, түүний дотор нийгмийн бүтцийг агуулдаг. Хувь хүмүүстэй харилцах харилцаа нь хувь хүмүүсийн хувьд жижиг үр дагавар, хамт олны хувьд том макро үр дагавар бүхий байдаг (Лин ба Эриксон 2010). Иймээс нийгмийн капитал нь хувь хүний болон хамт олны чиглэлтэй байдаг хэдий ч ном зохиолд холилдуулан авч үзэх хандлагатай байдаг”⁹⁶

Нийгмийн капиталыг хувь хүмүүсийн хоорондын нийгмийн харилцааг хамарсан гэж ойлгодог. Тиймээс нийгмийн капитал нь хувь хүнд олгодог боломж бололцоо, өгөөжид анхаарал хандуулах хандлагатай байдаг боловч ихэнх зохиогчид нийгмийн харилцан үйлчлэлийн уг чанар, шинж чанарт нөлөөлөх нийгмийн илүү өргөн хүрээний үүргийг хүлээн зөвшөөрөх юм уу оруулсан байдаг.⁹⁷

- 3) Нийгмийн капитал ба нийгмээс тусгаарлагдах үйл явцыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэмжигдэхүүний хувьд давхцуулан судалж болохоор байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн тусгаарлагдах үйл явцыг хэмжиж буй онолын 4-н хэмжигдэхүүний нийгэм-соёлын тусгаарлагдалт буюу нийгмийн харилцаанаас тусгаарлагдах, нийгмийн хэм хэмжээний интеграцийн дутагдал гэсэн 2 хэмжигдэхүүнээр харилцаа, нийгмийн сүлжээ, итгэлцэл, хэмжээ, үнэт зүйлсийн нэгдэл зэргийг хэмжих боломжтой юм.

⁹⁶ T. Claridge. Explanation of the different levels of social capital: individual or collective?. *Social Capital Research & Training, Dunedin, New Zealand.*

⁹⁷ T. Claridge. What is the difference between social capital and social cohesion? Өгүүллээс дам ишлэв.// Uphoff, N. (1999). Understanding social capital: Learning from the analysis and experience of participation. In P. Dasgupta & I. Serageldin (Eds.), *Social Capital: A multifaceted perspective* (pp. 215–253). Washington, DC: World Bank.

Эрдэм шинжилгээний илтгэл (дотоод)

О.Баасантогтох. Нийгмийн тусгаарлалт: хэрэглээ, ойлголтын олон янз байдал (Монголд хийсэн зарим судалгааны тайлан, үр дүнд хийсэн шинжилгээ). (0.6 х.х) //“Идэр эрдэм” онлайн сэтгүүл. УБ., 2021.

Нийгмийн тусгаарлалт: хэрэглээ, ойлголтын олон янз байдал (Монголд хийсэн зарим судалгааны тайлан, үр дүнгийн шинжилгээ)

*О.Баасантогтох, МУИС-ийн докторант
ШУА-ийн Философийн хүрээлэн, СНСЗС-ын ЭШДЭА
Умас: 95343716, E-mail: oyu.baasan@yahoo.com*

Товч утга: Нийгмийн тусгаарлалт буюу “exclusion” гэх социаль ойлголт нь утга, агуулгын хувьд “нийгмийн харилцааны гадна талд байх” гэх ерөнхий санааг илэрхийлэх бөгөөд Монгол улсад хийсэн зарим судалгааны тайлан, үр дүнг шинжлэхэд уг ойлголттой шууд холбогдол бүхий судалгааны ажил маш бага, байхгүй гэж болохоор байгаа юм. Харин “тусгаарлалт” гэх ойлголтын хүрээг нарийн тодорхойлолгүйгээр заримдаг шинжтэй, зарим тохиолдолд “ялгаварлал, гадуурхал, эс хамрагдалт” гэх томъёоллыг дүйцүүлэн, гэхдээ ойлголтын зарим тал шинж, агуулгыг хөндсөн байдлаар ашигласан нь цөөнгүй боловч тэдгээр нь “тогтсон томъёолол, утга, агуулгын хүрээ заагийг заан тэмдэглэлгүй” болзвол шинжтэй хэрэглэсэн нь шинжилгээний үр дүнгээс тодорхой харагдана.

Философийн хүрээлэнгийн СНСЗС-аас хэрэгжүүлж буй “Нийгмийн оролцоо ба тусгайлагдах үйл явц, үр дагавар” (2019-2021) суурь судалгаанд “тусгайлах, тусгайрах” гэх байдлаар томъёолсон нь мөн л хэрэглээ болон хэл зүйн тайлбарлалын хувьд “exclusion” гэх ойлголтыг утга, агуулгын хувьд онохгүй байгаа юм. Өгүүллийн агуулгаас тусгаарлалт гэх ойлголтын онол арга зүйн тайлбар, монголын судлаачдын томъёолол, утга агуулгыг, мөн тусгаарлалт гэх нийгмийн үзэгдэлийн илрэх хэлбэр, тусгаарлалтад нийгмийн аль хэсэг, эсвэл бүлэг өртөж буйг тодруулан харах боломжтой.

Түлхүүр үг: тусгаарлалт, оролцоо, тусгайлагдах, тусгайрах, ялгаварлал, эс хамрагдалт.

Онолын тайлбар, үндэслэгээ

“Social exclusion” буюу нийгмийн тусгаарлалт гэх ойлголт нь нийгэм, олон “нийтээс тусгаарлагдах, гадуурхагдах” гэсэн үйл явцыг “нийгмийн халамжийн хөтөлбөрүүд”-ээр дамжуулан шийдвэрлэхэд бэрхшээлтэй болсны үр дүн болж 1970 оны дунд үеэс хэрэглэгдэж, шинжлэх ухааны эргэлтэд орж эхэлсэн. Үүнээс өмнө улс орнууд ядуурал, ялангуяа орлогын ядуурлыг хэмжих судалгаанд илүү анхаарал хандуулж ирсэн⁹⁸. Шинжлэх ухааны эргэлтэд орсон тухай зарим материалд тухайлбал, уг ойлголт нь 1960 оны үеэс Францад мэтгэлцээн, маргааны гол сэдэв болж, 1980 оны эдийн засгийн хямрал, үндэсний тусламжийн тухай хууль (Revenue Minimum Insertion) баталсаны дараагаас өргөн хэрэглэгдэх болсон^{99,100} тухай тэмдэглэжээ.

⁹⁸ Martin Evans. Behind the rhetoric; The Institutional Basic of Social Exclusion and Poverty. IDS Bulletin. Vol 29. No 1. 1998. Page 42.

⁹⁹ Gerda Jehoel-Gijsbers & Cock Vroomen. Social Exclusion of the Elderly; A Comparative Study of EU Member States. ENEPRI Research Report No. 57. AIM WP 8.6. September 2008. Page 2.

¹⁰⁰ Suzanne Bronheim, Phyllis Magrab, Raymond Crowel. Social exclusion in the united states: policy implications for community solutions // <https://www.oecd.org/unitedstates/1855950.pdf> // 2020.11.29

Судлаачийн зүгээс хэн, анх хэзээ хэрэглэсэн тухай баримтаас илүүтэй уг ойлголтын анхны утга, түүгээр дамжуулан илэрхийлж буй санаа, агуулгыг ойлгохыг чухалчиллаа. Мартин Эванс “нийгмийн халамжийн бодлогоор шийдвэрлэж боломгүй шинэ үзэгдэл бий болж тэр нь ядуурлыг хэмжих, тогтоох судалгаанд өртөхгүй байгаа” гэх санааг дэвшүүлж “тусгаарлалт”-ыг судлах зайлшгүйн тухай, тэр нь “ядуурал” гэх харьцангуй объектив ойлголт, үзэгдэлтэй харьцуулахад судлаачдад шинээр өртөж (шинэ биш үзэгдэл), илүү өргөн, объектив болон субъектив хүчин зүйлээс хамаарах нийгмийн үзэгдэл болохыг илэрхийлснээрээ ач холбогдол өндөртэй юм.

Нийгмийн судалгаанд уг ойлголтыг хэрэглэж эхэлснээс хойш тусгаарлалтын талаар маш олон эрдэмтэн, судлаачид онолын болон практик түвшинд судлаж агуулга, бүтэц, хэлбэрийг нарийвчлан тодорхойлсон. Ийм судалгааны ажлуудаас “нийгмийн тусгаарлалт” гэх ойлголт, үзэгдлийг илэрхийлэх эмпирик судалгааны нэлээд үр дүнтэй арга зүй, хэрэглэгдэхүүнийг Нидерландын эрдэмтэд боловсруулж хэрэглэсэн гэж судлаачид тэмдэглэдэг.¹⁰¹

Судлаачид Голландын 860 өрхийг хамруулсан судалгааны үр дүнд үндэслэн нийгмийн тусгаарлалтын түвшинг илэрхийлэх хүчинтэй хэмжүүрийг олсон хэмээн мэдэгдсэн юм. Энэ хэмжүүр нь насанд хүрэгчдийн 11% нь нийгэмд хамааралгүй буюу нийгмээс тусгаарлагдсан гэжээ.¹⁰² Нийгмийн тусгаарлалтыг олон хэмжээст үзэгдэл гэж үздэг. Энэ нь а) материаллаг дутагдал, б) нийгмийн эрхийг үл хангах, в) нийгмийн оролцооны түвшин бага, г) хэм хэмжээ, соёл нэгдэл хязгаарлагдмал байх¹⁰³ гэсэн эдгээр үзүүлэлтийн хослолоор шинжилгээ хийжээ. Дараа нь учир шалтгааны шинжилгээгээр эрүүл мэнд муу байх нь хамгийн чухал эрсдэлт хүчин зүйл болж байгаагийн зэрэгцээ орлого багатай байх, санхүүгийн хараат байдал, хэлний мэдлэг, ганц бие эцэг эсвэл ганц бие эхтэйгээ хамт (ө.х өрх толгойлсон гэр бүл) амьдардаг хүмүүс нийгмийн тусгаарлалтад өртөх магадлалтай¹⁰⁴ болохыг судлан тодорхойлсон.

Европын холбоо 2000 оны Лиссабоны дээд хэмжээний уулзалтаас хойш нийгмийн нэгдмэл байдал, жигд оролцоог хангах (Inclusion)-ыг гол зорилтоо болгож ирсэн бөгөөд тухайн жилийн 12 дугаар сард болсон Ниццагийн дээд хэмжээний уулзалтаар нийгмийн жигд оролцоог хангах дөрвөн үндсэн зорилт дэвшүүлсэн. Үүнд: 1). Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бүх төрлийн нөөц ашиглах, чанартай бараа, үйлчилгээгээр хангагдах эрх, 2). Тусгаарлалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, 3). Нийгмийн эмзэг хэсэгт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, 4.) Нийгмийн тусгаарлалтыг даван туулахад холбогдох бүх байгууллагыг дайчлах¹⁰⁵ зэрэг болно.

Арга зүйн дээрх хоёр хандлагаас харахад орлогоос үүдэлтэй материаллаг болон хэрэглээний дутагдалд орох, социаль харилцаа хамаарал сулрах эрсдэл, үүнийг даван туулах эрх зүйн болон институтийн үүргийг аль алинд нь дурджээ. Ойлголтын хүрээ хийгээд энэ үзэгдэл бий болоход нөлөөлж буй хүчин зүйлийг Нидерландын эрдэмтэд:

- Харьцангуй ба үнэмлэхүй ойлголт: Үндсэн хэрэгцээгээ хангах хэмжээний орлогогүй болон туйлын ядуу хүмүүсийн тухайд тэднийг тусгаарлагдсан бүлэг гэж үзэх үнэмлэхүй зааг, хязгаарлалт тогтоодоггүй. Харин үүнийг нийгмийн хөгжлийн ижил нөхцөл, түвшинд байгаа бусад хүмүүстэй харьцангуй байдлаар жишин үнэлж болно.

¹⁰¹ Gerda Jehoel-Gijsbers & Cock Vroomen. Explaining Social Exclusion: A theoretical model tested in the Netherlands. The Hague. July 2007.

¹⁰² Мөн гэнд. Оршил.

¹⁰³ Мөн гэнд. 17 дахь тал.

¹⁰⁴ Мөн гэнд. 22-33 дахь тал.

¹⁰⁵ Ruth Levitas. The concept and measurement of social exclusion. Jan 2006. Page 124. // <https://www.researchgate.net> // 2020.11.29

- Нэг болон олон хэмжээсийн сул тал: Ядуурал нь материаллаг эх үүсвэрийн, эсвэл орлогын хомсдол гэсэн ганц хэмжигдэхүүнтэй. Гэтэл тусгаарлалт нь цалинтай ажил, орлого, боловсрол, орон сууц, эрүүл мэндийн үйлчилгээ, хууль эрх зүйн туслалцаа, нийгмийн хангамж, нийгмийн халамж хангамж зэрэг хүртээмжгүй байдлыг багтаадаг.
- Хамааралт шинж: Ядуурал нь орлого, хэрэглээтэй холбоотой эдийн засгийн хуваарилалттай холбоотой бол нийгмийн тусгаарлалт нь харилцан хамаарал буюу соёл, эв нэгдэл, нийгмийн холбоо хамаарал, оролцоо, эвлэлдэн нэгдэх зэрэг ойлголттой холбоотой бөгөөд энэ нь үзэл баримтлал, нийгэмшлийн хэм хэмжээнээс хамаардаг.
- Дотоод (эндоген), гадаад (экзоген) агент. Ядуурлын шинжилгээг хувь хүн, өрхийн түвшинд хийдэг бөгөөд эдгээр нь эмзэг бүлгийнхний онцлог, шинжийг өөртөө агуулж, тээгч буюу эндоген болно. Тусгаарлалт нь “нийтэд хамаарах нөөц” дутагдалтай байгаагаас хамааралтай бөгөөд үүнд хөрш (ойр тойрныхны харилцаа, дэмжлэг гэх утгаар хэрэглэжээ. О.Б), нийгмийн сүлжээ (харилцаа тогтоож буй хүмүүсийн холбоо. О.Б), нийгмийн хамгааллын байгууллага, нийгмийн дэд бүтэц ордог. Тусгаарлагдсан бүлэг, хүмүүсийн тухайд ийм гадаад (экзоген) хүчин зүйлийг маш бага, бүр огт хянах боломжгүй байж болно.

Дурдан буй баримт, материалд үндэслэвэл “нийгмийн тусгаарлалт” гэх уг ойлголт нь илүү өргөн бөгөөд хайхрахгүй орхиж үл болох нийгмийн олон тал эрсдэлт өөртөө агуулдаг үзэгдэл гэж ойлгож болох нь. Социологийн шинжлэх ухаанд К.Маркс, М.Вебер болон бусад¹⁰⁶ эрдэмтдийн үзэл, онолд энэ нь анги, давхраа, тэгш бус байдал гэх ойлголтуудтай холбоотой илрэн гарах ба хувь хүний болон бүлгийн эзэмшиж буй өмч, эрх мэдэл, орлого, нийгмийн байр суурь, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэргээс хамаардаг.

Хэрэглээний олон янз байдал

Өмнө тэмдэглэсэнчлэн нийгмийн тусгаарлалт гэх ойлголт, үзэгдэлийн агуулга, хэлбэр, бүтэц, нөлөөлөгч хүчин зүйлсийг дэлхийн улс орнууд, эрдэмтэд олон янз байдлаар судлан тодорхойлж, хэрэглэж байгаа бол монгол улсад энэ чиглэлээр хийсэн бие даасан судалгааны ажил бага байна. Ойлголтын агуулгад хамаарах санаа тусгасан цөөн судалгааны тайлан, үр дүнд “тусгаарлалт” гэх ойлголтыг хэрхэн ойлгож, томъёолон хэрэглэснийг шинжилж үзэхэд дараах дүр зураг тодорч байна. Үүнд:

НҮБ-ын Сайн дурынхны хөтөлбөрөөс “Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тайлан: Засаглалыг Өөрчлөх нь” (Пийникс Дизайн Эйд, Рэйнжерс Си, Дани., 2015) сэдэвт судалгааны тайланд “Оролцоо нь хязгаарлагдсан бүлгийнхэн, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд дуу хоолой болон оролцоогоо хүчтэйгээр илэрхийлэх шинэ, нэмэлт сувгууд нь тэдний хэрэгцээ шаардлагыг анхаарлын төвд аваачиж, нөөцийг тэдний онцгой хэрэгцээнд зориулан хуваарилахад ихээхэн нэмэр болдог.”¹⁰⁷ хэмээн тэмдэглэсэн нь нэгд, хязгаарлагдсан бүлгийнхэн гээд эмэгтэйчүүдийг онцолсон нь хүйсийн хувьд тусгаарлах хандлага байдгийг хоёрт, оролцооны хязгаарлагдмал байдал нь нийгмийн нөөцөөс хүртэх боломжийг нь бууруулдаг гэсэн санааг агуулж байна. Арга зүйн хувьд “хязгаарлах” гэсэн ойлголт нь нийгмийн оролцоо гэх ойлголттой шууд холбогдож байгаа нь үүнээс харагдаж байна. Мөн тайланд “... хүний оролцох эрхийн тэгш бус байдлыг анхаарч, оролцоо нь хамгийн ихээр хязгаарлагдсан иргэдийг

¹⁰⁶ Социологийг үндэслэгч суутнууд. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2006.

¹⁰⁷ Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тайлан: Засаглалыг Өөрчлөх нь. НҮБ-ын Сайн дурынхны хөтөлбөр. Пийникс Дизайн Эйд, Рэйнжерс Си, Дани., 2015. Хураангуй XIII.

хэлэлцүүлэгт оролцуулах талаар хэлэлцэх шаардлагатай”¹⁰⁸ гэж “хязгаарлах буюу хязгаарлагдсан бүлэг” гэсэн ойлголтыг тусгаарлах гэсэн ойлголттой утга дүйхүйц байдлаар, ингэхдээ “нийгмийн оролцоог хангах” гэсэн ойлголтын хамт хэрэглэжээ.

Монфемнет үндэсний сүлжээний “Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-н конвенцийн хэрэгжилтийн асуудлаар Монгол улсын Засгийн газраас бэлтгэсэн 8 ба 9 дүгээр ээлжит илтгэл”-д (УБ., 2015.05.19) мөн л эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхлын объект болж байна гэж тэмдэглэсэн. Тайланд “... эмэгтэйчүүдийг төр, зах зээл, олон нийт, гэр бүлийн хүрээнд ялгаварлан гадуурхагдах гол шалтгааныг бий болгож байгаа уламжлалт ёс заншил, олон нийтийн хандлагыг өөрчлөх төрийн хариуцлага дээр тулгуурлан бичих нь зүйтэй”¹⁰⁹ хэмээн эмэгтэйчүүдийн ялгаварлалыг институтын түвшинд авч үзсэн бөгөөд “Төр таслан зогсоох, ялгаварлан гадуурхалтын суурь шалтгааныг арилгахын оронд харин ч өөрөө санаачилж, өөгшүүлэн дэвэргэсээр байна.” “Хүн амаа өсгөх пронаталист бодлого болон эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн хэрэгсэл мэт харж байгаа.”¹¹⁰ гэсэн дүгнэлтийг хийжээ. Тухайлбал, тайлангийн 15 дахь талд “Нөхөн үржихүйн үүрэг хариуцлагатай холбоотой дарамт, гэр орны ажлын ачаалал, цагийн хомсдол, хөдөлмөрийн ээлгүй орчин зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж, эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдаж байна. ... нийгмийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх талаар огт тусгагдаагүй. ... залуу эмэгтэйчүүд ажлын байранд ялгаварлагдах, хөдөлмөрийн зах зээлээс шахагдах, нэг хүний цалин, орлогоор амьжиргаагаа залгуулахад хүргэх, хүүхэд асрах тэтгэмжээс өөр орлогогүй гэдгээр банкны шалгуурт унаж, орон сууцны зээл авч чадахгүй болох зэрэг эмзэг, эрсдэлт нөхцлүүдэд эмэгтэйчүүдийг төдийгүй залуу гэр бүлийг хүргэж байна.”¹¹¹ гэсэн арга зүйн хувьд нэгд тусгаарлалтыг институтын хувьд ялгаатай авч үзэх, хоёрт нийгмийн бодлого хөтөлбөр дэх тусгаарлалт хэрхэн илэрдэгийг, гуравт нийгмийн харилцаанд тусгаарлалт хэрхэн илэрч буйг тодруулан судлах боломжтой байна.

“Монгол улс дахь НҮБ-аас 2017 онд хийсэн ажлын үр дүнгийн тайлан” (2018.06)-д үр дүнгийн чиглэл 2 буюу “Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш нийгмийн үйлчилгээг дэлгэрүүлэх” талаар дөрвөн зорилт дэвшүүлснээс 2.2 “Хот, хотын захын хороолол болон хөдөө орон нутгийн ядуу, эмзэг хүн амд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн тэргүүлэх хөтөлбөрүүдийн хүрээнд эрүүл мэндийн чанартай үйлчилгээнд тэгш хамруулах; баримт нотолгоонд тулгуурласан бодлого болон шийдвэр гаргах зарчмыг сайжруулах чиглэлээр үндэсний байгууллагуудтай хамтран ажиллах”, 2.3 “Суурь боловсролын чанарыг сайжруулах, хүүхдийг бага наснаас хөгжүүлэх (ХБНХ) хөтөлбөрт түлхүү хамруулах, хотын захын сонгосон бүс, сумдуудад насан турш боловсрох нөхцөл бүрдүүлэх ажлыг хамтарсан хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх” 2.4 Бүх нийтийг хамарсан үр дүнтэй, бүтээмжтэй нийгмийн хамгааллын тогтолцоог нэвтрүүлэх, ингэхдээ ядуу болон эмзэг хүн амыг түлхүү хамруулах зорилтыг дэвшүүлэх”, 2.5 “Хүнс болон хоол тэжээлийн аюулгүй байдлыг сайжруулах (эрүүл хүнс/цагаан)”¹¹² гэсэн дэд зорилтууд тусгаарлах үйл явцтай дам, үр дүнгийн чиглэл-3 буюу “Олон нийтийн дуу хоолой, тайлагнах зарчмыг бэхжүүлэх” гээд “... улс орны хөгжлийн үр ашгийг хүн болгонд хүргэх, хэнийг ч орхигдуулахгүй, ялангуяа эмзэг бүлгийн хүн амд хүргэх, үүндээ жендерт суурилсан

¹⁰⁸ Мөн тэнд. Хураангуй XIV.

¹⁰⁹ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-н конвенцийн хэрэгжилтийн асуудлаар Монгол улсын Засгийн газраас бэлтгэсэн 8 ба 9 дүгээр ээлжит илтгэл. Монфемнет үндэсний сүлжээ. УБ., 2015.05.19. 1 дэх тал.

¹¹⁰ Мөн тэнд. 2 дахь тал.

¹¹¹ Мөн тэнд. 15 дахь тал.

¹¹² Монгол улс дахь НҮБ-аас 2017 онд хийсэн ажлын үр дүнгийн тайлан. 2018.06. 5 дахь тал.

хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд, залуучуудад хөгжлийн үр шимийг эрх тэгш хүртээх талаар засаглалын байгууллагуудын чадавхийг бэжжүүлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн шийдвэр гаргах үйл ажиллагаанд эдгээр бүлгийн хүн амын оролцоог нэмэгдүүлэх.”¹¹³ зорилт тавьсан нь бидний судалгааны ажилтай шууд холбогдоно. Тайланд дурдсан үр дүнгээс хүүхэд, хүчирхийлэлд өртөгсөд, шилжин суурьшигчид, хүний наймааны хохирогчид, хөгжлийн бэрхшээлтэй залуучууд зэрэг бүлгүүд нийгмээс тусгаарлагддаг талаар тэмдэглэжээ. Арга зүйн хувьд эндээс хоёр зүйл тодрох ба үүнд: нэгд нас, хүйс, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн байдал зэргээс хамаарч тусгаарлалтад өртөх, хоёрт тусгаарлалт нь бусдын оролцоогүй (жишээлбэл, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн зөвшөөрдөг ч тэднийг дэмжихгүй байх), бусдын оролцоотой (хүүхэд, эмэгтэйчүүдийг дур мэдэн /гийм хандлага соёлд нь шингэсэн байх/, зарим талаар хүч хэрэглэж тусгаарлах) буюу үл зөвшөөрөх байдлаар тусгаарлаж болохыг харж болохоор байна.

ХБНГУ-ын Фридрих Эбертийн сан, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хамтран “Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Судалгааны арга зүйн хэсэгт, “Hate Speech” гэх нэр томъёог олон улсад нэлээд түгээмэл ашиглаж байгаа ч Монголд яг энэ утгаар нь буулгасан, албан ёсоор орчуулсан, судалсан нь тун ховор байна. Тиймээс бид энэхүү шинэ ойлголтыг нутагшуулахын тулд нэлээд өргөн хүрээнд харж, тайлбарлах хэрэгтэй болж байгаа юм. Глоб интернэшнл төвөөс 2015 онд гаргасан “Хэвлэл мэдээллийн эрх зүй. Нэр төр гутаах, онлайнгаар үзэл бодлоо илэрхийлэх ба өөрийн зохицуулалт” сэдэвт сургалтын гарын авлагад үүнийг “үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэг” хэмээн орчуулсан байдаг. Энэ нь монгол хэлээр гарсан, “Hate Speech”-ийн тухай ойлголтыг мэргэжлийн түвшинд тайлбарласан ганц эх үүсвэр болж буй. Гэвч бидний хийсэн судалгаагаар “Hate Speech” нь зөвхөн үзэн ядалтаас үүддэггүй, мөн үзэн ядалт руу түлхэж, өдөөж, дэвэргэж байгааг харуулж байна. Иймд, энэ нэр томъёог “үзэн ядах үг хэллэг” хэмээн тодорхойлолтуудыг харгалзан авч үзэв:

- Арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл зэрэгт нь үндэслэн хэн нэгнийг, эсхүл хэсэг бүлэг хүнийг үзэн ядах хандлага гаргасан, эсхүл тэдний эсрэг хүчирхийллийг хөхүүлэн дэмжихүйц олон нийт рүү чиглэсэн үг хэллэгийг хэлнэ.
- Хэн нэгэн, эсхүл хэсэг бүлэг хүн рүү арьс өнгө, шашин шүтлэг, жендэр, эсхүл бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд нь суурилан дайрч давшлахыг хэлнэ.
- Арьс өнгөний үзэл, сенофоби, антисемитизм болон бусад үндэсний үзэл, үндсэрхэг дээрэнгүй үзэл, мөн цөөнх болон цагаачид, цагаач гаралтай хүмүүсийн эсрэг дайсагнал болон ялгаварлан гадуурхлыг тараах, өдөөх, сурталчлах, зөвтгөх бүх төрлийн илэрхийллийг ойлгоно.
- Хэсэг бүлэг хүнийг үзэн ядах илэрхийллээс өөр утга агуулаагүй харилцааны хэлбэр, ялангуяа тухайн харилцаа нь хүчирхийллийг өдөөхөөр байвал “hate speech” гэнэ. Юуны түрүүнд хэсэг бүлэг хүнийг арьс өнгө, үндэс угсаа, гарал үүсэл, жендэр, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа зэргээр нь үзэн ядахад турхирахыг үүнд хамааруулна. Үзэн ядах үг хэллэг нь арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг болон бусад онцгой цөөнх, эсхүл эмэгтэйчүүд рүү чиглэсэн бүх л төрлийн түрэмгий, давшилсан илэрхийлэл байж болно.

Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд, үзэн ядах үг хэллэгийн хохирогч нь үндэстний цөөнх, ижил хүйстэн хүмүүс, эмэгтэйчүүд, сэтгэцийн эмгэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг аливаа шинж тэмдгээрээ бусдаас ялгарч буй ямар нэгэн хэсэг бүлэг хүн байхаар байна. Үүний зэрэгцээ, хувь хүн рүү, ялангуяа олны танил хүн рүү

¹¹³ Мөн тэнд. 32-42 дахь тал.

чиглэсэн үзэн ядах үг хэллэг ч түгээмэл байдгийг олон улсын судалгаанууд, бидний хийсэн цахим мониторингийн үр дүн ч мөн харуулж байгаа юм.

Үзэн ядах үг хэллэг гэдэгт бид хэн нэгэн, эсхүл хэсэг бүлэг хүнийг үндэс угсаа, шашин шүтлэг, жендэр, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл зэрэгт нь үндэслэн ялгаварлан гадуурхсан, эсхүл гүтгэж, доромжилсон, мөн хүчирхийлэлд уриалан дуудсан, дайрч давшилсан, нэр хоч өгсөн зэрэг бүх төрлийн үг хэллэг, хэлэмжийг ойлгож болохоор байна”¹¹⁴ хэмээн ялгаварлалтай холбоотой илрэх шинж, түүнд өртөж болох нийгмийн бүлгүүдийг тодруулжээ.

Дэлхийн банкнаас “Улаанбаатар хот дахь ядуурлын байдал: Ядуурлын хэлбэрүүдийг ойлгон, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь” (Вашингтон хот., 2017) сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд тайланд тусгаарлалт гэсэн ойлголтыг “Нийгмийн тодорхой бүлгүүд өөрсдийн онцлог ухамсар (нийгэмд танигдсан байдал-identity) буюу нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан таагүй нөхцөл байдалд оршин байдаг. Уг таагүй нөхцөл байдал нь нийгмээс гутаан доромжлох (social stigma) хэлбэрээр илэрхийлэгддэг ба нийгмийн гадуурхал болон өртөмхий байдлыг бий болгоход гол хүчин зүйл болдог.” гэж тодорхойлоод “Шилжин ирсэн иргэдийг Улаанбаатар хотын ядуурлын өндөр түвшний гол эх сурвалж бөгөөд хотын зах руугаа тэлсэний гол шалтгаан хэмээн хотын оршин суугчдын зүгээс ихэвчлэн дорд үзэн гадуурхдаг.” гэжээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гудамжны хүүхдүүд, орон сууцны жижүүрүүдийг гадуурхагдаж буй бүлэгт хамруулан¹¹⁵ үзсэний зэрэгцээ гадуурхал нь хүүхдийн тоо, биеийн онцлог, нас¹¹⁶ зэргийг онцлон гадуурхдаг гэжээ.

Хэлэлцэн буй сэдэвтэй шууд уялдахгүй ч ядуус тусгаарлалтын эхний объект болох үндэслэлтэй гэх арга зүйн дагуу авч үзвэл тус судалгааг хийхэд ашигласан 22 шалгуур үзүүлэлт бүхий Алкайр Фостер аргын зарим үзүүлэлтийг өөрчлөх шаардлагатай буюу зөв гэсэн болгоныг судлаачид муйхарлан дагах нь өөрсдийгөө үл мэдэх, асуудлаа таньдаггүйн л илрэл гэлтэй. Тус аргачлалд жишээлбэл, “Ус ба ариун цэвэр” бүлэг үзүүлэлтийн хэмжээсийн дотор “бие засах байгууламж дангаараа ашиглах боломжтой” гэсэн шалгуур бий. Тайланд “Ус ба ариун цэвэр хэмжээсийн гачигдлыг (тус тайланд ус, ариун цэвэр гэх үзүүлэлтийг нэг хэмжээс гэсэн утгаар найруулгын хувьд ийм байдлаар оруулсан. О.Б) шийдвэрлэх юм бол олон хэмжээст ядуурал ихээхэн багасах буюу 23.4%-иас 15.7% болж буурахаар байна.” гэсэн нь уг үзүүлэлт нь өөрөө ядуурлыг хэмжих шалгуур болж чадах эсэх нь эргэлзээтэй юм.

МУ-ын Хүний эрхийн үндэсний комисс “Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилтийн судалгааны тайлан”-д (УБ., 2004)¹¹⁷ нас, хүйс (Үйлдвэрийн тэргүүний ажилчин байсан Б гэгч эмэгтэйг жирэмсэн болсон гээд цалин мөнгөний тооцоог хийлгүйгээр халж явуулсан тухай бичжээ. Мөн иймэрхүү явдал Чингэлтэй дүүргийн 5-р хорооны иргэн О гэх эмэгтэйг БНСУ-ын иргэний хөрөнгө оруулалттай Жулио ХХК-д ажиллаж байхад нь тохиолдсон бол Баянзүрх дүүргийн нэгэн хорооны өрхийн эмч Э-г хүүхэд төрүүлээд / ажилдаа эргэн орох гэхэд нь хүүхэд чинь бага гээд ажиллуулахгүй хохироосон), нийгэмд эзлэж буй байр суурь (“ажилд оруулж өгөөч, ажилд ороход минь туслаач” гэсэн агуулгатай өргөдлийг 2001 онд 25 хүн, 2003 онд 3 хүн бичсэн нь таарсан бөгөөд эдгээрийг Хөдөлмөр, нийгмин хамгааллын яам, Хөдөлмөрийн хяналтын алба, УИХ-ын дарга болон зарим гишүүд, ерөнхий сайдад

¹¹⁴ Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг. ХБНГУ-ын Фридрих Эбертийн сан, Хэвлэл мэдээллийн зөвлөл. УБ., 2018.

¹¹⁵ Улаанбаатар хот дахь ядуурлын байдал: Ядуурлын хэлбэрүүдийг ойлгон, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь. Дэлхийн банк. Вашингтон хот., 2017. 12-14 дэх тал.

¹¹⁶ Мөн тэнд. 31 дэх тал.

¹¹⁷ Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилтийн судалгааны тайлан. МУ-ын Хүний эрхийн үндэсний комисс. УБ., 2004. 5-10 дахь тал.

ирүүлсэн байв. Ийнхүү иргэд тэднийг ажилд авах эрхтэй шууд ажил олгогч болох аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад бус харин УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдэд ажил олгохыг хүссэн өргөдлийг бичиж байгаа нь хөдөлмөрийн харилцааны практикт ажил олгогч тал иргэдийг янз бүрийн үзүүлэлтээр шахаж, ялгаварлан ажилд авдагтай шууд холбоотой гэж дүгнэхэд хүргэж байна. Ийнхүү ажилд орохыг туйлаас хүсч Засгийн газрын гишүүнд хандаж орон гэргүй, тэнүүлчин иргэн “Т” өргөдөл бичиж байсныг зориуд дурдаж болох юм.), хувь хүний үзэмж (сул чөлөөтэй болон шинээр бий болсон ажлын байрандаа иргэн авч ажиллуулах тухай ажил олгогч нар зарлахдаа иргэдийг хувийн шинж байдлаар нь илэрхий ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэгэнд нь хууль бусаар давуу эрх олгосон шинжтэй шаардлага тавих нь түгээмэл болсон), үндэс угсаа (ХЭҮК-оос 2003 оны 10 дугаар сард ОХУ-ын хөрөнгө оруулалттай “Алтан дорнод” ХХК-д хийсэн шалгалтын тухай Комиссын ажилтан С.Гэрэлмаагийн бичсэн тайланд “Белазын жолооч, Монголын иргэний цалинг сард 205 ам.доллараар тогтоосон боловч ОХУ-ын иргэний цалинг сард 360 ам. доллар байхаар тогтоосон), үзэл бодол-итгэл үнэмшил (ажилтан, албан хаагчдыг улс төрийн үзэл бодол, намын харьяаллаар нь ялгаварлан гадуурхаж ажлаас нь халах, өөрчлөх нь хамгийн зонхилох хэлбэр. 2000 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулиас хойшхи хугацаанд яам, агентлаг, төр, захиргааны бусад байгууллагад ажиллаж байгаад халагдаж чөлөөлөгдсөн 3638 хүний 94.1 хувь (3422) нь нам бусчууд байжээ. Тэгвэл аймаг, нийслэлийн төр, захиргааны байгууллагад ажиллаж байгаад халагдаж чөлөөлөгдсөн 3595 хүний 68 хувь нь (2515) нам бусчууд байна. ХНХЯ-ны сайдад 2001-01-10, 17 -н д УИХ-ын 2 гишүүн тус тусдаа ирүүлсэн албан бичигт иргэн Б нь манай намын гишүүн ... дугаар үүрийн товчооны гишүүн бөгөөд УИХ-д сонгогдох ажилд минь идэвхитэй оролцсон тул яамандаа ажилд ороход нь туслахыг хүсч бичжээ.), үг хэлэх эрхийг нь хязгаарлах (О гэгч эмэгтэй улс төрийн томоохон нэг намын удирдах төв аппаратад архивын эрхлэгчээр ажиллаж байгаад ажиллах өрөөг нь подваль руу нүүлгэх болоход нь архив подвальд байж таарахгүй, ажилчдын эрүүл мэндэд ч нөхцөл нь тохирохгүй гэж хэлснийх нь төлөө удирдах, удирдуулах ёсыг мэддэггүй гэж адлагдаж ажлаасаа халагджээ.) зэргээр гадуурхдаг хандлага нэгэнт тогтжээ. Тус судалгааны тайланд ялгаварлал, гадуурхлын талаар ийнхүү тодорхой жишээ баримтуудыг гаргасан нь өргөн утгаар авч үзвэл тусгаарлалтын илэрч буй хэлбэр юм.

Ойлголтын олон янз байдал ба тайлбарлал

Шинжилгээний үр дүнгээс тусгаарлалт гэх ойлголтын утга, агуулгыг илэрхийлэхүйц байдлаар “тусгайлах, тусгайлагдах, ялгаварлах, гадуурхах, дэмжихгүй байх, үл зөвшөөрөх, эс хамрагдах” гэх ойлголтуудыг утга дүйн хэрэглэжээ. Дурдан буй ойлголтуудад “нийгмийн баялагаас хүртэх боломж, оршин амьдрахтай холбоотой бусад эрх нь хязгаарлагддаг” гэх санааг агуулж байгаа юм. Тусгаарлагдаж буй бүлэг нь “нийгмийн харилцаа-эдийн засаг-сэтгэл зүй”-н хувьд таагүй байдалд байх, нийгмийн бусад бүлгээс дорд үзэх, ялгаатай байдлаар харьцах, хяхаж хавчих, төр засгийн зүгээс анхаарал хандуулахгүй байх зэргээр илрэн гардаг гэх ойлголтыг өгч байна. Ойролцоо агуулгатайгаар хэрэглэж буй эдгээр утга, томъёоллын зэрэгцээ “тусгайлагдах” гэх ойлголтыг “оролцоо - inclusion” гэх эсрэгцсэн утга бүхий ойлголттой хамт хэрэглэх нь түгээмэл аж.

Хэл зүйн хувьд “Монгол хэлний их тайлбар толь”¹¹⁸, Query¹¹⁹ толь зэрэг онлайн тайлбар толь бичигт:

¹¹⁸ Монгол хэлний их тайлбар толь // mongoltoli.mn // 2020.11.29

¹¹⁹ Толь // toil.query.mn // 2020.11.29

- Тусгайлах гэдгийг “харилцаа, үйлдлээр хүндэтгэл үзүүлэх” гэх утгаар хэрэглэж буй бөгөөд тусгайлагдах гэдэг нь тусгайлах гэх үгийн үйлдэгдэх хэв гэж тайлбарлажээ.
- Ялгаварлах гэх үгийг “нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн чадамж зэрэг тодорхой шинжээр өөрөөс ангид, тусдаа бүлэг үүсгэх” гэж ялгаа гэх утгаар хэрэглэсэн байна.
- Гадуурхах, гадуурхал гэх үгийн тухайд “өөрийн биш, хамааралгүй” гэсэн утга оноон тайлбарлажээ.
- Үл зөвшөөрөх гэх үгийн тухайд зөвшөөрөх гэх үгийн эсрэг санааг илэрхийлэх бөгөөд “татгалзах, дагалдахгүй, оролцохгүй байх” гэж, “дэмжихгүй байх” гэх үг нь “тэтгэх, туслах, дэмж үзүүлэхээс татгалзах” гэсэн утгыг илэрхийлнэ.
- Эс хамрагдах гэх үгийн хувьд “оролцоогүй байх” гэсэн утгыг илэрхийлэх ч энэ нь “exclusion” гэх ойлголтын зөвхөн нэг талыг илэрхийлж байгаа юм.

Агуулга, багтаамжийн хувьд эс хамрагдалт гэхээс бусад “ялгаварлал, гадуурхал, дэмжихгүй байх, үл зөвшөөрөх тусгайлагдахуй, тусгаарлахуй” гэсэн томъёоллуудын тайлбар, хэрэглээний утга нь тусгаарлалт гэх ойлголтод хамаарах утга, агуулгын аль нэг талыг илэрхийлж байгаа юм.

Энд тэмдэглэснээс гадна “тусгайлагдахуй, тусгаарлахуй” гэж уянгын халилтай ч гэмээр ойлголтыг санал болгож буй бөгөөд шинжлэх ухааны ойлголт, үг хэллэг нь хэтрүүлэл, чамирхлаас ангид байх тухай суурь зарчимд үл нийцэх тул ийм ойлголт, томъёоллоос аль болох татгалзаж, зайлсхийх нь зүйн хэрэг юм. Утгын хувьд тусгайлагдахуй гэсэн томъёолол нь “бусдаар өөрийгөө өргөмжлүүлж, хүндэтгүүлэх”, тусгаарлахуй гэдэг нь “өөрөө өөрийгөө бусдаас, эсвэл нийгмийн бүлгүүдээс ангид” авч үзэх гэсэн утгыг илэрхийлэх тул exclusion гэх томъёоллын хувьд агуулгад үл нийцнэ.

Тусгаарлах гэх ойлголт нь “бусдаас саланги, хөндий байх, бие даах, тусдаа орших” гэсэн харьцангуй өргөн утгаар хэрэглэгдэж байгаа нь “exclusion” гэх ойлголтын агуулгыг зохих хэмжээнд илэрхийлнэ. Хэл зүйн ойлголт, тайлбарын хувьд харьцангуй оновчтой байж болох юм.

Практик түвшний буюу энгийн ажиглалт, мэдрэмж, дадалд суурилсан ойлголт нь тусгаарлалтын зөвхөн нэг тал, хэлбэрийг илэрхийлж, түүнд тулгуурлан үгүйсгэх няцаах хандлага илэрч буй тул шинжлэх ухааны талаас онолын хувьд түүнд хамаарах утга, агуулгыг оновчтой тодорхойлж, арга зүйн хувьд тусгаарлалтын хэлбэр, хэв маягуудыг ялгаж, бүтэцлэх бодит хэрэгцээ бий. Тухайлбал, арга зүйн хувьд тусгаарлалт гэх нийгмийн үзэгдэл нь хоёр хэлбэрээр бий болж байгаа нь шинжилгээний үр дүнгээс харагдаж буй бөгөөд эхнийх нь өөрийгөө нийгмээс тусгаарлах, хоёр дахь нь нийгмийн бусад бүлгээс тухайн субъект, эсвэл бүлгийг тусгаарладаг. Үүнийг тусгаарлах (өөрөө үйлдэх хэв), тусгаарлагдах (бусдын эрхэнд үйлдэгдэх хэв) гэсэн ойлголтуудаар дамжуулан илэрхийлэх боломжтой байна.

Дүгнэлт

Шинжилгээний үр дүнгээс харахад “exclusion” гэх ойлголтыг “тусгайлах, тусгайлагдах, ялгаварлах, гадуурхах, дэмжихгүй байх, үл зөвшөөрөх, эс хамрагдах” гэсэн ойлголт, томъёоллоор тайлбарлан, хэрэглэж байгаа ч хэл зүйн хувьд “тусгаарлалт” гэх томъёолол нь агуулгын хувьд, мөн Нидерландын эрдэмтдийн гаргаж тавьсан ойлготын хүрээ, зааг, агуулгыг тодорхой хэмжээгээр өөртөө шингээсэн гэж болохоор байна. Утга дүйн хэрэглэсэн бусад үгсийн тухайд тусгаарлалт гэх ойлголтын зарим нэг шинж, талыг агуулж байгаа бол зарим үгс “exclusion” гэх ойлголтын аль нэг талыг, эсвэл эсрэг утгыг тодруулах байдлаар хэрэглэсэн дүр зураг бууж байна.

Тусгаарлалт нь нийгэмд: нас, хүйс (хөдөлмөр эрхлэлт, боловсрол, гэр бүл, мэдээлэл г.м нийгмийн харилцааны талбар “улс төр, соёл, эдийн засаг, нийгэм”-ээс

хамаарч өөр өөр байдлаар илэрдэг), нийгмийн байр суурь (статус), амьжиргааны түвшин (ядуус, орон гэргүй иргэд г.м), итгэл үнэмшил-үзэл бодол, мөн цөөнх (хүйс, шашин шүтлэг, ястан угсаатны г.м)-ийн бүлэг, өвчлөл (олдмол болон төрөлхийн) гэх нийгэм, хүн ам зүй, эдийн засаг, эрүүл мэнд, соёлын гэх зэрэг янз бүрийн хүчин зүйлээр дамжин илэрдэг. Үйлдэгдэж буй хэвээр нь бусдаар болон өөрөө үйлдэгдэх, бусдаа үйлдэгдэх нь албан болон албан байдлаар хэрэгждэг. Харилцааны хэлбэрээр нь хийсвэр орон зай дахь (нийгмийн сүлжээ) болон бодит харилцаан дахь гэж ангилж болохоор байгааг цаашид энэ чиглэлээр хийх судалгаанд анхаарахад илүүдэхгүй.

Судлаачдын зүгээс социологийн ухаанд хэрэглэгдэж буй суурь ойлголтыг монгол хэлэнд буулгаж хэрэглэхийн өмнө хэл зүй, агуулга, утга санааны хувьд шинжилж хэрэглэж хэвших нь судлаачдад, цаашлаад судалгааны үр дүнг хэрэглэж, ашиглаж буй хүмүүст зөв, цэгцтэй ойлголт өгөх, шинжлэх ухааныг илүү тодорхой, зөв, дөгөм ойлгоход тустай.

Эрдэм шинжилгээний илтгэл (дотоод)

Д.Номун-Эрдэнэ. Нийгмээс тусгайлагдах үйл явцын шинжилгээнд нийгмийн шилжилтийг судлах арга зүйг хэрэглэх нь (0.4 х.х) // Идэр эрдэм онлайн сэтгүүл. УБ., 2021.

НИЙГМЭЭС ТУСГАЙЛАГДАХ ҮЙЛ ЯВЦЫН ШИНЖИЛГЭЭНД НИЙГМИЙН ШИЛЖИЛТИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙГ ХЭРЭГЛЭХ НЬ

Д.Номун-Эрдэнэ
докторант, ЭШДЭА
ШУА-ын Философийн хүрээлэнгийн
Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар

Энэхүү илтгэл нь нийгмээс тусгайлагдах үйл явцыг шинжлэхэд нийгмийн шилжилт (social mobility)-ийн арга зүйг хэрхэн хэрэглэх, түүний ач холбогдлын талаар авч үзэхийг зорьсон. Ингэхдээ нэгдүгээрт, нийгмийн тусгайралтын талаарх ойлголт, зарим онол, хандлагын талаар, хоёрдугаарт, нийгмийн шилжилтийн талаарх товч ойлголт, арга зүйн талаар, гуравдугаарт, нийгмийн тусгайралт ба нийгмийн шилжилтийн хамаарлын талаар авч үзнэ.

The purpose of this paper is how the methodology of social mobility can be applied and its importance in the analysis of the process of social exclusion. The report consists of three main parts: First, the concept of social exclusion, some theories and approaches, second, an understanding of social mobility and methodology, and third, the relationship between social exclusion and social mobility.

Түлхүүр үгс: Нийгмийн тусгайлагдах үйл явц, нийгмийн шилжилт, нийгмийн шилжилтийн хэвтээ болон босоо чиглэлийг хөдөлгөөн

Key words: Social exclusion, social mobility, horizontal and vertical movement of social mobility

1§ Нийгмийн тусгайралтын талаарх ойлголт, түвшин

Уг ойлголт нь poverty-ядуурал, deprivation-гачигдал, хоосрол, hardship- хомосдол, зовлон гэсэн үгнээс гаралтай. 1980 онд Европийн Холбооны баримт бичигт дурдагдсан боловч үндсэн ойлголтоороо “Less-industrialised” гэж нэрлэгддэг эрдэм шинжилгээний сэтгүүлд анхлан дурдагдсан байна. 1990 оноос хойш түгээмэл хэрэглэх болжээ.

“Нийгмийн тусгайралт”-ын үзэл баримтлал нь Европийн Холбооны гол үзэл баримтлал болсон ба Их Британийн ерөнхий сайд Тони Блэйрийн Хөдөлмөрийн шинэ засгийн газрын бодлогын үндсэн үзэл баримтлал байсан. 1980-аад онд Европийн Холбооны Ядуурлын Хөтөлбөрт нийгмийн тусгайралтыг бодлогын хувьд анх хэрэглэсэн байна.

Явцуу утгаараа нийгмийн тусгайралт нь орлогын ядуурал гэдэгтэй ижил утгаар хэрэглэгддэг. Тухайлбал маш бага цалинтай эсхүл цалинтай хөдөлмөр эрхлэдэггүй хүмүүсийг багтаадаг.

Өргөн утгаараа ядуурал, орлогын тэгш бус байдал, гачигдал, ажил эрхлэлтийн дутагдалтай холбоотой. Европийн холбооны Ядуурлын хөтөлбөрийн 1994 оны тайланд нийгмийн тусгайралтыг системчилсэн цогц байдлаар гаргаж тавьсан байдаг. Ингэхдээ нийгмийн тусгайралт нь нөөцийн дутагдал, нийгмийн эрхээ эдлэж чадахгүй байх зэрэг олон янзын дутагдлыг илэрхийлдэг динамик үйл явц гэж үзсэн байна. Нийгмийн тусгайлагдах үйл явц нь гэр бүлийн харилцаа болон нийгмийн харилцаа холбоо багасах, зорилго, ижилсэлээ алдах зэргээр олон төрлийн дутагдалд хүргэдэг гэжээ.

Гэхдээ улс орон бүр өөр өөрийнхөөрөө social exclusion-ийг тодорхойлон, тухайн бүлэгт хамаарах хүмүүс, бүлгийн шинжийг гаргасан байдаг. Тухайлбал,

Өмнөд Ирланд: Нийгмийн тусгайлагдалт нь хувь хүн, өрх айл, нийтлэгүүд болон нийгмийн ялгаатай байдлыг хадгалсан болон цаашаа түлхэгдсэн аливаа нийгмийн бүлгүүдийн хөдөлмөрийн зах зээл ба халамжийн тогтолцоонд хэрхэн багтаж байгааг илэрхийлсэн цогц үйл явц юм. Энэ нь зөвхөн материаллаг дутагдал бус, илүү өргөн хүрээнд нийгмийн болон хувь хүний амьдралын оролцоон дахь бүхий л боломжийн дутагдлыг агуулдаг.

Шотланд: Нийгмийн тусгайлагдах үйл явц нь шалтгаан, үр дагаврын холбоонд байдаг. Жишээлбэл, ядуурал нь гадуурхагдах шалтгаан бөгөөд үр дагавар юм.

Их Британ: Нийгмийн тусгайлагдалтыг хувь хүн болон тухайн газар нутагтай нь хослуулан авч үздэг. Жишээ нь: ажилгүйдэл, мэргэжил болон чадварын хомсдол, бага орлого, сууцны дутагдал, гэмт хэрэг эргэн тойронд нь их гардаг, эрүүл мэндийн байдал тааруу, гэр бүлийн харилцаа, холбооны дутагдал зэрэгтэй холбож тайлбарладаг.

1999 онд Английн судлаач *Burchardt* дараах тодорхойлолтыг гаргасан нь илүү ончтой гэж үзэх нь бий. Хувь хүмүүс байнга оршин суудаг байршилаараа, нийгэм дэх иргэний хэвийн үйл ажиллагаанд оролцдоггүй байдлаараа тусгаарлагддаг.

Бергман (1995) иргэний интеграцчилалыг бий болгох ардчилсан, эрх зүйн тогтолцоо; эдийн засгийн интеграцийг бий болгодог хөдөлмөрийн зах зээл; нийгмийн интеграцийг бий болгох нийгмийн халамжийн тогтолцоо; гэр бүлийн болон олон нийтийн системүүд хоорондын харилцаа холбоог бий болгоход анхаарах хэрэгтэй гэжээ. *Бергман* (1995), *Бергер-Шмитт* (2000) нар нийгмийн тусгайлагдалтыг нийгмийн хүрээнд авч үзвэл гол төлөв процесст нь чиглэх, хувь хүмүүс, бүлэг, олон нийтийн хувьд авч үзвэл гол төлөв үр дагаварт нь чиглэх нь зүйтэй гэж үзсэн. Тэднийхээр нийгмийн тусгайлагдалтыг нийгмийн халамжийн доор түвшин болон нийгмийн амьдралд оролцож чадахгүй байх явдал гэж тодорхойлжээ.

McCrystal нар (2001) ажилгүйдэл; орон нутгийн засаг захиргааны үйлчилгээ, харилцааны хүрээний нөөц, орон сууц, нийтийн тээврийн үйлчилгээний дутагдал; гэмт хэргийн түвшин, өвчлөл ба эрүүл мэнд, өр ба боловсролын хүрэлцээ муу зэргийг харгалзан үздэг байна. Мөн нийгмийн тусгайлагдалт нь олон тооны хязгаарлалтыг бий болгодог гэж үзжээ.

Steinert's (2003) нь нийгмийн гадуурхалын оролцоонд түшиглэсэн томъёоллыг гаргасан бөгөөд улс төр, эдийн засаг, нийгмийн, соёлын гэсэн тусгайлагдалтыг төрөл байна гэж үзжээ.

Wessels and Miedema нийгмийн тусгайлагдалтын нийтлэг таван хэв шинжийг тодорхойлсон. Үүнд:

1. Альтернатив тусгайлагдалт: Нийгмийн амьдралын үндсэн урсгалын гаднах альтернатив амьдралын хэв маягийг хамааруулдаг. Ерөнхийдөө сайн дурын шинжтэй юм. Ихэвчлэн үндэс угсаа, шашин шүтлэг, бизнес эрхлэх, нягт нийгмийн хүрээнд амьдардаг, гадны хүмүүстэй нийгмийн харилцаанд ордоггүй зэргээс нь шалтгаалаад хөдөлмөр эрхлэхээс тусгайлагдсан хүмүүс хамаардаг. Жишээ нь 20-р зууны эхэн үед Лондогийн зүүн төгсгөлд Еврейчүүдийг байрлуулдаг байсан явдал юм. (Phillips, 2002).

2. Урьдчилсан тусгайлагдалт: Хэдийгээр саад бэрхшээлтэй тулгардагч нийгэм, улс төр, соёлын амьдралд оролцох боломжтой хэвээр байдаг. Энэ нь жинхэнэ нийгмийн тусгайлагдалтын эхлэл юм. Жишээ нь, Их Британы Католикууд одоо ч зарим хязгаарлалттай байна, тухайлбал, Английн хаант улсын өв залгамжлагчтай гэрлэх боломжгүй гэх мэт.

3. Дунд буюу завсарын тусгайлагдалт: Энд хамаарч буй хүмүүс зарим онцгой институтаас тусгайлагдах боловч ерөнхийдөө үндсэн институтын бүтцэд хамаардаг. Жендерийн улмаас гадуурхагдах нь үүний сонирхолтой жишээ юм.

4. Ахисан буюу дээд түвшиний тусгайлагдалт: Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс хамаараад оролцооны институтчилагдсан хэлбэрүүд болон олон гол чиглэлээс гадуур байдаг бөгөөд тэдгээрийг оруулахад ихээхэн бэрхшээл гардаг.

5. Гүнзгий буюу хатуу тусгайлагдалт: Энэ бүлэгт хамаарах хүмүүс ихэвчлэн өөрийнхөө ертөнцөд л байдаг. Тэд ихэвчлэн нийгмийн албан ба албан бус институтууд болон

оролцооны хэлбэрүүдээс тусгайлагдсан байдаг. Ерөнхийд нь хэт хязгаарлагдмал тохиолдол гэж тодорхойлсон.

Нийгмийн тусгайлагдах үйл явцыг хэмжих үндсэн хоёр арга зүй байна. Нэгд, үйл явц, шалтгааны хүрээнд шинжлэх, хоёрт, үр дагаврын хүрээнд шинжлэх юм. Нийгмийн тусгайлагдахыг хэмжих гурван багц шалгуур бий. Үүнд:

- Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, дэд бүтэц гэх мэт боломжийн хүртээмжийг хэмжих
- Хөдөлмөр эрхлэлт, орлогын хүртээмжийг хэмжих
- Улс төр, иргэний болон соёлын амьдралд оролцох оролцоог хэмжих

2§ Нийгмийн шилжилтийн талаарх ойлголт, судалгааны арга зүй

Нийгмийн шилжилтийн уян хатан байдал өндөр байх тусам нээлттэй нийгэм хэмээн тодорхойлдог ч хэт их хөдөлгөөн нь нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдлыг харуулдаг билээ. Түүнчлэн нийгмийн шилжилтийн дүнд дунд ба дундаас дээш давхрааныхан өсч байвал эерэг хөдөлгөөн харин эсрэгээрээ буурч байвал сөрөг хөдөлгөөн гэж үздэг. Эерэг хөдөлгөөн нь нийгмийн хөгжлийг илэрхийлэх чухал үйл явц боловч сөрөг хөдөлгөөн нь нийгмийн тэгш бус байдал, ялгарал, ядуурал, эдийн засгийн болоод нийгмийн хөгжлийн буурангуй талыг илэрхийлэх тул судлаачид нийгмийн шилжилтийн үйл явц, чиглэл, шалтгааныг судалгаа шинжилгээнийхээ анхаарлын төвд байлган тогтмол судлах шаардлагатай юм.

Ойлголтын тухайд social mobility хэмээх нэр томъёог манай судлаачид “*нийгмийн шилжилт, хөдлөнгө чанар*” (Х.Гүндсамбуу¹²⁰), “*социаль мобиль хөдөлгөөн*” (Ү.Нямдорж¹²¹), “*зиндаачлал*” (Ц.Болд, Д.Ганхуяг нар¹²²) хэмээн орчуулан хэрэглэж байна. Угтаа нийгмийн мобиль хөдөлгөөн хэмээх эл нэршлийг шууд орчуулан хэрэглэвэл нийгэмд хэвшил болсон газар зүйн шилжилт хөдөлгөөнтэй нэршил давхардан ойлголтын хувьд төөрөгдүүлж магад тул бидэнд *нийгмийн шилжилт* гэсэн томъёолол нь илүү оновчтой гэж үзлээ.

Нийгмийн шилжилт гэдэг нь бие хүн болон бүлгийн статусын өөрчлөлт юм¹²³ (П.Сорокин), тухайн хүн юмуу бүлгийн нийгэм, эдийн засгийн байр суурь өөрчлөгдөх байдал юм¹²⁴ (А.Гидденс) зэргээр эрдэмтэд тодорхойлсон байдаг ч тэдгээрийг нэгтгэвэл нийгмийн шилжилт нь эд баялаг, удирдлагын тогтолцоон дахь байр суурь, статус гэсэн хэмжүүрүүдийн алинаар ч авч үзсэн бие хүний шилжин хөдлөж байгааг хэлдэг.

Нийгмийн шилжилтийг үнэмлэхүйн болон харьцангуй гэж хуваадаг. Үнэмлэхүйн шилжилт нь амьдралын чанар, орлогын өөрчлөлтийн хувиар, харьцангуй шилжилт нь тухайн хүний орлого эцэг эхийнхээ орлогоос өсөх байдлаар өөрчлөгдсөнөөр хэмжигддэг. Харин орлого нь эцэг эхийнхээ орлогоос буурах байдлаар өөрчлөгдсөн бол zero-sum гэж нэрлэдэг.

Мөн нийгмийн шилжилтийг үүсэх болсон шалтгаанаас нь хамаарч бүтцийн болон солилцооны гэж хоёр хуваадаг. Бүтцийн шилжилт нь хувь хүний хүчин чармайлтаас илүү нийгмийн өөрчлөлтөөс хамаардаг босоо чиглэлийн шилжилтийн хүчтэй хэлбэр юм. Харин хувь хүний үйл ажиллагаанаас хамаарсан нийгмийн бүтцийн өөрчлөлтийг солилцооны шилжилт гэж үздэг. Гэхдээ нийгмийн гарлаас хамаарсан статусын өөрчлөлт нь солилцооны шилжилт биш юм. Бүтцийн шилжилт нь нийгэм дээрх боломжтой ажлын тоо болон төрлийн өөрчлөлтийн үр дүнд бий болсон хөдөлгөөн юм. Социологич Жонн Х.Голдторп нийгмийн шилжилт илрэх ерөнхий хоёр зам байдаг гэж үзжээ. Үүнд эхнийх

¹²⁰Х.Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага. УБ., 2002.

¹²¹Н.Смелзер. Социологи. Орч. Ред. Ү.Нямдорж. УБ., 2001.

¹²²А.Гидденс. Социологи. Admon принтинг. УБ., 2006.

¹²³Нийгмийн социаль бүтэц ба социал давхраажилт. ОХУ-ын ШУА-ийн Социологийн институт. Шихихутуг ХЗДС. Шихихутуг судалгааны төв. УБ., 2012.

¹²⁴А.Гидденс. Социологи. Admon принтинг. УБ., 2006.

нь нийгмийн бүтэц, хоёр дахь нь нийгмийн статус юм. Өөрөөр хэлбэл шилжилт нь нийгмийн бүтцийг эсвэл нийгмийн статусыг өөрчилж байдаг.¹²⁵

Марксизмын хувьд нийгмийн бүтцийн өөрчлөлт буюу шилжилтийг өмч болон хөрөнгө, мэргэжлийн болоод эрх мэдлийн статус (удирдах, удирдуулах), нэр хүнд (боловсролын түвшин, мэргэжлийн түвшин, дээд боловсрол), өөрчлөлтөнд дасан зохицож буй зэрэглэлээр хэмждэг. Хэрэв нэг л хэмжүүрээр нь таарч байвал бусдаар нь ч гэсэн таарна гэсэн үг. Өөрөөр хэлбэл гурван хэмжүүр бие биеэ нөхөн таарч байдаг гэж үздэг.¹²⁶

М.Вебер социаль бүтцийг эрх мэдлээс хамаарсан тэгш бус байдал дээр үндэслэдэг дэслэн зохион байгуулагдсан, олон хэмжээст орон зай хэмээн авч үздэг. Тэрээр нийгмийн тэгш бус байдлыг анги /хөдөлмөрийн зах зээл дээрх хүний амьдралын боломж, амьдралын хэв маяг/, эрх мэдэл /эрх мэдлийн хэмжээгээр нөхцөлддөг/ статус гэж гурав хуваадаг. Тэрээр эдгээр гурван хэмжүүр гурвуул таарахгүй байж болох бөгөөд аль нэг нь дангаараа тодорхойлогч хүчин зүйл болж чаддаггүй, давхраажил ямагт гурван хэмжээстэй гэж үзсэн байдаг.¹²⁷

Нийгмийн шилжилтийг судлах үндсэн хоёр арга зүй бий. Нэгдүгээрт, үе хоорондын шилжилт (inter-generational) буюу бие хүн (бүлэг), өмнөх үеийн (гэр бүл, эцэг эх) хоорондох статусын өөрчлөлтийг судлах арга, хоёр дугаарт, үеийн дотоод дахь шилжилт (intra-generational) буюу бие хүн (бүлэг)-ий бүхэл амьдралынх нь туршид гарч буй статусын өөрчлөлтийг авч үздэг арга юм.¹²⁸

Үе хоорондын шилжилт нь үеүдийн хоорондох эдийн засгийн статистикийн босоо хамаарал буюу үеүдийн хоорондох уян хатан байдлаар хэмжигддэг. Үеүдийн хоорондох шилжилтийн уян хатан байдал бага бол нийгэмд гарах шилжилт бага байдаг байна. Өөрөөр хэлбэл үе хоорондох нийгмийн байр суурийн өөрчлөлт нийгмийн бүтцийн шилжилт хоёр шууд хамааралтай байна.

Нийгмийн шилжилтэд нөлөөлдөг олон хүчин зүйлсийг эрдэмтэд, судлаачид өөрсдийн судалгаа, өгүүлэл, онол, үзэл баримтлалд илэрхийлснийг энд нэгтгэхийг хичээлээ. Үүнд: орлого, эд хөрөнгө; эрх мэдэл буюу албан тушаал, зэрэг дэв; мэргэжил, боловсролын түвшин; нас, хүйс; гэрлэлт; засгийн газрын бодлого; үе залгамжлал; нийгэм эдийн засгийн өөрчлөлт; нийгмийн сүлжээ; ажлын амжилт; уур амьсгал; газар зүйн байрлал зэрэг хүчин зүйлс хамаарна. Эдгээрээс давхраажилтын үндсэн хэмжигдэхүүн болохынх нь хувьд орлого, эд хөрөнгө; эрх мэдэл буюу зэрэг дэв; мэргэжил, боловсролын түвшин зэргийг гол шалгуур үзүүлэлтэд тооцдог.

3§ Нийгмийн шилжилт ба нийгмийн тусгайлагдалтын хамаарал

Ерөөс нийгмийн шилжилт болон нийгмийн тусгайлагдалт хэмээх хоёр үйл явц нь нийгмийн бүтэц буюу давхраажилт, тэгш бус байдалтай шууд хамааралтай. Тиймээс Social exclusion-ыг судлахдаа нийгмийн шилжилтийн судалгааны үндсэн хоёр арга зүй болох үеийн доторх ба үе хоорондын шилжилтийг судлах арга зүйг хослуулан ашиглах шаардлагатай юм. Эл хоёр үйл явц нь шалтгаан үр дагаврын эргэх холбоонд байдаг үзэгдлүүд бөгөөд бие биеэ харилцан нөхцөлдүүлж байдаг. Тиймээс нийгмийн шилжилтийг нийгмийн тусгайлагдах үйл явцын шалтгаан, үйл явц, үр дагавар болохынх нь хувьд хослуулан авч үзэх шаардлагатай юм.


¹²⁵ John H. Goldthorpe. The role of Education in Intergenerational Social Mobility: Problems from Empirical Research in Sociology and some Theoretical Pointers from Economics, London., 2013.

¹²⁶ О.Мөнхбат. Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ., 2000. 58-59 дэх тал.

¹²⁷ О.Мөнхбат. Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ., 2000.58-59 дэх тал.

¹²⁸ А.Гидденс. Социологи. Admon принтинг. УБ., 2006.


Схем.1.



Схем.2.



Схем.3.



Нэгтгээд харвал ойлголтын хувь нийгэм, төр засгийн зүгээс эсвэл тухайн хувь хүн өөрөө өөрийгөө тодорхой бүлэгт харъяалуулж, бүлгийн нийтлэг шинжийн үүднээс хочлох, стигмадах буюу ялгаварлан гадуурхах, ямар нэг эрх ашиг, боломжийг нь хаах, эрхийг нь эдлүүлэхгүй байх, өөрсдийгөө хэтрүүлэн үнэлэх, бусдаас тусгаарлах үйл явц гэж ерөнхийд нь ойлгож болохоор санагдана.

Нийгмийн шилжилт хөдөлгөөн нь нийгмийн тусгайлагдах үйл явцын шалтгаан ба үр дагаврын харилцан холбоонд байдаг тул харьцуулан судлах шаардлагатай юм. Түүнчлэн тусгайлагдсан бүлэг бүрдэж буй үйл явц, бүлгийн нийтлэг шинж ба бүлгийг бэхжүүлж буй шинжийг тодруулахад нийгмийн шилжилтийн хэвтээ ба босоо, үе хоорондын ба үеийн доторх шилжилтийн аль нь давамгайлж байгааг судлах нь ач холбогдолтой юм.

Эрдэм шинжилгээний илтгэл (дотоод)

О.Баасантогтох. Малчдын нийгмийн ялгарал //Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага ЭШБХ. Зохион байгуулагч: Цогц хөгжлийн үндэсний төв ТББ. “Новотел” зочид буудал. УБ. 2021.11.26.



МАЛЧДЫН НИЙГМИЙН ЯЛГАРАЛ

О.БААСАНТОГТОХ
ШУА-ийн ФХ-ийн СНСЭС-ын ЭША
2021.11.26

АГУУЛГА

- МАЛЧДЫГ СУДАЛСАН ДҮР ЗУРАГ
- МАЛЧДЫН ЯЛГАРЛЫГ СУДЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ЧИГЛЭЛ
- ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОНЦЛОГООС ХАМААРАХ ЯЛГАА
- ДҮГНЭЛТ

МАЛЧДЫГ СУДАЛСАН ДҮР ЗУРАГ

ТҮҮХ, СОЁЛ, ИРГЭНШЛИЙН СУДАЛГАНЫ ТАЛБАР, ОБЪЕКТ

IX зуун | Дундад зуунаас XVII зуун | XVII зууны эхнээс | XX-XXI зуун: Нийгэм, хүмүүнлэгийн судалгааны объект

- Бэлэн үзэл онолыг хуульбарлан хэрэглэх
- Өөрийгөө таних хувилбарын эрэл
- Уламжлал, онцлогоо таних бүтээлч эрэл ориждоон
- Онол, сэтгэлгээний түвшинд бүтээгдсэн үр дүнд хүрээгүй
- Үзэгдлийг баримтын түвшинд бүртгэн судлах
- Үр дүнгүүд дагагдах шинжтэй, мөн чанарыг бага анхаардаг

СОЦИОЛОГИЙН ХАНДЛАГААР СУДАЛСАН НЬ

1970-аадыг хүртэлх	1970-1990 оны хооронд	1990 оноос хойш
<ul style="list-style-type: none"> ШУ-ны салбар Түүх Хүн ам зүй ХАА Бусад 	<ul style="list-style-type: none"> Судалгааны арга, хэрэглэгдэхүүн ШУ-ны бусад салбар Социологийн шинжлэх ухаан Нэг хэмжээст онолын хандлага Социологийн тодорхой судалгаа 	<ul style="list-style-type: none"> ШУ-ны бусад салбар Социологийн шинжлэх ухаан Олон хэмжээст онолын хандлага Социологийн тодорхой судалгаа

СУДАЛГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэд	Хамтын болон нэг сэдэвт бүтээл	Суурь болон хавсарга судалгаа
<ul style="list-style-type: none"> Ц.Уртнасан (Ph.D) О.Мөнхбат (Ph.D) Т.Бүрэнжаргал (Ph.D) Менежмент: Ц.Нансалмаа (Ph.D) Социологи, түүх, менежмент, нийгэм соёлын антропологи г.м магистрын ажлууд 	<ul style="list-style-type: none"> У.Нямдорж Х.Гүндсамбуу Ц.Уртнасан С.Дашдаваа Н.Хавх Ц.Пурзав Я.Мөнхжаргал ШУА-ФХ ШУА-ТХ Ховд УБДС бусад 	<ul style="list-style-type: none"> ШУА-ийн ФХ МУИС- Со-На тэнхим Удирдлагын академи ХНХСИ НУБ-ХХ ННФ Швейцарийн ХА, МБМХ ММСГ ЗЭСЭХХ г.м

"... монголын нийгэм бол хэзээнээс янагш нүүдэлчдийн нийгэм байсаар, үе улиран хөгжсөөр ирсэн жамтай, түүхэн замналтай. Энэ нь нийгмийн шинжлэх ухааны арга зүйн тавил, ойлголтуудыг нэгэн бодлын эргэлзээтэй, нөгөө бодлын сонирхол татам болгодог юм. орчин үеийн америкийн нэрт социологич Н.Смелзер ... ертөнцийн нөгөө талд монгол нийгмийн агуулга, мөн чанар, бодит давхраажилыг тодорхой судалгаагүйгээр ойлгоно гэдэг юу л бол"

Х.Гүндсамбуу.
Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага.
УБ. 2002, pp. 26, 103, 112.

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

СУУРЫНЛЫН ИЛГААТАЙ ХЭН МАЙГУУЛЫГ НЭГТГЭН ДҮРСЛЭХ
Суурин болон агуулийн амьдралын хэв маяг бүхий бүлгүүдийг аж нэгдсэн загвар, дүрслэлд багтан бүтээ, нэгдсэн нь хэвлэлийн интервал, хувилбарыг эрхлэй.

МАЛЧДЫН ЯЛГАРАЛ
Баруун үзэл онолыг үйлдвэр хандлага дивангайгаар өөрчлөн таних "бүтээлч" эрэл зайлуу, өргөжлөл, "жууца" тэгч мэтээр үзэх практик зорилт байхадарга тэвчлээр судлах нь хамраар.

БОДИТ АЧ ХОЛВОГДОЛ
Социализмы үед боловсруулах үйлдвэрлэлийн үр дүнд суурь, шинжлэх ухааны зөв үзэл, хүсэл, амьдралын нь үр дүнд, мөнхү эрхийн засгийн үр өгөөж бүрдсэн ч эхэлсэн хүчний 12.9 хувийг шинжлэх байна.


ӨӨРИЙГӨӨ ТАНИХ ХЭРЭГЦЭЭ

СЭТГЭЛЭЭНИЙ АСУДАЛ
Философи сэтгэлгээний түвшинд уламжлалт хэрэглэлийн талар баримтуудыг тайлбарлах шинжлэх үр дүнд хөгжсөртэй нь социаль баримт үзэгдлийн өөрчлөлтийг тодорхойлох уу гэсэн асууцлыг туслар ирнэ.

МАЛЧДЫГ СУДЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ЧИГЛЭЛ

СОЦИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН ДАХЬ ЯЛГАРЫН ТУХАЙ ОЙГОЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БОЛОВСРОН ХӨГЖСӨН НЬ

	Сүргэл мандалтай үе хургал	Маркс ба жаргисчууд	Спенсер ба функционалистууд	М.Вебер ба неоконберж	Шинэ хандлага	Постструктуралizm ба Фрейдийн шинэ сургуулийнхан
Нийгмийн тусвинд:	Плагон Аристотель И.Малковскай	К.Маркс Д.Лукат А.Гранш А.Горь Н.Луначас Э.Тоенсон Е.Карседи	Г.Спенсер А.Туннович В.Зомбарт Р.Ворис П.Парсонс О.Д.Динкен Л.Эрнгер К.Динке У.Мур	М.Вебер Ф.Парсонс Э.Гидденс Дж.Ленский У.Гранссонен	Жендеризм Угсаатны зандага Халамжиг төрийн үзэл	Мишель Фуко Пьер Бурдьё Ален Турейн
Нэвгэсүүлийн тусвинд:		М.Цейтлин С.Малле Х.Брандерман Р.Миллс Э.О.Райт	М.Эдвардс С.Прейс	Д.Ловард Ф.Бенксонер Х.Ньюби С.Свагерг		



НӨХЦӨЛ


ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОНЦЛОГООС ХАМААРАХ ЯЛГАА

МАЛ, МАЛЧДЫН ХАРЬЦАА СТАТИСТИКТ

- Баруун бүсд малчдын 24.6 хувь, малын 23.6 хувь (15,845.18),
- Хангайн бүсд малчдын 41.6 хувь, малын 33.9 хувь (22,752.40),
- Төвийн бүсд малчдын 20.3 хувь, малын 24.9 хувь (16,691.03),
- Зүүн бүсд малчдын 12.2 хувь, малын 16.9 хувь (11,311.20),
- Улаанбаатар хотод малчдын 1.3 хувь (3781), малын 0.7 хувь (468.7) нь бүртгэгдсэн.

(Үндэсний статистикийн хороо, 2021; Үндэсний статистикийн газар, 2021)


БҮС БА МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЭМШИЖ БҮЙ МАЛЫН ҮНЭЛГЭЭ



ЦАГ УУР БА ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

	2000 он	2005 он	2010 он	2015 он	2020 он
Баруун	10.9	3.3	40.6	0.7	1.2
Хангайн	11.7	1.2	35.5	1.7	0.0
Төвийн	17.5	1.6	30.1	0.8	0.1
Зүүн	2.4	3.2	11.9	0.8	0.0
УБ	2.8	1.1	28.1	0.7	0.2

БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ МАН-Н ҮЙЛДВЭРЛЭЛД



ҮР АШГИЙГ НЬ ХҮРТЭЖ БУЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Хэрэгжүүлэгч	Хөтөлбөрүүд	Хамрагдалт
Үндэсний хөтөлбөр, арга хэмжээ	Ноос ноолуурын урамшуулал	85.6
	Арьс ширний урамшуулал	67.7
	Залуу малчдыг малжуулах хөтөлбөр	8.5
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3.0
Олон улсын санхүүжилттэй	Монгол мал үндэсний хөтөлбөр	1.4
	ШХА-ыг “Ногоон алт” төсөл	11.2
	Дэлхийн зөн ОУБ-ын хөтөлбөр	7.3

БОЛОМЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ

Судалгаанд оролцогчдын 7 хувь нь буюу 73 хүн хөгжлийн бэрхшээлтэй. Үүний:

91.2 хувь нь 40 хүртэл

8.8 хувь нь 41-345 толгой малтай.


ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

	1	2	3	4	5	6	7
1. Өөрийн нийт малын тоо	1,000						
2. Нүүдлийн тоо	.452**	1,000					
3. Нэмэгдэл тэжээл, эрдэс бодис	.032	.053**	1,000				
4. Сүргээ хуваасан	.166**	.123**	.023	1,000			
5. Мал зарсан	.143**	.090**	.066**	.142**	1,000		
6. Мал махалсан	.150**	.101**	.084**	.089**	.530**	1,000	
7. Хашаа саравч барьж, сэлбэсэн	.047	-.058**	.281**	.107**	.085**	.167**	1,000
8. Отгогт явуулсан	.222**	.260**	.421**	.061**	.101**	.129**	.128**

ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

	1	2	3	4
1. Нийт орлого	1			
2. Малын эрүүл ахуйг сайжруулах	.118**	1		
3. Шилмэл үүлдрийн малтай болох	.161**	.235**	1	
4. Эрчимжсэн МАА хөгжүүлэх	.180**	.135**	.213**	1
5. Дэд бүтэц сайжруулах	.115**	.086**	.224**	.200**

МАЛЧДЫН СОЦИАЛЬ ЯЛГАА



Малчдын социаль ялгааг малын тоо, өмчийг буй малын зах зээлийн үнэлгээ, өрхийн орлого, өмчийг шалгуур болгон хэв маягаар үзсэн.

НИЙГМИЙН ЯЛГААГ ТОДОРХОЙЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

1. НАС, ХҮЙС	6. ӨМЧ, ӨМЧИЙН ХЭЛБЭР
2. ГЭР БҮЛИЙН ХЭВ МАЯГ	7. ОРЛОГО, ОРЛОГЫН БҮТЭЦ
3. АМ БҮЛИЙН ТОО	8. ӨМЧ ЗАХИРАХ ЭРХ
4. ТУРШЛАГА-БОЛОВСРОЛ	9. ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ АРГА
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ	10. СУУРЬШЛЫН ХЭВ МАЯГ

НИЙГМИЙН ХЭВ ШИНЖЭЭР

- 0.3-0.59 хүртэл насны дунджаас доош насныхан давамгайлах, энэ үзүүлэлтээс дээш, доош чиглэлд ахмад малчид давамгайлах хандлагатай байна.
- Хүйсийн хувьд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх,
- Боловсролын хувьд түвшин дээшлэх тусам,
- Гэр бүлийн хэв маягаар дан гэр бүлийн бүл,
- Ам бүлийн тоогоор дунджаас бага тооны гишүүдтэй өрх индексийн оройд байрлаж байна.

ДҮГНЭЛТ

Малчдын ялгаа нь “нөхцөл”, “боломж”-ийн харилцан үйлчлэлийн үр дүн бөгөөд нөхцөл нь өөр хоорондоо ялгарах суурь хүчин зүйл болох бол боломж нь шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэдэг.

Эрдэм шинжилгээний илтгэл (дотоод)

Ц.Пүрэв. Монголчуудын амьдралын нөөц боломжийн судалгааны зарим дүнгээс // “Монголын нийгмийн харилцаа: төлөв байдал, хандлага” Социологийн VI симпозиум. Зохион байгуулагч: МУИС, НШУС, Нийгмийн судалгааны хүрээлэн. УБ., 2022.6.15.



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УЛААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛЫН НӨӨЦ БОЛОМЖИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ДҮНГЭЭС

ШУА-ИЙН ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН
СОЦИОЛОГИЙН САЛБАРЫН ЭШАА,
ДОКТОР (PH.D) Ц.ПҮРЭВ

АГУУЛГА

- Судалгааны онол арга зүйн үндэслэл
- Амьдралын эдийн засгийн нөхцөл, ажил дээрх нөхцөл байдал, хүмүүн капиталын байдал, хэрэглээ ба чөлөөт цагийн индексийн харьцуулалт
- Иргэдийн амьдралын нөөц хийгээд хомсдол, нэгдсэн индексийн тархалт
- Нөөц боломжийн хомсдол ба эрсдэлт бүлгүүд

СУДАЛГААНЫ ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- Нийгмийн байгууллыг нэг адил эдийн засаг, улс төр болон соёлын байр суурь эзэлдэг бүлгүүдэд хуваагдсан бодгалиудын давхраажилт, анги бол “амьдралын нөөц боломж (life chances)”-оор ойролцоо хүмүүсийн бүлэг гэж М.Вебер үзжээ. Амьдралын боломжийг ангийг хуваах нэг шалгуур болгосон М.Веберийн энэхүү үзэл баримтлалыг социологичид уламжлан авч, нийгмийн давхраажилтын судалгаанд хэрэглэсээр ирсэн байна.
- Оросын социологичдын хэрэглэсэн арга зүй, аргачлалыг Монголчуудын амьдралын онцлог болон байгаа баримт өгөгдлийн хэр хэмжээнд нийцүүлэн өөриймшүүлж, Өнөөгийн Монголчуудын амьдралын боломж хийгээд эрсдэлийн нэгдсэн индексийг тоймлон гаргах зорилт тавьж байна.
 - а) амьдралын эдийн засгийн нөхцөл,
 - б) ажил дээрх нөхцөл байдал,
 - в) хүмүүн капиталаа хадгалах, өсгөх боломж,
 - г) хэрэглээ ба чөлөөт цагийн онцлог
- Дөрвөн багц үзүүлэлт тус бүрийг гурван эерэг, гурван сөрөг индикатороор тодорхойлж, нийтдээ эерэг талыг харуулах 12, сөрөг талыг харуулах 12 бүгд 24 хэмжүүрийг сонгосноо дараах хүснэгтэд харуулав.

АМЬДРАЛЫН БОЛОМЖ БА ЭРСДЭЛЭЭР МОНГОЛЫН НИЙГМИЙН БҮЛГИЙГ АНГИЛАХАД АШИГЛАСАН ХЭМЖҮҮРҮҮД (НЭГ ХЭМЖЭЭСТ ТАРХАЛТ)

Эерэг үнэлгээ (+1)	Сөрөг үнэлгээ (-1)
ӨРХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ	
<ol style="list-style-type: none"> Дөрөв ба түүнээс дээш өрөө бүхий байртай, Хаус, өвөл зунгүй амьдрах зуслангийн байртай, Амьдарч буй байрнаас гадна өөр орон сууцтай, Зуслангийн тохилог сууцтай (ӨЭ31-4.6%) Автомашинаас гадна Хүлэмж, Хувьцаа, Газар, Мал, Гараж, битүү зогсоол (ӨЭ32-13.1%) Хадгаламж хуримтлалаараа 1 жил хүртэлх хутагаанд амьдрах боломжтой, Түрээсийн орлого, зээлсэн мөнгөний хүү, хадгаламжийн хүү, Хувийн дэлгүүр, ААН-тэй (ӨЭ33-19.4%) 	<ol style="list-style-type: none"> Өр төлбөртэй. Үүнд: БЕСБ, ломбарданд барьцаат зээлтэй, хувь хүмүүст өртэй, байрны төлбөр төлөөгүй удсан (2 сар түүнээс дээш), хэрэглээ, үйлчилгээний төлбөр төлөөгүй удсан (шахилгаан, дулаан, хог г.м.) (ӨЭ31.2-24.0%) Өрхийн хэрэгцээний зардал маш хүнд, хүндэтгэр талдаа. (ӨЭ32.2-39.7%) Өрхийн нэг хүнд ноогдох сарын мөнгөн орлогоор амжиргааны доод түвшинд багтдаг (ӨЭ33.2-28.2%)
ХЭРЭГЛЭЭ БА ЧӨЛӨӨТ ЦАГ	
<ol style="list-style-type: none"> Хэрэглэж буй эдлэлийн тоо олон. (13 болон түүнээс дээш. Түүнийг 1 гэж кодолов). ХЧЦ1-19.3% Сууцны нөхцөл чанар маш сайн. ХЧЦ2-8.1% Амралт чөлөөт цагаа өнгөрөөх боломж сайтай (жилдээ ядаад нэг удаа гэрээс хөндий амардаг г. м) ХЧЦ3-20.7% 	<ol style="list-style-type: none"> Эд юмсын хэрэглээ нь нэн хязгаарлагдмал. Хэрэглэж буй эдлэлийн тоо цөөн (0-8. Түүнийг -1 гэж кодолов). Хооллолтоо муу гэж үнэлсэн. ХЧЦ1.2-29.4% Сууцны талбайн нэг хүнд ноогдох хэмжээ нь 6 метр квадратас бага, эсвэл амьдарч буй хашааны газар зай талбай багатай. ХЧЦ2.2-17.3%


АЖИЛ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ	
<ol style="list-style-type: none"> Ажиллах нөхцөл маш сайн (5.0%). АХН1-6.6% Ажил маш сонирхолтой . АХН2-9.1% Нэмэлт нийгмийн хангамж үйлчилгээ (байр, орон сууц, унаа тээвэр, эрүүл мэнд хооллолт, зээл г. м) үзүүлдэг. АХН3-10.2% 	<ol style="list-style-type: none"> Ажиллах нөхцлөө муу, маш муу гэж үнэлсэн АХН1.2-14.1% Ажил дээр хууль тогтоомж зөрчигдөх явдал гардаг АХН2.2-43.9% Удаан хутацаагаар ажилгүй байх эрсдэлтэй. Үүнд: Тэтгэврийн (ХБИ, группт орсон тэтгэврийн хүмүүсийг мөн энд хамруулна), гэртээ хүүхэд харж байгаа, гэр бүлийн болон эрүүл мэндийн шалтгаанаар ажил хийхгүй, хайхгүй байгаа, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж авдаг, ажилгүй. АХН3.2-26.4%
ХҮМҮҮН КАПИТАЛАА ХАДГАЛАХ, НЭМЭГ ДҮҮЛЭХ БОЛОМЖ	
<ol style="list-style-type: none"> Өнгөрсөн жил 6-18 хүртэл насны хүүхэд эсвэл өөрөө дамжаа сургалтад хамрагдсан. ХКН1-27.7% Сүүлийн 12 сарын хутагаанд эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ХКН2-25.2% Мэдээллийн технологийн хэрэгсэл тухайлбал ухаалаг утас, нүүтбүүк, суурин компьютерийн аль алианаар хангагдсан ХКН3-17,6% 	<ol style="list-style-type: none"> Өнгөрсөн жил 6-18 насны хүүхэд, эсвэл өөрөө дамжаа, сургалтад хамрагдаагүй ХКН1.2-64.3% Сүүлийн 12 сарын хутагаанд эрүүл мэндийн үйлчилгээнд гэр бүлийн гишүүд огт хамрагдаагүй. ХКН2.2-26.0% Өдөр тутмын амьдралдаа мэдээллийн технологи ашиглах дадал байхгүй, түүнийг ашиглах боломжгүй. ХКН3.2-11.4%

АМЬДРАЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ, АЖИЛ ДЭЭРХ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮМҮҮН КАПИТАЛЫН БАЙДАЛ, ХЭРЭГЛЭЭ БА ЧӨЛӨӨТ ЦАГИЙН ИНДЕКСИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Амьдралын нөөц боломжийн 4 багц үзүүлэлтийн тархалт болон дундаж утга

Хувьсагчийн утга	ӨЭЗ		АХН		ХКН		ХЧЦ	
	Давтамж	Хувь	Давтамж	Хувь	Давтамж	Хувь	Давтамж	Хувь
-3	30	3.3	9	1.4	27	3.0	62	6.9
-2	170	18.9	113	17.7	159	17.7	222	24.7
-1	256	28.4	370	58.1	249	27.7	295	32.8
0	279	31.0	81	12.7	203	22.6	185	20.6
1	134	14.9	46	7.2	169	18.8	96	10.7
2	29	3.2	18	2.8	82	9.1	36	4.0
3	2	.2			11	1.2	4	.4
Total	900	100.0	637	100.0	900	100.0	900	100.0
Дундаж утга		-0.54		-0.85		-0.31		-0.82


ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН НӨӨЦ ХИЙГЭЭД ХОМСДОЛ, НЭГДСЭН ИНДЕКСИЙН ТАРХАЛТ




Нэгдсэн индексийн дундаж утга сөрөг буюу -2.28; моод утга нь -2, медиан нь -2.0 стандарт хазайлт нь 3.09 гарсан. Амьдралын боломжийн индексийн хамгийн их утга 12 гарахаас 8, хамгийн бага утга -11 гарсны дээр судалгаанд хамрагдагсдын дийлэнх олонх нь (71.0%) амьдралын боломжоо сөргөөр үнэлсэн, түүний гуравны нэгээс илүүтэй нь (судалгаанд хамрагдагсдын дөрөвний нэг) 5 болон түүнээс дээш боломж нөөцдөө сэтгэл ханамж муутай байлаа.

НӨӨЦ БОЛОМЖИЙН НЭГДСЭН ИНДЕКС

INDEX				
	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
-11.00	1	.1	.1	.1
-10.00	2	.2	.2	.3
-9.00	9	1.0	1.0	1.3
-8.00	23	2.6	2.6	3.9
-7.00	37	4.1	4.1	8.0
-6.00	68	7.6	7.6	15.6
-5.00	96	10.7	10.7	26.2
-4.00	86	9.6	9.6	35.8
-3.00	107	11.9	11.9	47.7
-2.00	114	12.7	12.7	60.3
-1.00	96	10.7	10.7	71.0
.00	102	11.3	11.3	82.3
1.00	58	6.4	6.4	88.8
2.00	40	4.4	4.4	93.2
3.00	25	2.8	2.8	96.0
4.00	27	3.0	3.0	99.0
5.00	3	.3	.3	99.3
6.00	3	.3	.3	99.7
7.00	2	.2	.2	99.9
8.00	1	.1	.1	100.0
Total	900	100.0	100.0	



АМЬДРАЛЫН НӨӨЦ БОЛОМЖ, ЭРСДЛИЙН ТҮВШИНГЭЭС ХАМААРСАН БҮЛЭГ



■ Нөөц боломжоор давуутай ■ Дундаж ■ Хомсдолд өртөгсөд

Дурдсан гурван бүлгийн хувьд нөөц боломжийн дундаж индекс мэдэгдэхүйц ялгаатай буюу харгалзан -6.88; -2.44; +2.36 болно. Хэрвээ дөрвөн багц үзүүлэлтээс дор хаяад хоёроос доошгүйд нь нөөц боломжийн ямар нэг хэмжээний хомсдол бүхий иргэдийг нөөцийн хомсдолтой гэж тооцох юм бол (4 болон түүнээс дээш тооны хомсдолт шинж бүхий) ийм бүлэг нь нь 35.8 хувьд хүрч байна

АМЬДРАЛЫН НӨӨЦ БОЛОМЖИЙН ДУНДАЖ ИНДЕКСИЙГ ДООР ҮЗҮҮЛЛЭЭ

1. Мэдээллийн технологи эзэмшээгүй хүмүүс (103) - 5.74	8. Төвөөс алслагдсан хөдөөгийн оршин суугч (50 хүн) -3.94
2. Гэртээ хүүхэд харж байгаа (45 хүн) -5.13	9. Эрүүд мэндээ муу, маш муу гэж үнэлсэн (114 хүн) -3.78
3. Манайх өлөн зэлмүүн, хэцүүхэн амьдралтай айл (145 хүн) -4.85	10. Сэтгэл гутранги хүн (117 хүн) -3.69
4. Боловсролгүй болон бага боловсролтой (43 хүн) - 4.81	11. Ээж хүүхэдтэйгээ хамт (14 хүн) -3.57
5. Өрхийн нэг хүнд ноогдох сарын мөнгөн орлого нь доод квантильд харьяалагдагсад (180 хүн) -4.7	12. 65-аас дээш насныхан (57 хүн) -3.52
6. Ажил хөдөлмөр эрхлээгүй хүн (52 хүн) -4.55	13. Хөдөөнөөс шилжин ирэгсэд (51 хүн) -3.41
7. Гэрт амьдардаг (209 хүн) -4.21	14. Ганц бие хүн (63 хүн) -3.22
	15. Матад (30 хүн) -5,07
	16. Мөрөн (80 хүн) -3,67

- Анхаарал тавьсанд баярлалаа.